



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА
МОНГОЛБАНК

СУДАЛГААНЫ АЖИЛ

Товхимол-1

Улаанбаатар хот

2023 он

СУДАЛГААНЫ АЖИЛ

ТОВХИМОЛ

Энэхүү судалгааны ажлын товхимолд дурдагдах аливаа дүгнэлт, дэвшүүлсэн санал нь зөвхөн хувь судлаачийн байр суурийг илэрхийлэх бөгөөд Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны байр суурийг илэрхийлэх албагүй болно.

© САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА, 2023

ӨМНӨХ ҮГ

Эрхэм уншигч Таны амар амгаланг айлтгая.

Санхүүгийн мэдээллийн албанаас 2022 оны хувьд судлаач, оюутнуудыг соён гэгээрүүлэх чиглэлээр ач холбогдол өндөр бүхий нэгэн ажил хийсэн нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн эрдэм шинжилгээний хурлыг анх удаа зохион байгуулсан явдал байлаа. Тус ажлыг Хамтын ажиллагааны зөвлөлийн Судалгаа дүн шинжилгээний ажлын хэсгийн хүрээнд хийж гүйцэтгэсэн бөгөөд 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдөр амжилттай зохион байгуулсан билээ.

Уг эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдсанаар судлаач, оюутнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл туурвихад нь уриалж сэдэлжүүлэх, бүтээлийг нь олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, бодлогын шийдвэр гаргалтад оролцох оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой бөгөөд цаашид энэхүү хурлыг Санхүүгийн мэдээллийн албанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулсаар байх юм.

Энэ удаа 2022 оны эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцсон оюутнуудын судалгааны ажлуудаас түүвэрлэн Танд хүргэж байна.

Уншигч Та энэхүү судалгааны товхимлын талаарх санал бодлоо бидэнд ирүүлбэл бид талархах болно.

*Хүндэтгэсэн,
Санхүүгийн мэдээллийн албаны дарга
Б.Батбаатар*

ГАРЧИГ

Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны нэрэмжит эрдэм шинжилгээний бага хурлын I байр

1. Санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн комплаенсийн тогтолцоог сайжруулах нь

А.Одонтуяа, Б.Чинзэтөгс 1

Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны нэрэмжит эрдэм шинжилгээний бага хурлын II байр

2. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх: Алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээ ба татварын асуудлууд

Б.Амарбаясгалан, С.Будсүрэн, Д.Долгорсүрэн 26

Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны нэрэмжит эрдэм шинжилгээний бага хурлын III байр

3. Монгол Улс дахь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хүрээнд тавигдах мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалт

М.Маралмаа, Б.Мягмарсүрэн 46

4. КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор үүссэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл

А.Бат, Б.Намуунаа, Т.Цолмон 58

5. ФАТФ-ын 40 зөвлөмжийн эдийн засагт үзүүлэх нөлөө

Э.Бат-Очир, Б.Түмэнзаяа 73

6. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гарч буй дижитал шилжилт

Ц.Мишиээл, С.Хулан, Д.Өсөхжаргал..... 95

7. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн талаарх эрх зүйн орчин, тус гэмт хэргийн талаарх хүүхэд залуусын ойлголт

Г.Баясгалан, Н.Эрдэнэбаяр..... 113

8. Зэрлэг ан амьтдыг хууль бусаар худалдаалах замаар мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх явдал

Ц.Бямбадорж 132

9. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог технологид суурилан сайжруулах нь

Н.Чойжамц, Д.Сүхбат 146

10. Залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь

Д.Отгонбаяр, С.Амбасэлмаа 164



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

МОНГОЛБАНК

**САНХҮҮГИЙН БОЛОН САНХҮҮГИЙН БУС БИЗНЕС,
МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДИЙН
КОМПЛАЕНСИЙН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ**

А.Одонтуяа¹, Б.Чинзэтөгс²

¹ Санхүү эдийн засгийн их сургууль, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн тэнхим, IV курсын оюутан. Цахим хаяг: b18fa1016@ufe.edu.mn

² Санхүү эдийн засгийн их сургууль, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн тэнхим, IV курсын оюутан. Цахим хаяг: b18fa1222@ufe.edu.mn

ТОВЧ ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны хүрээнд манай улсын санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн комплаенсийн тогтолцоог судалж, түүнд тохирсон санал зөвлөмж, сайжруулах арга зам боловсруулах зорилгын хүрээнд комплаенсийн тогтолцоо, бодлого эрх зүйн орчин, санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж судалгааны үр дүнг шинжилж, дүгнэлт санал зөвлөмж боловсруулсан. Судалгааг тоон болон чанарын судалгааны аргачлал болох ганцаарчилсан ярилцлага, анкетын, кейс харьцуулалтын болон бичиг баримт цуглуулах аргуудын ашиглаж хийж гүйцэтгэсэн. Ингэхдээ нийт салбарын 12 комплаенс хариуцсан ажилтнуудаас байгууллагын комплаенсийн үйл ажиллагааг судлах зорилготой анкетын асуулга цуглуулж, комплаенсийн 9 мэргэжилтнээс комплаенс тогтолцооны өнөөгийн нөхцөл байдлыг тодруулах зорилготой ярилцлага авсан. Мөн Монгол улсын шүүхийн шийдвэрээр МУТС холбогдсон кейсүүдийг судлан баримт бичгийг харьцуулан судаллаа. Судалгааны үр дүнд Монгол улсын комплаенс тогтолцоо нь санхүүгийн салбарт харилцан адилгүй хөгжсөн ба банкнаас бусад салбарт уг ойлголт харьцангуй сүүлд түгээн дэлгэрч байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Нийт салбарт түгээмэл тулгамдаж буй асуудал нь комплаенсийн мэргэшсэн, туршлагатай ажлын хүч бөгөөд уг асуудалтай холбоотой хууль тогтоомж, дотоод дүрэм журам байгууллагуудад тусгагдсан хэдий ч хяналт шалгалт дутмаг байгаагаас үүдэн МУТС эрсдэл өндөр байгааг уг судалгаагаар илрүүллээ.

ТҮЛХҮҮР ҮГ

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, комплаенс, тогтолцоо

1. ОРШИЛ

Монгол улсад дотоод тэмцэл, зөрчил аль эсвэл томоохон санхүүгийн гэмт хэрэг гарах нь цөөн, терроризмын аюул, заналын идэвхтэй бүс нутаг биш учир ихэнх байгууллагууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тэр бүрчлэн ойшоолгүй үүнтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээнүүдийг өдөр бүрийн үйл ажиллагаа болон компанийн засаглалын хүрээнд чухалчилж авч үздэггүй билээ. Гэтэл эсрэгээрээ хөгжил буурай, санхүүгийн тогтолцоо сайтар хөгжөөгүй, хууль эрх зүйн зохицуулалт сул орнуудад далд эдийн засаг илүү хөгжиж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанууд явуулах тааламжтай байршил болдог бөгөөд гадаад улс орнууд руу чиглэсэн терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа тохиолдох магадлалтай байдаг. Хэдийгээр далд эдийн засагтай холбоотой судалгааг хийхэд нарийн мэдээлэл, тооцоолол шаардлагатайгаас ихээхэн хүндрэлтэй байдаг хэдий ч сүүлийн жилүүдэд Монгол улсад авлига, хээл хахууль, оффшор хөрөнгөтэй холбоотой тохиолдол олон нийтэд илрэх нь ихсэж, 2017-2019 онуудад нийт бүртгэгдсэн гэмт хэргээс 64.7%-ийг хууль бус мөнгөн хөрөнгө бүрдүүлэх боломжтой гэмт хэргүүд эзэлсэн байна. Манай улсын хэмжээнд банкнаас бусад санхүүгийн салбарын системд эзлэх хувь хэмжээ бага ч нэгжийн тоо, үйлчилгээний төрөл их байгаагаас хамаарч төвлөрсөн хяналт тавихад хүндрэл үүсдэг билээ. Мөн санхүүгийн байгууллага, бизнесийн байгууллага, төрийн бус байгууллага, худалдааны төвүүд тэдгээрийн комплаенсийн нэгжийн үйл ажиллагаа болон мэдээлэх эрх бүхий мэргэжилтнүүдийн мэдлэг чадвар, мэдээллийн хүртээмж болон олон улсын стандарт бүхий орчин нөхцөл, программ хангамжаас үзэхэд хангалттай бус байгаа нь МУТС эрсдэлийг нэмэгдүүлэх томоохон хүчин зүйлсийн нэг болоод байна. ОУВС-ийн гаргасан загварчлалын дагуу улсын хэмжээнд 900 гаруй тусгай зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаан дээр эрсдэлийн үнэлгээ хийхэд санхүүгийн салбарын аж ахуйн нэгжүүд комплаенсийг нэвтрүүлээгүй, аль эсвэл холбогдох ажилтан томилоогүйгээс шалтгаалан байгууллагын төдийгүй зах зээлийн нэр хүндийг унагах сөрөг үр дагавар авчирч болзошгүй хэмээн тодорхойлсон (Ж.Оймандах, Комплаенс систем ба удирдах арга барилыг шинэ түвшинд гаргах нь Эрдэм шинжилгээний өгүүлэл, 2017). Өөр нэгэн жишээ дурдвал, Глобал Скэйфийн 2018 оны тайланд Комплаенсийг дагаж мөрдөхгүй байх өртөг нь Комплаенсийг дагаж мөрдсөн зардлаас 2.71 дахин их байна. хэмээн дурдсан байдаг. Дээрх асуудлуудаас үзэхэд комплаенсийн тогтолцоо нь олон улсын түвшинд зайлшгүй хэрэгжүүлэх стандарт бөгөөд монгол улсад комплаенсийн тогтолцоог судлах, цаашид сайжруулах шаардлагатай хэмээн үзэж байна.

Судалгааны зорилго

МУТС эрсдэлийг бууруулахад Монгол улсын санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн комплаенсийн тогтолцооны ач холбогдол, түүний өнөөгийн нөхцөл байдлыг судалж, МУТС-тай тэмцэх, урьдчилан сэргийлэх комплаенсийн тогтолцоог сайжруулах арга зам боловсруулах, судалгааны үр дүнд тохирсон санал зөвлөмж боловсруулахад энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Судалгааны зорилт

- Комплаенс, МУТС түүний тогтолцооны талаар онолын судалгаа хийх;
- Салбарын судалгаагаар хууль эрхзүйн тогтоомж хэрэгжээд буй олон улсын стандартуудыг судлах, салбарын талаарх зах зээлийн мэдээллийг судлах;
- Эмпирик судалгаагаар түүврийн аргаар тоон болон чанарын судалгааг хийх;

- Судалгааны үр дүнд тохирсон дүгнэлт өгөх;
- Комплаенсийн тогтолцоог сайжруулах санал зөвлөмж боловсруулах.

Судалгааны ач холбогдол

Энэхүү сэдвийг судалж, санал зөвлөмж боловсруулсаар цаашдаа комплаенсийн тогтолцоог Монголд бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах, санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагууд комплаенсийг хангаснаар өөрийн байгууллагын засаглалыг сайжруулах, тэр бүү хэл санхүүгийн системийг хамгаалах, МУТС эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гадаад хөрөнгө оруулагчдаас санхүүжилт авах боломж нэмэгдэх ач холбогдолтой юм.

2. ОНОЛЫН ХЭСЭГ

2.1. *Комплаенсийн тухай ойлголт*

Комплаенс гэдэг нь италиар “complire”, испаниар “cumplir”, латинаар “complere”, англиар “compliment” буюу гүйцэтгэх, гүйцээх, биелүүлэх гэсэн үгнүүдээс гаралтай бол Монгол хэлэнд комплаенсийг “нийцэл” хэмээн тодорхойлдог (Санхүүгийн Зохицуулах Хороо, 2019). Комплаенс гэх ойлголт нь анх 1970 оны эхээр АНУ болон бусад хөгжингүй орнуудын Үндэстэн дамнасан корпорацууд хүчээ авч мөнгө угаах, авлига хээл хахуулийн болон залилангийн хэргүүд газар авч улмаар АНУ-д гадаадад үйл ажиллагаа эрхэлж буй Америкийн корпорацуудын авлига хээл хахууль, бизнесийн ёс зүйг зохицуулсан (FCPA) буюу хилийн чанадын авлига хээл хахуулийн эсрэг хууль 1977 онд батлагдсан байдаг (Ж.Оймандах, "Комплаенс систем ба удирдах арга барилыг шинэ түвшинд гаргах нь" Эрдэм шинжилгээний өгүүлэл, 2017). Цаашлаад олон улсуудад авлига хээл хахуулиас хамгаалсан мөн санхүүгийн зах зээл дээрх үйл ажиллагаа эрхэлж буй бизнесүүдэд бизнесийн ёс зүй болон комплаенсийн хөтөлбөрийг нэвтрүүлэхийг хуульчилсан нь өнөөгийн олон улсын стандартчиллын байгууллага (ISO) 2014 онд Комплаенсийн удирдлагын систем буюу ISO 19600 стандартыг боловсруулах суурь үндэс нь болсон билээ.

Олон Улсын Комплаенс удирдлагын тогтолцоо /ISO 19600:2014/ стандартад “Комплаенсийг байгууллага хууль тогтоомж, олон улсын стандарт шаардлагыг хэрэгжүүлэх” гэж тодорхойлжээ. Олон улсын комплаенсийн зөвлөл “Комплаенс” гэдэг нь компанийн засаглалын нэгэн хэсэг бөгөөд тухайн аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомж, журам, зааварт нийцүүлж үйл ажиллагаа явуулах чадамж” гэж тодорхойлсон байдаг. Олон улсын аудит, санхүүгийн зөвлөх үйлчилгээ болон эрсдэлийн удирдлагын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Deloitte” байгууллагаас “Комплаенс нь бизнесийн үйл ажиллагаа явуулахдаа ямагт зөв үйлдэл хийнэ гэсэн ойлголт бөгөөд энэ утгаараа байгууллагын бүх ажилтнуудад хамааралтай байж, банкны соёл, үнэт зүйл, үйл ажиллагааны салшгүй хэсэг болдог” хэмээдэг. Олон улсын хуульч Ж.Оймандахын тодорхойлсноор “Комплаенс гэдэг нь аливаа үйлдэл (баримт бичиг, аудитын тайлан бэлтгэх зэрэг)-ийн эзэн, үйлдвэрлэгч эсвэл бүтээгдэхүүн ханган нийлүүлэгч аливаа хууль тогтоомж, хүлээн зөвшөөрөгдсөн практикийн дадал, нарийн зохицуулсан дүрэм, журам, тусгай стандарт эсвэл гэрээгээр заасан шаардлагыг биелүүлснийг гэрчлэх эсвэл баталгаажуулах явдал” гэж ойлгоно (Ж.Оймандах, *Комплаенсийн талаарх цуврал лекц 3*, 2016).

Комплаенсийн эрсдэл гэдэг нь хууль тогтоомж, дүрэм, журам, ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын дотоод бодлого зэрэг зөрчигдсөнөөс үүсэх ба байгууллагын үйл ажиллагааг

доголдуулсан хүндрэл, бэрхшээлийг хэлнэ. Дараах нийтлэг эрсдэл үүсдэг (Санхүүгийн Зохицуулах Хороо, 2019).

- Санхүүгийн хууль бус үйлдэл, албан тушаалаа урвуулан ашиглах
- Зохицуулалтын байгууллагаас тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох
- Бүтээгдэхүүн, үйлчилгээгээ зах зээлд нэвтрүүлэхэд хүндрэл гарах
- Байгууллагын болон бизнесийн нэр хүндээ алдах
- Захиргааны арга, хэмжээ торгууль тавигдах
- Албан хаагчдын мэргэжлийн бус үйлдэл гаргах

2.2. **Комплаенсийн хамрах хүрээ, зарчмууд**

Хүснэгт 1. *Комплаенсийн цар хүрээ*



Комплаенсийн үндсэн зарчим:

Хүснэгт 2. *Комплаенсийн үндсэн зарчмууд*



Комплаенсийн тогтолцоо

Комплаенсийн тогтолцоо буюу систем гэдэг нь байгууллагын төлөөлөгчид болон ажилтнууд нь хүчин төгөлдөр бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, дүрэм журам, горим болон

практик дадлын шаардлагуудаа өдөр тутмын үйл ажиллагаандаа боловсруулах, нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн хяналтаар ханган ажиллахыг хэлнэ (Ж.Оймандах, LinkedIn.com, 2016).

Хүснэгт 3. Байгууллагын комплаенсийн тогтолцоо



Базелийн хорооноос комплаенсийн хяналт болон дотоод аудит, дотоод хяналтын чиг үүргүүдийн тусгаарлах тодорхой цаг хугацааны үечилсэн байдлаар комплаенсийг үнэлж байхыг зөвлөдөг. Эдгээр чиг үүргүүд нь бүгд өөр өөрийн гэсэн зорилтуудтай байдаг тул байгууллага эдгээр нэгжүүдийг нарийвчлан тодорхойлж өгөх шаардлагатай.

- Дотоод хяналт нь байгууллагын зорилтыг биелүүлэхэд чиглэсэн өдөр тутмын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.
- Комплаенс нь эрсдэлийг удирдах үүрэгтэй байгууллагын бүхий л шатанд үүсэж болох комплаенсийн хамрах хүрээнд хяналт тавих үүрэг хүлээнэ.
- Дотоод аудит нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой дотоодын хяналтын процессын алдааг илрүүлэх, хараат бус бодит баталгаа өгөх, зөвлөгөө хүргүүлэх чиг үүрэгтэй юм.

Комплаенсийн ажилтан гэдэг нь байгууллагын үйл ажиллагааг хууль тогтоомж, олон улсын стандарт шаардлагад нийцүүлэх замаар байгууллагыг нэр хүнд, хууль, эрх зүй, санхүүгийн алдагдалд орох эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй ажилтан юм. Комплаенсийн ажилтны хэрэгжүүлэх гол чиг үүрэгт эрсдэлийг илрүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн мониторинг хийх мөн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр үүрэг хүлээдэг (Санхүүгийн Зохицуулах Хороо, 2019).

Харилцагчийг таньж мэдэх: Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан этгээд харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэдэх үүрэгтэй.


Улс төрд нөлөө бүхий этгээд: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг хэлнэ.

Мэдээлэх үүрэгтэй этгээд: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн дагуу хяналт тавих арван хуулийн этгээдийг сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг СМА-д мэдэгдэх үүрэгтэй.

3. КОМПЛАЕНСИЙН ТОГТОЛЦОО, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА

3.1. Улс орнуудын МУТСТ тогтолцоо

Хүснэгт 4. Улс орнуудын МУТСТ тогтолцоо



Дэлхийн бусад улс орнуудын МУТСТ тогтолцоог харвал өөрсдийн орон нутгийн онцлог, санхүүгийн эрсдэл гэх мэтчилэн зүйлс дээр тулгуурлан МУТС гэмт хэрэгтэй илүү цогц бүтцээр зохион байгуулалттайгаар тэмцэж байна. Ихэнх улс орнуудын хувьд МУТС-д хяналт тавьж ажиллах үүрэгтэй байгууллага нь засгийн газрын агентлаг байгаа бол Их Британий хувьд The Financial conduct authority /FCA/ гэх бие даасан, төрийн бус байгууллага Их Британийн санхүүгийн үйлчилгээний салбар, тэр дундаа мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэх мэт бусад гэмт хэрэгтэй тэмцэх үүргийг гүйцэтгэдэг бөгөөд дараах эрх мэдэлтэй байдаг байна: (1) Зохицуулалт: Санхүүгийн бүтээгдэхүүний хамгийн бага хууль эрх зүйн стандартыг тогтоож, FCA дүрэмд нийцэхгүй бүтээгдэхүүнд хориг тавих; (2) Хяналт: Эрсдэлийн үнэлгээ хийх, сэжигтэй үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох байгууллагад тайлагнах зэрэг мөнгө угаалтын эсрэг тодорхой дүрэм журмыг дагаж мөрдөх; (3) Зөвшөөрөл олгох: Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохоос өмнө санхүүгийн байгууллагуудад бүртгэл, шаардлага тавих. Харин Австрали улсын хувьд Australian Transaction Reports and Analysis Centre (AUSTRAC) гэх Австралийн засгийн газрын санхүүгийн тагнуулын үндсэн агентлаг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, залилан болон бусад санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх үүрэгтэй ажилладаг байна (Financial Conduct Authority, 2022; Australian Government AUSTRAC, 2022).


Харин Монгол улсын МУТСТ тогтолцоог харвал АНУ гэх мэтчилэн бусад улс орнуудтай адил институцийн тогтолцоогоор МУТСТ үйл ажиллагаа явуулдаг буюу Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулах үүрэгтэй байдаг. Түүнчлэн АНУ болон Хонг Конгийн зохицуулагч байгууллагуудаас зохицуулалттай байгууллагуудаас комплаенсийн хөтөлбөр, ажилтнуудыг заавал биелүүлэх ёстой шаардлагад авч үздэг байна (Cov, Congress, 2022). Жишээлбэл, АНУ-д 2001 онд батлагдсан Patriot Act-ын 352-р зүйлийн 1(b)-д “Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд санхүүгийн байгууллага бүр Мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөрийг боловсруулахдаа дор хаяж

Комплаенсийн ажилтныг томилох ёстой” гэж заасан байдаг бол манай улсын хувьд 2013 онд батлагдсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хуульд мэдээлэх үүрэгтэй этгээдэд комплаенсийн нэгж/ажилтан заавал байх ёстой талаар заагаагүй ч 2018 оны 2-р сарын 6-ны өдөр батлагдсан Монголбанкны ерөнхийлөгчийн “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан зарчмыг хэрэгжүүлэх удирдамж”-нд Комплаенсийн ажилтны эрх үүргийг удирдлагаас хараат бус байдлаар сэжигтэй гүйлгээний тайланг Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх шийдвэрийг бие даан гаргах, харилцагчийн талаар банканд байгаа бүх бичиг баримт болон гүйлгээний мэдээлэлд нэвтрэх, гаргуулж авах эрхтэй хэмээн зааж өгсөн байна.

3.2. Монгол Улсын МУТСТ тогтолцоо

i. Зохицуулах байгууллагууд

Хүснэгт 5. Монгол улсын МУТСТ тогтолцоо



Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа банк, санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн бус мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгуулагчдын комплаенсийн үйл ажиллагааг Монголбанкны дэргэдэх Санхүү мэдээллийн алба болон СЗХ хяналт тавьж, зохицуулах үүргийг гүйцэтгэдэг. Монголбанкны болон СЗХ-ны зохицуулалттай байгууллагуудаас банк, ББСБ, ҮЦ, ХЗХ, ҮХХЗ болон даатгалын байгууллагууд хажуудаа холбоо зөвлөлтэй байна. Эдгээрээс Монголын банкны холбоо, Банк бус байгууллагуудын холбоо, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нар хажуудаа комплаенсийн хороо, зөвлөлтэй байгаа нь комплаенсийн тогтолцоо банк болон бусад санхүүгийн байгууллагад бүрдэж эхэлж байгааг харуулж байна.

Түүнчлэн МҮХҮАТ-ын дэргэд Үндэсний комплаенсийн зөвлөл 2019 онд байгуулагдсан ба АТГ, Монголын Комплаенсийн Холбоо, Монголын Олон Улсын Арбитр, Азийн Сан болон мэргэжлийн холбоодын төлөөллүүд нэгдсэн ба компанийн засаглалыг хөгжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомж, журам, зааварт нийцүүлж үйл ажиллагаа явуулах чадамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллахын зэрэгцээ Комплаенсийг олон нийтэд танилцуулах, дэлгэрүүлэх, хөгжүүлэх зорилготойгоор жил бүр Комплаенсийн форумыг бусад холбогдох байгууллагын хамтаар зохион байгуулах, гарын авлага гаргах, сургалт зохион байгуулах гэх мэт үйл ажиллагаа явуулдаг байна. Харин Монголын комплаенсийн холбоо нь комплаенсийн ажилтан, мэргэжилтнүүдэд Олон улсын Комплаенсийн холбооны сертификат олгох МУТСТ сургалт орох, Банк санхүүгийн болон СББМҮҮ байгууллагуудад комплаенсийн баримт бичгийг боловсруулахад чиглүүлэг өгөх, эрсдэлийг үнэлэх гэх мэтчилэн үйл ажиллагааг явуулдаг.

Доорх хүснэгтэд Монгол улсад МУТСТ тухай мөрдөгдөж, хэрэгжиж байгаа холбогдох хууль тогтоомжууд болон заавар зөвлөмжүүдийг жагсаасан ба Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа банк, банк бус санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын комплаенсийн нэгж, ажилтнууд дараах хууль тогтоомж, журмуудыг үйл ажиллагаа болон байгууллагын дүрэм журамдаа тусгаж, хэрэгжүүлэх ёстой байдаг.

ii. Монгол улсад зохион байгуулагдсан хурал цуглаан

Монгол улсад 2012 оноос эхлэн арилжааны банкууд өөрсдийн санаачилгаар жил болгон “Комплаенс форум”⁴ амжилттай зохион байгуулдаг уламжлалтай. Хамгийн анхны форумыг ХААН банк болон Монгол банк хамтран зохион байгуулж байсан түүхтэй. 2018 оноос эхлэн СЗХ нь өөрийн хяналт тавих зохицуулалттай салбаруудад зориулсан “Санхүүгийн салбарын комплаенс форум”⁵ зохион байгуулсан билээ. 2016 оноос Банк Санхүүгийн Академи нь комплаенсийн онлайн сургалт явуулдаг уламжлалтай байсан бол сүүлийн жилүүдэд энэхүү ойлголт нь монгол улсад ихээхэн түгээмэл болж, зохион байгуулагдаж буй хэлэлцүүлэг, сургалтуудад холбоод болон салбарын мэргэжилтнүүд идэвхтэй оролцож байна. 2019 он гэхэд 1500 этгээдийг хамруулсан 13 удаагийн сургалтыг зохион байгуулагдаж, комплаенсийн ажилтнуудад зориулсан 3 гарын авлага, иргэдэд чиглэсэн 1 гарын авлага олон нийтэд хүргэгдсэн. (Санхүүгийн Зохицуулах Хороо, 2021). Цар тахлаас үүдэлтэй хурал цуглаан 2020 онд эрс багассан ба 2021 оны сүүлийн үеийн байдлаар “Комплаенс, бизнесийн ёс зүйн анхдугаар чуулган” хуралдсан байна.

iii. Комплаенстай холбоотой бодлогын бичиг баримтууд

Хүснэгт 6. Комплаенсийн холбогдох хууль, журмууд

Бичиг баримтууд	Нэр	Батлагдсан огноо
Холбогдох хууль	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай	2013.05. 31
	Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль	2019.10.10
Тогтоолууд	Заавар, аргачлал, журам батлах (МҮЭ-ийн МУТСТ үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээний матриц, Тоон болон чанарын өгөгдөл цуглуулах маягт, МҮЭ-ийн дотоод хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх асуулга мөн улирал бүрийн тайлан мэдээний загвар)	2018.12.13

	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	2019.12.27
Журмууд	Мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам	2019.12.25
	Банкнаас бусад санхүүгийн болон СББМҮА-г тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам	2020.04.08
	Мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам	2018.11.14
	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам	2019.01.21
	Санхүүгийн мэдээллийн албаны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөлийн ажиллах журам	
	Банкны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийх журам	
	Санхүүгийн мэдээллийн албаны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөлийн ажиллах журам	
	Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам	
	Банкны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам	
	Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийнхөдөлгөөнийг зогсоох, хянах журам	
Заавар,	ФАТФ-аас гаргасан заавар, зөвлөмж, тайлан	
зөвлөмж гарын авлага	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн МУТСТ эрсдэлийг үнэлэх асуулга	
	Хяналт шалгалтын бодлогын баримт бичиг	2021
	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан зарчмыг хэрэгжүүлэх удирдамж	
	Сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэх гарын авлага салбар тус бүрээр	2021.05.27
	Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын МУТС-ээс урьдчилан сэргийлэх гарын авлага	2020.08.24

Доор харуулсанчлан мэдээлэх үүрэгтэй этгээд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хуулийн 7-р зүйлд заасан гүйлгээ гарсан тохиолдолд СМА-руу мэдээлж, СМА нь тухайн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэгтэй байдаг. Харин мэдээлсэн мэдээлэл нь гэмт хэргийн бус зөрчлийн шинжтэй байвал СЗХ руу хэргийг шилжүүлэх маягаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Хүснэгт 7. Сэжигтэй гүйлгээг мэдээлэх процесс



Сэжигтэй гүйлгээг мэдээлэх, МУТС гэмт хэргийг илрүүлэх энэхүү процедур нь илүү хүртээмжтэй, зохион байгуулалттай болж хөгжиж байгаа хэдий ч аль аль шатандаа асуудал, дутагдалтай байсаар байгааг хоёрдогч эх үүсвэрийн мэдээллүүд болон ганцаарчилсан ярилцлагын үеэр дурдаж байснаас жишээлбэл,

1/ 2021 онд СМА-д ирүүлсэн сэжигтэй гүйлгээний мэдээллийн 98% нь зөвхөн банкны салбараас ирсэн бол үлдсэн 2%-ийг буюу 10 орчим гүйлгээг бусад санхүүгийн салбарууд эзэлсэн. Энэ нь банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдийн хувьд мэдээ мэдээлэл харьцангуй дутмаг, байгууллагад комплаенсийн тогтолцоо бэхжээгүй учраас МУТС-тэй тэмцэх үйл ажиллагааны үр ашгийг ойлгоогүй, сэжигтэй гүйлгээг мэдээлсэн тохиолдолд өөрсдөө торгуулах эсвэл нэр хүнд унах зэрэг сөрөг үр дагавар гарч болзошгүй гэх мэт шалтгаануудтай хэмээн ганцаарчилсан ярилцлагын үеэр дурдсан.

2/ Санхүү мэдээллийн албаны хувьд тайлангаа өгсний дараа эргэх холбоо байдаггүй, тайлан хүлээж авсан талаар хариу өгөх эсвэл сануулга өгөх гэх зэрэг хариу үйлдэл үзүүлэлгүйгээр шууд дүгнэж, шийтгэх үйл ажиллагаа явуулдаг хэмээн ярилцлага өгсөн байгууллагууд онцолж байсан. Түүнчлэн Санхүү мэдээллийн алба нь газар дээр хяналт шалгалт явуулахад цөөн хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулдаг тул хүн хүч хүрэлцдэггүй, хүний нөөц талаасаа асуудалтай тулгардаг гэх мэтчилэн асуудлуудыг дурдаж байсан.

3/ Сэжигтэй гүйлгээг СМА шалгаж, үнэлэн холбогдох хууль сахиулах байгууллагууд руу явуулахад холбогдох хууль сахиулах байгууллага нь ямар арга хэмжээ авахаа мэддэггүй, энэ талаар бодлого зохицуулалт дутмаг байдаг тул шийдвэрлэж чадалгүй өнгөрөөх гэх мэтчилэн асуудлууд мөн адил арга хэмжээ авах шатанд байдаг байна.

Иймд МУТС үйл ажиллагааг шийдвэрлэх, арга хэмжээ авах үйл ажиллагаа шат шатандаа дутагдалтай байгаа тул институцийн түвшинд мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн комплаенсийн тогтолцоо, мэдлэг болон зохицуулах, шийдвэрлэх байгууллагуудад эргэх холбоо, хамтын ажиллагаа болон бодлогын орчинг сайжруулах, авах арга хэмжээг илүү нарийвчлан тодруулах шаардлагууд гарч байгааг харж болно.

4. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ МУТС ЭРСДЭЛ БОЛОН КОМПЛАЕНСИЙН ТОГТОЛЦОО БҮРДСЭН БАЙДАЛ

Санхүүгийн зах зээлийг нийт хөрөнгийн хэмжээгээр нь салбар салбараар ангилж үзвэл банк 81.31%, Үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагууд 11.88%, ББСБ 5.38%, Даатгалын байгууллага 0.84%-ийг эзэлж байгаа бол ХЗХ 0.58% байна. Харин тоо хэмжээгээрээ Үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагууд болон ҮЦЗЗ-д оролцогч байгууллагууд хамгийн олон байна (Тагнуулын Ерөнхий газар, 2019).

Хүснэгт 8. Санхүүгийн зах зээл

	Нийт хөрөнгийн хэмжээ (2021)	Зах зээлд эзлэх хувь	Нийт оролцогчдын тоо
Банк	40,935	81.31%	11
ҮЦ	5,982.90	11.88%	579
ББСБ	2709.9	5.38%	534
Даатгал	425.4	0.84%	322
ХЗХ	291.2	0.58%	209

Эдгээрээс санхүүгийн зах зээлийн хамгийн эрсдэлтэй салбарыг үнэлбэл, СЗХ-ноос 2019 онд хийсэн салбаруудын эрсдэлийн үнэлгээгээр ББСБ болон ҮХХЗ салбар хамгийн өндөр эрсдэлтэй, ҮЦЗЗ-д оролцогч мэргэжлийн байгууллагуудын эрсдэлийн түвшин дунджаас дээш бол даатгалын байгууллагуудын эрсдэл дунджаас доош, хадгаламж зээлийн хоршоонуудын эрсдэл хэмээн үнэлэгдсэн байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Салбарын МУТС эрсдэл

	Өндөр	Дунджаас дээш	Дунджаас доош	Бага
Банк бус санхүүгийн байгууллага	+			
Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид			+	
ҮЦЗЗ-д оролцогч мэргэжлийн байгууллагууд		+		
Хадгаламж зээлийн хоршоо				+
Үл хөдлөх хөрөнгө зуучлал	+			

4.1. Банк

Монгол улсын нийт активын 98%-ийг бүрдүүлж байгаа 11 арилжааны банкаар дамжин ихэнх бэлэн мөнгө болон гадаад төлбөр тооцооны гүйлгээ явагддаг хамгийн эрсдэлтэй салбар бөгөөд 2019 онд ТЕГ-аас хийсэн эрсдэлийн үнэлгээнд Төрийн банканд нийт 161,469 бэлэн

мөнгөний гүйлгээнээс 58 сэжигтэй гүйлгээ, Голомт банканд 43,148 гүйлгээнээс 27 сэжигтэй гүйлгээ, Хаан банканд 107,936 гүйлгээнээс 19 сэжигтэй гүйлгээ бүртгэгдсэн байна. Харин 11 арилжааны банк тус бүр комплаенсийн хэлтэс нэгжтэй, МУТСТ зүйл заалтыг бодлого, журмууддаа тусгаж хэрэгжүүлдэг, ерөнхий комплаенсийн тогтолцоо бусад санхүүгийн зах зээлийн оролцогчидтой харьцуулахад хамгийн сайн бүрдсэн байна. 2019 оны СМА-ын хяналт шалгалтын дүнгээр Богд банк тайлангийн чанар маш сайн үнэлгээтэй, Худалдаа хөгжлийн банк, Төрийн банк, Чингис хаан банк, ҮХОБ болон Ариг банк нар сайн үнэлгээтэй, Хас банк болон Капитрон банк нар дундаж үнэлгээтэй, Хаан болон Голомт банк нар тайлангийн чанар муу буюу олон алдаа гаргасан, чанарын шаардлага хангаагүй гэх үнэлгээтэй байна. Харин Тээвэр хөгжлийн банк гүйлгээний тайлан ирүүлдэггүй тул үнэлэх боломжгүй гэсэн дүгнэлт авсан байна.

4.2. Банк бус санхүүгийн байгууллага

Хүснэгт 10. ББСБ-н МУТС эрсдэл

	Терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ	Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ
Банкнаас бусад санхүүгийн байгууллага	57.5%	62.5%

Банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд комплаенсийн тогтолцоо хөгжиж эхэлж буй дараагийн салбар билээ. ББСБ-ууд нь санхүүгийн зах зээлд 5.38%-ийг эзэлж байгаа ч хамгийн олон аж ахуйн нэгжийг хамруулж байгаа салбар юм. Дээрх хүснэгтээс харвал ББСБ-ууд терроризмыг санхүүжүүлэх эрсдэл дундаж, харин үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэл өндөр байгааг харж болно. Харин ББСБ-уудын МУТСТ комплаенсийн тогтолцоог судлах явцад Лендмн ББСБ ХК, Нет капитал гэх мэт үйл ажиллагаа тогтворжиж, комплаенсийн тогтолцоо тодорхой хэмжээнд хөгжсөн ББСБ-аас эхлэн хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа МУТСТ-ын талаар ойлголт дутмаг ББСБ-ууд ч байсан тул энэ салбар нь МУТС гэмт хэрэгтэй тэмцэх комплаенсийн хөтөлбөр хэрэгжүүлэх талаар хамгийн том ойлголтын зөрүүтэй салбар юм.

ББСБ-уудад комплаенсийн ажилтан байх ёстой гэсэн ойлголттой, мөн ББСБ-уудын холбооны дэргэд Комплаенсийн хороо үүссэн хэдий ч үйл ажиллагааны чиг үүрэг тодорхойгүй, үүргээ тэр бүр гүйцэтгэдэггүй зэрэг асуудлууд нь түгээмэл байгаа ба цөөн хэдэн ББСБ-ууд нь комплаенсийн тогтолцоо нь тогтвортой байгаагаас харахад ББСБ-ын салбарт комплаенсийн тогтолцоо бүрдэж эхэлж байна гэж дүгнэж болохоор байна.

4.3. Үл хөдлөх хөрөнгө зуучлагч

Хүснэгт 11. ҮХХЗ-н МУТС эрсдэл

	Терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ	Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ
Үл хөдлөх хөрөнгө зуучлагч	60%	62.5%

Үл хөдлөх хөрөнгө зуучлагч байгууллагуудын терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ нь 60% буюу дундаж эрсдэлтэй байна. Монгол улсад сүүлийн жилүүдэд үл хөдлөх хөрөнгө зуучлах бизнес хөгжиж, томоохон үл хөдлөх хөрөнгө зуучлалын компаниуд өндөр дүнтэй гүйлгээ хийдэг, гадаадын иргэн хуулийн этгээдүүд үйлчлүүлдэг гэх мэтээр эрсдэл өндөртэй салбарын нэгт тооцогдож байгаа хэдий ч өндөр дүнтэй гүйлгээ болгон харилцагч нарын бүртгэл мэдээлэл байхгүй, эцсийн өмчлөгчийг таних үйл ажиллагааг хэрэгжүүлдэггүй гэх мэт эрсдэлийг хянах тогтолцоо сул байна.

Судалгааны явцад үл хөдлөх хөрөнгийн зуучлагч байгууллагуудаас реалторууддаа МУТС үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх зорилготой сургалт ордог гэх хариултууд байсан хэдий ч СЗХ-ноос гаргасан 2020 оны Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын эрсдэлийн судалгаагаар ажилтнууд, реалтор, төлөөлөгч нарын ойлголт, мэдлэг, хандлага хангалтгүй, хяналт шалгалтад хамрагддаггүй гэх мэтчилэн комплаенсийн тогтолцоо тэр бүр сайн бүрдээгүй байгааг илэрхийлж байна.

Дээр дурдсан хамгийн өндөр эрсдэлтэй санхүүгийн зах зээлийн салбарууд болон бусад салбаруудыг МУТС эрсдэлийг комплаенсийн тогтолцоо хөгжсөн байдалтай нь харьцуулж үзвэл эерэг хамааралтай байна. Эндээс дүгнэвэл хамгийн эрсдэл өндөртэй буюу банк, банк бус санхүүгийн байгууллагууд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, МУТСТ тулд комплаенсийн тогтолцоог хамгийн сайн бэхжүүлж байгаа, бэхжүүлэх үе шатандаа явж байна. Харин үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд эрсдэл өндөр хэдий ч одоогоор комплаенсийн тогтолцоо бусад салбартайгаа харьцуулбал тэр бүр сайн хөгжөөгүй байна гэж харагдаж байна.

5. ЭМПИРИК СУДАЛГАА

Энэхүү судалгаагаар банк, санхүүгийн болон бусад мэргэжлийн оролцогчдын комплаенсийн өнөөгийн үйл ажиллагааг үнэлэх зорилготойгоор (1) анкетын арга, (2) ганцаарчилсан ярилцлагын арга, (3) кейс харьцуулах арга болон (4) хоёрдогч эх үүсвэрийг судлах судалгааны аргуудыг ашиглан нөхцөл байдлыг судалж дүгнэлээ.

5.1. Анкетын судалгааны үр дүн

Банк санхүүгийн байгууллагууд болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн нэгдсэн холбоодоос түүвэрлэн авч нийт 44 байгууллагаас утсаар холбогдон комплаенс хариуцсан ажилтантай холбогдохыг хүсэхэд 9 байгууллага ажилтангүй, 21 байгууллага эргүүлэн холбогдоно, одоогоор эзгүй, утсаа аваагүй, үлдсэн 14 байгууллагын холбогдох ажилчидтай холбогдон тандалтын судалгааг хийсэн. Тус салбарт үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж буй 12 байгууллагын комплаенс хариуцсан ажилтнуудаас тандалтын судалгаа авсан. Ингэхдээ Google Form ашиглан судалгааг авч Excel болон SPSS програмуудыг ашиглан судалгааны үр дүнг нэгтгэлээ.

Нийт судалгаанд оролцогчдын 33% нь ББСБ, 25% СББМҮҮ, 17% Банк, үлдсэн хувийг үнэт цаас болон даатгалын салбарынх эзэлж байгаа бөгөөд үүнээс 83.3% нь эмэгтэй, 16.7% нь эрэгтэй хүмүүс судалгаанд хамрагдлаа. Байгууллагын 58.3% нь 50 хүртэлх ажилтантай бол хамгийн бага буюу 8.3%-ийг 1000-с их ажилтантай ба дийлэнх хувийг нягтлан бодогч, санхүүгийн шинжээч мэргэжилтнүүд, ердөө 9.1% комплаенсийн мэргэшсэн хүмүүсээс бүрдэж байна.

Байгууллагуудын 58.3% нь комплаенс хэлтэс/ажилтантай бөгөөд 36.4% нь хариуцсан ажилтангүй, үлдсэн 9.1% нь мэдэхгүй хэмээн хариулсан. Доорх хүснэгтээс нийт 12 оролцогчдыг салбар бүрийг комплаенс ажилтантай эсэхийг задалж харвал 4 ББСБ-аас 3 нь комплаенс хэлтэс/ажилтантай ба СББМҮҮ-ээс 67% нь хариуцсан ажилтангүй, Даатгалын 2 компаниас 1 нь хэлтэс ажилтантай, Үнэт цаасны компани хэлтэсгүй хэмээн хариулсан байна.


Хүснэгт 12. Судалгааны үр дүн

		Танай байгууллага комплаенсийн хэлтэс/ажилтантай юу?			Бүгд
		Тийм	Үгүй	Мэдэхгүй	
Танай байгууллага ямар чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг вэ?	Банк	2	0	0	2
	Банк бус санхүүгийн байгууллага	3	0	1	4
	Үнэт цаас	0	1	0	1
	Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч	1	2	0	3
	Даатгал	1	1	0	2
Бүгд		7	4	1	12

Комплаенсийн ажилтнуудын 50% нь давхар албан тушаал хашдаг ба тус байгууллага нь 50-аас доош ажилчидтай байгаа юм. Комплаенстай холбоотой мэдээллийг толгой компани болон зохицуулагч байгууллагуудаас мэдээллээ авдаг ба сургалтад хамрагдалт харьцангуй тогтворгүй болох нь харагдсан. Комплаенстай холбоотой эрсдэл болон үнэлгээний хэрэгжилтийг тодруулахад гүйцэтгэх удирдлага болон дээд албан тушаалтанд үүсэх эрсдэлийг мэдээлж, үйл ажиллагааг тайлагнадаг ба байгууллагын дотоод дүрэм журамд комплаенсийн бодлого 75%-д нь, МУТСТ зүйл заалт 91.7%-д нь тусгагдсан боловч комплаенсийн хэрэгжилтийг 50% нь л үнэлдэг байна.

Зураг 1. Судалгааны үр дүн

Танай комплаенсийн хэлтэс/ажилтан өөр албан тушаалыг давхар гүйцэтгэдэг үү?



■ Тийм ■ Үгүй ■ Мэдэхгүй

Танай байгууллага комплаенсийн хэрэгжилтийг үнэлдэг үү?




Байгууллагуудад одоогоор комплаенстай холбоотой зөрчил илрээгүй ба харилцагч, ажилчдадаа комплаенсийн талаарх мэдээллийг 59% нь хүргэдэг, үйл ажиллагаанд зарцуулагдаж буй санхүүжилт нь 66%-д нь хангалттай хэмээн хариулсан (Зураг 1).

5.2. Ганцаарчилсан ярилцлагын үр дүн

Нийт судалгаанд оролцогчдын хувьд банк, ББСБ болон комплаенсийн холбооны 3-8 жилийн туршлагатай 13 мэргэжилтнүүд уг судалгаанд хамрагдсан. Салбар бүрд харилцан адилгүй комплаенсийн тогтолцоо хөгжиж байгаа бөгөөд банкны хувьд харьцангуй цогц байдаг бол бусад санхүүгийн салбарууд саяхнаас анхаарал хандуулж эхэлж буйг онцолсон байна.

Хүснэгт 13. Судалгааны үр дүн



Нийтлэг ажиглагдсан асуудал нь комплаенсийн мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадвар ба харилцагчдын ойлголтгүй байдал, дотоодын сургалтын хүртээмж, агуулгын хүрээнд хангалтгүй хэмээн шүүмжлэлтэй ханддаг байна. Олон улсын хэмжээний сургалтад хамрагдах боломж байдаг ч гадаад хэлний мэдлэг дутмаг байдал, мөн байгууллагууд комплаенсийн мэдээллийн үр ашиг, ач холбогдлыг ойлгохгүйгээс үүдэн санхүүжилт хангалттай олгохгүй байх, хөдөө орон нутаг, газарзүйн байршлаас үүдэн мэдээллээс алслагдах зэрэг асуудлуудыг хөндлөө. Мэргэжилтнүүд зохицуулагч байгууллагаас тавьж шаардлага нь хэт ерөнхий, байгууллагын үйл ажиллагааны түвшинд хангалттай хүрдэггүй, хяналт шалгалт дутмаг байдаг. Жишээ дурдвал СЗХ-оос огт хяналт, шалгалт ирдэггүй, сэжигтэй гүйлгээг өөрийн Шанхай дахь толгой компанид мэдээлдгээс өөр газраас ямар нэг хяналт тавьдаггүй байна.. Түүнчлэн ББСБ-уудын комплаенсийн ажилчид нь комплаенсийн ажилтан байх ёстой гэсэн шаардлагаар өөр албан тушаалтай нэгнийг давхар томилдгоос ямар нэг шалгуураар эсвэл комплаенсийн талаар сургалтад сууж, сертификат авсны дараа комплаенсийн ажилтны үүргийг даалгадаггүй талаар ярьсан бөгөөд байгууллагуудад “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, дүрэм, журам” болон комплаенс хариуцсан мэргэжилтэнг бүгд томилдог хэдий ч энэ нь мөнгө угаах гэмт хэргээс бүрэн дүүрэн урьдчилан сэргийлж чадахгүй, нэр төдий байгаа нь зохицуулагч байгууллагын шаардлага асуудалтай байгааг илтгэж байна. Судалгаагаар комплаенсийн мэдээллээр хангах, мэргэжилтнүүдийг бэлтгэх, чадавхжуулах, бичиг баримт, бодлогын түвшинг сайжруулах шаардлагатай ба сургалтын чанарыг сайжруулах, салбарын хяналтыг бүх түвшинд сайжруулах хэрэгтэй байна.

5.3. Кейс харьцуулсан судалгааны үр дүн

Хүснэгт 14. Судалгааны үр дүн

№	ДУГААР	ХЭРГИЙН ТОВЧ	ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭСЭН
1	128/ШШ202 1/0073	ТХБ ХХК нь МҮЭ бөгөөд Монголбанканд заасан хугацаанд мэдээллийг хүргүүлдэг байсан ч гүйлгээ дутуу ирүүлсэн гэх шалтгаанаар 10.000 нэгж буюу 10.000.000 төгрөгөөр торгох шийтгэлийн хуудасхүлээн авсан. Харин ТХБ ХХК нь Монголбанкнаас тайлан хүлээн авсан талаар, дутуу байгаа талаар өмнө нь огт мэдээлж, сануулга өгч байгаагүй, ямар ч эргэх холбоо байдаггүй байсан тул гүйлгээг дутуу ирүүлснээ мэдээгүй гэх шалтгаанаар шийтгэлийг хүчингүй болгох гомдол гаргасан.	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 7 дугаар зүйлийн 7.1, Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйлийн 21 дэххэсэгт заасныг тус тус баримтлан нэхэмжлэгчийн гомдлыг хэрэгсэхгүй болгосон.
2	2021/ДШМ/ 548	Бусдын эд хөрөнгийг авахаар хүч хэрэглэн довтолж дээрэмдсэн гэмт хэргийн улмаас олж авсан хууль бус эх үүсвэртэй 7.800 ам.долларыг гэмт хэрэг үйлдэж олсон мөнгө гэдгийг мэдсээр байж эзэмшсэн, ашигласан, хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах зорилгоор арилжаанд оруулж буюу төгрөгт солиуланөөрчилж, бусдаас авсан өр, зээлээ барагдуулж мөнгө угаасан.	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 6 сарын хугацаагаар хорих ялаар шийтгэсэн.
3	2019/ШЦТ/9 18	Холбооны Бүгд Найрамдах Нигер улсын иргэн шүүгдэгч нь Монгол Улсын иргэн Б.Х, Д.Г, Т.А нартай бүлэглэн гадаадын аж ахуйн нэгж, байгууллагуудтай ижил нэртэй аж ахуйн нэгж, байгууллагуудыг Монгол Улсад үүсгэн байгуулж, улмаар гадаадын аж ахуй нэгжийг цахим хэрэгсэл ашиглаж залилах замаар гэмт хэрэг байнга үйлдэж, Голомт банкны төгрөгийн дансаар өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авч залилан, бусдад нийт 2.125.339.102.74 төгрөгийн хохирол учруулсан.	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Холбооны Бүгд Найрамдах Нигер улсын иргэн 3 жил, шүүгдэгч Б.Хд 3 жил, шүүгдэгч Д.Год 2 жилийн хугацаагаар хорих ял, шүүгдэгч Т.Ат 1 жилийн хугацаагаар хорих ял тус тус оногдуулсан.

Дээрх 3 кейсийг харьцуулахад салбарын байгууллагууд болон зохицуулагч байгууллагуудын хамтын ажиллагаа, хүргүүлж шаардлагууд нь байгууллагын үйл ажиллагааны түвшинд хүрдэггүй ба журамд заасан хяналт шалгалт нь бодит байдал дээр биеллээ олоогүйн улмаас комплаенс хөгжөөгүй байгууллагуудад хууль бус мөнгө гүйлгээнд орох, сэжигтэй гүйлгээг хянан шалгалтгүй мөнгө угаах гэмт хэрэгт оролцсон нь энэхүү судалгаагаар харагдаж байна.

Эмпирик судалгааны үр дүнд байгууллагын ажилтан нь комплаенсийн талаарх мэргэшсэн албан тушаалтан цөөн, өөр албан тушаалыг зэрэг хашдаг. Байгууллагуудаас ажилчид болон харилцагчдаа, комплаенсийн үйл ажиллагаанд олгож буй санхүүжилт хангалттай гэж үздэг ч сургалтад хамрагдалтыг асуухад хангалттай бус хэмээн судалгаанд

харагдсан. Үүний шалтгаан нь дотоодод явагддаг сургалтууд агуулгын хүрээнд хангалтгүй үнэлгээтэй мөн ажилчдын хэлний мэдлэгийн асуудлаас болж гадны сургалтуудад хамрагддаггүй байна. Дотоод дүрэм журамд МУТСТ зүйл заалт болон комплаенсийн бодлого тусгагдсан хэдий ч комплаенс хэрэгжилт үнэлэлт дээр тодорхой буй нөхцөл байдалтай байдаг нь шүүхийн шийдвэрээр нотлогдсон кейсүүдийг харьцуулахад ажилтны ур чадвар дутмаг, байгууллагын хяналт муу, зохицуулагч байгууллагын хамтын ажиллагаанд асуудал тулгарч буйг чанарын болон тоон судалгаагаар баталлаа.

6. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

- Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хувьд мэдээ мэдээлэл харьцангуй дутмаг, байгууллагад комплаенсийн тогтолцоо бэхжээгүй учраас МУТСТ-тэй тэмцэх үйл ажиллагааны үр ашгийг ойлгоогүй, сэжигтэй гүйлгээг мэдээлсэн тохиолдолд өөрсдөө торгуулах эсвэл нэр хүнд унах зэрэг сөрөг үр дагавар гарч болзошгүй гэх мэт шалтгаануудаар МУТСТ үйл ажиллагааг тэр бүр ойшоодоггүй байна. Үүнд одоо санал болгож буй сургалтуудыг илүү хүртээмжтэй, үр дүнтэй болгох, комплаенсийн ажилтны үүрэг гүйцэтгэж буй ажилтанд заавал хамрагдах шаардлагыг тавих, хянаж шалгах шаардлагатай.
- Салбарын түвшинд комплаенсийн тогтолцоо бүрэлдэж, хөгжихөд хамтын ажиллагаа, мэдээлэл туршлага солилцох үйл явц чухал ач холбогдолтой бөгөөд СЗХ-ны зохицуулалттай байгууллагуудын дэргэд салбар, мэргэжилтнүүдийн холбоо, тэдгээрийн дэргэд Комплаенсийн зөвлөл, хороонууд үүсч эхэлж байгаа нь зохицуулагч байгууллагуудын үйл ажиллагааг илүү хүртээмжтэй болгох, комплаенсийн холбоог салбарын түвшинд хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.
- Комплаенсийг байгууллагын засаглалын түвшинд бүрэн бүтэн нэвтрүүлэхийн тулд GRC тогтолцоо буюу засаглал (Governance), эрсдэлийн удирдлага (Risk management) болон комплаенс (Compliance) гурвын цогц тогтолцоог хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй. Ингэснээр байгууллагын бүтэц, дотоод хяналт нягт уялдан ажиллаж, нэг бүтэц байдлаар хөгжиж, МУТС- аас илүү цогц байдлаар урьдчилан сэргийлэх, тэмцэх боломжтой юм.
- Хууль сахиулах байгууллагууд СМА-аас шалгагдаж ирсэн сэжигтэй гүйлгээнүүдэд ямар арга хэмжээ авахаа мэддэггүй, энэ талаар бодлого зохицуулалт дутмаг байдгаас шийдвэрлэж чадалгүй өнгөрөөх, ял шийтгэл оноохгүй өнгөрөх гэх мэтчилэн асуудлууд гардаг нь цаашдаа бодлого, зохицуулалтын хүрээнд илүү нарийвчлан зааж өгөх, МУТС-тай тэмцэхэд комплаенсийн үүрэг ролийг илүү дэлгэрэнгүй хуульчлах гэх мэтчилэн бодлогын хүрээний сайжруулалт зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.
- МУТС-тай тэмцэх, урьдчилан сэргийлэхийн тулд эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг удирдах үр дүнтэй арга хэмжээ, арга зүй чухал байна. Одоогоор хамгийн эрсдэл өндөртэй буюу банк, банк бус санхүүгийн байгууллагууд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, МУТС-ийн эсрэг комплаенсийн тогтолцоог хамгийн сайн бэхжүүлж байгаа, бэхжүүлэх үе шатандаа явж байгаа хэдий ч бусад салбаруудын хувьд хараахан сайн хөгжөөгүй, эрсдэлээс сэргийлэх, комплаенсийн үйл ажиллагааг явуулах бодлого, тогтолцоо бүрдэх шаардлагатай байна.
- Асуулгын хамрагдалтын байдал болон ганцаарчилсан ярилцлагын хүрээнд авсан мэдээллээс харвал МУТСТ стандарт, бодлого журам байгууллагын түвшинд байдаг хэдий ч тэр нь газар дээр бууж хэрэгжих, стандартын дагуу үйл ажиллагаа явуулах тал

дээр саармаг байгаа нь харагдаж байна. Тиймээс стандартыг ясчлан мөрдөх, түүнд зохицуулах байгууллагаас тогтмол хяналт шалгалт хийж, зөвлөмж чиглүүлгээр хангаж байх нь чухал ач холбогдолтой юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Australian Government AUSTRAC. (2022). <https://www.austrac.gov.au/>-ээс Гаргасан
- Cov, Congress. (2022). <https://www.congress.gov/107/plaws/publ56/PLAW-107publ56.pdf>-ээс Гаргасан
- Financial Conduct Authority. (2022). <https://www.fca.org.uk/>-ээс Гаргасан
- IKON.MN. (2016). "Комплаенс Форум 2016". <https://ikon.mn/n/va5>-ээс Гаргасан
- ММСГ. (2019). Санхүүгийн зохицуулах хорооны хяналт тавих мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын эрсдэлийн үнэлгээ. Улаанбаатар.
- Zbysław Dobrowolski, Ł. S. (2019). Implementing a Sustainable Model for Anti-Money Laundering in the United Nations Development Goals.
- Ж.Оймандах. (2016). Комплаенсийн талаарх цуврал лекц 3. <https://www.linkedin.com/>-ээс Гаргасан
- Ж.Оймандах. (2017). "Комплаенс систем ба удирдах арга барилыг шинэ түвшинд гаргах нь" Эрдэм шинжилгээний өгүүлэл. 2.
- Ж.Оймандах. (2017). Комплаенс систем. <https://www.linkedin.com/>-ээс Гаргасан
- Монголбанк. (2021). <https://www.mongolbank.mn/>-ээс Гаргасан
- Монголбанк. (2016). Монгол улсын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ. https://www.mongolbank.mn/documents/cma/20161025_risk_assessment.pdf-ээс Гаргасан
- Монголбанк. (2016). Үндэсний эрсдэлийн үнэлгээ. Улаанбаатар.
- Монголбанк. (2018). Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан зарчмыг хэрэгжүүлэх журам. https://www.mongolbank.mn/documents/regulation/control_check/20180206_A32.pdf-ээс Гаргасан
- Монголбанк. (2019). Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт. <https://www.mongolbank.mn/documents/cma/20180531F2.pdf>-ээс Гаргасан
- Монголбанк. (2021). Мөнгө санхүүгийн статистик. Улаанбаатар: Монголбанк.
- Монголбанк. (2021). Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг. <https://www.mongolbank.mn/documents/cma/news/202104.pdf>-ээс Гаргасан
- Монголбанк. (2022). Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн МУТС эрсдэлийг үнэлэх асуулга. <https://fiu.mongolbank.mn/regulation.aspx?id=02#guide>-ээс Гаргасан

Санхүүгийн боловсролын Хаб. (2022). "Комплаенсийн эрсдэлийг удирдахуй" панел хэлэлцүүлэг. Улаанбаатар. <https://www.facebook.com/FEDHUB/videos/629873518197455/>-ээс Гаргасан

Санхүүгийн Зохицуулах Хороо. (2019). Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын комплаенсийн ажилтнуудад зориулсан гарын авлага.

Санхүүгийн Зохицуулах Хороо. (2019). Санхүүгийн салбарын комплаенс хэлэлцүүлэг 2019. <http://www.frc.mn/a/2951>-ээс Гаргасан

Санхүүгийн Зохицуулах Хороо. (2021). Санхүүгийн салбарын тойм 2021. <http://www.frc.mn/resource/frc/uploads/file/307f61e99d7b698f98295b58943c45e764ac0380.pdf>-ээс Гаргасан

Санхүүгийн Зохицуулах Хороо. (2021). Сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэх гарын авлага. <http://www.frc.mn/resource/frc/Document/2021/05/27/>-ээс Гаргасан

Санхүүгийн Зохицуулах Хороо. (2022). Хяналт шалгалтын бодлогын баримт бичиг. <http://www.frc.mn/resource/frc/Document/2022/01/11/>-ээс Гаргасан

Тагнуулын Ерөнхий газар. (2019). Монгол улсын терроризмыг санхүүжүүлэх үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ. <https://gia.gov.mn/5/item/548>-ээс Гаргасан

ХАВСРАЛТ*i. Комплаенс болон МУТСТ талаар мэргэжлүүлэх сургалт, зохион байгуулагдсан*

Он	Зохион байгуулагч	Хурлын нэр	Оролцогчид	Хэлэлцсэн асуудал
2016	Банк Санхүүгийн Академи	“Комплаенс ба ёс зүй” Онлайн сургалт	Салбарын оролцогчид	Комплаенсийн сургалтыг банк санхүүгийн байгууллагын нийт ажилтнуудын ажлын онцлогт нийцүүлэн, хүртээмжийг нь анхааран онлайн хэлбэрээр сургалт орсон.
2016.11.07	ХААН Банк, Монголын Банкны Холбоо болон Монголбанк	“Комплаенс Форум2016	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, нийт арилжааны банкууд, олон улсын байгууллагууд болон аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл болох 100 гаруй зочид оролцсон	Монгол Улсын арилжааны банкуудын комплаенсийн үйл ажиллагаа, түүний хөгжил ямар түвшинд байгааг ярилцан, гарч буй асуудлуудыг тодорхойлж, Монголын Банкны Холбооны дэргэдэх Комплаенсийн мэргэжлийн зөвлөл 2017 онд хэрхэн хамтарч ажиллах ажлын төлөвлөгөөг хэлэлцсэн.
2017.11.08	Төрийн банк, Монголын банкны холбоо хамтран	Комплаенс Форум-2017	Олон улсын болон дотоодын банк, санхүү, цагдаагийн байгууллагын төлөөллийг оролцуулсан нь өмнөх жилүүдийг бодвол илүү цар хүрээгээ нэмсэн.	Комплаенсийг хэрэгжилт, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал, олон улсын сайн туршлагаас танилцуулсан.
2018	Санхүүгийн зохицуулах хороо	Санхүүгийн салбар дахь комплаенсийн форум-2018”	Даатгалын, банк бус санхүүгийн, хадгаламж, зээлийн хоршооны, үнэт цаасны болон үл хөдлөх хөрөнгө зуучлалын зах зээлийн мэргэжлийн холбоод оролцсон	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, сэргийлэх арга техникүүд болоод комплаенсийн үйл ажиллагааг нэвтрүүлэх ажлуудын санхүүгийн салбарт төдийгүй макро эдийн засгийн түвшин дэх ач холбогдлын талаар хэлэлцсэн.
2019	Санхүүгийн зохицуулах хороо	Санхүүгийн салбарын комплаенс хэлэлцүүлэг-2019”	“Бизнесийн ёс зүй ба комплаенс”, “Комплаенс ба мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг” хоёр хэсэгтэй	Санхүүгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, Олон улсын санхүүгийн хориг хэрэгжүүлэх байгууллага (FATF)-ын Ази номхон далайн бүс нутаг хариуцсан бүлгээс (APG) өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын явц илтгэлүүд хэлэлцүүлсэн.

2019.06.06-16	Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо	“Комплаенс ба ёс зүй” онлайн сургалт	Салбарын оролцогчид	Сертификатжуулах цахим сургалт зохион байгуулсан.
2019.11.07	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим	Комплаенсийн Үндэсний Зөвлөл байгуулагдсан	АТГ, Монголын Комплаенсийн Холбоо, Монголын Олон Улсын Арбитр, Азийн Сан болон мэргэжлийн холбоодын төлөөллүүдийг багтаасан	Авлигатай тэмцэх, шүгэл үлээгчийг хамгаалах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог дэмжиж ажиллах бөгөөд цаашид бизнесийн байгууллагын дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, мэргэшлийн холбоодын үйл ажиллагааг шинэ түвшинд аваачих зорилт тавин ажиллаж эхэлсэн.
2020.6.30	Санхүүгийн зохицуулах хороо	МУТСТ хэлэлцүүлэг	Зохицуулалттай 6 салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн болон мэргэжлийн 12 холбоодын төлөөлөл зэрэг 121 хүн оролцсон.	ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтад бэлтгэхтэй холбоотой мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд Хорооноос авч хэрэгжүүлсэн ажлыг тайлагнаж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр зохицуулалттай салбаруудад тулгамдаж буй асуудлуудын талаар хэлэлцэн, комплаенсийн ажилтнуудын анхаарах асуудлуудыг хөндсөн.
2020.11.05	Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо	Комплаенс ба “Ёс зүй” онлайн сургалт	Банк санхүүгийн байгууллагын нийт ажилтнууд	Банк санхүүгийн байгууллагад Комплаенсийн тухай ойлголтыг өгөх, комплаенсийн зорилго, бодлого, чиг үүргийг таниулах, тэдгээрийн хэрэгжилтийг хангахад туслах, ажилтнуудад ажлын байрандаа ёс зүйн хэмжээг дагаж мөрдөх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, хувь хүний мэдээллийг ямагт хамгаалах, мэргэжлийн стандартыг баримтлах ухамсрыг төлөвшүүлэх сургалт.
2021.11.30	Комплаенсийн үндэсний зөвлөл болон Бизнесийн ёс зүйн зөвлөл	Комплаенс, бизнесийн ёс зүйн анхдугаар чуулган	Нийт 200 орчим бизнесийн байгууллагын төлөөллүүд	Бизнес эрхлэгчид хууль, дүрэм журмаа мөрдөж ажиллахад учирч буй саад бэрхшээлийг тодорхойлж, сайн засаглал, бизнесийн ёс зүй, комплаенсийг нэвтрүүлж, хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай арга хэмжээнүүдийн талаар тус чуулганаар хэлэлцсэн.

ii. Анкетийн судалгааны асуултууд

1. Танай байгууллага комплаенсийн хэлтэс/ажилтантай юу?
2. Танай комплаенсийн хэлтэс/ажилтан өөр албан тушаалыг давхар гүйцэтгэдэг үү?
3. Танай байгууллагын комплаенсийн үүрэг гүйцэтгэдэг ажилтан ямар мэргэжилтэй вэ?
4. Комплаенсийн ямар сургалт, хөтөлбөрт хамрагдаж байсан бэ? Гэрчилгээ, сертификат авч байсан уу?
5. Гадаад болон дотоодын комплаенсийн сургалтанд хэр давтамжтай суудаг вэ? Мэдээллээ хаанаас авдаг вэ?
6. Танай байгууллагад Комплаенсийн бодлого, дүрэм журам байдаг уу?
7. Олон улсын байгууллагуудаас гаргасан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бичиг баримт, зөвлөмжүүд /ФАТФ-ын 40 зөвлөмж, НҮБ-ын аюулгүйн зөвлөл/ танай байгууллагын үйл ажиллагаатай нийцдэг үү? Танай байгууллагын дотоод дүрэм, бодлогод МУТСТ зүйл заалт бий юу?
8. Комплаенсийн асуудал, эрсдэл үүсэхэд хэнд мэдэгдэж, үйл ажиллагаагаа тайлагнадаг вэ? Танай байгууллага комплаенсийн хэрэгжилтийг үнэлдэг үү?
9. Танай байгууллагад комплаенсийг зөрчсөн асуудал хэр их гардаг, түүнийг шийдвэрлэхэд хэр их хугацаа шаарддаг вэ?
10. Танай байгууллага ажилчид болон харилцагчиддаа Комплаенсийн талаар мэдээлэл өгдөг үү?
11. Байгууллагаас комплаенсийн үйл ажиллагаанд олгож буй санхүүжилт хангалттай байдаг уу?
12. Таны хүйс
13. Таны албан тушаал
14. Тантай холбоо барих утас
15. И-мейл хаяг
16. Танай байгууллага ямар чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг вэ?
17. Танай байгууллага хэдэн ажилтантай вэ?

iii. Ганцаарчилсан ярилцлага авсан комплаенсийн ажилчдын жагсаалт

№	БАЙГУУЛЛАГА	НЭР	
1	Монголын комплаенсийн холбооны гүйцэтгэх захирал	З.Эрдэм	КП
2	Юнион пей ББСБ	Энхжаргал	КП
3	Сендли ББСБ	Нямжаргал	КП
4	ХААНБанк	П.Орхон	КП
5	Монголын Комплаенсийн Холбоо	Х.Гэрэлчулуун	КП
6	Төрийн банк	Оюунаа	КП
7	ХААН Банк	Б.Төрбат	КП
8	Капитрон банк	Б.Булган	КП
9	Тээвэр хөгжлийн банк	Шинэцэцэг	КП



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА
МОНГОЛБАНК

**МОНГОЛ УЛСЫН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ: АЛТНЫ БИЧИЛ
УУРХАЙН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ БА
ТАТВАРЫН АСУУДЛУУД**

Б.Амарбаясгалан³, С.Будсүрэн⁴, Д.Долгорсүрэн⁵

³ Монгол улсын их сургууль, Эдийн засгийн тэнхим, IV курсын оюутан. Цахим хаяг: 18b1num1709@stud.num.edu.mn

⁴ Монгол улсын их сургууль, Эдийн засгийн тэнхим, IV курсын оюутан. Цахим хаяг: 18b1num0213@stud.num.edu.mn

⁵ Монгол улсын их сургууль, Эдийн засгийн тэнхим, IV курсын оюутан. Цахим хаяг: 18b1num2003@stud.num.edu.mn

ТОВЧ ХУРААНГУЙ

Дэлхий дахинд Мөнгө Угаах Терроризмыг Санхүүжүүлэх (МУТС) гэмт хэрэгт алтны зах зээлийн эрсдэл өндөр байх хандлагатай байна. Энэхүү судалгаанд 2016 оны бичил уурхай эрхлэгчдийн судалгааны анхан шатны мэдээллийг ашиглан (i) Монгол Улсын алтны бичил уурхай эрхлэгчдийн татвар төлөлтийн орчин, (ii) нэмэгдэл өртгийн байдал нь макро эдийн засагт хэрхэн нөлөөлдөг, (iii) олборлосон алтыг борлуулах үйл явц нь алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээний сувгаар хэрхэн явагддаг, энэ нь МУТСТ тогтолцоонд хэрхэн нөлөөлдөг талаар судалгаа, шинжилгээ хийсэн. Алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээний хүрээнд эмпирик судалгаа, шинжилгээ болон тоон мэдээлэл хязгаарлагдмал тул дескриптив шинжилгээнд үндэслэн логик учир шалтгааныг тайлбарлан харуулахыг зорив.

ТҮЛХҮҮР ҮГ

Алтны бичил уурхай, нийлүүлэлтийн сүлжээ, татвар, нэмэгдэл өртөг, үр дүнгийн хэрэгжилт

1. ОРШИЛ

Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх⁶ (МУТСТ) нь дэлхий нийтийн анхаарлыг татсаар ирсэн цогц асуудал юм. Монгол Улс 2004 онд МУТСТ үйл ажиллагааг зохицуулах байгууллага болох ФАТФ-ийн Ази, Номхон далайн бүсийн байгууллага (APG)- д гишүүнээр элссэнээр МУТСТ тогтолцооны анхны үнэлгээг 2007 онд зохион байгуулсан. Харилцан үнэлгээний тайланд ФАТФ-ийн 40+9 шалгуураас 21-г биелүүлээгүй, 15-г хэсэгчлэн биелүүлсэн гэсэн маш муу үнэлгээ авч, 2013 онд Монгол Улс ФАТФ-ийн “саарал жагсаалт”-д орсны дараагаар, МУТСТ тогтолцоог 2016-2017 онд дахин үнэлүүлсэн бөгөөд дахин үнэлгээний тайланд эрчимтэй хяналтад оруулах шийдвэр гаргаснаар 2019 онд дахин саарал жагсаалтад орсон. Саарал жагсаалтад ороход Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулан холбогдох журам, зааврыг богино хугацаанд батлуулсны үр дүнд 2014 болон 2020 онд саарал жагсаалтаас хасагдсан билээ.

Монгол Улсын хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийн мөнгөн эргэлт нь судлаачдын тооцсон сүүдрийн эдийн засгийн хэмжээнд багтаж байна. Сүүдрийн эдийн засгийн хэмжээ өндөр байх тусам гэмт хэргийн мөнгөний хэмжээ өсөх эрсдэлтэй. Сүүдрийн эдийн засаг нь Монгол Улсад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл учруулах үндсэн хэсгийн нэг юм (Монгол улсын МУТС үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлан, 2016). Далд эдийн засаг гэсэн ойлголтын хүрээнд албан бус секторын үйл ажиллагаа, нуугдмал үйлдвэрлэл, хууль бус үйлдвэрлэл, өөртөө зориулсан өрхийн хэрэглээний үйлдвэрлэл болон мэдээллийг бүрэн цуглуулаагүй зэргээс албан ёсны мэдээлэлд орохгүй байгаа хэсгийг хамруулж авч үздэг (Үндэсний статистикийн хороо, 2020).

Сүүлийн үед дэлхийн эдийн засагт гарсан өөрчлөлтүүдээс шалтгаалан түүхий эдийн эрэлт, түүний тогтвортой хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр улс орнуудын хянан шалгах, хууль сахиулах эрх бүхий байгууллагууд албан ёсны санхүүгийн салбар болон бэлэн мөнгөний зах зээлийг илүү чангатгаснаар МУТС үйл ажиллагаа эдгээр салбараас шахагдаж далд хэлбэрийн алтны зах зээл рүү шилжих байдал ихсэж байгаад ФАТФ болон олон улсын байгууллагууд анхаарал хандуулан судалж байна. Монгол Улсын хувьд далд эдийн засгийн дийлэнх хувийг нуугдмал үйлдвэрлэл, бичил уурхай бүрдүүлдэг нь алтны зах зээлийн бичил уурхай эрхлэгчид, нуугдмал үйлдвэрлэлийг дэлгэрүүлэн судлах судалгааны эрэлтийг үүсгэж байна. Алтны бичил уурхай эрхлэгчид хууль бусаар мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээний хүрээнд авч үздэг. Иймд алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээ ба тэдний татварын асуудлуудыг авч үзье.

⁶ ФАТФ-аас олон улсын стандартад нийцсэн МУТСТ 40 зөвлөмжийг боловсруулан гаргасан.

2. СУДЛАГДСАН БАЙДАЛ

МУТС үйл ажиллагаа нь алтны зах зээл рүү шилжих байдал ихэсч байгаатай холбоотойгоор ФАТФ болон ФАТФ-ийн төрлийн бүсийн байгууллагуудаас гишүүн орнуудыг тайлан, зөвлөмжөөр ханган ажилласаар байна. Мөн олон улсын түвшинд алтны зах зээлийн мөнгө угаахтай холбоотой судалгааг тоймлон авч үзье.

Хүснэгт 1. Судлагдсан байдлын тойм

Хүрээ	Судлаачийн байгууллага/ нэр	Судалгаа, тайлангийн нэр	Он	Арга зүй	Үр дүн
Олон улсад судлагдсан байдал	ФАТФ	Алтны салбар дахь МУТС эрсдэл, эмзэг байдал	2015	Кейс судалгаа	Олон улсад алтны салбарт үйлдэгдсэн хэргийн кейс-д үндэслэн мөнгө угаалтын хэлбэр, хууль бус хил давуулалт зэрэгт дүн шинжилгээ хийсэн.
	Abebe Senbete	Factor affecting artisanal and smallscale gold supply	2018	Олон хүчин зүйлийн регресс	Этиоп улсын алтны бичил уурхай эрхлэгчдийн нийлүүлэлтэнд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ, хамаарлыг корреляцын матрицаар харуулсан. Судалгаагаар нийт нийлүүлэлтэд тухайн орон нутгийн алтны үнэ , дэлхийн зах зээлийн алтны үнэ , алт тушаах босго хэмжээ , гар аргаар алт олборлох урамшуулал , алтны хууль бусаар нэвтрүүлэх зэрэг хүчин зүйлсийн нөлөөллийг тооцоолсон ирсэн болно.
Монгол улсад судлагдсан байдал	Санхүүгийн зохицуулах хороо	Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх салбарын эрсдэлийн үнэлгээ	2019	Салбарын эрсдэлийн түвшин тооцох	Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн салбар нь МУТСТ-д дунджаас дээш гэсэн эрсдэлийн үнэлгээтэй байна. Тэр дундаа дундын худалдан авагчид 14.7%, хоёрдогч зах зээл дээр тоглогчид 13.4%, олборлогчид 11.3%-н эрсдэлийн түвшинтэй байсан бол жижиглэн худалдаачид, үнэт эдлэл үйлдвэрлэгчид, боловсруулах үйлчилгээ үзүүлэгчид эрсдэлийн түвшин багатай гэж үнэлэгдсэн байна.
	Planet Gold Mongolia	Монгол улсын бичил уурхай дахь алтны худалдаа	2022	Бодлогын тайлан	Монгол Улс нь одоогоор алтны гарал үүслийг мөшгөх тогтолцоо болон магадлан шинжилгээний олон улсад мөрдөгдөж буй стандарт, хууль дүрэм журамтай бүрэн нийцэж ажиллахгүй байна Алтны гарал үүслийг мөшгөх тогтолцоог дагаж мөрдөхийн тулд алтны сүлжээнд оролцогчдыг албажуулах хэрэгтэй.

Монголын экспортлогчдын холбоо	Бичил уурхайгаар олборлосон алтны нийлүүлэлтийн сүлжээ, түүний макро эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр, бодлогын санал, зөвлөмж	2015	Түүвэр судалгааны үр дүн	Алтны бичил уурхайчдын 90 гаруй хувь нь дундын худалдан авагчдад зах зээлийн үнээс 15-20%-р хямд борлуулж байна. Энэ нь алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээг далд хэлбэрт шилжүүлэх, хууль бус алт олборлолт, татвараас зайлсхийх зэргээр Монгол улсын МУТСТ тогтолцоонд сөргөөр нөлөөлөх гол шалтгаан болж байна.
--------------------------------	---	------	--------------------------	---


3. АЛТНЫ БИЧИЛ УУРХАЙН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ

Зураг 1. Монгол улсын алтны нийлүүлэлтийн сүлжээний загвар



Эх сурвалж: Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн МУТСТ салбарын эрсдэлийн үнэлгээ

Зураг 2. Олон улсын алтны нийлүүлэлтийн сүлжээний загвар



Эх сурвалж: *Analyses of the gold value chain, IRBC*

Монгол дахь алтны нийлүүлэлтийн сүлжээний сүүлийн шат буюу Монголбанканд алтыг тушааснаар энэ сүлжээ нь албан ёсных болдог (Швейцарийн хөгжлийн агентлаг, 2017). Олон улсын түвшинд алтны нийлүүлэлтийн сүлжээ нь ихэвчлэн хэвтээ загвараар дүрслэгддэг бөгөөд бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг цэвэршүүлэх үйлдвэр, металлын биржүүдээр дамжуулан дахин боловсруулах замаар эргэх холбоотой ажилладгаараа ялгаатай.


4. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү сэдвийн судлагдсан байдлын хүрээнд эмпирик судалгаа шинжилгээ болон тоон мэдээлэл хязгаарлагдмал тул дескриптив шинжилгээнд үндэслэн логик учир шалтгааныг тайлбарлан харуулна. Ингэхдээ 2016 оны бичил уурхай эрхлэгчдийн түүвэр судалгааны анхан шатны мэдээллийг ашигласан. Бичил уурхай эрхлэгчдийн 2016 оны судалгаанд нийтдээ 11962 иргэн бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байгаагаас 9596 иргэн судалгаанд хамрагдаж, 2366 иргэн нь судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн ам бүлийн гишүүн буюу бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байна (Үндэсний статистикийн хороо, 2016). Бичил уурхай эрхлэгчдийн 53 хувийг алтны бичил уурхай эрхлэгчид эзэлж байгаа бөгөөд цаашид алтны бичил уурхай эрхлэгч 5108 иргэний судалгааны мэдээллийг ашиглан статистик тооцооллыг хийв.

5. АЛТНЫ БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТАТВАРЫН ОРЧИН

Алтны бичил уурхай эрхлэгчид алтны нийлүүлэлтийн сүлжээний албан ёсны шат дамжлагын дагуу олборлосон алтыг борлуулах нь алтны нөөц ашигласны төлбөр, хүн амын орлогын албан татвар, Монгол Улсын гадаад валютын нөөц, импортын худалдааны нөөц, ажлын байр, өрхийн амьжиргааны түвшин, алтны бичил уурхай эрхлэгчдийн нэмэгдэл өртгийн хэмжээ, орон нутгийн нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах зэргээр макро эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

Зураг 3. Алтны бичил уурхай эрхлэгчдийн төвлөрөл, газарзүйн байршлаар



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Нийт судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн дийлэнх буюу **19.7 хувь нь Говь-Алтай, 12.5 хувь нь Өмнөговь, 12.1 хувь нь Сэлэнгэ, 11.3 хувь нь Ховд, 10.1 хувь нь Баянхонгор** аймагт төвлөрч байна. Дорнод, Булган, Хэнтий аймгуудын хувьд алтны бичил уурхай эрхлэгчдийн тоо харьцангуй цөөн байна.

“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ийн дагуу бичил уурхайчид, нөхөрлөл нь олборлосон алтаа худалдан авах эрх бүхий хуулийн этгээдэд худалдах үүрэгтэй байдаг. Үүнд Монголбанк эсвэл лиценз эзэмшигч хамаардаг. Алтны орд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд, бичил уурхайчид нь сорьц хяналтын газарт алтны сорьцыг тогтоолгож, Монголбанкид тушааснаар албан ёсны сүлжээгээр борлуулсанд тооцогдоно. Алтны бичил уурхай эрхлэгчид олборлосон алтаа Монголбанкинд борлуулахын тулд алтны орд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшсэн байх ёстой.

Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.г Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно. Байгалийн өнгөт болон үнэт чулууг түүх, олборлох үйл ажиллагааг ердийн ашигт малтмалын адил тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ (Монгол Улсын Их Хурал, 2006). Энэ хууль-д дурдсанаар алтны бичил уурхай эрхлэгчид ашигт малтмалын орд газрын зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхлэх боломжтой байна.

Зураг 4. Зөвшөөрөлтэй талбайд үйл ажиллагаа явуулдаг эсэх, хувийн жингээр, аймгаар




Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

2016 оны бичил уурхай эрхлэгчдийн судалгаанд хамрагдсан нийт алтны бичил уурхай эрхлэгчдийн 15 хувь нь зөвшөөрөлтэй талбайд олборлолт явуулдаг бол дийлэнх буюу 85 хувь нь зөвшөөрөлгүй талбайд олборлолт явуулж байгаа нь Монголбанкинд бичил уурхай эрхлэгчдийн тушааж буй алтны хэмжээг бууруулахад нөлөөлж байна.

Зөвшөөрөлтэй талбайд үйл ажиллагаа эрхэлдэг нийт алтны бичил уурхай эрхлэгчдийн дийлэнх буюу 26 хувийг Говь-Алтай, 21 хувийг Баянхонгор, 18 хувийг Сэлэнгэ аймаг эзэлж байгаа бол Дорнод, Хэнтий аймгуудад зөвшөөрөлтэй талбайд үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо маш бага байна. Зөвшөөрөлгүй талбайд үйл ажиллагаа эрхлэгчдийн дийлэнх буюу 19 хувийг Говь-Алтай, 14 хувийг Өмнөговь, 13 хувийг Ховд аймаг эзэлж байгаа бол Дорнод, Хэнтий, Булган, Улаанбаатар аймгуудын хувьд зөвшөөрөлгүй талбайд үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо цөөн байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй алтны бичил уурхай эрхлэгчдийн дийлэнх нь олборлосон алтаа мөнгө угаах эрсдэлийн түвшин хамгийн өндөртэй дундын худалдан авагчид борлуулдаг нь нийлүүлэлтийн сүлжээний албан бус шат дамжлагаар мөнгө угаах гэмт хэргийг бий болгох магадлалтай.

Зураг 5. Татвар төлдөг эсэх, татварын хэмжээнд эзлэх хувь, аймгаар



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Нийт судалгаанд хамрагдсан алтны бичил уурхай эрхлэгчдээс 5036 иргэн татвар төлдөг эсэх асуулагд хариулсан бөгөөд 25.8 хувь нь татвар төлдөг, дийлэнх буюу 74.2 хувь нь татвар төлдөггүй ба алтны бичил уурхай эрхлэгчдийг газарзүйн байршлаар ангилан татвар төлөлтийн хэмжээг авч үзэхэд нийт татвар төлдөг иргэдийн дийлэнх буюу 17.3 хувийг Баянхонгор, 15.2 хувийг Говь-Алтай, 10.5 хувийг Өмнөговь аймгууд эзэлж байна. Нийт татвар төлдөггүй иргэдийн дийлэнх буюу 21.6 хувийг Говь-Алтай, 13.7 хувийг Сэлэнгэ, 12.3 хувийг Өмнөговь, 11.8 хувийг Ховд аймгууд эзэлж байна.

Алтны бичил уурхай эрхлэгчдийн төлсөн нийт татварын дийлэнх буюу 29.3 хувийг Сэлэнгэ, 19.4 хувийг Баянхонгор, 17.4 хувийг Төв аймаг, харин татвар төлөлтөд хамгийн бага буюу 0.03 хувийг Хөвсгөл, 0.4 хувийг Архангай, 1 хувийг Өвөрхангай эзэлж байна. Үүнээс үзэхэд алтны бичил уурхай эрхлэгчдийн тоогоор тэргүүлэгч аймгуудын дийлэнх хувь нь татвар төлдөггүй ба нийт төлсөн татварын хэмжээнд бага хувийг эзэлдэг бөгөөд Сэлэнгэ, Баянхонгор аймгуудын хувьд татвар төлөгчдийн тоо бага хэдий ч нийт татварын ихэнх хувийг бүрдүүлж байна.

Нийт татвар төлдөг алтны бичил уурхай эрхлэгчид нь АТБӨЯТХАТ (Авто тээвэр болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татвар), ОТБТБИТ (Орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй иргэдийн татвар), ХХОАТ (Хувь хүний орлогын албан татвар), ААНОАТ (Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар), АМНАТ (Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр), Гишүүнчлэлийн татвар, НӨАТ (Нэмэгдсэн өртгийн албан татвар), Газрын хураамж (газрын эзэд), Бусад буюу (ус ашигласны төлбөр, хогны төлбөр, нөхөрлөл, ТББ-д татвар, нөхөн сэргээлтийн сан) гэсэн төрлийн татварууд төлдөг.

Зураг 6. Татвар төлөлтийн хэмжээнд эзлэх хувь, татварын төрлөөр



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Алтны бичил уурхай эрхлэгчдийн төлсөн нийт татварын хэмжээнд дийлэнх буюу 30.6 хувийг ХХОАТ, 25.1 хувийг АТБӨЯТХАТ, 15.6 хувийг бусад төрлийн татвар, 10.5 хувийг ОТБТБИТ, 8.9 хувийг НӨАТ, 4.3 хувийг Гишүүнчлэлийн татвар, 3.2 хувийг Газрын хураамж, 1.5 хувийг АМНАТ, 0.4 хувийг ААНОАТ тус тус бүрдүүлж байна.

Нийт татвар төлөлтийн дийлэнх буюу 29.6 хувийг бүрдүүлсэн Сэлэнгэ аймгийн төлсөн нийт татварын 45.4 хувийг ХХОАТ, 31.4 хувийг ус ашигласны төлбөр, 5.8 хувийг АТБӨЯТХАТ, 7.1 хувийг ОТБТБИТ, 0.3 хувийг ААН-н орлогын албан татвар, 1.5 хувийг АМНАТ, 9.9 хувийг гишүүнчлэлийн татвар, НӨАТ болон Газрын хураамжид татвар төлдөггүй. Алтны бичил уурхай эрхлэгчдийн хувьд хууль эрхзүйн дагуу бүртгэлтэй иргэд ХХОАТ-ийг төлнө. Харин алтны бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож буй бүртгэлгүй иргэдийн хувьд ХХОАТ-г төлөх тохиолдол бага байна. Алтны бичил уурхайн үйл ажиллагаанд авто тээвэр зайлшгүй шаардлагатай тул тодорхой хэмжээнд АТБӨЯТХАТ-ийг төлсөн бөгөөд олборлосон алтыг Монголбанкнаас бусад газарт борлуулсан тохиолдолд АМНАТ болон ААНОАТ-аас зайлсхийх боломж бүрдэж байгаа нь алтны бичил уурхайн үйл ажиллагаа албан бус сүлжээнд орох магадлалыг нэмэгдүүлж байна.

Судалгаанд хамрагдсан нийт алтны бичил уурхай эрхлэгчид олборлосон алтаа борлуулахдаа 95.1 хувь нь хувь хүнд, 3.9 хувь нь баяжуулах үйлдвэрт, 0.6 хувь нь ААН-д 3.1 хувь нь Монголбанкинд борлуулдаг. Судалгаанд хамрагдсан алтны бичил уурхай эрхлэгчид нь нийт 212 кг алтыг олборлосон. Үүнээс дунджаар 0.4 кг алтыг шат дамжлагагүйгээр Монголбанкинд тушаасан ба 211.6 кг алтыг ААН, Хувь хүн, дундын худалдан авагчид тушаасан байна. 2016 онд Монголбанк нэг грамм алтыг дунджаар 86.8 мянган төгрөгөөр, аймаг, нийслэл 21.5 хувиар бага буюу дунджаар 68.1 мянган төгрөгөөр газар дээр нь худалдан авсан бол нийт ААН, Хувь хүн, дундын худалдан авагчдын иргэдээс авсан алтыг Монголбанкид борлуулсан гэж үзвэл ойролцоогоор 3.95 тэрбум (татвар, зардал тооцоогүй) төгрөгийн орлого олсон тооцоо гарч байна.


Судалгаанд хамрагдсан нийт алтны бичил уурхай эрхлэгчид жилд дунджаар 4 сар тогтмол олборлолт явуулдаг. Энэ хугацаанд 212.0 мянган төгрөгийн ХХОАТ төлнө гэж тооцож үзээд

5099 (18 нас хүрээгүй иргэдийг хассан) алтны бичил уурхайчдыг бүгдийг нь хамруулж чадвал 2016 онд 1.1 тэрбум төгрөгийн хүн амын орлогын албан татвар төлөх боломжтой. Харин судалгаанд хамрагдсан алтны бичил уурхай эрхлэгчдийн хувьд нийт 85.5 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар төлсөн нь татварын орлогод ойролцоогоор 995.4 сая төгрөгийн алдагдал хүлээсэн гэж үзэж болох юм. 2016 оны байдлаар “Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.16 дахь заалтын дагуу бичил уурхайгаар алт олборлож байгаа гишүүн бүр сар тутам 53.0 мянган төгрөгийн хүн амын орлогын албан татварыг төлөх үүрэг хүлээдэг. Энэхүү татварт алтны 5099 бичил уурхай эрхлэгчдийг бүгдийг нь хамруулж чадвал ойролцоогоор 270 сая төгрөгийг татварын орлогод нэмэгдүүлэх боломжтой юм. Үүнээс 29.3 сая төгрөгийн ОТБТБИТ төлөгдсөн ба ойролцоогоор 241 сая төгрөгийн орлогын татвар алдсан хэмээн үзэж болох юм.

5.1. Алтны бичил уурхай эрхлэгчдийн нэмэгдэл өртөг

Алтны бичил уурхай эрхлэгчдийн хувьд макро эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх өөр нэгэн хэмжүүр бол нэмэгдэл өртөг юм. Нэмэгдэл өртөг нь үйл ажиллагааны нийт ашиг, цалин, татварын төрлүүд, зээлийн хүүгийн зардал, ажилчдад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн тусламж дэмжлэг, гамшгийн улмаас учирсан хохирлыг нөхөхөд олгосон нөхөн төлбөр, газар эзэмшигчид төлсөн төлбөр, татаас зэргээс шууд, завсрын хэрэглээний бүтээгдэхүүний бүрэлдэхүүн буюу түүхий эд, материал, сэлбэг хэрэгсэл, цахилгаан эрчим хүч, дулаан, шатахуун, шатах тослох материал, барилга байшин түрээсэлсний зардал, машин тоног төхөөрөмж түрээсэлсний зардал, тээврийн зардал, хөдөлмөр хамгааллын зардал, байгаль орчныг нөхөн сэргээх зардал, бусад төрлийн зардал хэсгээс сөрөг хамааралтай.


Зураг 7. Нэмэгдэл өртгийн хэмжээнд аймгуудын эзлэх хувийн жин



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Алтны бичил уурхай эрхлэгчдийн нийт нэмэгдэл өртгийн дийлэнх буюу 15.5 хувийг Өмнөговь, 15.1 хувийг Төв, 14.4 хувийг Говь- Алтай, 12.6 хувийг Ховд аймгууд эзэлж байгаа бол хамгийн бага буюу 0.1 хувийг Дорнод, 0.4 хувийг Хэнтий, 0.7 хувийг Хөвсгөл аймаг эзэлж байна. Тус үзүүлэлтэд аймгуудын алтны бичил уурхай эрхлэгчдийн тоо, татвар төлсөн, төлөөгүй иргэд, татварын хувь хэмжээ чухал нөлөөтэй.


Зураг 8. Нэмэгдэл өртгийн хэмжээнд төрлүүдийн эзлэх хувийн жин



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Нийт нэмэгдэл өртгийн 82 хувийг тооцооны ашиг буюу нийт алтны бичил уурхай эрхлэгчдийн ашиг, 13 хувийг цалин, бусад 5 хувийг алт олборлогчдын төлж буй нийт татвар хураамж, болон зээлийн хүүгийн зардал, ажилчдад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн тусламж, гамшгийн улмаас учирсан хохирлыг нөхөхөд олгосон нөхөн төлбөр, газар эзэмшигчдэд төлсөн төлбөр, татаас зэрэг эзэлж байна.

Зураг 9. Нэмэгдэл өртөгт тооцооны ашигийн эзлэх хувь, аймгаар




Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Аймгуудын нэмэгдэл өртгийн бүрэлдэхүүнд тооцооны ашигийн хэмжээ дийлэнх хувийг эзэлж байна. Дорнод аймгийн хувьд нийт нэмэгдэл өртгийн 100 хувийг, Архангай, Хөвсгөл, Өмнөговь зэрэг аймгуудад 99 хувийг тооцооны ашиг бүрдүүлж байна. Үүнээс үзэхэд нийт нэмэгдэл өртөг нь макро эдийн засагт маш бага хэмжээний нөлөөг үзүүлж байна. Нэмэгдсэн өртгийн нийт хэмжээнд ААНОАТ 0.01 хувь, ОТБТБИТ 0.3 хувь, АМНАТ 0.04 хувийг тус тус эзэлж байгаа нь энэ салбарт хууль эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлэлт, хяналт сул байгааг илтгэж буй бөгөөд бичил уурхай эрхлэгчид татвараас зайлсхийх нөхцөлийг бүрдүүлж байна.

6. АЛТНЫ БИЧИЛ УУРХАЙН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ БА ЗӨВЛӨМЖИЙН ҮР ДҮНГИЙН ХЭРЭГЖИЛТ

6.1. Алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээ

Зураг 10. Алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээ, өргөтгөсөн байдлаар



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Дараах алтны нийлүүлэлтийн сүлжээг судалгааны үр дүн болон бусад алтны нийлүүлэлтийн сүлжээг харьцуулах байдлаар дүрслэн сайжруулсан болно. Алтны бичил уурхай эрхлэгчид олборлосон алтаа борлуулахад тулгардаг хүндрэл нь алтыг хууль бус замаар борлуулах, татвараас зайлсхийх маш том хөшүүрэг болж байна. Тиймээс дээрх хүндрэлүүдийг стандартын болон худалдааны хүндрэл гэж ангилан үзэж худалдааны хүндрэлүүдэд дундын худалдан авагчид зах зээлийн үнээс доогуур үнээр худалдан авдаг, ашигт малтмалын ханш тогтвортой бус байдаг, орон нутагт албан ёсны худалдан авагч байдаггүй зэргийг хамааруулан авч үзье. Стандартын хүндрэлийг хууль эрх зүй, дүрэм журмаар зохицуулах бол худалдааны буюу зах зээлийн хүндрэлийг бууруулахын тулд шат дараалсан арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлэх юм.

Алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээ нь албан ёсны нэг сувгаар дамждаггүй тул гарал үүслийг нь тодорхойлох боломжгүй байдгаас шалтгаалан нэмүү өртгийг нь тооцох хүндрэлтэй байдаг.

Дээрх хүндрэлүүдийг бууруулах нэг арга бол монгол банк, алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээнд оролцогчидтой эргэх холбоотой ажиллах, албан ёсны шат дамжлагыг хэвшүүлэх нь зүйтэй гэдгийг дээрх алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээгээр харуулав.

6.2. ФАТФ-ын 40 зөвлөмжийн үр дүнгийн байдлын хэрэгжилтэд нөлөөлөх нь

Монгол Улсын хувьд алтны бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны эерэг нөлөөг бий болгоход алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээ бүрэн албажаагүй байгаа нь сул тал болсон хэвээр байна. Алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээний албан бус сувгийг хумиснаар мөнгө угаах гэмт хэргийн нөхцөл буурах бөгөөд Монгол Улсын ФАТФ-ын 40 зөвлөмжийн үр дүнгийн байдлын хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлнэ. Алтны бичил уурхай эрхлэгчдийн хувьд Санхүүгийн бус байгууллага, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч (СББМҮҮ)-ийн дараах зөвлөмжүүдтэй шууд хамааралтай.

Бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авдаг ААН, дундын худалдан авагчид бүртгэлжүүлж албан ёсны сүлжээгээр дамжуулан үйл ажиллагаа эрхэлдэг болгосноор доорх зөвлөмжүүдийн хэрэгжилтийг сайжруулна.

Зөвлөмж 22. СББМҮҮ: Харилцагчийг таньж мэдэх

Зөвлөмж 10, 11, 12, 15, 17-д заасан харилцагчийг таньж мэдэх, баримт бичгийг хадгалах шаардлага дараах нөхцөлд СББМҮҮ-дэд хамаарна:

Бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авдаг дундын худалдан авагчид болон ААН-ыг бүртгэлжүүлснээр босго дүнтэй тэнцүү буюу түүнээс дээш гүйлгээ хийх үед тухайн гүйлгээний оролцогчдыг хянах боломжийг сайжруулна.

Зөвлөмж 23. СББМҮҮ: Бусад арга хэмжээ

Зөвлөмж 18-21-д заасан шаардлага дараах нөхцөлд бүх СББМҮҮ-дэд хамаарна:

Бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авдаг дундын худалдан авагчид, болон ААН-ийг бүртгэлжүүлснээр сэжигтэй гүйлгээг мэдээлэх нь дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулна.

Зөвлөмж 28. СББМҮҮ-ийн зохицуулалт, хяналт шалгалт

Бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авдаг дундын худалдан авагчид, болон ААН-ийг бүртгэлжүүлснээр тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг тогтмол хийж үр дүнг мэдээллэх нь дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулна.

7. ДҮГНЭЛТ

Алтны бичил уурхай, тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдох эдийн засгийн чухал үзүүлэлтүүдийн нэг бол нэмэгдэл өртөг юм. Бичил уурхай эрхлэгчдэд буюу нийлүүлэлтийн үе шатнаас хамааран макро эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл харьцангуй бага байна. Алтны бичил уурхай эрхлэгчид олборлосон алтны дийлэнх хувийг хувь хүн, дундын худалдан авагчдад борлуулдаг нь алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээний албан бус сувгаар дамжин мөнгө угаах буюу далд эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлж байна.

Алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээнд оролцогчдыг албан сувгаар дамжуулан олборлосон алтаа борлуулдаг болгох нэг хөшүүрэг бол татварын санаачилгын тогтолцоо юм. Алтыг албан сүлжээгээр дамжуулан борлуулахад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, холбогдох бусад арга хэрэгслийг ашиглах тогтолцоог бүрдүүлэх нь алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээнд шаардлагатай арга хэмжээ юм.

ФАТФ-ийн зөвлөмжийн дагуу алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудыг бүртгэлжүүлж, Монгол банк, оролцогч тал хооронд эргэх холбоотой ажиллах нь МУТСТ тогтолцоо болон макро эдийн засаг, Монголын уул уурхайн салбарт өрсөлдөөнт орчныг сайжруулахад нөлөөлөх болно. Алтны бичил уурхай эрхлэгчдийг бүртгэлжүүлснээр МУТСТ тогтолцоо сайжирч, татварын орлого нэмэгдэх, байгаль орчны нөхөн сэргээлт хийгдэх, нийгмийн хариуцлага нэмэгдэхээс гадна бичил уурхай эрхлэгчдийн эрх ашиг хамгаалагдах зэрэг олон эерэг нөлөөг үзүүлэх юм.

8. САНАЛ

- Бичил уурхай эрхлэгчдийн Монголбанканд тушаах алтны хэмжээг нэмэгдүүлэх, тэдгээрийн далд эдийн засгийн байдлыг хумихын тулд;
- Бичил уурхайгаар олборлосон алтны худалдааг зохицуулах эрх зүйн техникийн зохицуулалттай болох;
- Тухайн шат дамжлага бүрт нэмүү өртгийг тооцох мэдээллийн санг үүсгэх;
- Алтны бичил уурхай эрхлэгчдийг нийлүүлэлтийн сүлжээ рүү татах татварын санаачилгын тогтолцоог бүрдүүлэх;
- Алтны бичил уурхайн төвлөрөл үүссэн Говь-Алтай, Ховд, Сэлэнгэ, Өмнөговь, Төв аймгуудад сорьц шинжилгээний төвийг байгуулж, алтыг тухайн аймгийн Монголбанкны салбаруудад хүлээн авах дэд бүтэц, логистикийг шийдэх;
- Алтны бичил уурхай эрхлэгчдийг орон нутгийн нийгмийн зөвшөөрөл (лиценз)-тэй болгох;
- Монголбанканд алт тушааж байгаа иргэд, ААН-г бүртгэж, мэдээллээр ханган ажиллах
- Судалгааны саналууд: Алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээн дэх дундын худалдан авагчдын талаарх судалгаа хийх;

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

APG. (2017.09). Anti-money laundering and counter-terrorist financing measures Mongolia MER.

APG. (2019.10). 2nd Mutual Evaluation FUR of Mongolia.

IRBC. (2019.11). Analysis of the Gold Value Chain.

PlanetGold Mongolia. (2021). ЭЗХАХБ-ын зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэрээс гаралтай эрдэс баялгын хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний магадлан шинжилгээний удирдамж.

Senbete, A. (2018.10). Factors affecting artisanal and small scale of gold supply: The case of Ethiopia.

Department of Management Addis Ababa University. (2015.12). Алт 2025 хөтөлбөрийн суурь судалгааны тайлан.

(огноо байхгүй). Монгол Улс дахь уул уурхайн дэд салбар - бичил уурхай.

Монгол Улсын Засгийн газар. (2010). Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам.

Монгол Улсын Их Хурал. (2006). Ашигт малтмалын тухай хууль (шинэчилсэн найруулга).

Улаанбаатар.

(2016). Монгол улсын МУТС үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлан. Улаанбаатар: Монголбанк. Монголбанк. (2019.09). Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай.

Монголын экспортлогчдын холбоо. (2015.07). Тогтвортой бичил уурхай төсөл.

Санхүүгийн зохицуулах хороо. (2020.01). Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх салбарын эрсдэлийн үнэлгээ.

Үндэсний статистикийн хороо. (2016). Бичил уурхай эрхлэгчдийн судалгааны нэгдсэн тайлан.

Улаанбаатар.

Үндэсний статистикийн хороо. (2018). Stata 14 програмыг шинжилгээнд ашиглах нь, гарын авлага.

Улаанбаатар.

Үндэсний статистикийн хороо. (2020). Далд эдийн засгийг хэмжих судалгаа. Улаанбаатар.

ФАТФ. (2015.07). Алтны салбар дахь мөнгө угаах/терроризмийг санхүүжүүлэх эрсдэл, эмзэг байдал.

Швейцарийн хөгжлийн агентлаг. (2017). Бичил уурхайгаар олборлосон алтыг боловсруулах, албан ёсны сүлжээгээр худалдаалах арга зам.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Алт олборлогчдын тоо, хувийн жингээр, аймгаар

Бүс аймаг, нийслэл	Бүгд	Баруун										Төв						Улаанбаатар			
		Завхан	Говь-Алтай	Ховд	Увс	Хангайн бүс	Өвөрхангай	Булган	Баянхонгор	Архангай	Хөвсгөл	Төв	Сэлэнгэ	Өмнөговь	Зүүн бүс	Дорнод	Хэнтий				
Бүс аймаг, нийслэл	Бүгд	5108	2274	323	1005	578	368	963	207	43	551	90	72	1721	468	616	637	56	44	12	94
хувь	Эзлэх	100%	45%	6%	20%	11%	7%	19%	4%	1%	11%	2%	1%	34%	9%	12%	12%	1%	1%	0%	2%

Хавсралт 2. Алтны бичил уурхай эрхлэгчдийн татвар төлдөг эсэх, аймгаар

Бүс аймаг, нийслэл	Бүгд	Татвар төлсөн алт олборлогчид	Эзлэх хувь	Татвар төлөөгүй алт олборлогчид	Эзлэх хувь
Бүгд	5036	1297	25.8	3739.0	74.2
Баруун бүс	2259	577	11.46	1682.0	33.4
Завхан	322	183	3.63	139	2.8
Говь-Алтай	1005	197	3.91	808	16.0
Ховд	567	125	2.48	442	8.8
Увс	365	72	1.43	293	5.8
Хангайн бүс	952	278	5.52	674.0	13.4
Өвөрхангай	204	23	0.46	181	3.6
Булган	43	13	0.26	30	0.6
Баянхонгор	543	224	4.45	319	6.3
Архангай	90	16	0.32	74	1.5
Хөвсгөл	72	2	0.04	70	1.4
Төвийн бүс	1675	358	7.11	1317.0	26.2
Төв	463	121	2.40	342	6.8
Сэлэнгэ	615	101	2.01	514	10.2
Өмнөговь	597	136	2.70	461	9.2
Зүүн бүс	56	12	0.24	44.0	0.9
Дорнод	12	12	0.24	0	0.0
Хэнтий	44	0	0.00	44	0.9
Улаанбаатар	94	72	1.43	22	0.4

Хавсралт 3. Зөвшөөрөлтэй талбайд үйл ажиллагаа эрхэлдэг бичил уурхай эрхлэгчдийн тоо, хувийн жингээр, аймгаар

Бүс аймаг, нийслэл	Бүгд	Зөвшөөрөлтэй талбайд үйл ажиллагаа эрхэлдэг БУ эрхлэгчдийн тоо		Эзлэх хувь	Зөвшөөрөлгүй талбайд үйл ажиллагаа эрхэлдэг БУ эрхлэгчдийн тоо		Эзлэх хувь
		Бүгд	Эрхлэгчдийн тоо		Бүгд	Эрхлэгчдийн тоо	
Бүгд	5036	748	15%	4288	85%		
Баруун бүс	2259	290	6%	1969	39%		
Завхан	322	51	1%	271	5%		
Говь-Алтай	1005	193	4%	812	16%		
Ховд	567	9	0%	558	11%		
Увс	365	37	1%	328	7%		
Хангайн бүс	952	210	4%	742	15%		
Өвөрхангай	204	29	1%	175	3%		
Булган	43	20	0%	23	0%		
Баянхонгор	543	160	3%	383	8%		
Архангай	90	0	0%	90	2%		
Хөвсгөл	72	1	0%	71	1%		
Төвийн бүс	1675	171	3%	1504	30%		
Төв	463	20	0%	443	9%		
Сэлэнгэ	615	137	3%	478	9%		
Өмнөговь	597	14	0%	583	12%		
Зүүн бүс	56	15	0%	41	1%		
Дорнод	44	3	0%	41	1%		
Хэнтий	12	12	0%	0	0%		
Улаанбаатар	94	62	1%	32	1%		

Хавсралт 4. Амжиргаанд өөрчлөлт орсон алтны бичил уурхай эрхлэгчдийн татвар төлсөн байдал, хувиар

	Татвар төлдөг иргэд	Эзлэх хувь	Татвар төлдөггүй иргэд	Эзлэх хувь	Нийт
Амжиргаанд өөрчлөлт орсон иргэд	987	19.6	2,522	50.1	3,509
Амжиргаанд өөрчлөлт ороогүй иргэд	310	6.2	1,217	24.2	1,527
Нийт	1,297	25.8	3,739	74.2	5,036

Хавсралт 5. Алтны бичил уурхай эрхлэгчдийн амжиргаанд өөрчлөлт орсон эсэх, аймаг бүсээр

Бүс, аймаг, нийслэл	Бүгд	Амжиргаанд өөрчлөлт орсон иргэд	Эзлэх хувь	Амжиргаанд өөрчлөлт ороогүй иргэд	Эзлэх хувь
Бүгд	5108	3558	69.66	1550	30.34
Баруун бүс	2274	1438	0.28	836	0.16
Завхан	323	159	0.03	164	0.03
Говь-Алтай	1005	574	0.11	431	0.08
Ховд	578	393	0.08	185	0.04
Увс	368	312	0.06	56	0.01
Хангайн бүс	963	702	0.14	261	0.05
Өвөрхангай	207	116	0.02	91	0.02
Булган	43	36	0.01	7	0.00
Баянхонгор	551	442	0.09	109	0.02
Архангай	90	82	0.02	8	0.00
Хөвсгөл	72	26	0.01	46	0.01
Төвийн бүс	1721	1278	0.25	443	0.09
Төв	468	363	0.07	105	0.02
Сэлэнгэ	616	459	0.09	157	0.03
Өмнөговь	637	456	0.09	181	0.04
Зүүн бүс	56	52	0.01	4	0.00
Дорнод	44	44	0.01	0	0.00
Хэнтий	12	8	0.00	4	0.00
Улаанбаатар	94	88	0.02	6	0.00

Хавсралт 6. Алтны бичил уурхай эрхлэгчдийн орон нутагт хувь нэмэр оруулсан эсэх, аймаг бүсээр

Бүс, нийслэл	аймаг, Бүгд	Орон хувь орлуулсан	нутагт нэмэр иргэд	Эзлэх хувь	Орон хувь оруулаагүй иргэд	нутагт нэмэр	Эзлэх хувь
Бүгд	5108	955		18.7	4153		81.3
Баруун бүс	2274	304		0.1	1970		0.4
Завхан	323	34		0.01	289		0.06
Говь-Алтай	1005	84		0.02	921		0.18
Ховд	578	50		0.01	528		0.10
Увс	368	136		0.03	232		0.05
Хангайн бүс	963	247		0.05	716		0.1
Өвөрхангай	207	22		0.00	185		0.04
Булган	43	10		0.00	33		0.01
Баянхонгор	551	191		0.04	360		0.07
Архангай	90	19		0.00	71		0.01
Хөвсгөл	72	5		0.00	67		0.01
Төвийн бүс	1721	313		0.1	1408		0.3
Төв	468	37		0.01	431		0.08
Сэлэнгэ	616	246		0.05	370		0.07
Өмнөговь	637	30		0.01	607		0.12
Зүүн бүс	56	12		0.002	44		0.0
Дорнод	44	1		0.00	43		0.01
Хэнтий	12	11		0.00	1		0.00
Улаанбаатар	94	79		0.02	15		0.00

Хавсралт 7. Татварын бүрэлдэхүүнд эзлэх хувийн, төрлүүдээр, аймгаар

Алт олборлогч иргэдийн тоо	Зүүн бүс	Хэнтий	Төвийн бүс	Төв	Сэлэнгэ	Өмнөговь	Хангайн бүс	Баянхонгор	Булган	Архангай	Хөвсгөл	Баруун бүс	Завхан	Говь-Алтай	Ховд	Увс	Улаанбаатар	Нийт	Эзлэх хувь	
Алт олборлогч иргэдийн тоо	12	12	1721	468	616	637	963	207	43	551	90	72	2274	323	1005	578	368	94	9972	
Автомобиль болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татвар	404000	404000	24830400	10487200	4209100	10134100	15167500	1283000	700000	12151700	946800	86000	29712355	9747690	10711665	7811000	1442000	0	139824510	50.0
Орлогыг гухай бүр тодорхойлох боломжгүй иргэдийн татвар	20000	20000	6438000	50000	5870000	518000	12249500	0	2399500	9850000	0	0	3835000	1250000	99000	1891000	595000	6744000	45065000	16.1
Хувь хүний орлогын албан татвар	0	2160000	48453300	10908000	37085300	460000	28213000	830000	150000	27210000	23000	0	6680000	2307000	391000	3880000	102000	0	168852600	60.3
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	0	0	290000	40000	250000	0	483000	0	0	483000	0	0	427000	392000	35000	0	0	0	2400000	0.9
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	0	0	1262000	0	1206000	56000	866500	0	0	866500	0	0	1868000	0	1465000	0	403000	73500	7993000	2.9
Гишүүнчлэлийн татвар	540000	540000	9077000	245000	8170000	662000	836000	130000	0	706000	0	0	1586000	106000	325000	50000	1105000	134000	23538000	8.4
Нэмэгдсэн өртгийн албан татвар (газрын эзэд)	0	0	25000000	25000000	0	0	20000	0	0	20000	0	0	0	0	0	0	0	0	50040000	17.9
Газрын хураамж	114000	114000	152000	113000	0	39000	3005600	30000	0	2875600	100000	0	5671200	5247200	297000	0	127000	0	17771600	6.4
Бусад	864000	864000	27900080	1734000	26000000	166080	4026000	606000	3300000	120000	0	0	410640	5200	342440	63000	0	10342000	65537440	23.4
Нийт	4102000	4102000	143402780	48577200	82790400	12035180	64867100	2879000	6549500	54282800	1069800	86000	50190195	19055090	13666105	13695000	3774000	17293500	279855575	100.0
Эзлэх хувь	1.47	1.47	51.24	17.36	29.58	4.30	23.18	1.03	2.34	19.40	0.38	0.03	17.93	6.81	4.88	4.89	1.35	6.18	100.0	



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

МОНГОЛБАНК

**МОНГОЛ УЛС ДАХЬ ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ХҮРЭЭНД ТАВИГДАХ
МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ**

М.Маралмаа⁷, Б.Мягмарсүрэн⁸

⁷ Монгол улсын их сургууль, Хууль зүйн сургууль, Эрх зүйн тэнхим, V курсын оюутан

⁸ Монгол улсын их сургууль, Хууль зүйн сургууль, Эрх зүйн тэнхим, V курсын оюутан.

ТОВЧ ХУРААНГУЙ

Сүүлийн үед технологийн дэвшлүүд ар араасаа гарч хурдацтай хөгжин санхүүгийн зах зээлд шинээр бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрэх нь инноваци болон үр ашигтай байдлыг үүсгэж цаашлаад санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж буй хэдий ч зарим төрлийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нь гэмт хэрэгтэн, террористуудад мөнгө угаах эсвэл өөрсдийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх арга замуудыг бий болгож байна. Эдгээр технологийн дэвшилтэт шийдлүүдийн нэг нь виртуал хөрөнгө юм. Виртуал хөрөнгө нь шинэ технологийн үндсэн дээр үүссэн бөгөөд цаашид ч техник, технологийн хөгжлийг дагаад шинээр санхүүгийн үйлчилгээний тоо ихсэж, түүнийг дагаад гарах эрх зүйн зохицуулалтууд нэмэгдэх хандлагатай байна⁹.

Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (“ФАТФ”)-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орны жагсаалт буюу “Саарал” жагсаалтаас 2020 оны 10 дугаар сард гарсан бөгөөд ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах үүрэг хүлээсэн.

ФАТФ-ын Зөвлөмж 15-д¹⁰ “Улс орнууд виртуал хөрөнгөтэй холбоотой эрсдэлийг удирдах, бууруулах үүднээс виртуал хөрөнгөтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгч нарыг тусгай зөвшөөрөл эсвэл бүртгэлд хамруулж ФАТФ-ын Зөвлөмжийн холбогдох заалтыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих арга хэмжээ авах шаардлагатай.” тухай дурджээ. Түүнчлэн тус зөвлөмжийн тайлбарт “Улс орнууд ФАТФ-ын Зөвлөмжийн холбогдох арга хэмжээнд виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч - ВХҮҮ¹¹ нарыг хамруулна.” гэж виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх зохицуулалтад оруулах шаардлагатай тухай заасан.

Иймд ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд зөвлөмж 15-т заасны дагуу виртуал хөрөнгийн салбарын эрх зүйн орчинг бүрдүүлж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах буюу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх олон улсын стандарт шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй.

Виртуал хөрөнгө нь санхүүгийн зах зээлийн шинэ төрлийн хэрэгсэл болж их хэмжээний гүйлгээ хийгдэж байгаагийн хувьд манай улсад төдийгүй олон улсад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хэрэгсэл болох эрсдэлтэй тул ФАТФ-ын зөвлөмжид тусгаж, улс орнуудад үүрэг болгож байна.

Тус үүргийг хэрэгжүүлж манай улс 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай” хууль (“ВХҮҮТХ”)-ийг баталж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид тавих шаардлага болон төрөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээг хуульчилсан.

Хуульд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргийг хүлээлгэсэн бөгөөд уг хууль батлагдсантай холбоотойгоор 2013 оны Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (МУБТСТХ)-д нэмэлт

⁹ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөл, төслийн үзэл баримтлал. <https://mojha.gov.mn/wp-content/uploads/2021/01/VASP-%D1%82%D0%B0%D0%BD%D0%B8%D0%BB%D1%86%D1%83%D1%83%D0%BB%D0%B3%D0%B0.pdf> сүүлийн хандалт 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр.

¹⁰ ФАТФ-ын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт.

¹¹ Virtual asset service providers- VASPs /Анг./

өөрчлөлт орж 4 дүгээр зүйлийн 4.1.10-т “виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” гэж зааснаар мэдээлэх үүрэг бүхий этгээдүүдийн нэг болсон.

Иймд манай улсаас гадна дэлхий дахинд шинэ төрлийн харилцаа болж буй виртуал хөрөнгийн харилцаанд үйлчилгээ үзүүлэгч нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, түүнтэй тэмцэх харилцаанд оролцогч болохын хувьд манай улсын эрх зүйн зохицуулалтаар ямар үүрэг хүлээж байгаа, цаашид тулгарч болох хүндрэл, бэрхшээл болон олон улсад энэ төрлийн харилцааг хэрхэн зохицуулж байгааг харьцуулан судлаж, санал дэвшүүлэхийг зорилоо.

ТҮЛХҮҮР ҮГ

Виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх

1. ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ НЬ МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ НЬ

1.1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухайд

ФАТФ-ын зөвлөмжид “Виртуал хөрөнгийг үйлчилгээ үзүүлэгч” гэж дараах бизнесийн үйл үйл ажиллагааг хувь хүн хуулийн этгээдийн өмнөөс ажиллагаа эрхэлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ гэж тодорхойлсон. Үүнд:

- Виртуал хөрөнгө болон бодит мөнгө хөрвүүлэх арилжаа хийх;
- Виртуал хөрөнгө хооронд хөрвүүлэг арилжаа хийх;
- Виртуал хөрөнгө шилжүүлэх¹²;
- Виртуал хөрөнгө, хэрэгслийг хадгалах виртуал хөрөнгийн хяналтыг хэрэгжүүлэх;
- Виртуал хөрөнгө гаргагч, борлуулагчид санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, оролцох;

ФАТФ-ын зөвлөмжид виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх эсхүл тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэх буюу үйл ажиллагааг нь хуулиар зохицуулах, улмаар эрх бүхий байгууллагаас хянах тухай заасны дагуу манай улс ВХҮҮТХ-ийг баталсан. Тус хууль нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, холбогдох эрх, үүргийг тодорхойлох зорилготой бөгөөд Монгол Улсад бүртгэлтэй компани Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улс руу энэ хуульд заасан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 6 дугаар зүйлийн 6.1-т зааснаар хүн, хуулийн этгээд гэрээ, хэлцэлд оролцогчийн нэрийн өмнөөс тэдгээрийн захиалгаар, эсхүл тэдгээрт зориулан виртуал хөрөнгийн дараах 5 төрлийн үйлчилгээ үзүүлж буй компанийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч гэж тодорхойлж байна. Үүнд:

- Виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд нь арилжих;
- Нэг болон олон төрлийн виртуал хөрөнгийг хооронд нь арилжих;
- Виртуал хөрөнгийг шилжүүлэх;
- Виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах;
- Виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүгийн үйл ажиллагаанд оролцох болон үйлчилгээ үзүүлэх.

Дээрхээс үзвэл ВХҮҮТХ-д заасан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь ФАТФ-ын зөвлөмжид заасан тодорхойлолттой агуулгын хувьд нэг байна.

Харин ФАТФ-ын зөвлөмжид виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь хувь хүн болон хуулийн этгээд байх боломжтой тухай заасан бол ВХҮҮТХ-д зөвхөн компани байна гэдгийг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т тодорхой заажээ.

Иймд манай улсын хувьд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч гэж ВХҮҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан 5 төрлийн үйл ажиллагааг эрхэлдэг компанийг ойлгох бөгөөд компани нь тус хуульд заасан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлагыг

¹² Виртуал хөрөнгийн хувьд виртуал хөрөнгө шилжүүлэх гэж хувь хүн, этгээдийн нэрийн өмнөөс виртуал хөрөнгийг нэг данс, хаягнаас нөгөө данс, хаяг руу шилжүүлэх гүйлгээ хийхийг хэлнэ (ФАТФ-ын зөвлөмж, 2012-2019).

хангаж, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэгдсэн¹³ байх шаардлага тавигдаж байна¹⁴.

ВХҮҮТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1-т “Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш дөрвөн сарын хугацаанд аливаа компанийг Хорооноос энэ хуулийн 6.1-д заасан үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэхгүй” гэж шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгажээ. Тодруулбал, тус хуулиар Санхүүгийн зохицуулах хороо нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, үйл ажиллагааг нь хянахтай холбоотой 6 төрлийн журам¹⁵ батлах бүрэн эрхтэй болсон. Уг журмуудыг хууль хүчин төгөлдөр болсноос¹⁶ хойш 4 сарын дотор буюу 2022 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн дотор баталж, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хүчин төгөлдөр захиргааны хэм хэмжээний акт болсон байх ёстой.

Эдгээр журам хүчин төгөлдөр болсноор виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч компани бүртгүүлэх боломжтой болох тул одоогийн байдлаар хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд албан ёсоор бүртгэгдсэн бирж¹⁷ байхгүй юм.

Мөн тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлж байсан этгээд энэ хуулийн 17.1-д заасан дөрвөн сарын хугацаа дууссанаас хойш гурван сарын дотор энэ хуульд заасан шаардлагыг хангаж, Хороонд бүртгүүлнэ” гэж заасан. Уг хуулийн төслийг хэлэлцэж байх явцад буюу 2021 оны 11 дүгээр сарын байдлаар 9 бирж байсан¹⁸ бол 2021 оны 12 дугаар сарын 17-нд хууль батлагдах хүртэл 22 орчим бирж (албан бус тоо) үйл ажиллагаа явуулж байгааг харвал виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч компани цаашид ч олон болох хандлагатай байна.

1.2. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тухай ойлголт

Мөнгө угаах гэдэг нь хууль бус үйл ажиллагаанаас олсон мөнгийг эдийн засгийн үйл ажиллагаанаас хууль ёсны дагуу олсон ашиг гэж харуулахын тулд бизнес-санхүүгийн баримт бичгийг хуурамчаар үйлдэх эсвэл бусад үйлдэл хийх замаар хууль бус мөнгийг хууль ёсны мэт

¹³ ВХҮҮТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Энэ хуулийн 6.1-д заасан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх компани Хороонд хүсэлт гаргаж, бүртгүүлнэ”.

¹⁴ ВХҮҮТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.6-д “Энэ хуульд заасны дагуу бүртгүүлээгүй этгээд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно”.

¹⁵ ВХҮҮТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэл, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зохистой засаглал, үйл ажиллагаа, тайлан мэдээнд тавих шаардлагыг тодорхойлох, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгийн хэмжээг тогтоох, түүнд өөрчлөлт оруулах, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох, түр зогсоох, зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх, аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох, энэ хуулийн 10.8-д заасан мэргэжлийн холбоонд тавих шаардлагыг тогтоох журмыг батлах”. Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 02 дугаар 25-ны өдөр 4 журамд Захиргааны ерөнхий хуулийн 62.1-т заасны дагуу олон нийтээс санал авахаар нийтлээд байна. <http://www.frc.mn/a/3910> сүүлийн хандалт 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр.

¹⁶ ВХҮҮТХ нь Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргадаг албан ёсны сэтгүүл болох “Төрийн мэдээлэл” сэтгүүлд 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр хэвлэгдсэн. Тиймээс Монгол Улсын Үндсэн Хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т “Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно” гэж заасны дагуу 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдөр хүчин төгөлдөр болсон. /М.М; Б.М/

¹⁷ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг практикт “Бирж” гэж байна.

¹⁸ “Виртуал хөрөнгө үнэт цаас, төлбөрийн хэрэгсэл биш” нийтлэл, 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр., <https://news.mn/t/2496630/>, сүүлийн хандалт 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр.

харагдуулах үйл ажиллагаа юм¹⁹. Мөнгө угаах нь хууль бусаар олсон мөнгийг хууль ёсны бизнесийн үйл ажиллагаанд ашиглаж болохуйц мөнгө болгон хувиргадаг мөнгө татах, шилжүүлэх зэрэг санхүүгийн хэд хэдэн үйл ажиллагаанаас бүрдэнэ. Хууль ёсны болгосон мөнгийг бизнесүүдээр дамжуулан “дахин боловсруулдаг” бөгөөд тэндээсээ хууль ёсны зах зээлд нэвтэрч, эдийн засаг даяар мөнгө тархдаг²⁰.

Мөнгө угаах нь маш нарийн төвөгтэй үйл явц бөгөөд мөнгө угаагчид зорилгодоо хүрэхийн тулд янз бүрийн арга техникийг ашигладаг. Энэхүү үзэгдлийг илрүүлэх, дүн шинжилгээ хийхэд хөнгөвчлөхийн тулд үндсэн гурван үе шатыг судлаачид тодорхойлсон байдаг²¹. Үүнд:

1. Байршуулах - гэмт хэргийн үйл ажиллагаанаас олсон мөнгийг санхүүгийн байгууллагад байршуулах, эсвэл бараа бүтээгдэхүүн худалдан авахад ашигладаг;
2. Нуун дарагдуулах - хөрөнгийн эх үүсвэрийг нуун дарагдуулах, далдлах;
3. Буцаан төвлөрүүлэх - мөнгийг хууль ёсны эдийн засаг, санхүүгийн системд нэгтгэж, тухайн системийн бусад бараатай уусгах үе шат.

Хууль бус мөнгийн хууль ёсны мэт харагдуулах зорилгод санхүүгийн байгууллагууд түгээмэл арга хэрэгсэл болдог. Саяхныг хүртэл смурфинг хийх, их хэмжээний бэлэн мөнгийг хил давуулах, бэлэн мөнгө шаардагдах бизнес эрхлэх зэрэг уламжлалт аргуудаар мөнгө угаах тохиолдол байсан.

Мөнгө угаах уламжлалт аргууд

Смурфинг: Мөнгө угаах хамгийн түгээмэл тархсан уламжлалт арга бөгөөд их хэмжээний бэлэн мөнгийг олон жижиг хэсэгт хуваан хадгаламж болгон хувиргах үйл явц юм. Улс орон бүрд арилжааны банкнууд хууль эсхүл журмуудад зааснаар тодорхой мөнгөн дүнгээс дээш гүйлгээг зохицуулагчдад тайлагнах, тэдэнд сэжиг бүхий шилжүүлэг, гүйлгээг мэдээлэх үүрэгтэй байдаг учир мөнгө угаагчид тухайн тодорхойлсон мөнгөн дүнгээс бага дүнгээр байршуулдаг.

Бэлэн мөнгө шаарддаг бизнесүүд: Энэ аргаар гэмт хэрэгтнүүд бэлэн мөнгө шаардагддаг бизнес эрхэлдэг бөгөөд бизнесийн дансаа ашиглан гэмт хэрэгт холбогдсон бэлэн мөнгөө байршуулдаг. Ийм бизнесүүд нээлттэй үйл ажиллагаа явуулж, хууль бус мөнгийг хууль ёсны ашигтай нэгтгэн үйл ажиллагаа явуулдаг.

Бараа бүтээгдэхүүний хөрөнгө оруулалт: Алмаз, эрдэнийн чулуу, алт зэрэг үнэт зүйлсийг мөнгө угаах гэмт хэргийн хэрэгсэл болгон ашигладаг.

Банк барих: Мөнгө угаагчид банкин дахь хяналтын багцыг худалдаж авч банкаар дамжуулан ямар ч хяналтгүйгээр мөнгө шилжүүлдэг.

Хар цалин: Компани бүртгэлтэй боловч бодитоор ажилладаггүй олон ажилтантай байх бөгөөд цалин хөлсийг нь бэлнээр нь олгох замаар ихээхэн хэмжээний мөнгө угаадаг.

Техник, технологи хөгжих тусам мөнгө угаах шинэ арга замууд гарч ирсээр байгаа юм. 2006 оны 10 дугаар сард ФАТФ мөнгө угаагчид ашиглаж болох хууль ёсны эдийн засгийн гүйлгээнд ашигладаг төлбөрийн шинэ аргуудын төрлүүдийн тайланг 14 танилцуулсан.

¹⁹ Natasha Georgieva, CONCEPT, DEFINITION AND CHARACTERISTICS OF THE MONEY LAUNDERING PHENOMENON, Journal of Process Management – New Technologies, International Vol. 8, No 2, 2020, at 23.

²⁰ Мөн тэнд,

²¹ Мөн тэнд, 27 дахь тал.

Мөнгө угаах шинэ аргууд

Гүйлгээгээ угаах: Гүйлгээгээ угаах нь хууль ёсны борлуулагчдын дансаар дамжуулан үл мэдэгдэх цахим худалдааны гүйлгээг тохируулах замаар төлбөрийн экосистемийн давуу талыг ашигладаг. Онлайн худалдаа, гар утасны дижитал төлбөр тооцоо улам их хөгжих нь гүйлгээг угаахыг ихэсгэж улмаар зөвхөн АНУ-д онлайн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр мөнгө угаасан явдал 2016 онд 159 тэрбум доллар давсан байна.

Худалдаанд суурилсан мөнгө угаалт: Энэ бол мөнгө угаах хамгийн шинэ бөгөөд төвөгтэй хэлбэрүүдийн нэг юм. Энэ арга нь мөнгөний хөдөлгөөнийг далдлахын тулд нэхэмжлэхийг дутуу эсвэл хэт өндөр үнэлдэг.

Цахим мөнгө угаах: Гэмт хэрэгтнүүд цахим худалдаа, дижитал валют, онлайн тоглоом, краудфандинг гэх мэт аргыг ашиглан хурдан, хялбар аргаар мөнгө угаадаг.

Техник, технологид суурилсан үйлчилгээнүүд гэмт хэрэгтнүүдийг цагдаад таниулж чадах санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчтэй нүүр тулан харилцахаас зайлсхийх боломжийг олгосон учраас урьдчилсан төлбөрт карт, цахим хэтэвч, цахим төлбөрийн үйлчилгээ, дижитал бүтээгдэхүүн иргэдэд санал болгоход банк бус санхүүгийн байгууллагуудын үүрэг нэмэгдэж байна²².

Харин терроризмыг санхүүжүүлэх гэдэг нь террорист үйл ажиллагаа үйлдэхээр санаархаж, төлөвлөж эсхүл оролцохоор төлөвлөж байгаа хүн, байгууллага болон бусад этгээдэд зориулан хууль ёсны болон хууль бус хөрөнгө, орлогыг хуримтлуулах, шилжүүлэх, зарцуулах үйл ажиллагаа юм²³. Мөнгө угаах үйл ажиллагаа тойрог хэлбэрээр буюу гэмт хэрэгтэнд эргээд очдог бол терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа нь шулуун хэлбэрээр буюу мөнгө нь гэмт хэрэгтэнд эргэж очихгүйгээр, зэвсэг, терроризмын үйл ажиллагаанд зарцуулагддаг.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг бол дэлхий нийтийг хамарсан үзэгдэл бөгөөд тус гэмт хэргийн хамрах хүрээг зөвхөн ойролцоогоор үнэлэх боломжтой. Зарим тооцоогоор мөнгө угаах гэмт хэргийн эргэлдэж буй мөнгө жил бүр дэлхийн ДНБ-ий 2-5 хувьтай тэнцэж байна²⁴. Европолийн мэдээлснээр Европын Холбооны улсуудад л гэхэд гэмт хэргийн ашгийн бараг 99 хувь нь хураагддаггүй²⁵ үлддэг гэсэн судалгаа бий.

Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлого нь санхүүгийн системийг санхүүгийн урсгалыг тогтворгүй болгож, санхүүгийн салбарын хямрал үүсгэх нөхцөл болж, татварын орлого цуглуулалтад нөлөөлж, төр засгийн бодлогыг сулруулж, санхүүгийн байгууллагуудын

²² See, Jean B. Weld, CURRENT INTERNATIONAL MONEY LAUNDERING TRENDS AND ANTI-MONEY LAUNDERING CO-OPERATION MEASURES, at 40. Available at: https://www.unafei.or.jp/publications/pdf/RS_No83/No83_08VE_Weld3.pdf, сүүлийн хандалт 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр.

²³ Монголбанк, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь” гарын авлага, УБ.,2020, 7 дах тал. <https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/24.pdf>, сүүлийн хандалт 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр.

²⁴ United Nations Office on Drugs and Crime, Estimating illicit financial flows resulting from drug trafficking and other transnational organized crimes, October 11, at 7. Available at: https://www.unodc.org/documents/data-and-analysis/Studies/Illicit_financial_flows_2011_web.pdf, сүүлийн хандалт 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр.

²⁵ See, European Parliament, Proposal for a regulation to fight money laundering and counter terrorist financing, at 2. Available at: [https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2021/698862/EPRS_BRI\(2021\)698862_EN.pdf](https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2021/698862/EPRS_BRI(2021)698862_EN.pdf), сүүлийн хандалт 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр.

нэр хүнд, гадаадын корреспондент банкны харилцаанд нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл мөнгө угаах нь мөнгөний эрэлтэд шалтгаангүйгээр нөлөөлж, гадаад хөрөнгийн урсгал, хүү, ханш тогтворгүй болж, эдийн засаг, санхүүгийн бодлогын арга хэрэгслийн үйлчлэл сулрах²⁶ нөхцөл болдог тул улс орнууд гэмт хэрэг болгон хуульчилдаг.

1.3. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд оролцогч болох нь, зохицуулалтын хэрэгцээ, шаардлага

ФАТФ-ын зөвлөмжийн Зөвлөмж 15-д 2018 оны 10 дугаар сард орсон өөрчлөлтөд тухайн улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо нь “виртуал хөрөнгөд” нэгэн адилаар үйлчлэхээр тогтож, ФАТФ-ын хүлээн зөвшөөрсөн нэр томъёонд “виртуал хөрөнгө” болон “виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” нарыг тодорхойлсон.

Учир нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь санхүүгийн ямар ч төрлийн хэрэгслийг ашиглан үйлдэх боломжтой бөгөөд сүүлийн хэдэн жилийн хугацаанд санхүүгийн цахим үйлчилгээ, хэрэглээ хурдацтай хөгжиж, дэлхий даяар түгээмэл хэрэглэгдэж байна. Иймд виртуал хөрөнгийн зах зээл нь мөнгө угаах гэмт хэргийг үйлдэгчид ашиглаж болох хууль ёсны эдийн засгийн гүйлгээнд ашигладаг төлбөрийн шинэ арга болоод байна. Виртуал хөрөнгийн зах зээлд маш их хэмжээний мөнгөн хөрөнгө эргэлдэх болсон. Тухайлбал, ВХҮҮТХ батлагдахаас өмнө буюу 2021 оны 11 дүгээр сарын байдлаар виртуал хөрөнгийн анхдагч зах зээлд 339 тэрбум төгрөгийн захиалга хийгдсэн бол хоёрдогч зах зээлийн эргэлтийн хөрөнгийг тодорхойлох боломжгүй байгаа ч 7-10 их наядын арилжаа хийгдсэн гэдэг таамаглалыг дэвшүүлээд байсан юм²⁷.

Криптовалютын хамгийн онцлог шинж нь хэрэглэгчийн хувийн мэдээлэл шаардлагагүйгээр хүссэн этгээд рүү шилжүүлэг хийж болдог. Криптовалютаар шилжүүлэг хийх үед банкаар дамжуулах эсвэл төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах шаардлага байдаггүй. Энэ онцлог шинж нь криптовалютыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд ашиглаж болох хамгийн тохиромжтой хэрэгсэл болгосон гэж хэлж болно. Учир нь блокчэйн технологи дээр шилжүүлэг хийж буй виртуал хаягийг тогтоох боломжтой ч шилжүүлэг хийгч, хүлээн авагчийг хэн болохыг тогтоох боломж бага байдаг²⁸.

Криптовалютын зах зээл өсөхийн хэрээр энэ төрлийн хууль бус үйл ажиллагааны арга хэрэгсэл болох магадлал улам нэмэгдэж байна. “Economist” сэтгүүл дээр нийтлэгдсэн өгүүлэлд “Биткойны зах зээл дээрх үнэ яагаад ийм өндөр байгаагийн хамгийн том шалтгаан бол түүнийг мөнгө угаах арга хэрэгсэл болгон ашиглах сонирхолтой бүлэг хүмүүс байдаг” гэж тодотгосон байдаг²⁹. Жишээ нь биткойны арилжааны 82 хувийг гүйцэтгэж байсан арилжааны цахим платформ болох Silkroad (marketplace) цахим хуудсыг АНУ-ын Холбооны мөрдөх газар (FBI)-аас хаасан үйл явдал юм. Тус пратформ мансууруулах бодисын худалдаа, захиалгат аллага гэх

²⁶ Монголбанк, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” гарын авлага, УБ.,2019, 7 дахь тал. <https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/23.pdf>, сүүлийн хандалт 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр.

²⁷ 2021.12.15-ны өдрийн Улсын Их хурлын Инновац, цахим бодлогын болон байнгын хороодын “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай” хуулийн туслийн эцсийн хэлэлцүүлэгт УИХ-ийн гишүүн Н.Учрлын хэлсэн үгээс, <https://www.toim.mn/article/2gb1ch7g>, сүүлийн хандалт 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр.

²⁸ Mehmet Ata Sarikatipoğlu, Timur Arif Çapkın, Fatma Karaalioglu, “Bitcoin: Its Regulation as a Virtual Currency and Its Position with Respect to Money Laundering”, 2015.

²⁹ М.Түвшинжаргал, “Виртуал хөрөнгийг эрх зүйн үүднээс тодорхойлох нь” Криптовалютын жишээн дээр, 14 дэх тал., Parlaktuna , 36 (2019).

мэт хэд хэдэн гэмт хэрэгтэй нэр холбогдсон юм. Тус платцорм нь 2011-2013 оны хооронд хууль бус үйл ажиллагаас 9.5 сая ширхэг 1.2 тэрбум долларын үнэлгээ бүхий биткойныг ашигласан нь тогтоогдсон³⁰.

Иймд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх харилцаанд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг оролцуулж, хуулиар зохицуулах нь зайлшгүй байгаа тул ФАТФ-ын зөвлөмжид зааснаар улс орнууд дотоодын эрх зүйгээрээ зохицуулж эхлээд байна.

2. МОНГОЛ УЛС ДАХЬ ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Монгол Улсын хуулиуд дахь зохицуулалт

ВХҮҮТХ нь ФАТФ-аас гаргасан зөвлөмж 15-н хэрэгжилтийг ханган Монгол Улсыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс сэргийлэх харилцан үнэлгээнд эрсдэлтэй орны тоонд оруулах эрсдэлээс хамгаалах зорилготой тухай тус хуулийн танилцуулгад³¹ дурдсан байдаг. Тиймээс тус хуульд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой дараах үүргийг хүлээлгэсэн. Үүнд:

- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлэх хүсэлт гаргагч нь МУБТСТХ, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах тогтолцоо, автомат хяналтын системтэй байх /ВХҮҮТХ 7.1.6/;
- Тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологитой холбоотой мөнгөх угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийсэн байх /ВХҮҮТХ 7.1.8/;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх /ВХҮҮТХ 7.1.9/;
- Мөнгө угаах, мөнгө угаах гэмт хэрэгт холбогдуулан шалгагдсан бусад гэмт хэрэг, терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдоогүй байх /ВХҮҮТХ 7.1.6/;

Монгол Улсад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг 2013 оны Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар зохицуулж байна. 2021 оны ВХҮҮТХ батлагдсантай холбогдуулан тус хуульд дараах агуулга бүхий нэмэлт өөчлөлт орсон. Үүнд:

- Мэдээлэх үүрэгтэй этгээдээр “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч”-ийг нэмсэн. Улмаар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь тус хуульд заасан үүргийг хүлээсэн /МУБТСТХ 4.1.10/;
- Мөн хуулийн мэдээлэх үүрэгтэй этгээдүүд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй виртуал хөрөнгийн гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэг хүлээсэн /МУБТСТХ 7.1/;

³⁰ Мөн тэнд,

³¹ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөл, төслийн үзэл баримтлалаас. <https://mojha.gov.mn/wp-content/uploads/2021/01/VASP-%D1%82%D0%B0%D0%BD%D0%B8%D0%BB%D1%86%D1%83%D1%83%D0%BB%D0%B3%D0%B0.pdf>, сүүлийн хандалт 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр.

- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тус хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлнэ /МУБТСТТХ 19.1/.

Дээрх хуулийн зохицуулалтуудаас үзвэл Монгол Улсад виртуал хөрөнгийн үйл ажиллагаа явуулах виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь МУБТСТТХ-д заасан мэдээлэх үүрэгтэй бусад этгээд болох банк, банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын адилаар мэдээлэх үүрэг хүлээсэн этгээд болж хуульд заасан гүйлгээний талаар мэдээлэх, харилцагчийг таньж мэдэх, тусгай хяналт тавих, нэргүй, дугаарласан, эсхүл хуурамч нэрээр данс нээх, гүйлгээ хийх, хаагдсан данс ашиглахгүй байх зэрэг үүргийг хүлээж байна.

Одоогоор Санхүүгийн зохицуулах хороонд албан ёсоор бүртгэгдсэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч байхгүй байгаа тул дээрх зохицуулалтууд нь практикт хэрэгжиж эхлээгүй байна.

2.2. Холбогдох дүрэм журмууд дахь зохицуулалт

МУБТСТТХ-д заасан мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэхтэй холбоотой үйл ажиллагаа, үүргийг Монгол Банкны Ерөнхийлөгчийн 2019 оны А/26 дугаар тушаалаар баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-аар нарийвчлан зохицуулж байна. Тодруулбал, тус журамд эрсдэлийн үнэлгээ, харилцагчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг тогтоох, улс төрд нөлөө бүхий этгээдийн гүйлгээнд тусгайлан хяналт тавих, харилцагчийг таньж мэдэх ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх, корреспондент харилцаа, шинэ технологи, мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналтын хөтөлбөр, цахим шилжүүлэг, материалыг хадгалах, гүйлгээг мэдээлэх зэрэг харилцааг журамласан. Мэдээлэх үүрэгтэй этгээд хуульд заасан үүргийг биелүүлэхдээ тус журмаар нарийвчлан зохицуулсан зохицуулалтыг баримтлах үүрэгтэй.

Мэдээлэх үүрэг бүхий этгээдийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч тус журмын зохицуулалт харилцан адилгүй үйлчилдэг. Тухайлбал, банк, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани зэрэг МУБТСТТХ-ийн 4.1.1-4.1.6-д заасан 6 этгээд нь тус журмыг бүхэлд нь дагаж мөрдөх үүрэг хүлээдэг бол 4.1.7-4.1.9-д заасан үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага зэрэг 3 этгээд нь корреспондент харилцаа, цахим шилжүүлэгтэй холбоотой зохицуулалтаас бусад хэсгийн заалтыг дагаж мөрдөх үүргийг хүлээдэг.

“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгч 2019 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр баталсан тул одоогоор тус журамд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой зохицуулалт оруулаагүй байна.

3. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

3.1. Европын холбоо (“ЕХ”)

ЕХ нь 1990-ээд оны эхэн үеэс ФАТФ-ын зөвлөмжүүдэд тулгуурлан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх цогц хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Гэсэн хэдий ч сүүлийн үед технологийн дэвшил, шинээр гарч ирж буй гэмт хэргийн хэв маягийг өмнөх хууль эрх зүй, тогтолцоо гүйцэхгүй байсан юм. Энэ төрлийн хөгжлийн нэг нь виртуал хөрөнгийг

(тухайлбал, биткойн) мөнгө угаах зорилгоор ашиглах нь нэмэгдэж, түүгээр ч зогсохгүй ЕХ-ны хэмжээнд олны анхаарлыг татсан мөнгө угаахтай холбоотой хэд хэдэн дуулианууд гарсан нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, түүнтэй тэмцэх одоогийн тогтолцоо нь дутагдалтай байгааг илтгэсэн³² юм. Үүнтэй холбогдуулан Европын Комисс, Европын Парламент зэрэг байгууллагууд тогтолцоог шинэчлэхийг уриалсны дагуу 2021 оны 7 дугаар сарын 20-ны өдөр Европын Комиссоос хууль тогтоомжийн багцыг³³ танилцуулсан. Тус хууль тогтоомжийн багцад санхүүгийн системийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд ашиглахаас урьдчилан сэргийлэх зохицуулалтыг тусгажээ.

Тус хууль тогтоомжийн багцад орсон гол зохицуулалтууд нь ФАТФ-ын зөвлөмжид үндэслэсэн бөгөөд нэргүй данс, нэргүй сейф болон нэргүй виртуал хөрөнгийн хэтэвчийг бүрмөсөн хориглохын зэрэгцээ 10 000 еврогоос дээш гүйлгээг зохицуулагч байгууллагад мэдэгдэх үүрэгтэй байдлаар зохицуулсан. Гишүүн орнууд 10 000 еврогоос доош гүйлгээг мэдэгдэх үүрэгтэй байдлаар зохицуулах эрхтэй болохыг мөн дурджээ³⁴.

3.2. *Норвеги*

2018 онд Норвегийн мөнгө угаахтай тэмцэх шинэ журам батлагдсанаар виртуал хөрөнгө солилцох, хадгалах үйлчилгээ үзүүлэгчид Норвегийн Мөнгө угаахтай тэмцэх тухай хуулийн хамрах хүрээнд багтсан.²⁸ Норвегийн Мөнгө угаахтай тэмцэх журмын 1-3 дугаар хэсэгт “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ нь Мөнгө угаахтай тэмцэх тухай хуульд заасан үйлчилгээ болон виртуал хөрөнгө хадгалах, бусад байдлаар үйлчилгээ үзүүлэгчдэд шууд хэрэглэнэ”³⁵ гэсэн байдаг.

§ 4-9. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй - харилцагчийн арга хэмжээг чангатгасан.

Тус журмын 4-9 дэх хэсэгт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдлийн үнэлгээний шалгууруудыг дурдсан байх бөгөөд дараах хүчин зүйлсүүд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өндөр байгааг илтгэнэ гэжээ. Үүнд:

- a. Үйлчлүүлэгчийн төрөлтэй холбоотой эрсдэлт хүчин зүйлүүд: үйлчлүүлэгчтэй харилцахтай холбоотой онцгой нөхцөл байдал үүссэн, үйлчлүүлэгчид өндөр эрсдэлтэй гэж үзсэн газарт оршин суудаг, хувийн хөрөнгийн менежментийн компанитай, бэлэн мөнгөнд суурилсан бизнес, болон бизнесийн шинж чанарт үндэслэн өмчлөлийн бүтэц нарийн төвөгтэй компанитай.
- b. Бүтээгдэхүүний төрөл, гүйлгээ, үйлчилгээ, хүргэх сувагтай холбоотой эрсдэлт хүчин зүйлүүд: хувийн банк, нэрээ нууцлах боломжтой бүтээгдэхүүн, гүйлгээ, цахим гарын үсэг зэрэг баталгаажуулалт ашиглахгүйгээр хувийн оролцоогүй гүйцэтгэх боломжтой

³² See, European Parliament, Proposal for a regulation to fight money laundering and counter terrorist financing, at 2. Available at: [https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2021/698862/EPRS_BRI\(2021\)698862_EN.pdf](https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2021/698862/EPRS_BRI(2021)698862_EN.pdf), сүүлийн хандалт 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр.

³³ Anti-money Laundering Package /Анг./

³⁴ See, European Parliament, Proposal for a regulation to fight money laundering and counter terrorist financing, at 6. Available at: [https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2021/698862/EPRS_BRI\(2021\)698862_EN.pdf](https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2021/698862/EPRS_BRI(2021)698862_EN.pdf), сүүлийн хандалт 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр.

³⁵ Regulation on Measures on Money Laundering and Financing of Terrorism (Money Laundering Regulation), Oct. 15, 2018, https://lovdata.no/dokument/SF/forskrift/2018-09-14-1324/KAPIT-TEL_2#KAPITTEL_2, сүүлийн хандалт 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр.

харилцаа, гүйлгээ, үл мэдэгдэх гуравдагч этгээдийн төлбөр, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, одоо байгаа бүтээгдэхүүнийг хөгжүүлэх шинэ технологийг ашиглах.

- с. Газарзүйн эрсдэлт хүчин зүйлс: мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар хангалттай, үр дүнтэй арга хэмжээ авдаггүй гэж тодорхойлогдсон улс орнууд, авлига болон бусад гэмт хэргийн гаралт ихтэй улс орнууд, НҮБ болон ЕХ-ны хориг арга хэмжээ, хориг, түүнтэй адилтгах арга хэмжээ авсан улс орнууд, террорист үйл ажиллагааг санхүүжүүлдэг, дэмжигч эсвэл тус улсад террорист байгууллага үйл ажиллагаа явуулдаг улс.³⁶

Эрсдэл өндөртэй гэж үзвэл үйлчлүүлэгч болон эцсийн өмчлөгчийн талаар нэмэлт мэдээлэл авах, харилцагчийн гүйлгээний зорилго, зорилгын шинж чанарын талаар нэмэлт мэдээлэл авах зэрэг арга хэмжээ авах боломжтой байдаг.

4. ДҮГНЭЛТ, САНАЛ

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж буй технологид суурилсан, зайнаас хэрэгжүүлэх боломжтой санхүүгийн үйлчилгээнүүд тэр тусмаа виртуал хөрөнгийн үйлчилгээнд тулгуурлан явагдах нь нэмэгдсэн тул мөнгө угаах, терроризмтай тэмцэх үйл ажиллагаа, тогтолцоо ч мөн виртуал хөрөнгийн үйлчилгээг хамрах шаардлага зүй ёсоор гарч ирсэн. Тиймээс ч ФАТФ-ын зүгээс виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх зүйн байдлыг тодорхойлж, үйл ажиллагааг нь хуулиар зохицуулах үүрэг хүлээлгэсэнээс гадна мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх харилцаанд хамруулах шаардлагатай гэж үзсэн. Үүний дагуу Монгол Улс төдийгүй бусад улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой асуудлыг зохицуулсан хууль болон бусад холбогдох дүрэм журмууддаа нэмэлт, өөрчлөлт оруулж виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид холбогдох шаардлага тавьж, үүрэг хүлээлгэсэн. Монгол Улс Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль баталж холбогдох 10 гаруй хуулиудад³⁷ нэмэлт, өөрчлөлт оруулсан нь ФАТФ-ын зөвлөмж болон бусад улс орны жишигт тулгуурласан шинэчлэл болсон байна.

Хэдий тийм боловч тус харилцааг нарийвчлан зохицуулах журмуудыг хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн батлах, хууль болон тус журмуудын хэрэгжилтэд онцгой анхаарах нь чухал байна. Иймд, уг дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. ВХҮҮ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх харилцааны оролцогч тул “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-д нэмэлт, өөрчлөлтийг оруулж, ВХҮҮ-ийн зохицуулалтыг тусгах;
2. Ийнхүү нарийвчлан зохицуулахдаа виртуал хөрөнгийн зах зээл, уг зах зээлийн хэрэглэгч, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны онцлог, блокчэйн технологийн онцлогийг харгалзаж, харилцагчийг таньж мэдэх, шинэ технологи, цахим шилжүүлэгтэй холбоотой зохицуулалтыг ялгаатай зохицуулах.

³⁶ Forskrift om tiltak mot hvitvasking og terrorfinansiering (hvitvaskingsforskriften), https://lovdata.no/dokument/SF/forskrift/2018-09-14-1324/KAPIT-%20TEL_2#KAPITTEL_2

³⁷ Тус хууль батлагдсанаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль зэрэг 10 хуульд холбогдох нэмэлт өөрчлөлт орсон. /М.М; Б.М/



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА
МОНГОЛБАНК

**КОВИД-19 ЦАР ТАХАЛТАЙ ХОЛБООТОЙГООР
ҮҮССЭН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРСДЭЛ**

А.Бат³⁸, Б.Намуунаа³⁹, Т.Цолмон⁴⁰

³⁸ Санхүү эдийн засгийн их сургууль, Эдийн засгийн тэнхим, IV курсын оюутан. Цахим хаяг: B18FA1507@ufe.edu.mn

³⁹ Санхүү эдийн засгийн их сургууль, Эдийн засгийн тэнхим, IV курсын оюутан. Цахим хаяг: B18FA1517@ufe.edu.mn

⁴⁰ Санхүү эдийн засгийн их сургууль, Эдийн засгийн тэнхим, IV курсын оюутан. Цахим хаяг: B17FA1462@ufe.edu.mn

1. ОРШИЛ

1.1. Судалгааны асуудал

АНУ-ын ихэр цамхаг руу халдлага хийсэн 9-р сарын 11-ний үйл явдлын дараа мөнгө угаах гэмт хэрэг нь дэлхий нийтийн хувьд улам бүр чухал асуудал болсон юм. Үүнээс хойш дэлхий даяар мөнгө угаах асуудалд анхаарал хандуулж, энэ нь терроризмыг санхүүжүүлэх эх үүсвэр болохыг хүлээн зөвшөөрчээ. Даяаршлын үйл явц, харилцаа холбооны хувьсгал, түүнчлэн дэлхий дахиныг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр энэхүү гэмт хэрэг улам олон улсыг хамрах болж, технологийн дэвшлийн улмаас мөнгө угаах гэмт хэрэг илүү төвөгтэй болж байна. Олон улсын банкнууд дэлхийн даяар тархсан байдаг нь мөнгөн хөрөнгийн гарал үүслийг нуун дарагдуулж, шилжүүлэхэд илүү дөхөм болгож байгаа юм. Энэхүү үзэгдэл нь хөгжингүй, хөгжиж буй гээд том, жижиг аль ч орны аюулгүй байдалд заналхийлж, нийгэм эдийн засгийн асар том сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй юм. Мөнгө угаах нь хар тамхины наймаачид, террористууд, хууль бус зэвсгийн наймаачид, авлигалд идэгдсэн төрийн албан хаагчид гэх мэтчилэн бүх төрлийн гэмт хэрэгтнүүдийг гэмт хэргийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжоор хангадаг. Цаашилбал, мөнгө угаах нь нөөцийг эдийн засгийн бүтээмж багатай салбар руу чиглүүлж, улмаар эдийн засгийн өсөлтийг бууруулдаг. Мөнгө угаах гэмт хэргийн улмаас учирч болзошгүй нийгэм, улс төрийн хохирлыг тоолгүй орхих, эсвэл үр ашиггүй шийдвэрлэх нь тун ноцтой асуудал юм. Түүнчлэн гэмт хэргийн байгууллауудын эдийн засаг, улс төрийн нөлөө нь нийгмийн бүтэц, хамтын ёс зүйн хэм хэмжээ, цаашлаад нийгмийн ардчилсан институцийг ч сулруулж болзошгүй юм.

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр засгийн газрууд татварын хөнгөлөлтөөс эхлээд нислэгийн хориг хүртэл олон төрлийн бодлого авч хэрэгжүүлж байгаа билээ. Гэсэн хэдий ч эдгээр бодлого нь нөгөө талаас гэмт хэрэгтнүүд болон террористуудад мөнгө угаах шинэ боломж, арга зам үүсгэж байж болзошгүй юм. Хэдийгээр улс бүрийн Ковид-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй эрүүл мэндийн хариу арга хэмжээ нь ялгаатай боловч тэдгээр нь ерөнхий тохиолдолд дараах байдлаар тодорхойлогдож байна.

- Засгийн газар, бизнес эрхлэгчид болон хувь хүмүүс зайнаас ажиллахын тулд онлайн системд хандах хандалт нэмэгдсээр байна. "Хөл хорио" (эсвэл хөдөлгөөнийг хязгаарлах бусад арга хэмжээ)-д байгаа хүмүүс нийгмийн харилцаанд орохын тулд онлайн платформ руу ихээр хандсаар байна.
- Нэн шаардлагатай бус аж ахуйн нэгжүүдийг биечлэн үйл ажиллагаа явуулахыг хориглосон ба нэн шаардлагатай болон шаардлагатай бус бизнесүүдийн аль аль нь онлайн борлуулалтаа нэмэгдүүлжээ.
- Ковид-19 цар тахал нь хувийн хамгаалах хэрэгсэл, агааржуулагч, эм зэрэг эмнэлгийн хэрэгслийн ихээхэн эрэлт хэрэгцээг бий болгож дэлхийн хэмжээнд энэ төрлийн барааны хомстол үүсч байв.
- Банк, санхүүгийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулсаар байгаа бөгөөд зарим нь илүү хязгаарлагдмал үйлчилгээ үзүүлж, биечлэн харилцах үйлчилгээг хязгаарлаж байв.
- "Хөл хорио" болон бусад хязгаарлалтын улмаас худалдаа, аялал жуулчлалын олон бизнесийг хаасан нь олныг хамарсан ажилгүйдэл, цомхтголд хүргэж ингэснээр засгийн газрын орлого буурч, эдийн засаг уналтад орсон нь бизнес эрхлэгчид болон хувь хүмүүсийн санхүүгийн болон нийгмийн үйл хөдлөлд нөлөөлж байна.

- Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авахын тулд засгийн газар нөөц хуваарилалтыг дахин эрэмбэлэн, бусад салбарт зарцуулах нөөцийг багасгаж байв.
- Ковид-19 цар тахлын нөлөөгөөр олон улсын худалдаа буурч, аялал зогсонги байдалд ороод байгаа нь дэлхийн нийлүүлэлтийн гинжин хэлхээг ашигладаг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлийн уламжлалт хууль бус орлогын схемүүдэд нөлөөлж байна.

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дэлхий даяар бүх төрлийн үйл ажиллагаа цахимжиж байгаа нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг кибер хэлбэр рүү эрчимтэй шилжихэд нөлөөлж байна. Түүнчлэн хөгжингүй орнууд болон олон улсын байгууллагуудаас хөгжиж буй орнуудын цар тахлын хохирлын хэмжээг багасгах, тэдний эмзэг байдлыг бууруулах зорилгоор өгч буй мөнгөн болон эд материалын тусламжийг зүй бусаар зарцуулах, цаашилбал мөнгө угаах зорилгоор ашиглах нөхцөл бүрдэж байв. Ийнхүү Ковид-19 цар тахлаас үүдэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг арга зүй, хэлбэрийн хувьд өөрчлөгдөж буй нь бидний судалгааны ажлын асуудал болж байгаа юм.

1.2. Судалгааны асуултууд

Судалгааны асуудлын хүрээнд дараах асуултуудыг дэвшүүлж байна.

- Ковид-19 цар тахал мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн гаралт өсөхөд нөлөөлсөн үү?
- Ковид-19 цар тахлын үед мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь ямар шинэ сувгаар хийгдэж, мөн ямар хэв маягтай болсон бэ?
- Ковид-19 цар тахлын үед мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг гарах эрсдэлийг хэрхэн бууруулах вэ?

1.3. Судалгааны зорилго

Энэхүү судалгааны ажлаар бид Ковид-19 цар тахлын үед мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн эрсдэл хэрхэн өөрчлөгдсөн болохыг судалгааны үр дүнд тулгуурлан тодорхойлж, энэхүү эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах бодлого, зөвлөмжийг олон улсын туршлага дээр суурилан санал болгохыг зорилоо. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ.

1.4. Судалгааны зорилт

Судалгааны ажлын зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно.

1. Ковид-19 цар тахлын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн гаралтад үзүүлсэн нөлөөллийг судлах;
2. Ковид-19 цар тахлын үеийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг үйлдэгдсэн арга зам, хэв маягийг тодорхойлох;
3. Ковид-19 цар тахлын үеийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг гарах эрсдэлийг бууруулах санал, зөвлөмж боловсруулах.

1.5. Судалгааны таамаглал

Судалгааны ажлын хүрээнд дараах таамаглалуудыг дэвшүүлж байна.

1. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн гаралт өссөн.
2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг цар тахлын үед кибер хэлбэрээр үйлдэгдэх нь нэмэгдсэн.

2. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

2.1. Судлагдсан байдал

Мөнгө угаах гэмт хэрэг нь үндэстнүүдийн засгийн газар, цаашлаад үндэсний эдийн засагт ноцтой аюул учруулж байна. Улс орнуудын албан ёсны санхүүгийн салбар, үндэсний тооцоонд бохир мөнгө орж ирснээр тухайн улсын эдийн засаг, улс төрийн тогтвортой байдал заналхийлдэг. Энэ төрлийн эдийн засгийн гэмт хэрэг нь бусад төрлийн гэмт хэргийг бодвол хамаагүй өргөн цар хүрээг хамардаг, шууд болон дам хохирогчид олонтой байдаг. Жишээлбэл, эдгээр нь татвараас зайлсхийснээр засгийн газрын татварын орлого алдагдаж, засгийн газраас хөгжлийн хөтөлбөрт зарцуулах төсөвт нөлөөлснөөр засгийн газрын энэ төрлийн хөтөлбөрөөс ашиг хүртэх байсан хүн амын дийлэнх хэсэгт нөлөөлөх юм (Blog, 2020). Мөнгө угаах гэмт хэргийн эдийн засгийн хөгжилд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тооцоход хэцүү ч уг үйл ажиллагаа нь эдийн засгийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг санхүүгийн салбарт хохирол учруулж, эх үүсвэрийг өөр тийш нь чиглүүлж, гэмт хэрэг, авилгыг хөхүүлэн дэмжих замаар эдийн засгийн бодит секторын бүтээмжийг бууруулах нь ойлгомжтой. Энэ нь эдийн засгийн өсөлтийг удаашруулж, эдийн засгийн гадаад секторын олон улсын худалдаа, хөрөнгийн урсгалыг гажуудуулж, урт хугацааны эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлдөг (John McDowell, 2001).

(Masciandaro, 1998) болон (Masciandaro D. a., 2003) ажлуудад мөнгө угаалтын эсрэг хууль тогтоомжийг дотоодын болон олон улсын банкны үр ашигт сөргөөр нөлөөлдөг тул өндөр өртөгтэй гэж тооцжээ. (Huang, 2015) ажлаар АНУ-д мөрдөгдөж буй мөнгө угаалтын эсрэг хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийн үндэс суурь болж буй шалтгаануудын талаар макро түвшний шинжилгээ хийжээ. Судалгаагаар АНУ-ын мөнгө угаалтын эсрэг дэглэмийн банкны салбар дахь үр нөлөөг судалсан бөгөөд мөнгө угаалтын эсрэг хууль тогтоомжийг дагаж мөрдөх, зөрчихөөс болгоомжлох нь нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байгааг ажигласан байна.

(John McDowell, 2001) ажлаар мөнгө угаахтай холбоотой гарах эдийн засаг, нийгмийн хохирлыг авч үзжээ. Энд дурдагдсан мөнгө угаах гэмт хэргийн эдийн засгийн үр дагаврыг дурдвал: (1) хууль ёсны хувийн хэвшлийг доройтуулах, (2) санхүүгийн маркеруудын нэгдмэл байдлыг алдагдуулах, (3) эдийн засгийн бодлогыг хянах чадвараа алдах, (4) эдийн засгийн гажуудал ба тогтворгүй байдал, (5) орлогын алдагдал, (6) хувьчлалын хүчин чармайлтын эрсдэл, (7) нэр хүндийн эрсдэл зэрэг юм. Мөнгө угаах гэмт хэргийн нийгмийн хохирол нь хар тамхины наймаачид, хууль бус наймаачид болон бусад гэмт хэрэгтнүүдэд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, эдийн засгийн эрх мэдлийг зах зээл, төр, иргэдээс гэмт хэрэгтнүүдэд шилжүүлэх боломжийг олгодог. Энэ нь даамжирвал хууль ёсны засгийн газрыг ч булаан авахад хүргэдэг.

Иймээс мөнгө угаах гэмт хэрэг нь дэлхий нийтийн анхаарал татсан асуудал болоод байгаа төдийгүй мөнгө угаах гэмт хэргийг бууруулахын тулд хууль тогтоомж, түүний хяналтыг сайжруулах, олон улсын хамтын ажиллагааг үр дүнтэй явуулах нь нэн чухал болоод байна.

(FATF, 2020) нь ФАТФ-ын гишүүд болон бүс нутгийг байгууллагуудтай 2020 оны 4-р сарын 7-ноос 23-ны хооронд хуваалцсан баримт бичигт үндэслэн COVID-19 хямралаас үүдэлтэй мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх шинэ аюул заналхийлэл, эмзэг байдалд тулгарч буй сорилт, сайн туршлага, бодлогын хариу арга хэмжээг тодорхойлсон юм. Энэхүү тайлангийн гол үр дүнгээс дурдвал:

- Залилан, кибер гэмт хэрэг, цаашлаад засгийн газрын сан, олон улсын санхүүгийн тусламжийг буруугаар ашиглах, мөлжих зэрэг COVID-19-тэй холбоотой гэмт хэрэг нэмэгдэж байгаа нь хууль бус этгээдүүдэд орлогын шинэ эх үүсвэрийг бий болгож байна.
- Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх арга хэмжээ нь эрүүгийн эдийн засагт нөлөөлж, гэмт хэргийн үйл хөдлөлийг өөрчилснөөр ашиг хонжоо хайсан гэмт хэрэгтнүүд хууль бус үйлдлийн бусад хэлбэрт шилжиж болзошгүй.
- COVID-19 тахал нь засгийн газар болон хувийн хэвшлийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналт, зохицуулалт, бодлогын шинэчлэлээс эхлээд сэжигтэй гүйлгээний тайлан, олон улсын хамтын ажиллагаа зэрэг үүргээ хэрэгжүүлэх чадамжид мөн нөлөөлж байна.

Эдгээр аюул заналхийлэл, эмзэг байдал нь шинээр гарч ирж буй мөнгө угаах (ML) болон терроризмыг санхүүжүүлэх (TF) эрсдэлүүдийг илэрхийлэх бөгөөд ийм эрсдэл нь дараах үр дагаварт хүргэж болзошгүй юм.

- Хууль бус хөрөнгийг шилжүүлэх, нуун дарагдуулах зорилгоор онлайн санхүүгийн үйлчилгээ болон виртуал хөрөнгийг зүй бусаар ашиглах явдал нэмэгдсэн;
- Эдийн засгийг эрчимжүүлэх арга хэмжээ, төлбөрийн чадваргүй байдлын схемийг хувь хүн, хуулийн этгээдийн хууль бус орлогоо нуун дарагдуулах, угаах хэрэгсэл болгон ашиглах;
- Зохицуулалтгүй санхүүгийн салбарын хэрэглээ нэмэгдэж, гэмт хэрэгтнүүдэд хууль бус мөнгө угаах нэмэлт боломжийг бий болгох;
- Дотоод, гадаадын санхүүгийн тусламж, яаралтай тусламжийн санхүүжилтийг зориулалтын бусаар ашиглах, зарцуулах;
- Гэмт хэрэгтнүүд, террористууд хөгжиж буй орнуудад бэлэн мөнгө их шаарддаг, хөрвөх чадвар өндөртэй бизнесийн шинэ салбар руу шилжихийн тулд Ковид-19-ийг болон үүнтэй холбоотой эдийн засгийн уналтыг ашиглаж байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт авах бодлогын хариу арга хэмжээ нь шинэ эрсдэл, эмзэг байдлыг удирдахын зэрэгцээ Ковид-19-д авах хариу арга хэмжээг хурдан бөгөөд үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой. Үүнд:

- COVID-19-ийн үеийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл ба тогтолцооны нөлөөллийг үнэлэх дотоодын зохицуулалт;
- Хувийн хэвшлийнхэнтэй харилцах харилцааг бэхжүүлэх;
- Цахим болон тоон төлбөрийн сонголтуудыг дэмжих.

Ковид-19 цар тахал гэмт хэрэгтнүүд хэр хурдан шинэ төрлийн луйвар санаачилж, эсвэл хуучин гэмт хэргийн арга хэлбэрээ өөрчилдөг болохыг харууллаа. Ковид-19 цар тахлын үед гэмт хэрэгтнүүд хуурамч, стандартын бус буюу зөвшөөрөлгүй эм, вакцин, ариутгалын бодис, ариутгагч бодис, нүүрний маск зэрэг голдуу худалдан авалтын луйвар хийв. Хуурамчаар үйлдэх нь үндэстэн дамнасан хамгийн том гэмт хэрэг бөгөөд Дэлхийн Санхүүгийн Нэгдлийн тооцоолж буйгаар энэ нь 1 триллион ам доллартай тэнцэх хэмжээтэй байдаг аж. Энэ гэмт хэрэг мөнгө угаах гэмт хэргийн хувьд хууль бус хар тамхи, хүний наймаа, цахим гэмт хэргээс ч том урьдач нөхцөл болдог байна.

Ковид-19 тахлын үеийн хөл хорио болон хүмүүсийн интернет ашиглалт өссөнтэй холбоотойгоор гэмт хэрэгтнүүдийн залилан хийх арга замаа өөрчилж, хүмүүсийг хорионд орсон, ганцаардсан үед санхүүгийн эмзэг байдлыг нь ашиглан цалингийн зээл болон бүх төрлийн зээлийн залилан хийх болжээ. Мөн олон нийтийн өгөөмөр сэтгэлийг ашиглан хуурамч хандивын сан цуглуулж, залилах гэмт хэрэг ч гарах болов. Гэмт хэрэгтнүүд тахлын үед засгийн газрын тусламжийн багц, өвчний тархалтын зураглал болон хамгаалах хэрэгслийн худалдаа зэрэг хуурамч интернет холбоосууд ашиглан кибер гэмт хэрэг хийж байна. Мөн ФАТФ-ын мэдээлж буйгаар тахлын үед хүний наймаа, ажилчдын мөлжлөг болон хүүхдийн цахим мөлжлөг нэмэгджээ (Blog, 2020).

2020 оны 5-р сард Бахрайн улсын төв банк Ковид-19 цар тахлын үеийн мөнгө угаалт болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл хэмээх судалгааг хийсэн байна. Судалгааны асуудал нь олон улсад Ковид-19 цар тахал гарснаар санхүүгийн луйвар, мөлжлөгийн луйвар, тухайлбал хуурамч эм зарах, худалдах, хөрөнгө оруулалтын залилан хийх, вирустай холбоотой айдсыг золиослох фишинг схемд оролцуулах зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

2.2. ФАТФ-ын 2018-2021 оны тайлангийн үр дүн

Энэхүү хэсэгт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн Ковид-19 цар тахлын өмнөх ба дараах нөхцөл байдлыг харьцуулан судлах зорилгоор FATF буюу “Санхүүгийн Үйл Ажиллагааны Ажлын Хэсэг”-ийн 2018-2021 оны тайлангуудад харьцуулалт хийж, гол үр дүнгүүдийг тайлбарлан, хоорондын ялгааг нэгтгэн дүгнэлээ.

2.2.1. 2018 - 2019 оны ФАТФ-ын тайлан

ФАТФ виртуал хөрөнгөөр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй тэмцэхэд ихээхэн ахиц дэвшил гаргасан. G20-ийн дэмжлэгтэйгээр виртуал хөрөнгийг гэмт хэрэг, терроризмд зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх дэлхийн шинэ стандартуудыг тогтоосон ба эдгээр шинэ шаардлагыг улс орнуудад хэрэгжүүлэхэд нь туслах зааварчилгааг боловсруулсан юм. Эдгээр удирдамжаас гадна ФАТФ нь мөн салбарын эрсдэлд суурилсан арга барилын удирдамжийн таван баримт бичгийг нийтэлсэн. Энэ онд ФАТФ үй олноор хөнөөх зэвсгийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартыг бэхжүүлэх ажлыг эхлүүлсэн. Энэхүү ажил нь ФАТФ-ын шаардлагуудыг зөвхөн хориг арга хэмжээ авахаас давж, үй олноор хөнөөх зэвсгийг түгээн дэлгэрүүлэхтэй тэмцэхэд илүү өргөн хүрээтэй урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах боломжтой болгоно. ФАТФ нь хувийн хэвшлийн зөвлөлдөх форум, жил бүр зохион байгуулдаг Финтек, Регтек форумаар дамжуулан ФАТФ-ын хийж буй ажлын талаар тэдний санал бодлыг авах зорилгоор хувийн хэвшилтэй хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэв.

2.2.2. 2019 - 2020 оны ФАТФ-ын тайлан

Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд КОВИД-19 цар тахлын үзүүлсэн нөлөө

КОВИД-19 тахал нь дэлхий даяар олон хүний аминд хүрч, урьд өмнө хэзээ ч байгаагүй дэлхийн хэмжээний сорилт, хүн төрөлхтний зовлон зүдгүүр, эдийн засгийн хямралд хүргэсэн билээ. Дэлхий даяар засгийн газрууд хөл хорио болон аялал жуулчлалын хязгаарлалтыг нэвтрүүлснээр өдөр тутмын амьдрал эрс өөрчлөгдсөн. Энэ нь хувь хүн, аж ахуйн нэгж, засгийн газар, олон улсын байгууллагад шууд нөлөөлсөн ба ФАТФ болон түүний дэлхийн сүлжээний үндсэн ажлын урсгалд ихээхэн нөлөө үзүүлсэн. Эрсдэл өндөртэй улсуудын харилцан үнэлгээ, хяналтын тайлан, тойм хийх хуваарь, түүнчлэн олон хурал, арга хэмжээг цуцлах, хойшлуулах зэрэг саатал гарсан. Гэсэн хэдий ч эдгээр хүнд хэцүү нөхцөл байдлыг үл харгалзан ФАТФ чухал ажлаа үргэлжлүүлэн ахиулах, гишүүдийнхээ биечлэн уулзах саадыг даван туулах шинэ арга замыг олсон юм.

Гэмт хэрэгтнүүд засгийн газрын тусламжийг буруугаар ашиглахаас эхлээд хуурамч эмнэлгийн хэрэгсэл зарах хүртэл энэхүү хямралыг ашиглах арга замыг яаралтай хайж байна. Гишүүд болон ажиглагчдын тусламжтайгаар ФАТФ хямралд хурдан хариу арга хэмжээ авснаар дасан зохицох чадвар, тэсвэр хатуужилтай гэдгээ харуулсан. ФАТФ-ын ерөнхийлөгчийн мэдэгдэлд засгийн газар болон санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагаа шаардлагатай байгааг онцолжээ. Дараачийн баримт бичигт КОВИД-19-тэй холбоотой аюул заналхийлэл, эмзэг байдал, түүний дэлхийн хэмжээний ML/CFT хэрэгжилтэд үзүүлэх нөлөө, үндэсний бодлогын янз бүрийн арга хэмжээний талаар дурджээ. Уг баримт бичиг нийтлэгдсэний дараа ФАТФ-ын нарийн бичгийн дарга нарын газар энэхүү баримт бичгийн үр дүнг онцолж, асуултад хариулахын тулд вебинар зохион байгуулав.

Ерөнхийлөгчийн мэдэгдэлд засгийн газрууд санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж, ФАТФ-ын эрсдэлд суурилсан арга барилд суурилагдсан уян хатан байдлыг ашиглан КОВИД-19-ээс үүдэлтэй сорилтуудыг шийдвэрлэхийн зэрэгцээ шинээр гарч ирж буй эрсдэлүүдээс сэрэмжтэй байхыг уриалж байна. Тухайн үед хөл хоригийн өргөн хүрээтэй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн тул уг мэдэгдэлд ФАТФ-ын стандартын дагуу дижитал хэрэглэгчдийг элсүүлэх хэрэгслийг ашиглах, дижитал санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг дэмжсэн.

Цар тахалтай холбоотой мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл ба бодлогын хариу арга хэмжээний тухай ФАТФ-ын баримт бичигт COVID-19-ийн хямралаас үүдэн орлого олдог гэмт хэргийн дэлгэрэнгүй тоймыг багтаасан болно. Эдгээр гэмт хэргүүдээс хамгийн түгээмэл нь залилангийн гэмт хэрэг, цахим гэмт хэрэг юм. Тухайлбал, цар тахал эхэлснээс хойш албан тушаалтны дүр эсгэх, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийг хуурамчаар үйлдэх зэрэг залилангийн гэмт хэрэг эрс нэмэгджээ. Мөн хямралын энэ үед гэмт хэрэгтэн, авлигач албан тушаалтнууд мөнгө завшихыг эрмэлзэж байгаа тул дотоодын эдийн засгийг эрчимжүүлэх арга хэмжээний зарцуулалт, санхүүгийн яаралтай тусламжтай холбоотой эрсдэл нэмэгдсээр байна.

ФАТФ-ын баримт бичгийг нийтлэх үед мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх чиг хандлага, төрлүүдийг тодорхойлох ажил эхний шатандаа байсан. Хэдийгээр мэдээлэгдсэн хэргүүд

хязгаарлагдмал боловч албан ёсны банкны систем болон виртуал хөрөнгийг буруугаар ашиглах замаар гэмт хэрэгтнүүд хууль бус орлогоо угааж байгааг харуулж байна.

Бодлогын хариу арга хэмжээ нь шинэ эрсдэл, эмзэг байдлыг удирдахын зэрэгцээ КОВИД-19 цар тахалд хариу арга хэмжээ авах арга хэмжээг хурдан бөгөөд үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж чадна. Өнөө үед хөгжиж буй мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй тэмцэхэд дотоодын зохицуулалт онцгой чухал юм. Мөн засгийн газрууд ML/CFT арга хэмжээг хэрэгжүүлэх талаар хувийн хэвшилтэй хамтран ажиллаж, КОВИД-19-ийн үйл ажиллагаанд үзүүлж болзошгүй нөлөөллийг багасгахын тулд бүтээлчээр ажиллах шаардлагатай байна.

КОВИД-19-ийн үр дүнд дэлхий дахин урьд өмнө хэзээ ч байгаагүй хүнд хэцүү хямралтай тулгарч байна. Нөгөө талаас энэхүү ер бусын цаг үе нь хариуцлагатай инновацийн хэрэглээг хурдасгах боломжийг олгож байна. Дараагийн Ерөнхийлөгчийн үеэр ФАТФ нь шинэ технологи ашиглах, КОВИД-19-ийн хямралтай холбоотой мөнгө угаахтай тэмцэх асуудлыг төр, хувийн хэвшлийнхэнд таниулах чиглэлээр БНХАУ-ын ерөнхийлөгчийн үед эхлүүлсэн ажлаа үргэлжлүүлнэ.

2.2.3. 2020 - 2021 оны ФАТФ-ын тайлан

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд дэлхий нийтийг хамарсан цар тахлын үзүүлсэн нөлөө

КОВИД-19 цар тахал нь нийгэмд хүчтэй нөлөөлсөөр байна. Гэмт хэрэгтнүүд дэлхийн хэмжээнд эмнэлгийн барааг хуурамчаар үйлдэх, хөрөнгө оруулалтын луйвар хийх, дасан зохицсон кибер гэмт хэргийн луйвраас зэргээс эхлээд засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийг дэмжих арга хэмжээг ашиглах хүртэл тахал өвчнийг олон талаар ашиглан луйвар хийж байна. Үүний зэрэгцээ дэлхийн улс орнуудын засгийн газрууд эрүүл мэндийн чухал үйлчилгээ, эдийн засгийг сэргээх санаачилгад нөөцөө төвлөрүүлэх шаардлагатай болсон. Энэ нь тэдний мөнгө угаах үйл ажиллагааг илрүүлэх, мөрдөн шалгах, яллах, таслан зогсоох чадварт нөлөөлж байна.

ФАТФ-ын Ерөнхийлөгч 2020 оны 10-р сард мэдэгдэл гаргаж, гэмт хэрэгтнүүд болон террористууд КОВИД-19 тахлын эсрэг хэрхэн ашиглаж болохыг идэвхтэй тодорхойлж, үнэлж, ойлгохыг хууль эрх зүйн байгууллагуудад уриалсан. Мөн ФАТФ нь санхүүгийн чухал үйлчилгээг үргэлжлүүлэх, эмзэг бүлгийн хүн амд засгийн газрын тэтгэмжийг олгохын тулд FinTech, RegTech, SupTech зэрэг технологийн хэрэглээг аль болох дэмжихийг зөвлөсөн юм.

2020 оны арванхоёрдугаар сард ФАТФ-аас COVID-19-тэй холбоотой мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх тайлангаа шинэчилсэн бөгөөд уг тайланд тахлын тархалт нэмэгдэхийн хэрээр эрсдэл хэрхэн өөрчлөгдсөнийг онцлон тэмдэглэв. Үүнд онлайн худалдан авалт, банктэй харилцах гэх мэт санхүүгийн зан үйлийн өөрчлөлт, олон сая ажлын байраа алдах, компани хаагдах зэрэг санхүүгийн тогтворгүй байдал ихсэх зэрэг орно.

Олон орны хувьд COVID-19 тахал одоо шинэ үе шатанд орж байгаа бөгөөд зарим улс орнууд хэвийн байдалдаа орохоор бэлтгэж байна. Энэ тахал зөвхөн гэмт хэрэгтнүүдэд боломж олгосонгүй. Олон засгийн газар үүнийг ашиглан шинэчлэл хийж, технологийг илүү сайн ашиглах болсон.

Технологийг ашиглах, ухаалаг, хиймэл оюун ухаанд болон эрсдэлд суурилсан хандлагыг хэрэгжүүлэх замаар бид AML/CFT-ийн эсрэг ижил зүйлийг хийх хэрэгтэй.

2.3. Ковид-19 гарснаар шинээр үүсэх эрсдэлүүд

ФАТФ-ын гишүүд, ажиглагчид болон нээлттэй эх сурвалжуудын мэдээлж буйгаар залилан мэхлэх ажиллагаа нэмэгдсэнээр гэмт хэрэгтнүүд Ковид-19 цар тахлаас ашиг олохыг оролджээ. Эдгээр залилангийн үйлдлүүдээс дурдвал:

- **Албан тушаалтны дүр эсгэх.** Ийм тохиолдолд гэмт хэрэгтнүүд хувь хүмүүстэй (биеэр, цахим шуудан эсвэл утсаар) холбогдож, хувийн банкны мэдээлэл эсвэл бэлэн мөнгө олж авах зорилгоор төрийн албан хаагчийн дүрд хувирдаг. Зарим тохиолдолд гэмт хэрэгтнүүд эмнэлгийн албан тушаалтнуудын дүр эсгэж хамаатан саданг нь өвчтэй гэж хэлээд эмчилгээний төлбөр шаарддаг (Interpol, 2020), эсвэл татварын хөнгөлөлт үзүүлэх зорилгоор хувийн банкны мэдээлэл хүссэн төрийн албан хаагчийн дүр эсгэдэг (US Treasury, 2020).
- **Нэн шаардлагатай барааг хуурамчаар үйлдэх (эм, эмнэлгийн хэрэгсэл гэх мэт).** Эрэлтийг өгөгдсөн үед, зарим эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, эмийн бүтээгдэхүүнтэй холбоотой онлайн залилан мэхлэлт мэдэгдэхүйц нэмэгдэж байна. Ийм тохиолдолд гэмт хэрэгтнүүд амны хаалт, шинжилгээний багж болон бусад бүтээгдэхүүн санал болгодог аж ахуйн нэгж, буяны байгууллага, олон улсын байгууллагын ажилтнууд гэж хэлээд, захиалагчдаас төлбөрийн болон тээвэрлэлтийн хураамжийг авахын тулд зээлийн картын мэдээлэл авдаг боловч хүргэж өгдөггүй (FDA, 2020). Зарим тохиолдолд хохирогчдыг банкны шилжүүлгээр урьдчилан төлбөрөө хийлгэж, дараа нь янз бүрийн газраас бараагаа очиж авахыг зааж өгдөг ба дараа нь ийм зохицуулалт байхгүй гэж мэдэгдсэн байна (Сингапурын цагдаагийн алба). Мөн ФАТФ-ын гишүүд Ковид-19-ийн талаар хуурамч, гайхамшигт эмчилгээ гэж итгүүлэх хууль бүс бүтээгдэхүүний бараа мөн нэмэгдэж байгааг тэмдэглэжээ.
- **Хуурамч буяны байгууллагуудад хандив цуглуулах.** ФАТФ-ын гишүүд хандив цуглуулах луйврын хэрэг нэмэгдэж байгааг онцолж байна. Гэмт хэрэгтнүүд олон улсын байгууллага эсвэл буяны байгууллага гэж өөрийгөө таниулж, Ковид-19-тэй холбоотой хандив цуглуулах кампанит ажилд хандив хүссэн цахим шуудан илгээдэг бөгөөд сэжигтэн дижитал хэтэвчээр дамжуулан төлбөрөө хийдэг.
- **Хуурамч хөрөнгө оруулалтын луйвар.** Коронавируст халдвар (COVID-19)-аас үүдэлтэй эдийн засгийн хямрал нь олон нийтэд худалдаалагддаг компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг Ковид-19-ээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, эмчлэх боломжтой гэсэн худал сурталчилгаа зэрэг хөрөнгө оруулалтын луйврыг нэмэгдүүлэхэд хүргэсэн (Europol, 2020). ФАТФ-ын гишүүдийн тайланд ихэвчлэн хамгийн жижиг компаниудын гаргадаг микрокап хувьцаанууд нь олон нийтэд хүртээмжтэй мэдээлэл багатай, хямд үнэтэй хувьцаанууд учраас луйврын хөрөнгө оруулалтын схемд онцгой өртөмтгий байдгийг онцолжээ.

2.3.1. Кибер гэмт хэрэг

Нийгмийн инженерчлэлийн халдлага, ялангуяа спам кампанит ажлаар дамжуулан фишинг цахим шуудан болон гар утасны мессежүүд огцом өссөн байна. Эдгээр халдлага нь хувийн

төлбөрийн мэдээллийг олж авахын тулд залилан мэхэлсэн вэбсайтууд эсвэл вирустэй хавсралтуудын холбоосыг ашигладаг.

Имэйл болон SMS фишинг халдлага: Гэмт этгээдүүд хувийн компьютер эсвэл мобайл төхөөрөмжид вирустэй програм суулгахын тулд COVID-19-ийн талаарх санаа зовнилыг ашиглаж байна. Жишээлбэл, кибер гэмт хэрэгтнүүд өөрийгөө Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) гэж нэрлэж, цахим шуудан, гар утасны мессеж илгээж, хүмүүсийг вирустэй холбоос дээр дарж, хавсралтыг нээлгэдэг бөгөөд энэ нь тухайн хувь хүний хэрэглэгчийн нэр, нууц үгийг илчилдэг (WHO, 2020).

Бизнесийн цахим шуудангийн залилан: Дэлхий даяар зайнаас ажиллах үйл явц хурдацтай нэмэгдэж байгаа энэ үед кибер гэмт хэрэгтнүүд үйлчлүүлэгчтэй харилцах болон гүйлгээний мэдээлэлд нэвтрэхийн тулд бизнесийн сүлжээний аюулгүй байдлын сул талыг ашиглаж байна. Өөр нэг жишээнд, нэг компани мэс заслын маск, гарны их хэмжээний нийлүүлэлтийн төлбөрийг төлнө гэсэн нэрийдлээр луйварчдын хяналтанд байдаг банкны данс руу төлбөрийн шилжүүлгийг шилжүүлэхийн тулд бизнесийн түншийнхээ илгээсэнтэй адил хуурамч имэйл хүлээн авсан байна.

Рэнсомвэр халдлага: Цахим гэмт хэрэгтнүүд хувийн компьютер болон мобайл төхөөрөмж дээр ransomware оруулах янз бүрийн арга хэрэглэж байна. Тухайлбал, FATF-ын зарим гишүүд кибер гэмт хэрэгтнүүд төлбөрийг хүлээн авах хүртэл хохирогчдын төхөөрөмжид хандах эрх олж авах зорилгоор Ковид-19-тэй холбоотой мэдээллийг хуваалцдаг вирустэй вэб сайт, гар утасны програмуудыг ашиглаж байна гэж мэдээлж байна. Ковид-19-ийн эсрэг хариу арга хэмжээний тэргүүн эгнээнд байгаа байгууллагууд кибер гэмт хэрэгтнүүдийн бай болох магадлал өндөртэй. Тодруулбал, эмнэлгийн байгууллагууд ransomware халдлагын кибер гэмт хэрэгтнүүдийн бай болж байна (Интерпол, 2020).

2.3.2. Бусад гэмт хэрэг

Хүн худалдаалах, ажилчдын мөлжлөг: Гэмт этгээдүүд тахлын далимдуулан эмзэг бүлгийг ашиглах боломжтой. Энэ нь ажилчдын мөлжлөг, хүний наймаа нэмэгдэхэд хүргэж болзошгүй юм (Европын Зөвлөл, 2020). Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, хохирогчдыг илрүүлэх чиглэлээр тогтмол ажилладаг төрийн байгууллагуудын (ажлын байрны байцаагч, нийгмийн болон эрүүл мэндийн ажилтнуудыг оролцуулан) үйл ажиллагааг нь түр зогсоосон буюу бууруулсан нь гэмт хэргүүд илрэхгүй байж болзошгүй гэсэн үг юм. Ажлын байр хаагдах, эдийн засгийн удаашрал, ажилгүйдэл нэмэгдэж, санхүүгийн баталгаагүй байдал өсөх зэрэг нь хүний мөлжлөгийг нэмэгдүүлэхэд хүргэж болзошгүй хүчин зүйлүүд юм. Иймээс ФАТФ-ын гишүүд ажилчдыг мөлжих, эмзэг бүлгийн хүмүүсийг худалдаалах зэрэгт сэрэмжтэй байхыг зөвлөжээ (Australian Government, 2021).

Хүүхдийн мөлжлөг: Хүүхдийн мөлжлөгийн талаарх онлайн материалыг ихэвчлэн ашиг олох зорилгоор үйлдвэрлэж, түгээх нь нэмэгдсэн тухай ФАТФ-ын зарим гишүүдийн мэдээллүүд байна. Сургуулиуд хаагдаж хүүхдүүд гэртээ үлдэх үед хүүхдүүдийн интернет ашиглаль нэмэгдэж байгаа нь хүүхдийн цахим мөлжлөгийг нэмэгдүүлэхэд хүргэж болзошгүй юм (FBI, 2020).

Зохион байгуулалттай өмчийн гэмт хэрэг: Коронавируст халдварын улмаас одоогоор оршин суудаггүй олон үл хөдлөх хөрөнгө байгаа тул зохион байгуулалттай өмчийн гэмт хэрэг, хулгайлах гэмт хэрэг нэмэгдэж байгаа тухай мэдээлэл байна (Europol, 2020).

3. ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

3.1. Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга

Орчин үеийн техник технологийн дэвшлийн ачаар мөнгө угаагчдын арга улам сайжирсаар байна. Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь тухайн улсын нийгэм эдийн засгийн үйл хөдлөлд сөргөөр нөлөөлж, тухайн улсын нэр хүнд, бусад улсуудтай хийх хамтын ажиллагаа зэрэг зүйлсэд муугаар нөлөөлдөг.

Өнгөрсөн хугацаанд Ковид-19 цар тахлын улмаас Мөнгө угаах гэмт хэрэг олон улсад виртуал байдлаар ихээхэн явагдах болсон бөгөөд үүний эсрэг улс орнууд ч мөн адил техник технологид тулгуурласан шийдлийг эрэлхийлж эхэлсэн. Үүний нэг жишээ нь: Финтек байгууллагууд болно. Финтек нь Fin буюу Санхүүгийн зах зээлийг (Finance), Tech буюу Технологи (Technology) дээр суурилан хуучин уламжлалт Санхүүгийн зах зээлийг илүү дэвшилтэд, хялбар, түргэн, шуурхай болгож, Санхүүгийн үйлчилгээний зардлыг бууруулж, үйлчилгээний шимтгэл, хураамжийг багасгах шинэ төрлийн үйлчилгээ болно. (Э.Анар, 2019) Олон улсад Финтекээр дамжуулж мөнгө угаах гэмт хэрэг хийж болзошгүй байдаг ба энэ нь гэмт хэрэгтнүүдэд нууцалсан дансны гүйлгээ, мөнгөний хязгааргүй урсгал нь мөнгө угаах үйл ажиллагааг хөнгөвчилдөг байна. Иймд финтек байгууллагууд мөнгө угаахтай тэмцэх арга технологийг яаралтай судлах шаардлагатай болсон. Үүний үр дүнд олон улсад дан ганц финтек байгууллага гэлтгүй, тухайн улсын Санхүү Мэдээллийн албаныхан хүртэл финтек инновациудыг ашиглан мөнгө угаахтай тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх шийдлүүдийг сүүлийн үед ашиглах болсон.

3.1.1. Регтек

Регтек буюу Regulatory technology нь технологи болон зохицуулалтыг хослуулан аливаа санхүүгийн байгууллагад тулгараад байгаа асуудлыг шийдвэрлэдэг. Регтек нь олон өгөгдлүүдийг нэгтгэн, цогц, эмх цэгцтэй нэгдсэн тайлан гаргаж чаддагаараа давуу талтай технологи юм. Энэ нь санхүүгийн байгууллагад хурдан шуурхайг, цагын оновчтойгоор ажиллахад тусалдаг болно. Регтек нь түүхэн хөгжлийн хувьд нийт 2 үе шатаас бүрдэнэ.

1-р үе шат (1967-2008) Энэхүү үе шатын үед Компаниуд илүү тайлан дээр тулгуурлаж өөрсдийн эрсдэлийг хянадаг байсан бол, Зохицуулагч байгууллагууд илүү тоон аргад суурилаж үйл ажиллагаа явуулдаг байсан

2-р үе шат (2008-одоог хүртэл) компани болон зохицуулагч байгууллага аль аль нь зохицуулалтад үүрэг оролцоотой болж, технологи ашиглах болсон. Энэ үед харилцагч таньж мэдэхээс илүүтэй өгөгдөлд илүү анхаарч, уг өгөгдөл дээр тулгуурлан шинжилгээ хийн түүгээрээ бусдад зөвлөгөө өгдөг болсон.

Эхний үе шатын үед Регтекийг томоохон байгууллагууд л ашигладаг байсан бөгөөд цаг хугацаа өнгөрөхийн хэрээр улс орон даяар финтек байгууллагууд ихсэж, регтекийг ашиглах нь элбэг болсон (АРИУНЗУЛ, 2021).

3.1.2. Сунтек

Suptech буюу Supervision Technology нь өөрийн байгууллагын хяналтыг сайжруулах зорилгоор байгууллагуудад мэдээлэл цуглуулах, түүндээрээ анализ хийж, хийсэн анализаа сайжруулахын тулд хиймэл оюун ухаан машин сургалт гэх мэт зүйлсийг ашиглахыг хэлнэ. Энэхүү програмын гол зорилго нь тухайн компани ачааллыг бууруулж, хяналт шалгалтыг илүү сайн хийх, тайлагнах, хяналт тавих зэрэг зүйлсийг илүү сайн хийх боломжийг олгодгоороо давуу талтай болно.

Орчин үеийн техник технологийн дэвшилтэд хэрэгслүүд нь мөнгө угаахтай тэмцэх арга механизмыг илүү боловсронгуй болгосоор байгаа. Санхүүгийн байгууллагууд мөнгө угаахтай тэмцэх зорилгоор их хэмжээний гүйлгээг хянан шалгах шаардлагатай болдог бөгөөд үүний 90-95 хувь нь энгийн гүйгээ болоод дуусдаг. Энэ тоог багасгахын тулд санхүүгийн байгууллагууд суптекийг ашиглах шаардлагатай болдог бөгөөд өөрсдийн цуглуулсан их хэмжээний өгөгдөл дээр тулгуурлан илүү нарийн тоо баримт гаргах боломжтой байдаг.

Монгол улсын хувьд ч эдгээр техник технологийг ашиглах хэрэгтэй бөгөөд өмнөх судлагдсан байдал, олон улсын чиг хандлага болон фатфын тайланг харахад Ковид-19-ийн нөлөөнөөс болж дэлхийн эдийн засгийн гэмт хэрэг тэр дундаа мөнгө хэрэг ихсэх төлөвтэй байхад Монголд эсрэгээрээ байгаа нь доорх статистикаас харж болно (УДАМЗАЯА, 2021).



Эх сурвалж: (Institute, 2019)


График 1. 2002 оноос хойш эдийн засгийн гэмт хэргийн гаралт



Эх сурвалж: (Гэмт хэргийн статистик, 2021)

Тайлбар: 2015 оноос хойш эдийн засгийн гэмт хэргийн гаралт эрчимтэй буурсан болохыг энэхүү графикаас харж болно. Монгол улс нь фатфын саарал жагсаалтад 2013 болон 2019 онуудад орж байсан бөгөөд 2014 болон 2020 онд энэхүү жагсаалтаас гарч байсан болно. 2019-2020 оны хооронд дэлхий дахинд Ковид-19 цар тахлын өндөр тархалттай байсан он жил. Бидний судлагдсан байдлын дүгнэлтүүдэд үндэслэн тухайн он жилүүдэд мөнгө угаах гэмт хэрэг ихсэх төлөв хандлагатай байсан болно. Гэвч тус он жилийн хугацаанд манай улсад тийм зүйл болоогүй бөгөөд харин ч эсрэгээрээ буурсан шинж хандлага ажиглагдаж байна.

График 2. Мөнгө угаах гэмт хэрэг



Эх сурвалж: (Гэмт хэргийн статистик, 2021)

Тайлбар: Сүүлийн 3 жилийн хугацаанд мөнгө угаах гэмт хэрэг өсөж буурсан байна. 2018- 2019 оны хооронд өсөлттэй харагдаж байгаа бол 2019-2020 оны хооронд бууралттай харагдаж байна. Хэрэв Ковид-19 гараагүй бол энэ тоо өсөх байсан.

4. ДҮГНЭЛТ

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь 2009 оны ихэр цамхгийн халдлагаас хойш улам илүү анхаарал татсан асуудал болоод байгаа билээ. Даяаршлын үйл явц, харилцаа холбооны хувьсгал, түүнчлэн дэлхий дахиныг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр энэхүү гэмт хэрэг улам олон улсыг хамрах болж, технологийн дэвшлийн улмаас мөнгө угаах гэмт хэрэг илүү төвөгтэй болж байна. Ялангуяа энэ төрлийн гэмт хэрэг нь сүүлийн жилүүдэд гуравдагч буюу хөгжиж буй орнуудыг хамрах болсон тул манайх шиг улсуудын хувьд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн гаралтын шалтгаан, үүнд ашиглаж буй суваг, энэхүү гэмт хэрэгтэй хэрхэн тэмцэх талаар хууль зүйн орчинг сайтар бүрдүүлж, үр дүнтэй арга хэмжээ авах нь нэн тулгамдсан асуудал болоод байна. Сүүлийн хоёр жилийн хугацаанд дэлхий дахиныг хамарсан цар тахал гарсантай холбоотойгоор энэ төрлийн гэмт хэрэг хэрэгжих арга хэлбэрээ өөрчилсөн тул энэ үзэгдлийг судлах, түүнтэй хэрхэн тэмцэх талаар судлах нь өнөөгийн түвшинд нэн чухал асуудал болоод байгаа юм. Энэхүү судалгааны ажлаар бид Ковид-19 цар тахлын үеийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн эрсдэл, түүний сувгийн талаар олон улсын байгууллагуудын судалгаа болон бусад эх сурвалжаас судалгаа хийж, монгол улсад энэхүү гэмт хэргийн гаралтыг хэрхэн илрүүлэх талаар өөрсдийн санал болгож буй зөвлөмжийг боловсрууллаа.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

US Treasury. (2020). Terrorism and Illicit Finance. US: US Treasury. Australian Government. (2021). AUSTRAC Annual Report. AUSTRAC.

Blog, W. S. (2020). The Impact of Covid-19 on Money Laundering. LA: Wed Shield Blog. Europol. (2020). European Union Terrorism Situation and Trend Report. Europol.

FATF. (2020). COVID-19-related Money Laundering and Terrorist Financing: Risks and Policy Responses. Paris: FATF.

FBI. (2020). The Cyber Threat . Retrieved from FBI: <https://www.fbi.gov/investigate/cyber> FDA. (2020). Food And Drug Administration.

Institute, F. S. (2019). Bank for International Settlements.

John McDowell, G. N. (2001). THE CONSEQUENCES OF MONEY LAUNDERING AND FINANCIAL CRIME. Electronic Journal of the U.S. Department of State, 6(2), 6-8.

WHO. (2020). WHO reports fivefold increase in cyber attacks, urges vigilance. Retrieved from World Health Organization: <https://www.who.int/news/item/23-04-2020-who-reports-fivefold-increase-in-cyber-attacks-urges-vigilance>

АРИУНЗУЛ, Э.-А. (2021). Дипломын ажил. Retrieved from repository: <http://repository.ufe.edu.mn:8080/xmlui/handle/8524/2212>

Гэмт хэргийн статистик. (2021, 2 23). Retrieved from Үндэсний статистикийн хороо: https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2300_027V1&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=_0&YearY_select_all=1&YearYSingleSelect=&viewtype=linechart

УДАМЗАЯА, С. (2021). Дипломын ажил. Retrieved from repository: <http://repository.ufe.edu.mn:8080/xmlui/handle/8524/2212>

Э.Анар (2019, 4 19). Монголбанк. Retrieved from “Ирээдүй-ФИНТЕК”: https://www.mongolbank.mn/documents/press_conference/20190419_04.pdf



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА
МОНГОЛБАНК

ФАТФ-ЫН 40 ЗӨВЛӨМЖИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Э.Бат-Очир⁴¹, Б.Түмэнзаяа⁴²

⁴¹ Санхүү эдийн засгийн их сургууль, Эдийн засгийн тэнхим, IV курсын оюутан. Цахим хаяг: b18fa1644@ufe.edu.mn

⁴² Санхүү эдийн засгийн их сургууль, Эдийн засгийн тэнхим, II курсын оюутан. Цахим хаяг: b20fa1517@ufe.edu.mn

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сүүлийн арванд ФАТФ-аас авч хэрэгжүүлэх мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг тэмцэл үлэмж нэмэгдсэн байдаг. Энэхүү цаг үетэй зэрэгцэн эдийн засагт оролцогчид уг үйл явцын эсрэг чиглэлд явж буй мөнгө угаах өндөр эрсдэлтэй орнуудаас хөрөнгөө гадагшлуулах зүй тогтол ажиглагдлаа. Энэхүү судалгаа нь ФАТФ-аас санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэхээр гаргадаг зөвлөмжүүдийг хангалтгүй биелүүлэн хар, саарал жагсаалтад багтах нь хөрөнгийн урсгалд хэрхэн нөлөөлөхийг шинжлэхэд чиглэх болно. Судалгааны явцад тухайн улс ФАТФ-аас зарлах жагсаалтад багтах нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, нэг хүнд ногдох ДНБ-д сөрөг нөлөө үзүүлдэг тухай эмпирик нотолгоог гаргаж авав. Мөн уг жагсаалтад багтахад нөлөөлсөн зөвлөмжийн үнэлгээ буурах үзэгдэл нэг хүнд ногдох орлогыг бууруулдаг болох нь тогтоогдлоо. Судалгааны үр дүнд бага орлоготой улс оронд уг сөрөг нөлөө илүү хүчтэй тусдагийг илрүүллээ.

ТҮЛХҮҮР ҮГС

ФАТФ-ын 40 зөвлөмж, ФАТФ-ын жагсаалт, Хөрөнгийн урсгал, Гадаадын шууд хөрөнгө оруулалт, Эрсдэлээс зайлсхийх

1. ОРШИЛ

Даяарчлалаас үүдсэн эдийн засаг ба олон улсын худалдааны өсөлт нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зэрэг санхүүгийн гэмт хэрэг эрчимтэй ихсэхэд хүчтэй нөлөөлжээ. 2018 оны хувьд дэлхий даяар 5.8 их наяд ам.доллартой тэнцэх хэмжээний хууль бус мөнгө эргэлдсэн байгаа нь тухайн жилийн дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 6.7%-тай дүйцэж байна (John Cusack, 2018). Дэлхий нийтээр энэхүү төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд жилд дунджаар 180 гаруй тэрбум ам.долларыг зарцуулдаг (LexisNexis, 2018). Хэдийгээр Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (МУТС)-ийн эсрэг арга хэмжээнүүдэд асар их ач холбогдол өгч байгаа ч эдгээр гэмт хэргийн цар хүрээг хангалттай түвшинд тогтоож дийлэхгүй байна. Иймд санхүүгийн гэмт хэрэг, тэдгээрийн үр дагаврыг судлах нь энэхүү төрлийн хууль бус үйл ажиллагаанаас сэргийлэх, МУТС-тэй тэмцэхэд бодитой үр дүнг авчрах ач холбогдолтой билээ.

Эдүгээ уг гэмт хэргийн эсрэг хамгийн үр дүнтэй ажиллаж, санхүүгийн арга хэмжээ авдаг байгууллага (Financial Action Task Force буюу ФАТФ) нь 1989 онд Их Долоогийн санаачилгаар мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх бодлого боловсруулах зорилгоор байгуулагдсан засгийн газрууд хоорондын байгууллага юм. 2001 оны 9 сарын 11-ний террорист халдлагын дараа уг байгууллагын үйл ажиллагааг терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр өргөтгөжээ. ФАТФ нь даян дэлхийн МУТС гэмт хэргийн эсрэг жишиг арга хэмжээнүүдийг авдаг. Тус байгууллагаас гаргадаг мөнгө угаахтай тэмцэх 40 зөвлөмж, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой 9 тусгай зөвлөмж нь хууль бус мөнгөтэй холбоотой гэмт хэргийн эсрэг баримтлах олон улсын стандарт болон тогтсон байна.

ФАТФ-аас гаргасан 40 зөвлөмж нь МУТС-тэй тэмцэхэд олон улсын дагаж мөрддөг стандарт төдийгүй одоогийн байдлаар санхүүгийн гэмт хэргээс сэргийлэх үр дүнтэй хэрэгсэл болж байна. Анх 1990 онд батлагдсан стандартууд нь гэмт хэргийн арга аргачлал, цаг хугацааны өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэн тодорхой хугацаанд шинэчлэн батлагдсаар байгаа бөгөөд анх 130 гаруй улс энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэхэд гарын үсэг зурсан байдаг. ФАТФ-ын 40 зөвлөмжийг бүх улс орон дагаж мөрдөх, биелүүлэх үүрэгтэй байдаг ба зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, үнэлгээ олгодог журамтай. Хяналтын үнэлгээн дээрээс тулгуурлан эдгээр зөвлөмжүүдийг хангалтгүй биелүүлж байгаа эсвэл биелүүлэх сонирхолгүй байгаа улс орнуудыг хоёр жагсаалтанд багтаадаг: “хяналтыг ихэсгэсэн улсууд” буюу “зөвлөмжийн хэрэгжилтийн стратегийн дутагдлаа арилгахын тулд ФАТФ-тай идэвхитэй хамтран ажиллаж байгаа” (саарал жагсаалт), “хориг арга хэмжээнд орсон улсууд” буюу “зөвлөмжийнхөө дутагдлаа арилгахаар ФАТФ-тай хамтарч ажилладаггүй” (хар жагсаалт). Хавсралт 1-т эдгээр жагсаалтад орсон улсуудыг харуулав.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх нь ихээхэн цаг хугацаа, хүчин чармайлт, зардал хөрөнгө шаардсан төвөгтэй үйл ажиллагаа тул эдийн засагт оролцогчид уг гэмт хэрэгтэй холбогдсон улс орон, байгууллагатай явуулах хамтын ажиллагаагаа хумих замаар эрсдэлээс зайлсхийдэг (de-risking) байна. Ил зардлуудаар ч зогсохгүй санхүүгийн гэмт хэрэг, үүнд холбогдсон улс орон, байгууллагатай хамтран ажиллах нь эдийн засагт оролцогчдын зах зээл дээрх нэр хүндэд хохирол учруулдаг. Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагуудын анхаарлыг татах нь богино хугацааны өсөлт, санхүүгийн тогтворгүй байдалд сөргөөр нөлөөлөх тул ямар ч оролцогч мөнгө угаах үйл ажиллагаа, үүнтэй холбогдсон талтай харилцаа тогтоохыг хүсдэггүй. МУТС-тэй тэмцэхэд хангалтгүй ажиллан ФАТФ-ын жагсаалтад багтах нь олон

улсын зах зээл дээрх эдийн засагт оролцогчдод түгшүүрийн дохиог өгч, тус бүс нутгаас их хэмжээний хөрөнгө гадагшилж байгаагийн шалтгаан болж байна.

ФАТФ-ын үйл ажиллагаа, хяналт шалгалт жил ирэх тусам сайжирч, олон улсын мэргэжилтнүүдийн чухал ач холбогдол өгдөг үзүүлэлт болж байгаа нь улс орнууд уг байгууллагын стандарт, дүрэм журам, үүнийг хэрэгжүүлээгүйгээс үүдэх эрсдэл, хор уршгийн талаар нухацтай хандаж, судалж шинжлэх хөшүүрэг болж байна. Нөгөөтгээгүүр, Монгол улс нь 2019 оны 10-р сарын 18-нд ФАТФ-ын МУТС стандартыг хангалтгүй биелүүлэн саарал жагсаалтад орсон нь манай улсын хувьд МУТС-тэй тэмцэх хангалттай чадавхгүй байгаа бөгөөд уг асуудалд сайжруулалт, хүчин чармайлт гаргах шаардлагатайг харуулсан байдаг. МУТС-ийн эсрэг тэмцэх тэмцэлд зөвхөн макро хүчин зүйлүүд болох ЗГ, УИХ, Монголбанк бус микро хүчин зүйлүүд болох хувь хүмүүс чухал оролцоотой. Хувь хүмүүс МУТС-ийн хор уршиг, үүний нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөг мэдэж байх нь санхүүгийн гэмт хэргийг бууруулах үр дүнтэй аргуудын нэг юм. Энэхүү судалгааны ажлын гол зорилго нь ФАТФ-ын 40 зөвлөмж, үүнийг хангалтгүй биелүүлэн хар, саарал жагсаалтад багтах нь эдийн засаг, тухайлбал, хөрөнгийн урсгалд ямар нөлөө үзүүлэхийг тодорхойлж, оюутан залуус, хувь хүмүүсийн МУТС-ийн мэдлэгийг дээшлүүлэхэд оршино.

Судалгааны ажлын эхний хэсэгт энэхүү сэдвийн талаар дэлхий дахинд судлагдсан байдлыг харуулах бол хоёр дахь хэсэгт ФАТФ-ын 40 зөвлөмж, хар саарал жагсаалтад багтах болон хөрөнгийн урсгал хоорондын холбоо хамаарлыг авч үзнэ. Гурав дахь хэсэгт судалгаанд ашиглах онол, өгөгдөл, эконометрикийн шинжилгээ багтана. Эцэст нь загварын үр дүнг танилцуулж, нэгдсэн дүгнэлтэд хүрнэ.

2. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

ФАТФ-ын 40 зөвлөмжийг хангалтгүй гүйцэлдүүлэн түүнээс зарлах хар, саарал жагсаалтанд багтах нь эдийн засгийн үзүүлэлтүүдэд олон сувгаар нөлөөлдөг. Гэсэн хэдий ч уг холбоо хамаарлыг баталсан эмпирик нотолгоонууд хангалттай сайн биш бөгөөд түгээмэл бус байна. Энэхүү хэсэгт ФАТФ-ын хар, саарал жагсаалт болон эдийн засгийн зарим гүйцэтгэл хоорондын хамаарлыг харуулсан судалгааны ажлуудыг авч үзэх болно.

Кадрл 2008 онд хийсэн “Хар жагсаалт нь татварын диваажинд хохирол учруулах уу? судалгааны ажлаараа хар жагсаалт болон хөрөнгийн урсгал хоорондын хамаарлыг шинжилжээ. Тэрээр татварын диваажингийн 38 улс орон дээр хийсэн шинжилгээгээрээ ФАТФ-ын хар, саарал жагсаалтад багтах нь тухайн татварын диваажин бүхий бүс нутаг дахь банкны хөрөнгийн урсгалд сөрөг нөлөө үзүүлж байгаа гэсэн бага хэмжээний ч ач холбогдолтой нотолгоог гарган авсан байна. Энэхүү судалгааны ажлын үр дүн нь магадгүй ФАТФ-ийн үйл ажиллагаа орчин үетэй харьцуулахад сул байсан үед хийснээс шалтгаалан сул үр нөлөөтэй гарсан байж болох юм (Kudrle, 2008).

Фариас ба Алмейда нар Латин Америк болон Карибын тэнгисийн 36 улс орнууд дээр хийсэн судалгаагаараа ФАТФ-ын хар жагсаалт, түүний үнэлгээ ба дотоодын хөрөнгө оруулалт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн хөгжил хоорон дахь хамаарлыг шинжилжээ. Энэхүү судалгааны ажлаараа институцийн үзүүлэлтүүд (ФАТФ-ын хар жагсаалт, ФАТФ-ын үнэлгээ, авилгал) нь дотоодын хөрөнгө оруулалт, гадаадын шууд хөрөнгө оруулалт ба зээлийн хэмжээг ДНБ-д харьцуулсан харьцаанд сөрөг нөлөө үзүүлдэг тухай нотолгоог гарган авсан бөгөөд эдгээр институцийн үзүүлэлтүүдийн сөрөг нөлөө нь богино хугацаанаас илүү урт хугацаанд илэрдгийг олж тогтоожээ. Судалгааны үр дүнд ФАТФ-ын гаргасан зөвлөмжүүдийг үл биелүүлэх эсвэл хангалттай биелүүлэхгүй байж, сөрөг үнэлгээ аван хар жагсаалтад багтах нь тухайн улс орныг эдийн засгийн хувьд хохироож, олон улсын тавцан дахь нэр хүндийг нь унагааж байгааг харуулсан байна (Farias & Almeida, 2014).

Балакина ба бусад (2016) 1996-2014 оны хугацаан дахь банкны хөрөнгийн урсгал (BIS)-ын 126 улс орны өгөгдөл дээр хийсэн шинжилгээгээрээ хар жагсаалтад багтах нь банкны хөрөнгийн урсгалд нөлөөлдөг эсэх талаар судалжээ. ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зөвлөмжүүдийг хангалтгүй биелүүлэн үүнээс зарладаг жагсаалтад багтах нь олон улсын банкны тухайн улс оронд үйл ажиллагаагаа явуулах эрсдэл, зардлыг өсгөдөг бөгөөд уг судалгааны ажлаараа олон улсын банкууд хэрхэн ФАТФ-ын зарласан жагсаалтад хариу үйлдэл үзүүлдгийг тодорхойлжээ. Судалгааны үр дүнд хар жагсаалтад орох нь банкны гадагшлах хөрөнгийн урсгалд өчүүхэн хэмжээтэй нөлөөлдгөөс өөр ямар нэгэн ач холбогдолтой холбоо хамаарлыг олж чадаагүй байна (Balakina, D’Andrea, & Masciandaro, 2016).

Коллин, Күүк, Сорамаки нар 2016 онд олон улсын төлбөрийн мэдээллийг агуулсан СВИФТ-ын өгөгдөл дээр МУТС-тэй тэмцэхэд тавих хяналт шалгалтын түвшин ихсэх буюу ФАТФ-аас гаргадаг жагсаалтад орох нь улс хоорондын гүйлгээний тоо хэмжээнд хэрхэн нөлөөлдөг талаар судалжээ. Энэхүү судалгааны ажлаараа өндөр эрсдэлтэй саарал жагсаалтад орсон орнуудад бусад улс орнуудаас орж ирэх гүйлгээний хэмжээ 10%-иар багасаж байгааг харуулжээ. Харин эдгээр өндөр эрсдэлтэй орнуудаас гарах мөнгөн урсгалд өөрчлөлт ажиглагдаагүй бөгөөд эрсдэл өндөр байх нь гадаад худалдаа болон бусад төрлийн хөрөнгийн урсгалд сөрөг нөлөө үзүүлдэг талаарх хязгаарлагдмал нотолгоог гарган авсан байна. Шинжилгээний үр дүнд саарал

жагсаалтад харьцангуй буурай хөгжилтэй улсууд багтах хандлагатай байгааг харуулсан бөгөөд эрсдэлээс үүдэн гарах сөрөг нөлөөнүүд нь уг улс орнуудад илүү хүчтэй мэдрэгдэж байгааг олж тогтоожээ (Collin, Cook, & Soramäki, 2016).

Аллиена болон бусад (2017) Карибын тэнгисийн орнууд дахь банкуудын чухал харилцагч бүхий корреспондент банкны харилцаагаа алдсан үзэгдэлд дүн шинжилгээ хийжээ. Уг улс орнуудын эдийн засаг олон улсын худалдаа, аялал жуучлал зэрэг зүйлсээс өндөр хамааралтай байсан нь корреспондент банкны тухайн улс орнуудын эдийн засагт үзүүлэх нөлөө их байх шалтгаан болсон бөгөөд эдгээр банкны харилцаа байхгүй болсноор Карибын тэнгисийн зарим орнуудын эдийн засагт мэдэгдэхүйц нөлөөлсөн байна. Карибын тэнгисийн улс орнуудын ФАТФ-аас гаргадаг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зөвлөмжүүдийг хангалтгүй биелүүлсэн байдал нь корреспондент банкнуудын эрсдэлийн үнэлгээг ихэсгэж, эрсдэлээс зайлсхийх, зардлаа багасгах зорилгоор харилцагч банкны харилцаагаа тасалдаг тухай уг судалгаанд авч үзжээ. Судалгааны үр дүнд корреспондент банкны харилцаа алдагдах үзэгдэлд i) Европын хямрал, ii) тухайн улсын эдийн засгийн хэмжээ, iii) АНУ-ын хориг хэмжээний нөлөө чухал ач холбогдолтой байдгийг эконометрик шинжилгээгээр харуулсан байна (Alleyne, et al., 2017).

Жулиа Морц (2019) “Хар жагсаалт, зах зээлийн хэрэгжилт ба терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дэлхийн дэглэм” сэдэвт судалгаагаараа олон улсын байгууллагуудын үүрэг нөлөөг онцолж, тэдний гаргадаг Дэлхийн Гүйцэтгэлийн Үзүүлэлтүүд (Global Performance Indicator) нь олон улсын бодлогын арга хэрэгсэл болж, зах зээлийн хэрэгжилтэд нөлөөлөх хүчин зүйл болдог талаар онцлон тэмдэглэсэн байна. Тэрээр уг судалгаандаа мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага буюу ФАТФ-ын онцгой зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлж байгаа улс орнуудыг багтаадаг жагсаалтыг ашиглажээ. Судалгааны үр дүнгээрээ Морц ФАТФ-ын зөвлөмжийн шаардлагыг хангаагүй орнуудын жагсаалтад орох нь түүний дэвшүүлсэн хөгжингүй орнуудын банкнаас хөгжиж буй улс орнуудын банканд очих зээлийн хэмжээ буюу хөрөнгийн урсгалыг багасгадаг гэсэн таамаглалыг дэмжсэн эмпирик нотолгоог гарган авсан байна. Энэхүү судалгааны ажил нь мэдлэг, мэдээлэл чухал ач холбогдолтой нэгэн төрлийн баялаг болсон одоогийн цаг үед олон улсын нэр хүнд бүхий байгууллагаас гаргаж буй гүйцэтгэлийн үзүүлэлт тухайн улс орны ирээдүйд хэрхэн нөлөөлдгийг харуулжээ (С.Морсе, 2019).

Ц.Бямбацогт ба Л.Очгэрэл нар 2019 онд хийсэн “Саарал жагсаалтад орсноор эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөө” сэдэвт судалгаагаараа i) ФАТФ-ын ямар нэгэн жагсаалтад орох, ii) 2008 оноос хойш зарлах болсон хар, саарал жагсаалтад багтах, iii) Монгол улстай орлогын ижил ангилалд багтдаг улс орнуудын хувьд саарал жагсаалтад орох нь макро эдийн засгийн үзүүлэлтэд хэрхэн нөлөөлөх талаар шинжилгээ хийжээ. Энэхүү судалгааны ажлаар нь ФАТФ-аас гаргадаг мөнгө угаах, терроризмын эсрэг тухайн улсын хэрэгжүүлж буй ажлын үнэлгээ нь эдийн засгийн чухал үйл ажиллагаануудад хэрхэн нөлөөлөхийг ФАТФ-ын жагсаалт зарлах ангиллын өөрчлөлт, улс орнуудын тоон мэдээллийн олоц, орлого, эдийн засгийн хөгжлийн түвшнээс хамааруулан 3 төрлийн үнэлгээг эконометрик шинжилгээгээр гүйцэтгэжээ. Судалгааны үр дүнд тухайн улсын гадаад өр ихсэж, гадаад худалдаа буурахад хар болон хар саарал жагсаалтад орох нь нөлөөтэй байдаг бол зээлжих зэрэглэл буурахад ФАТФ-ын жагсаалтад орох сөрөг үр дагавартайг харуулсан байна (Бямбацогт & Очгэрэл, 2020).

ФАТФ-ын саарал жагсаалт тухайн улс орны капиталын урсгалд хэрхэн нөлөөлдөг нь бодлого боловсруулагчид, хөрөнгө оруулагчдын анхаарал хандуулдаг чухал асуудал юм. Кида ба Паеццольд нар 2021 онд машин сургалтын аргыг ашиглан саарал жагсаалтын капиталын урсгалд үзүүлэх нөлөөг тооцоолжээ. Саарал болон хар жагсаалтын эдийн засаг, санхүүгийн салбаруудад үзүүлэх нөлөөний эмпирик нотолгоо бага байдаг ч тэдний хийсэн уг судалгааны ажил нь саарал жагсаалт ба капиталын урсгал хооронд хүчтэй хамаарал байгааг олж илрүүлсэн байна. Хөгжиж буй 89 улс орны капиталын урсгалын өгөгдөл дээр хийсэн шинжилгээгээрээ саарал жагсаалт нь капиталын урсгалд мэдэгдэхүйц чухал ач холбогдолтой сөрөг нөлөө үзүүлдгийг харуулжээ. Судалгааны үр дүнд саарал жагсаалтад багтах нь ДНБ-ий 7.6%-тай тэнцэх хэмжээний капиталын урсгалын агшилтыг бий болгож, эдийн засгийн үлэмж зардал үүсгэдгийг тогтоосон байна (Kida & Paetzold, 2021).

3. ОНОЛЫН ХЭСЭГ

а. Мөнгө угаах үйл ажиллагаа

Мөнгө угаах гэдэг нь хар тамхины наймаа, терроризмыг санхүүжүүлэх зэрэг гэмт хэргийн улмаас олсон их хэмжээний мөнгийг нуун дарагдуулахын тулд хэлбэр, төрхийг хувиргаж, хууль ёсны эх сурвалжаас гаралтай мэт харагдуулах хууль бус үйл явц юм. Энэ нь зохион байгуулалттай гэмт хэрэг болон сүүдрийн эдийн засгийн гол үйл ажиллагаа болдог.

Хууль бусаар олсон мөнгийг үр ашигтай зарцуулахыг хүсдэг гэмт хэргийн байгууллагуудын хувьд мөнгө угаах нь зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаа юм. Их хэмжээний хууль бус мөнгөтэй орооцолдох нь үр ашиггүй байдал ба аюулыг дагуулдаг. Тодорхой гэмт хэргээс олсон мөнгө нь “бохир”-т тооцогддог бөгөөд үүнийг хууль ёсны үйл ажиллагаанаас үүдэлтэй мэт харагдуулахын тулд “цэвэрлэх” шаардлага гардаг. Мөнгө угаах үйл ажиллагаа нь ихэвчлэн 3 үе шаттай. Үүнд:

- Байршуулах: Бохир мөнгийг хууль ёсны санхүүгийн системд далд хэлбэрээр оруулах,
- Далдлах: Цуврал гүйлгээ болон нягтлан бодох бүртгэлийн заль мэхийг ашиглан мөнгөний эх үүсвэрийг нуун дарагдуулах,
- Нэгтгэх: Угаасан мөнгийг гэмт хэрэгтнүүдийн санаачилсан цаашдын зорилгод ашиглахаар хууль ёсны данснаас гаргах гэсэн гурван үе шат багтдаг.

Бодит амьдрал дээр уг загвар өөр хэлбэртэй байж болно. Мөнгө угаах гэмт хэрэг нь эдгээр үе шатуудыг бүгдийг нь хамрахгүй, зарим үе шатуудыг нэгтгэж эсвэл хэд хэдэн удаа давтах тохиолдол бий. Энгийнээс эхлээд нарийн төвөгтэй хүртэл маш олон мөнгө угаах арга байдаг.

Сүүлийн жилүүдэд олон улсын засгийн газрууд санхүүгийн байгууллагуудыг сэжигтэй үйл хөдлөлийг илрүүлж, мэдээлэх системийг ажиллуулахыг шаардсан зохицуулалт тавих замаар мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хүчин чармайлтаа эрчимжүүлж байна. Мөнгө угаах гэмт хэрэгт ашиглагдаж буй мөнгөний хэмжээ асар их байна. Хэдий мөнгө угаах гэмт хэргийн далд шинж чанараас үүдэн нийт дүнг тооцох төвөгтэй байгаа ч НҮБ-ын Мансууруулах Бодис, Гэмт Хэрэгтэй Тэмцэх Газрын мэдээлснээр мөнгө угаах гэмт хэргийн гүйлгээ жил бүр ойролцоогоор 800 тэрбум доллароос 2 их наяд доллар буюу дэлхийн ДНБ-ий 2-5%-ийг эзэлж байна.

Мөнгө угаах үйл ажиллагаа нь сүүдрийн эдийн засгийг дэмжиж, нийгэмд гарах гэмт хэргийг өдөөдөг. Уг үйл явц нь эдийн засагт асар их хохирлыг учруулж байдаг. Хууль бус үйл ажиллагаа явуулан мөнгө угаах нь татвараас зайлсхийх явдлыг бий болгон макро түвшинд

улсын орлогын тодорхой хэмжээг үгүй болгож, бодлогын тогтворгүй байдлыг үүсгэж байна. Мөнгө угаах нь санхүүгийн салбарт ч хор уршигтай юм. Тухайлбал, их хэмжээний мөнгө санхүүгийн байгууллагад гэнэт орж ирэн ямар ч ул мөргүй гарах нь тухайн байгууллагын хөрвөх чадвар, тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлдэг. Дэлхий даяар туйлын хор уршигтай гэмт хэрэг гэж хүлээн зөвшөөрөн үүний эсрэг арга хэмжээ авахаар тэмцэж байхад мөнгө угаахын эсрэг тэмцэх сонирхолгүй, хичээл зүтгэлгүй байх нь тухайн улсын дэлхий дахин дахь нэр хүндийг унагааж, гадаадаас орж ирэх санхүүгийн, эдийн засгийн хөрөнгө бололцоог устгадаг байна. Үүний талаар дараагийн хэсгүүдэд нарийвчлан авч үзнэ.

b. Олон хүчин зүйлийн регресс

Олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээний гол зорилго нь хоёр ба түүнээс дээш тайлбарлагч хувьсагчид болон тайлбарлагдагч хувьсагчид хоорондын шугаман хамаарлыг загварчлах юм. Үл хамаарах хувьсагч x -ийн утга бүр хамаарах хувьсагч y -ийн утгатай холбоотой байдаг. Олон хүчин зүйлийн регрессийн ерөнхий хэлбэрийг дараахаар харуулав:

$$y_i = \beta_0 + \beta_1 \cdot x_1 + \beta_2 \cdot x_2 + \beta_3 \cdot x_3 + \dots + \beta_k \cdot x_k + \varepsilon_i$$

Энд, y нь тайлбарлагдагч хувьсагч, x нь тайлбарлагч хувьсагч, β_k нь x -ийн y -д үзүүлж буй нөлөөг хэмжих параметр, ε_i нь y -ийн тааруулсан утга ба түүний бодит утга хоёр хоорондын зөрүүг илтгэж байна. Бодит болон үнэлгээнээс гарч ирсэн тааруулсан утгууд нь зөрүүтэй байдаг учир үнэлгээний тэгшитгэлийг дараах байдлаар бичдэг.

$$y_i = \beta_0 + \beta_1 \cdot x_1 + \beta_2 \cdot x_2 + \beta_3 \cdot x_3 + \dots + \beta_k \cdot x_k + \varepsilon_i$$

Хамгийн бага квадратын загварт хамгийн сайн тохирох үнэлгээ нь үнэлгээний шулуун дахь утгаас эх олонлогийн утгын хазайх хазайлтыг хамгийн бага байлгаснаар тооцоологддог (Хэрвээ эх олонлогийн утга нь үнэлгээний шулуун дээр оршиж байвал хазайлт нь 0 байна). Өөрөөр хэлбэл дараах тэгшитгэлийн утга хамгийн бага байх болзлыг хангах ёстой.

$$\varepsilon_i = \sum (y_i - \beta_0 - \beta_1 \cdot x_1 + \beta_2 \cdot x_2 + \beta_3 \cdot x_3 + \dots + \beta_k \cdot x_k)^2 \quad i=1$$

Энэхүү ОХЗР-ийн шинжилгээ нь Гаусс-Марковын дараах 5 таамаглалыг хангасан тохиолдолд хамгийн сайн хазайлтгүй үнэлгээ болно. Үүнд:

1. Эх олонлогийн хувьд тайлбарлагч болон тайлбарлагдагч хувьсагчдын хоорон дахь хамаарал шугаман байна.
2. Өгөгдөл эх олонлогоос санамсаргүй түүвэрлэгдсэн байна.
3. Түүврийн тайлбарлагч хувьсагчдын аль нь ч тогтмол биш бөгөөд хоорондоо шугаман хамааралгүй байна.
4. Тайлбарлагч хувьсагчийн ямар ч утганд алдааны нөхцөлт дундаж утга тэг байна.
5. Тайлбарлагч хувьсагчийн утга бүрт алдааны нөхцөлт вариаци тогтмол байна.

Эдгээр Гаусс-Марковын таамаглалаас шинжилгээнд ажиглагдаж болохуйц асуудлуудын талаар авч үзье.

Мультиколлинеар

Гаусс-Марковын 3 дахь таамаглал ёсоор тайлбарлагч хувьсагчид хоорондоо шугаман хамааралгүй байхгүй байвал мультиколлинеарын асуудал үүсдэг. Мультиколлинеар нь үнэлэгдсэн коэффициентын нарийвчлалыг бууруулж, регрессийн загварын статистик ач холбогдлыг сулруулдаг. Регрессийн загварт мультиколлинеар үүссэн эсэхийг вариацийг өсгөгч хүчин зүйл (VIF)-г тооцон шалгадаг.

$$VIF_j = \frac{1}{(1 - R^2)}$$

Вариацийг өсгөгч хүчин зүйлийн утга 10-аас их гарсан нь мультиколлинеарын асуудал гарч ирснийг харуулна. Мультиколлинеарын асуудлыг засварлах нэг арга нь тухайн хувьсагчийг үнэлгээнээс хасч, шинэ хувьсагч оруулах юм.

Хетероскедастик

Гаусс-Марковын 5 дахь таамаглал дахь таамаглал биелэгдэхгүй тохиолдолд хетероскедастикийн асуудал үүсдэг. Уг асуудал үүссэн тохиолдолд үнэлэгдсэн утгад өөрчлөлт орохгүй боловч коэффициентуудын стандарт алдаа ихэсч, статистикийн хувьд ач холбогдолгүй болох магадлал нэмэгддэг. Тиймээс үнэлгээ хетероскедастикийн асуудалтай эсэхийг шалгах зайлшгүй хэрэгтэй бөгөөд үүнийг Брүш Пэген болон Вайтын тестээр тус тус шалгаж болно. Хэрэв хетероскедастикийн асуудал үүссэн бол тогтвортой стандарт алдаа бүхий ХБКА, жинлэсэн ХБКА, боломжит ерөнхийлсэн ХБКА зэргээр засварлаж болно.

4. ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

а. Өгөгдлийн шинжилгээ

Эконометрик шинжилгээний хэсэг нь үндсэн хоёр үнэлгээний загвараас бүрдэнэ. Эхний загвар нь ФАТФ-аас МУТС-тэй тэмцэхээр эрхлэн гаргадаг 40 зөвлөмжийн хэрэгжилтийн эдийн засгийн хувьсагчдад үзүүлэх нөлөөг авч үзэх бол хоёр дахь загварт уг 40 зөвлөмжийг хангалтгүй биелүүлэн ФАТФ-аас зарладаг жагсаалтад орсноос үүсэх эдийн засгийн хор уршгийг харуулна.

Загвар 1-ийн эконометрик шинжилгээг хийхдээ 2019 оны 33 улсын хөндлөн өгөгдлийг ашиглалаа. Энэхүү загварын хамаарлыг илрүүлэх гол хувьсагчаар улс орнуудын ФАТФ-аас мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэхээр гаргадаг 40 зөвлөмжийн биелэлтийг авч үзэв. ФАТФ улс орнуудын 40 зөвлөмжийн хэрэгжилтэд бүрэн биелүүлсэн (C-Compliant), ихэнх хэсгийг биелүүлсэн (LC-Largely Compliant), хэсэгчлэн биелүүлсэн (PC-Partly Compliant), биелүүлээгүй (NC-No Compliant) гэх 4 үнэлгээг тавьдаг. 33 улс орны 40 зөвлөмжийн биелэлтийг бүрэн биелүүлсэн тохиолдолд 4 оноо, ихэнх хэсгийг биелүүлсэн биелэлтэд 3 оноо, хэсэгчлэн биелүүлсэн биелэлтэд 2 оноо, биелүүлээгүй байдалд 1 оноог өгч индексжүүлэн тоон өгөгдлийг гаргаж авав. Харин тайлбарлагдагч хувьсагчаар нэг хүнд ногдох ДНБ-ийг сонгосон ба уг өгөгдлийг Пенн Дэлхийн Хүснэгт (Penn World Table)-ийн өгөгдлийн сангаас шинжилгээндээ авч ашиглалаа. Загварын хяналтын хувьсагчдаар эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болох инфляц, мөнгөний нийлүүлэлтийг сонгов. Эдийн засгийн бус ч эдийн засгийн хувьсагчдад нөлөөлж байдаг институцийн хувьсагч хуулийн хэрэгжилт (rule of law), хүмүүн капиталыг орлуулж хүний хөгжлийн индексийг бусад хувьсагчдаар загвар 1-т оруулж өгөв. Хуулийн

хэрэгжилт нь нийгэм, эдийн засгийн шударга ёсны талаарх нийгмийн үзэл баримтлалыг дэлгэрүүлж, ядуурал гачигдалд анхаарлаа хандуулах замаар эдийн засгийн өсөлтөд нөлөөлж байдаг. Харин хүмүүн капитал нь мэдлэг, ур чадвар, туршлага, эрүүл мэнд гэх мэт ажилчдын бүтээмжийг дээшлүүлэхэд нөлөөлөх чухал ойлголт ба эдийн засгийн өсөлттэй өндөр корреляцтай байна (Pelinescu, 2015).

Загвар 2-ын эконометрик шинжилгээнд 2002-2019 оны хугацаанд ФАТФ-аас зарласан жагсаалтад багтсан 27 улс орны панел тоон өгөгдлийг ашиглалаа. Уг загварт тухайн улс орон ФАТФ-ын зарласан жагсаалтад багтах үеийг дамми хувьсагч болгон оруулж, энэхүү хугацааны агшинд гадаадын шууд хөрөнгө оруулалт, бодит нэг хүнд ногдох ДНБ хэрхэн өөрчлөгдөхийг шинжиллээ. Тайлбарлагч хувьсагчдаар эдийн засгийн гол үзүүлэлтүүд болох инфляц, мөнгөний нийлүүлэлтийг сонгон авав. Бусад тайлбарлагч хувьсагчдаар хар, саарал жагсаалтад багтсан үеийг дамми хувьсагчаар, тухайн улс орны институцийн чадавхийг хуулийн хэрэгжилтээр төлөөлүүлээ.

Хүснэгт 1. Хувьсагчдын тайлбар

Тэмдэглэгээ	Хувьсагч	Тайлбар
gr	ФАТФ-ын 40 зөвлөмжийг индексжүүлсэн хувьсагч	Тухайн улс орны ФАТФ-аас эрхлэн гаргадаг 40 зөвлөмжийг биелүүлсэн байдлын индекс
inf	Инфляц	ДНБ-ий дефлятароор тооцсон инфляц, (жилээр)
m	Мөнгөний нийлүүлэлт	Тухайн улс орны нийлүүлсэн М3 мөнгөний тоо хэмжээ
fdi	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	Тухайн улсаас гадагшилсан ба тухайн улс руу орж ирсэн хөрөнгө оруулалтын цэвэр зөрүү
rol	Хуулийн хэрэгжилт	Нийгмийн дүрэм журамд түүнд оролцогчид нь хэр зэрэг итгэж, дагаж мөрддөг болон гэрээний хэрэгжилт, өмчийн эрх, цагдаа, шүүх ба гэмт хэрэг, хүчирхийлэлд өртөх магадлалын талаарх ойлголт
hdi	Хүний хөгжлийн индекс	Хүн капиталыг төлөөлүүлж оруулсан НҮБ-аас эрхлэн гаргадаг хүний хөгжлийн индекс
pcrgdpe	Нэг хүнд ногдох бодит ДНБ	2017 оны үнийг суурь болгосон нэг хүнд ногдох бодит ДНБ
corruption	Авилгалын хяналт	Төрийн эрх мэдлийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглаж байгаа зэрэг болон элитүүд хувийн ашиг сонирхолд барьцаалагдаж байгаа талаарх ойлголтыг авч үздэг.
listing	Жагсаалтанд орсон хугацаа	ФАТФ-аас зарладаг жагсаалтанд орсон нийт цаг хугацаа


Тайлбар: Хавсралт 2-д эконометрик шинжилгээнд ашигласан өгөгдлүүдийн эх сурвалжуудыг харууллаа.

4.2. ФАТФ-аас зарлах жагсаалтын эдийн засагт үзүүлэх нөлөө

Орчин үеийн даяарчлагдсан эдийн засагт гадаад худалдаа нь амин чухал хүчин зүйл бөгөөд дэлхийн ядуурлыг бууруулах зорилгод гол тоглогч болж оролцдог. Гадаад худалдааны үр ашгийг хурдасгагч гол элемент болсон санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүдэд ФАТФ, түүний үйл ажиллагаа сүүлийн арванд олон талаар нөлөөлж байна.

ФАТФ-аас МУТС-тэй тэмцэхээр гаргасан зөвлөмж, стандарт жил ирэх тусам чангарч байгаа ба тэдний эрхлэн гаргадаг зөвлөмжүүдийг биелүүлэхгүй байх нь тухайн улсыг МУТС онц ноцтой, туйлын өндөр хор уршигтай гэмт хэргийн эсрэг тэмцэх сонирхолгүй байгааг илтгэн өндөр эрсдэлтэй орнуудын жагсаалтад багтах шалтгаан болдог. ФАТФ-ын өндөр эрсдэлтэй орнуудын жагсаалт нь “нэрлээд & жигш (name & shame)” зарчмаар явагддаг ба ФАТФ-тай хамтын нягт ажиллагаа явуулдаг хөгжингүй гишүүн орнуудаас МУТС-тэй тэмцэх сонирхолгүй өндөр эрсдэлтэй орон руу шилжих хөрөнгийн урсгал багасдаг (Kida & Paetzold, 2021). Олон улс хоорондын хөрөнгийн урсгал олон хүчин зүйлсээр дамжин багасдаг. Энэхүү хэсэгт хар, саарал жагсаалтад багтсаны улмаас үүсэх хөрөнгийн урсгалын агшилтад нөлөөлөх эдийн засгийн сувгуудыг авч үзнэ.

Зураг 1. ФАТФ-аас зарлах жагсаалтын эдийн засагт үзүүлэх нөлөө



Эх сурвалж: Судлаачийн таамаглал

Эрсдэлээс зайлсхийх (De-risking)

Терроризм, хууль бус санхүүгийн үйл ажиллагаа нь дэлхийн санхүүгийн тогтвортой байдалд заналхийлж буй томоохон аюулуудын нэг болж байгаа нь уг төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх дэлхийн бодлого, зохицуулалтыг чангатгах хөшүүрэг болж байна. Энэхүү үйл явц нь хил дамнасан эдийн засгийн үйл ажиллагааг эрсдэлээс зайлсхийх хэлбэрээр бууруулж байна. ФАТФ эрсдэлээс зайлсхийх үйл ажиллагааг “санхүүгийн байгууллагууд тодорхой төрлийн үйлчлүүлэгчдээс тэдэнтэй холбогдох эрсдэлийг ФАТФ-ын эрсдэлд суурилсан арга барилын дагуу удирдах бус бизнесийн харилцаагаа тасалж буй үйл явц” гэж тодорхойлжээ (FATF, 2021).

Санхүүгийн байгууллага нь хил дамнасан гүйлгээ хийх, харилцагч банкын харилцааг бий болгох, шинэ үйлчлүүлэгчтэй болох шийдвэрээ зардал-үр ашгийн шинжилгээн дээр үндэслэн

гаргадаг. Эдгээр төрлийн шийдвэр гаргалт, явуулах үйл ажиллагаа нь тодорхой хэмжээний зардал ба орлогыг дагуулах ба үүний зөрүүн дээр банк үйл хөдлөл хийдэг. ФАТФ-ын хэрэгжүүлэх бодлого, зохицуулалт чангарсан нь санхүүгийн байгууллагуудын МУТС-тэй тэмцэх зардлыг үлэмж ихэсгэсэн байна. МУ-ын эсрэг хэрэгжилтийг зарцуулж буй Европын жижиг пүүс ойролцоогоор нийт хөрөнгийнхөө 1.77% (1 тэрбум ам.доллар), том пүүсүүд нийт хөрөнгийнхөө 0.08% (50 тэрбум ам.доллар)-ын зардлыг гаргадаг байна. Европ тивийн бүс нутаг дахь санхүүгийн институцүүд жилд дунджаар нийт 83.5 тэрбум ам.долларын зардал гаргадаг байна (LexisNexis, 2017). МУТС-тэй хангалтгүй тэмцэж буй бүс нутагтай хамтран ажиллах нь илүү их хяналт шалгалтыг шаардаж, зардлыг улам ихэсгэх тул үүнийг багасгахаар тус бүс нутаг дахь үйл ажиллагаагаа эрсдэлээс зайлсхийх зорилгоор хумьдаг.

Зөвхөн ФАТФ-ын гаргаж буй зөвлөмжийг хэрэгжүүлэхээс гадна санхүүгийн байгууллагуудын явуулж буй үйл ажиллагаа нь МУТС гэмт хэрэгтэй холбогдсон нь илэрвэл өндөр хэмжээний торгуулийг төлдөг. 2014 онд зөвхөн АНУ дангаараа эрх баригчдад 15 тэрбум ам.долларын торгуулийг төлсөн байна. 2020 оны Голдман Сакс Корпораци МУ гэмт хэрэгтэй холбогдсоноос үүдэн 2.9 тэрбум ам.доллар, Уэстпак Банк 900 сая ам.долларын торгуулийг тус тус төлсөн байна. Санхүүгийн гэмт хэрэгтэй хангалтгүй тэмцэн уг төрлийн үйл ажиллагаатай холбогдох нь их хэмжээний нэмэлт урьдчилан тооцоогүй зардлыг бий болгож, тухайн байгууллагын санхүүгийн тогтвортой байдалд хүчтэй нөлөөлдөг тул хөгжингүй орнуудын банк, санхүүгийн байгууллагууд МУТС-тэй холбогдон ФАТФ-аас зарласан жагсаалтад орнуудаас зайгаа барин эрсдэлээс зайлсхийдэг. МУТС гэмт хэрэгтэй холбогдох нь зөвхөн ил зардлаар ч зогсохгүй тухайн байгууллага, улс орны чадамж, нэр хүндийг унагааж, дэлхий дахинтай хамтран ажиллах боломжийг хаадаг байна. Эрсдэлээс зайлсхийх үйл явцаас үүдэн өндөр эрсдэлтэй саарал жагсаалтад орсон орнуудад бусад улс орнуудаас орж ирэх гүйлгээний хэмжээ 10%-иар багасдаг байна (Collin, Cook, & Soramäki, 2016).

Зээлжих зэрэглэл буурах

Улс орны эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдлыг илтгэх хамгийн хүчтэй хүчин зүйл бол зээлжих зэрэглэл юм. Улс орнууд болон хувь хүн, албан байгууллагын зээлжих зэрэглэлийг тухайн зээл хүсэгчийн зээлийн түүх, эргэн төлөгдөх чадварын мэдээлэл дээр үндэслэн Moody's, S&P Global, Fitch зэрэг үнэлгээний агентлагууд тодорхойлдог. Зээлжих зэрэглэл өндөртэй улс оронд хөрөнгө оруулалт ихээр хийгдэж, зээлийн хүү бага түвшинд тогтох давуу талтай байдаг бол доогуур зээлжих зэрэглэлтэй улсын хувьд тухайн оронд хөрөнгө оруулагчид итгэх итгэл багассаны улмаас зээлийн хүү өндрөөр тогтоогдох сөрөг нөлөөтэй байна. Зээлжих зэрэглэл өндөр байхын өөр нэгэн давуу тал нь гадаад улсаас зээлийн эх үүсвэртэй болох, гадаадын шууд хөрөнгө оруулалт гэх мэт бусад төрлийн санхүүжилтийг тухайн улс руу татах боломжийг олгодог. Хөрөнгө оруулалт хөрөнгийн нөөцийг нэмдэг бөгөөд эдийн засагт байгаа хөрөнгийн тоо хэмжээ нь түүний нийт гарцыг тодорхойлох чухал хүчин зүйл юм. Тиймээс хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлтөд туйлын чухал хувь нэмэр оруулдаг.

Зээлжих зэрэглэлд тухайн улсын МУТС-ийн эсрэг арга хэмжээний хэрэгжилт нь санхүүгийн хүчин зүйлсээс илүү хүчтэй нөлөөлдөг. Тухайн улсын эрсдэлийн үнэлгээний нэг хэлбэр нь зээлжих зэрэглэл бөгөөд ФАТФ-аас МУТС-ийн эсрэг хангалтгүй тэмцэж буй орнуудын жагсаалтад орох нь эрсдэлд сөрөг шок учруулдаг. Энэхүү эрсдэлийн үнэлгээгээр тухайн улсад гадаад орноос хөрөнгө оруулалт татах шалгуур хангасан эсэх, зээлийн хүүний түвшин, зээлийн хэмжээ, эргэн төлөгдөх хугацаа зэрэг чухал хүчин зүйлс тодорхойлогддог.

Зээлжих зэрэглэл буурах үед зээл олгох эрсдэл өндөр тул хөрөнгө оруулагч нар өндөр зардлаар санхүүжилт олгодог. МУТС-ийн эсрэг арга хэмжээний хангалтгүй хэрэгжилт нь

тухайн улсад орж ирэх зээлийн нийлүүлэлтийг багасгаж, зээлийн хүүний түвшинг өсгөх замаар тухайн улсын эдийн засгийн байдлыг муутгаж, санхүүгийн тогтвортой байдлыг алдагдуулан сөрөг үр дагаврыг авчирдаг. Гадаад эх үүсвэрээс хөрөнгө босгох зардал нэмэгдсэнээр тухайн улсын хөрөнгө оруулалтаар хийгдэх капиталын урсгалууд зогсонги байдалд орж, үйлдвэрлэл болон хөрөнгийн нөөц буурч, эдийн засаг муу тэнцвэрт очдог байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах

Хөрөнгө оруулалт нь эдийн засагт байгаа хөрөнгийн тоо хэмжээг нэмэгдүүлдэг гол хүчин зүйл бөгөөд капитал хуримтлагдах нь бүтээмжийг эрчимжүүлэн, улмаар эдийн засгийн өсөлтийг бий болгодог. Хадгаламж багатай, өр зээл ихтэй улс орнуудын эдийн засаг, санхүүгийн хөгжил нь гадаадын шууд хөрөнгө оруулалттай хүчтэй хамааралтай байна. Тиймээс эдгээр улс орнууд эдийн засгийн байдлаа муутгалгүйгээр санхүүгийн салбарын хөгжлийг эрчимжүүлэх, бүтээмжээ дээшлүүлэхийн тулд гадаадаас орох хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх шаардлагатай байдаг. Үүний сацуу, хөрөнгийн урсгал өндөр байх нь олон улсын зохицуулагч байгууллагаас тавигддаг хяналт, шалгалт нэмэгдүүлдэг учир зардлыг өсгөх шалтгаан болдог байна.

ФАТФ-аас тавигддаг МУТС-ийн эсрэг тэмцэх шаардлага, арга хэмжээ авах стандартуудыг хангалтгүй биелүүлэн тухайн байгууллагын зүгээс зарладаг жагсаалтад багтсан тохиолдолд i) хөрөнгө оруулалтын үр ашигтай байдалд хязгаарлалт бий болох, ii) хөрөнгө оруулалт саарах нөхцөлтэй тулгарах сөрөг үр дагавартай. Энэхүү хориг, арга хэмжээнүүдийн үр дүнд хууль ёсны шаардлага хангасан хөрөнгө оруулалтууд удаашрах хандлага бий болдог ба улмаар төлбөрийн тэнцлийн тогтвортой байдал алдагдаж, санхүүгийн систем нь эрсдэлд хэт өртөмтгий болдог.

Харин ФАТФ-аас гаргадаг зөвлөмж, тавигддаг шаардлагуудыг хангалттай, сайн биелүүлэх нь тухайн улсын нэр хүндийг олон улсад нэмэгдүүлдэг. Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь компаниуд олон улсын борлуулалтаа өргөжүүлэхийн тулд тэдэнд шаардагдаж буй санхүүжилт, ноу хауг олж авах үйл явц бүхий хөгжиж буй эдийн засагт чухал ач холбогдолтой зүйл юм. Дэд бүтэц, эрчим хүч, усны салбарт хувийн хөрөнгө оруулалт хийх нь эдийн засгийн чухал хөдөлгөгч хүч болдог бөгөөд хөдөлмөрийн зах зээлд ажлын байр, цалин хөлсийг нэмэгдүүлэхэд тусалдаг байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт хязгаарлагдсан тохиолдолд тухайн улсын үндсэн хөрөнгийн нөөцийн хэмжээ багасаж, үйлдвэрлэл бууран, санхүүгийн салбарын хөгжил саатаж, эдийн засгийн тогтвортой байдал алдагдах эрсдэлтэй байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хүлээн авах чадваргүй болсон улс орон гадаадын зээл, зээлийн хүүг төлөх чадамжгүй болон олон улсын зах зээл дээрх нэр хүндээ унагааж, өрийн мөчлөгт өртөх хандлагатай байдаг. Тийм ч учраас гадаадын шууд хөрөнгө оруулалтын чөлөөтэй урсгал нь эдийн засгийн сайн тэнцвэрт хүргэх гол түлхүүр болдог.

Корреспондент банкны харилцааг алдах

Корреспондент банкны харилцаа гэдэг нь нэг санхүүгийн байгууллага бусад улс орон дахь санхүүгийн байгууллагад банкны үйлчилгээ үзүүлж байгаа үйл явц юм. Дотоодын банкууд үргэлж хил дамнасан хадгаламж болон зээлийн данстай байх, улс хооронд гүйлгээ хийх шаардлагатай байдаг бөгөөд үүнийг корреспондент банк гүйцэтгэж байдаг. Дэлхий дээрх олон улс орнууд гадаад худалдаанаас хүчтэй хамааралтай байдаг нь корреспондент банкны оролцоотой хил дамнасан гүйлгээ явуулах шаардлагыг ихэсгэж байна. Корреспондент банкны

харилцаатай байх нь тухайн бүс нутагт олон улсын зах зээлд төлбөр гүйлгээг илүү түргэн шуурхай, зардал багатай хийх боломжийг олгох замаар үр ашигтай байдлыг бий болгодог бол ийм төрлийн харилцаа байхгүй бүс нутагт төлбөр тооцоо удаан, өндөр зардалтай байх хандлагатай. Үүгээр ч зогсохгүй корреспондент банкны харилцаа нь сайн бүтэцлэгдсэн олон улсын санхүүгийн системийн гол бүрэлдэхүүн хэсэг болж оролцдог.

ФАТФ-ын зөвлөмжид тулгуурласнаар корреспондент банк өөрийн харилцагч банк, санхүүгийн байгууллагууд үйлчлүүлэгчид болон үйл ажиллагаанд нь хяналт тавих шаардлагатай байдаг. ФАТФ-ын зөвлөмжийг биелүүлэлгүй, МУТС-ийн эсрэг стандартыг баримтлаагүйгээс үүдэн “саарал” ба “хар” жагсаалтад орох нь тус улстай харилцах корреспондент банкны гүйлгээг МУТС гэмт хэрэгтэй холбогдсон эсэхийг шалгах хяналтын зардлыг их хэмжээгээр өсгөж, үр ашгийг бууруулж байна. Үлэмж хэмжээний нэмэлт зардлыг хүлээн авч, эрсдэлд орж байгаа нь корреспондент банкны хамтын ажиллагаа явуулах хүслийг бууруулж, уг төрлийн харилцаа зогсох үр дагаварт хүргэдэг. Сүүлийн арван жилд хил дамнасан корреспондент банкны харилцаа 20 гаруй хувиар багассаны гол шалтгаан нь ФАТФ-ын МУТС-тэй тэмцэхээр явуулж буй бодлого болж байна.


Олон улсын худалдаа, хил дамнасан төлбөр тооцооноос өндөр хамааралтай байх нь тухайн эдийн засгийг корреспондент банкнаас өндөр хамааралтай болгож байна. Корреспондент банкны харилцаа алдагдах нь тухайн эдийн засагт хэд хэдэн сувгаар нөлөөлж байдаг, i) олон улсын худалдаа, мөнгөн гуйвуулга, хөрөнгө оруулалтын урсгалыг бууруулах, ii) төлбөр тооцооны гүйлгээ удааширнаас үүдэн ажил хэрэг явуулах зардлыг өсөх, iii) олон улсын худалдаа гүйлгээнээс хамааралтай эдийн засгийн салбаруудад сөрөг нөлөө үзүүлэх замаар нийт эдийн засагт хүнд цохилтыг өгдөг байна. Тухайлбал, Белиз улсын банкны өгөгдөл дээр хийсэн шинжилгээ нь корреспондент банкны харилцаа байхгүй болсон нь эдийн засгийг багадаа 1 хувиар, ихдээ 6 хувиар агшаасныг харуулжээ (Alleyne, et al., 2017).

3.3 Эконометрик шинжилгээ

Энэхүү дэд бүлэгт судлагдсан байдлын тоймоос гарган авч өмнөх хэсэгт хийсэн онолын таамаглалыг эконометрик шинжилгээний тусламжтай шалгана. Эконометрик шинжилгээний хэсэг нь i) ФАТФ-ын 40 зөвлөмжийн эдийн засгийн гүйцэтгэлд үзүүлэх нөлөө, ii) ФАТФ-ын 40 зөвлөмжийг хангалтгүй биелүүлснээс үүдэн хар, саарал жагсаалтад орсноос үүдэх сөрөг нөлөө гэсэн хоёр үндсэн шинжилгээнээс бүрдэнэ.

Загвар 1. ФАТФ-ын 40 зөвлөмжийн эдийн засгийн гүйцэтгэлд үзүүлэх нөлөө

Зураг 2. ФАТФ-ын 40 зөвлөмжийн хэрэгжилт болон нэг хүнд ногдох бодит ДНБ-ы хамаарал



Дээрх зурагт нэг хүнд ногдох бодит ДНБ ба ФАТФ-ын 40 зөвлөмж хоорон дахь 2019 оны хамаарлыг харууллаа. Уг хоёр хувьсагчид хооронд эерэг хамаарал ажиглагдаж байгаа бөгөөд ФАТФ-ын зөвлөмжүүдийг чухалчлан биелүүлж байгаа орнуудад орох валют болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал их байх хандлагатай байдаг. Уг хамаарлыг эконометрик аргаар загвар 1-ийн хүрээнд шинжлэх бөгөөд дараах тэгшитгэлийг ашиглана:

$$\ln prcrgdpe = \beta_0 + \beta_1 \cdot rp + \beta_2 \cdot rol + \beta_3 \cdot inf + \beta_4 \cdot lnm + \beta_5 \cdot hdi + \varepsilon_i$$

Дээрх тэгшитгэлийг 2019 оны байдлаарх 42 улс орны ФАТФ-ын 40 зөвлөмжийн хэрэгжилтийн өгөгдөл дээр үнэлгээг хийж, дараах үр дүнг гаргаж авлаа.

Хүснэгт 2. ФАТФ-ын 40 зөвлөмжийн нэг хүнд ногдох бодит ДНБ-д үзүүлэх нөлөөний үнэлгээ
Тайлбарлагдагч хувьсагч: $\ln prcrgdpe$

Хувьсагчид	Коэффициент	Стандарт алдаа	T стат	P утга
Огтлогч	3.408366	0.485116	7.0259	0.0000***
rp	0.007996	0.00317	2.5223	0.0179**
rol	0.093458	0.074255	1.2586	0.2189
inf	0.016113	0.010504	1.534	0.1367
lnm	0.018883	0.01274	1.4822	0.1499
hdi	6.103549	0.439621	13.884	0.0000***

***- 99 хувь, **- 95 хувь, *-90 хувийн итгэх түвшин

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүснэгт 2-т ФАТФ-ын 40 зөвлөмжийн нэг хүнд ногдох бодит ДНБ-д үзүүлэх нөлөөг Гаусс-Ньютон / Маркуартын аргаар үнэлсэн үнэлгээний үр дүнг харуулсан байна. Загвар 1-ийн үр дүнгээр нэг хүнд ногдох бодит ДНБ ба ФАТФ-ын 40 зөвлөмжийн хэрэгжилт хооронд эерэг хамаарал байгааг харуулсан ба тухайн улс орон ФАТФ-ын 1 зөвлөмжид ахиц дэвшил гаргах нь нэг хүнд ногдох ДНБ-г 0.7%-иар өсгөдгийг харууллаа. ФАТФ-ын 40 зөвлөмжийн

үнэлгээний утга нь 95%-ийн итгэх түвшинд ач холбогдолтой гарсан дээр коэффициентийн утга багагүй байгаа нь уг хоёр хувьсагчийн хооронд хүчтэй хамаарал байгааг харуулж байна.

Загвар 2. ФАТФ-аас зарлах жагсаалтанд багтахын эдийн засагт үзүүлэх хор уршиг

ФАТФ-ын МУТС-тэй хангалтгүй тэмцэх эсвэл тэмцэх сонирхолгүй байгаа орнуудын жагсаалт гаргаж байгаа үйл ажиллагаа нь “нэрлээд & жигшээ” зарчмаар явагддаг. Уг жагсаалтад орох нь тухайн улс орны зээлжих зэрэглэлийг бууруулж, өндөр эрсдэлтэй орнуудын тоонд багтаадаг. Үүнээс үүдэн гадаадын хөрөнгө оруулагчид, банк санхүүгийн байгууллагууд тус бүс нутаг дахь хамтын ажиллагаагаа хумих шаардлага гардаг байна. Эрсдэлээс зайлсхийж байгаа энэхүү үйл явцад хөгжингүй улсуудтай харьцуулахад хөгжиж буй улсууд илүү эмзэг байдаг (Collin, Cook, & Soramäki, 2016). Загвар 2-ын хүрээнд хар, саарал жагсаалт болон гадаадын шууд хөрөнгө оруулалт, нэг хүнд ногдох бодит ДНБ хооронд дахь хамаарлыг бага орлоготой ба өндөр орлоготой улс орнууд дээр салган шинжиллээ. ФАТФ-аас зарлах жагсаалтанд орсон 12 өндөр орлоготой, 27 бага орлоготой улсуудын 2002-2019 оны панел өгөгдөл дээр шинжилгээг ашиглав.

Дараах тэгшитгэлийг ашиглан үнэлгээг хийв.

Өндөр орлоготой улс:

$$pcrgdpe = \beta_0 + \beta_1 \cdot inf + \beta_2 \cdot m + \beta_3 \cdot listing + \beta_4 \cdot fdi + \varepsilon_i$$

$$fdi = \beta_0 + \beta_1 \cdot inf + \beta_2 \cdot m + \beta_3 \cdot rol + \beta_4 \cdot listing + \varepsilon_i$$

Бага орлоготой улс:

$$pcrgdpe = \beta_0 + \beta_1 \cdot inf + \beta_2 \cdot m + \beta_3 \cdot rol + \beta_4 \cdot listing + \varepsilon_i$$

$$fdi = \beta_0 + \beta_1 \cdot inf + \beta_2 \cdot m + \beta_3 \cdot pcrgdpe + \beta_4 \cdot corruption + \beta_4 \cdot listing + \varepsilon_i$$

Эдгээр тэгшитгэлийг ашиглан хийсэн үнэлгээний үр дүнг доор харууллаа.

Хүснэгт 3. ФАТФ-ын жагсаалтын өндөр орлоготой улс орнуудад үзүүлэх нөлөө

Хувьсагчид	Коэффициент	Стандарт алдаа	T стат	P утга
Огтлогч	20502.83	335.9877	61.023	0.0000***
inf	15.41187	21.9694	0.7015	0.4838
m	4.17E-11	1.38E-11	3.0244	0.0028***
listing	761.1613	420.2407	1.8113	0.0716*
fdi	2.66E-08	6.74E-08	0.3943	0.6938
Тайлбарлагдагч хувьсагч: fdi				
Хувьсагчид	Коэффициент	Стандарт алдаа	T стат	P утга
Огтлогч	-1.81E+09	4.21E+08	-4.298	0.0000***
inf	-1049979	23060547	-0.046	0.9637
m	3.85E-05	1.47E-05	2.6306	0.0092***
rol	-3.03E+08	1.06E+09	-0.286	0.7751
listing	-7.67E+08	4.44E+08	-1.727	0.0858*
***- 99 хувь, **- 95 хувь, *-90 хувийн итгэх түвшин				

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүснэгт 3-т ФАТФ-аас зарладаг өндөр эрсдэлтэй орнуудын жагсаалтад орж байсан өндөр орлоготой 12 улсын жагсаалт багтсанаар үүсэх гадаадын шууд хөрөнгө оруулалт ба нэг хүнд

ногдох бодит ДНБ-ий бууралтыг харууллаа. Өндөр орлоготой улс орнууд ФАТФ-аас зарладаг жагсаалтад багтах нь нэг хүнд ногдох бодит ДНБ-г 761 ам.доллараар, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг 767 сая доллараар бууруулдаг байна.

Хүснэгт 4. ФАТФ-ын жагсаалтын бага орлоготой улс орнуудад үзүүлэх нөлөө

Тайлбарлагдагч хувьсагч: *pcrgdpe*

Хувьсагчид	Коэффициент	Стандарт алдаа	T стат	P утга
Огтлогч	6729.607	299.611	22.4611	0.0000***
<i>inf</i>	3.573641	9.64067	0.37068	0.711
<i>m</i>	2.99E-13	1.21E-13	2.47282	0.0138**
<i>rol</i>	1727.951	304.056	5.683	0.0000***
<i>listing</i>	-823.2471	458.146	-1.7988	0.0727*

Тайлбарлагдагч хувьсагч: *fdi*

Хувьсагчид	Коэффициент	Стандарт алдаа	T стат	P утга
Огтлогч	2.03E+09	8.69E+08	2.33266	0.0201**
<i>inf</i>	-12572684	6201388	-2.0274	0.0432**
<i>m</i>	-1.53E-06	1.17E-07	-13.085	0.0000***
<i>pcrgdpe</i>	-810854.4	126704	-6.3996	0.0000***
<i>corruption</i>	-1.47E+09	4.91E+08	-3.0044	0.0028***
<i>listing</i>	-5.63E+08	2.64E+08	-2.13121	0.0336**

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүснэгт 4-т бага орлоготой улс орнууд ФАТФ-аас зарладаг жагсаалтад багтах нь нэг хүнд ногдох бодит ДНБ ба гадаадын шууд хөрөнгө оруулалтад хэрхэн нөлөөлөхийг харууллаа. Уг жагсаалтад багтах нь тухайн улс орны нэг хүнд ногдох бодит орлогыг 823 ам.доллараар, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг 563 сая доллараар бууруулж байна.

Дээрх хоёр үнэлгээг харьцуулан шинжилбэл ФАТФ-аас зарласан жагсаалтад багтаснаас үүсэх эдийн засгийн хор уршиг нь өндөр орлоготой улсуудаас илүү бага орлоготой улсуудад илүү хүнд мэдрэгдэх нь харагдаж байна. Тухайлбал, үнэлгээгээр гарч ирсэн нэг хүнд ногдох бодит орлогын хэмжээ бага орлоготой улсуудад огцом буурч байгаа бөгөөд гадаадын шууд хөрөнгө оруулалтад үзүүлэх сөрөг нөлөө ч өндөр орлогтой улсуудтай харьцуулахад их зөрүүгүй байна.

5. ДҮГНЭЛТ

Дэлхийн санхүүгийн тогтвортой байдалд заналхийлж буй хамгийн том хүчин зүйлсийн нэг бол МУТС үйл ажиллагаа юм. Энэхүү төрлийн гэмт хэргийн эсрэг арга хэмжээ авч, дэлхийн жишиг болсон бодлогыг боловсруулдаг байгууллага болох ФАТФ-ын цар хүрээ сүүлийн жилүүдэд хурдацтай өсжээ. ФАТФ-аас гаргах санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх зөвлөмжийг биелүүлэх нь асар их зардал, цаг хугацаа, хүчин чармайлтыг шаардах ч дэлхийн улс орон бүр үүнийг биелүүлэх хариуцлага хүлээж байна. Харин ФАТФ-ын дүрэм журам, стандартыг хэрэгжүүлэхгүй байгаа орныг “нэрлээд & жигшээ” зарчмын дагуу олон улс дахинд зарлаж, өндөр эрсдэлтэй орнуудын тоонд багтаадаг. Арга хэмжээ авахуулсан бүс нутагтай хамтын ажиллагаа явуулдаг эдийн засгийн оролцогчид өндөр торгууль, их хэмжээний нэмэлт зардал, нэр хүнд уналтын эрсдэл зэрэг олон шалтгаанаас үүдэн хөрөнгөө уг бүс нутгаас зайлсхийн гадагшлуулдаг.

Олон улсын эдийн засгийн харилцаанд оролцогч ЗГ, банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид ФАТФ-аас зарлах жагсаалтад тулгуурлан бизнесийн шийдвэрээ гаргадаг байна. Энэхүү судалгааны ажлаар эдийн засагт оролцогчдын уг шийдвэр гаргалт нь олон улсын хөрөнгийн урсгалд хэрхэн нөлөөлж байгаа талаар шинжиллээ. Шинжилгээний үр дүнд ФАТФ-аас зарлах жагсаалтад багтах нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг өндөр орлоготой улс оронд 767 сая ам.доллараар, бага орлоготой улс оронд 563 сая ам.доллараар тус тус бууруулдаг гэсэн эмпирик нотолгоог гарган авав. Мөн хар, саарал жагсаалтад багтах нь дан ганц гадаадын шууд хөрөнгө оруулалтад бус нэг хүнд ногдох бодит орлогод ч сөргөөр нөлөөлдөг байна. Үүгээр ч зогсохгүй ФАТФ-аас зарлах жагсаалтад багтах шалтгаан болсон зөвлөмжийн хангалтгүй биелэлт нь нэг хүнд ногдох бодит орлогод сөрөг нөлөө үзүүлдэг. Тухайлбал, ФАТФ-ын МУ-тай тэмцэх 40 зөвлөмжийн нэг зөвлөмжийн биелэлтэд ухралт гаргах нь нэг хүнд ногдох бодит ДНБ-г 0.7%-иар багасгадаг байна.

МУТС-ийн талаарх бодит, дэлгэрэнгүй, ил тод мэдээлэл байдаггүй нь уг гэмт хэрэг, үүнтэй холбогдох эдийн засгийн хор уршгийг бүрэн тооцоолох боломжийг хомс болгож байна. МУТС-т тогтолцооны эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөг судалсан эмпирик ажлууд ч мөн түгээмэл бус байдаг учир уг асуудалд нэмэлт судалгаа, шинжилгээнүүд хэрэгцээтэй байна. Энэхүү судалгааны ажлаар ФАТФ-ын зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлэхийн зардал болон үүнээс улбаалан ФАТФ-ын жагсаалтад орох нь ямар хор уршигтайг харуулахыг оролдсон бөгөөд макро хувьсагчдын гүн дэх үзүүлэлтүүдэд шинжилгээ хийснээр уг хамаарлыг илүү нарийвчлан харуулах боломжтой.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Alleyne, T., Bouhga-Hagbe, J., Dowling, T., Kovtun, D., Myrvoda, A., Okwuokei, J., & Turunen, J. (2017, August). Loss of Correspondent Banking Relationships in the Caribbean: Trends, Impact, and Policy Options. IMF Working Paper.

Balakina, O., D'Andrea, A., & Masciandaro, D. (2016, May). Bank Secrecy in Offshore Centres and Capital Flows: Does Blacklisting Matter? BAFFI CAREFIN Centre Research Paper.

C.Morse, J. (2019, March 6). International Organization. Blacklist, Market Enforcement, and Global Regime to Combat Terrorist Financing, pp. 61-97.

Collin, M., Cook, S., & Soramäki, K. (2016, October 20). The Impact of Anti-Money Laundering Regulation on Payment Flows: Evidence from SWIFT Data. CGD Working Paper 445.

Cox, D. (2014). Handbook of Anti Money Laundering. United Kingdom: John Wiley & Sons, Ltd. Duynes, P. C. (2018). The Critical Handbook of Money Laundering. New York: Palgrave Macmillan.

Farias, M. E., & Almeida, M. A. (2014). DOES SAYING 'YES' TO CAPITAL INFLOWS NECESSARILY MEAN GOOD BUSINESS? THE EFFECT OF ANTIMONEY LAUNDERING REGULATIONS IN THE LATIN AMERICAN AND THE CARIBBEAN ECONOMIES. Economics & Politics, 96-127.

FATF. (2021, October 27). High-Level Synopsis of the Stocktake of the Unintended Consequences of the FATF Standards. Retrieved from FATF-GAFI Web site: <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/Unintended-Consequences.pdf>

FATF. (2022, March 21). Consolidated assessment ratings. Retrieved from FATF Web site: <https://www.fatf-gafi.org/publications/mutualevaluations/documents/assessment-ratings.html>

FATF. (2022, March 21). FATF Members and Observers. Retrieved from FATF Web site: <https://www.fatf-gafi.org/about/membersandobservers/>

FATF. (2022, March 21). Money Laundering. Retrieved from FATF Web site: <https://www.fatf-gafi.org/faq/moneylaundering/>

Hopton, D. (2006). Money Laundering: a Concise Guide for All Businesses. Burlington: Gower Publishing Limited.

The International Bank for Reconstruction and Development. (2006). Reference Guide to Anti-Money Laundering and Combating the Financing of Terrorism. Washington D.C.: The International Bank for Reconstruction and Development.

Kida, M., & Paetzold, S. (2021, May). The Impact of Gray-Listing on Capital Flows: An Analysis Using Machine Learning. IMF Working Paper.

Kudrle, R. T. (2008, August 1). Did Blacklisting Hurt the Tax Havens? Journal of Money Laundering Control.

LexisNexis. (2017). The True Cost of Anti-Money Laundering Compliance. LexisNexis.

Pelinescu, E. (2015). The Impact of Human Capital on Economic Growth. Procedia Economics and Finance, 174-190.

TURNER, J. E. (2011). Money Laundering Prevention. New Jersey: John Wiley & Sons, Inc.

Бямбацогт, & Очгэрэл. (2020). Саарал жагсаалтад орсноор эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөө. Монголбанк товхимол 15, pp. 165-186.

ХАВСРАЛТ*Хавсралт 1. ФАТФ-ын жагсаалтад багтаж байсан орнууд*

Азербайжан	Иран	Пакистан
Айсланд	Ирак	Панам
Албани	Камбож	Папау Шину Гвиней
Алжир	Катар	Парагвай
Ангол	Кейман арал	Сан-Томе ба Принсип
Антигуа ба Барбуда	Кени	Сент Винсент ба Гранадис
Аргентин	Кипр	Серби
Афганистан	Киргизстан	Синт Мартин
Багам	Күүк арал	Сири
Бангладеш	Куб	Судан
Босниа ба Херзеговниа	Кувэйт	Суринам
Ботсвана	Лаос	Тажикстан
Бруней	Лебанон	Тайланд
Вануату	Лейхтенштейн	Танзани
Венесуэл	Маршал арал	Тринадад ба Тобаго
Вьетнам	Монгол	Тунис
Гана	Морокко	Турк
Гондурас	Мьянмар	Туркменистан
Грек	Намиб	Уганда
Гринада	Науру	Узбекстан
Гуатамала	Непал	Украйн
Гуаян	Неуй	Унгар
Доминик	Нигер	Филиппин
Египт	Никарагуа	Хайти
Зимбабве	ОХУ	Хойд Солонгос
Йемен	Индонез	Шри Ланка
Израйл	Этиоп	Экуадор

Эх сурвалж: ФАТФ-ын тайлан 2000-2019

Хавсралт 2. Өгөгдлийн эх сурвалжб

Тэмдэглэгээ	Хувьсагч	Эх сурвалж
gr	ФАТФ-ын 40 зөвлөмжийг индексжүүлсэн хувьсагч	ФАТФ-ын нэгдсэн үнэлгээний тайлан
inf	Инфляц	Дэлхийн Банк
m	Мөнгөний нийлүүлэлт	ОУВС
fdi	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	ОУВС, төлбөрийн тэцнлийн статистик тайлан
rol	Хуулийн хэрэгжилт	Дэлхийн Банк, Дэлхийн засаглалын үзүүлэлтүүд
hdi	Хүний хөгжлийн индекс	НҮБ, Хүний хөгжлийн индексийн тайлан 2019
pcrgdpe	Нэг хүнд ногдох бодит ДНБ	Пенн дэлхийн өгөгдлийн хүснэгт
corruption	Авилгалын хяналт	Дэлхийн Банк, Дэлхийн засаглалын үзүүлэлтүүд
listing	Жагсаалтанд орсон хугацаа	ФАТФ-ын жилийн тайлан, 2000-2019



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА
МОНГОЛБАНК

**МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ГАРЧ
БУЙ ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ**

Ц.Мишээл⁴³, С.Хулан,⁴⁴ Д.Өсөхжаргал⁴⁵

⁴³ Санхүү эдийн засгийн их сургууль, Санхүү удирдлагын тэнхим, II курсийн оюутан. Цахим хаяг: b20fa1199@ufe.edu.mn

⁴⁴ Санхүү эдийн засгийн их сургууль, Санхүү удирдлагын тэнхим, II курсийн оюутан. Цахим хаяг: b20fa1267@ufe.edu.mn

⁴⁵ Санхүү эдийн засгийн их сургууль, Санхүү удирдлагын тэнхим, II курсийн оюутан. Цахим хаяг: b20fa1118@ufe.edu.mn

ТОВЧ ХУРААНГУЙ

Дэлхий нийтийн дунд илт хууль бусаар мөнгө угааж, түүнээс ашиг хүртэгч олшрох нь жинхэнэ асуудал болоод байна. Техник технологи хөгжихийн хэрээр санхүүгийн системийн хяналтыг сайжруулах шаардлага ихээр үүсэхийн зэрэгцээ шийдэл олохгүй аваас санхүүгийн системийг гэмтээх, сүйтгэх аюул нүүрлээд байгаа тул энэхүү судалгааны ажлаараа дижитал шилжилтийг ашиглан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хяналтын тогтолцоог сайжруулах шийдлийг олохыг зорив. Судалгааны явцад мөнгө угаахтай тэмцэх дижитал шилжилтийг нэвтрүүлэн ажиллаж буй банк, санхүүгийн байгууллагуудын кейс судалгаа, дэлхийн дахинд хэрэгжүүлж байгаа мөнгө угаахтай тэмцэх хяналтын тогтолцоо ямар байгааг судлан, судалгааны үр дүнд арилжааны банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэж болох шинэ дижитал арга зам, шийдэл олно хэмээн үзсэн.

ТҮЛХҮҮР ҮГ

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаахтай тэмцэх дижитал шилжилт

1. ОРШИЛ

Мөнгө угаах үйл ажиллагаа нь бүхий л улс орнуудад тулгамдаж буй асуудал бөгөөд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй байх нь гэмт хэрэгтнүүдэд мөнгө угаах үйл ажиллагааг дэлгэрүүлэх, түүнээс ашиг хүртэх боломжийг олгож байна. Техник технологи хөгжихийн хэрээр мөнгө угаагчдын арга улам нарийсаж, төрөл бүрийн арга техник ашиглан мөнгийг их хэмжээгээр угаасаар байна. Мөнгө угаах гэмт хэрэг нь нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж, банкны үйл ажиллагаа болон нэр хүндэд ихээхэн хүндрэл учруулж, үйл ажиллагаанд томоохон гарз хохиролтой байдаг ба мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх шийдэл дутмаг байдаг учир арилжааны банкны хувьд энэхүү гэмт хэргийн гаралтыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хяналтын үйл ажиллагааг улам сайжруулахад орчин үеийн санхүүгийн техник технологи, арга аргачлал зайлшгүй хэрэгтэй байна. 1990-д оны эхэн үеэс цахим шилжилт гэх нэр томъёо олон улсад судлагдахуун болж, 2000-д оноос цахим засаглалын санаачилга гарч улс орнууд цахим засаглалын санаачилгад нэгдэж цахим шилжилтийг эрчимжүүлсэн. Цаг үеийн шинэчлэлээс үүдэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх арга аргачлал өөрчлөгдөж, дижитал шилжилт хийн сайжруулалт гаргах нь нэн чухал асуудал болоод байна.

2. ОНОЛЫН ХЭСЭГ

2.1. Мөнгө угаалт

1920 оны эхээр мөнгө угаах нэр томъёог анх АНУ-ын мафийн толгойлогч болох Аль Капоне болон тухайн мафийн Итали гаралтай хүмүүсээс үүдэлтэй гэж үздэг бөгөөд архи, хар тамхи, биеэ үнэлэлтээс олсон хууль бус ашгаа өөрийн хувцас угаалгын газрын хууль ёсны ашиг мэт харагдуулдаг байсан бөгөөд жил бүр 100 сая долларын хууль бус орлого олж үүнийгээ нуун далдалдаг байсан нь ийнхүү мөнгө угаах гэх нэр томъёо болгожээ (About Business Crime Solutions, 2017).

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) нь олон улсын санхүүгийн системийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс сэргийлэх бодлого боловсруулж, дэлгэрүүлэх үүрэг бүхий засгийн газар хоорондын, хараат бус байгууллага юм. ФАТФ нь Их долоогийн уулзалтаар 1989 онд байгуулагдсан, 35 өндөр хөгжилтэй улс, 2 бүс нутгийн холбоо гишүүдээс бүрддэг бөгөөд бүс нутгийн байгууллагуудаар дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг. ФАТФ-ын бүс нутгийн байгууллага болох Ази, Номхон далайн бүсийн байгууллага (The Asia/Pacific Group on Money Laundering буюу APG) нь 1997 онд байгуулагдсан бөгөөд бүс нутгийн хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) үйл ажиллагааг зохицуулах байгууллага билээ. (Монгол банк)

Монгол Улс 2003 онд “Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын конвенц”-д нэгдэн орж, 2004 онд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх олон улсын бодлогыг тодорхойлдог Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын салбар байгууллага болох Ази, Номхон далайн бүс нутгийн мөнгө угаахтай тэмцэх байгууллага (APG)-д элсэн орсноор мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээх болсон. (СХЗ, 2013)

Монгол Улс 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталж энэхүү хууль нь 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн шинэчилсэн найруулгаар хэрэгжин Санхүүгийн мэдээллийн албыг байгуулж мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндэс, суурийг бий болгосон. (Монгол банк, 2016)

"Мөнгө угаах" гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг хэлнэ; (МУ-ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1)

Сүүлийн үед онлайн банк, криптовалюта гэх цахим хэрэгслүүд нь арилжааны банк болон зохицуулагчдад мэдэгдүүлэлгүйгээр мөнгө шилжүүлэх, буцааж авахад хялбар болгодог учир сүүлийн үед тэдний тусламжтайгаар мөнгө угаах нь элбэг болсон. Мөнгө угаах нь олон гэмт хэргээр илэрдэг бөгөөд нэгдүгээрт гэмт хэрэгтэн эрүүгийн хэргийн орлогыг бий болгодог ба үүнийг урьдчилсан гэмт хэрэг ч гэж нэрлэдэг. Дараа нь гэмт хэрэгтэн хууль бус орлогоо хууль ёсны гарал үүсэлтэй мэт харагдуулах шаардлага үүсдэг байна. Өөрөөр хэлбэл, мөнгө угаах нь маш их мөнгийг чөлөөтэй ашиглахын тулд гэмт хэргийн гарал үүслийг далдалдаг үйл ажиллагаа юм.

2.2. Мөнгө угаах үйл ажиллагааны үе шатууд

Мөнгө угаах үйл ажиллагаанд тансаг эд бараа, үнэт зүйлсийг худалдан авах, эргүүлэн зарах, хууль ёсны бизнесүүд болон "халхавч компаниуд"-ын олон улсын цахим хуудсаар дамжуулан мөнгө оруулж, гаргах хүртэлх үйл ажиллагаануудыг оруулан үздэг. Иймэрхүү мөнгө угаах олон янзын аргууд байдаг ч мөнгө угаах үйл ажиллагаа нь ихэвчлэн дараах гурван үе шатнаас бүрддэг байна. Үүнд:

- a. Байршуулалт: Гэмт хэргийн замаар олсон орлого, хөрөнгийг хууль ёсны болгож санхүүгийн системд байршуулах, мөнгөн тэмдэгтийг өөр дэвсгэрт, гадаад валютаар солиулах, бэлэн мөнгийг тээвэрлэх эсвэл банкны дансанд байршуулах гэх мэт.
- b. Далдлах: Хууль бус, гэмт хэргийн гаралтай хөрөнгө, орлогын гарал үүслийг нуун дарагдуулах зорилгоор бэлэн бус шилжүүлэг хийх, өөр банкны дансанд байршуулах, банк хооронд хувааж, нийлүүлж шилжүүлэх, олон банк санхүүгийн байгууллага, улс орнуудаар дамжуулан эх үүсвэрийг нуун далдлах гэх мэт.
- c. Нэгтгэх: Нэгэнт гарал үүслийг нь тогтооход хүндрэлтэй болсон эсхүл хууль ёсны мэт харагдуулсан мөнгөө буцаан өөрийн нэр дээр төвлөрүүлэх.

2.3. Мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх хэрэгцээ, шаардлага

Хяналтгүй санхүүгийн тогтолцоо нь санхүүгийн бие даасан байгууллага төдийгүй улс гүрнийг бүхэлд нь сүйрэлд хөтлөх үр дагавартай. Олон улсын түвшинд нийтээр мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг сайжруулахгүй аваас дэлхийн санхүүгийн системийн даяаршил, санхүүгийн байгууллагын хооронд санхүүгийн хэрэгслийг чөлөөтэй хөрвөх

боломжийг бүрдүүлж байгаа нь мөнгө угаах үйл ажиллагааг хялбаршуулан тэдгээрийн үйл ажиллагааг хянах явцыг нарийн төвөгтэй болгож байна. Жишээлбэл, хууль ёсны эргэлтэд орж угаагдсан мөнгө нь зохион байгуулалттай гэмт хэрэг, авлига, терроризмын санхүүгийн эх үүсвэрийг нууцлах хамгийн тохиромжтой сегмент болдог. Мөн улсын төсөвт орох орлого буурч, татвараа шударгаар төлөгч иргэдийг хохироодог. Түүнчлэн санхүүгийн байгууллагын хүчин чадлыг доройтуулан их хэмжээний мөнгө дамжигдан явах нь улс орон, санхүү, эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдалд асар их хор уршигтай (Монгол банк, 2019).

2.4. *Терроризмыг санхүүжүүлэх*

“Терроризмыг санхүүжүүлэх гэдэг нь террорист үйл ажиллагаа үйлдэхээр санаархаж, төлөвлөж эсхүл оролцохоор төлөвлөж байгаа хүн, байгууллага болон бусад этгээдэд зориулан хууль ёсны болон хууль бус хөрөнгө, орлогыг хуримтлуулах, шилжүүлэх, зарцуулах үйл ажиллагаа” юм. (Монгол банк, 2020)

Терроризмыг ямар эх сурвалжаас санхүүжүүлдэг вэ?

- Их хэмжээний эд хөрөнгө хулгайлах
- Хар тамхи, зэвсгийн наймааны хууль бус эргэлт
- Хууль бус цагаачлал, хүн худалдаалах
- Барьцааны төлбөр гаргуулж авах зорилгоор хүн хулгайлах
- Хүн сүрдүүлэх үйл ажиллагаа явуулах
- Хууль ёсны болон хууль бус орлогоос хандив тусламж өгөх (Монгол банк, 2019)

2.5. *Мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөр*

Санхүүгийн хориг арга хэмжээ авах олон улсын байгууллага /ФАТФ/ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт (ФАТФ-ын 40 зөвлөмж)-ыг гаргасан бөгөөд тус стандартын дагуу улс орнууд Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх үүрэгтэй. Монгол Улс ФАТФ-тай төстэй бүс нутгийн байгууллага болох Ази номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлэг (APG)-т гишүүнчлэлээрээ дамжуулж уг стандартыг хэрэгжүүлэх бүрэн хүсэл эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлсний үндсэн дээр 2016 онд Монгол улс анх удаа үндэсний эрсдэлийн үнэлгээг хийсэн (Монгол банк).

Хүснэгт 1. Эрсдэлийг бууруулах зөвлөмж

<p>Яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай</p>	<ul style="list-style-type: none">• Хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээг чангатгах хуулийн заалтыг яаралтай эцэслэн шийдвэрлэх;• Үр дүнтэй дотоод хяналтын тогтолцоог бий болгох;• Улс төрд нөлөө бүхий этгээдтэй холбоотой банкны авч хэрэгжүүлэх арга хэмжээг ФАТФ-ын 40 зөвлөмж, дотоодын эрх зүйн орчинд нийцүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;• Эцсийн өмчлөгчийг тогтоох үйл ажиллагааг сайжруулах;• Сэжигтэй гүйлгээг мэдээлэх үйл ажиллагаа сайжруулах;
--	--

Хэрэгжүүлэх шаардлагатай	<ul style="list-style-type: none"> • Банкны удирдлага, дотоод хяналтын ажилтнуудын МУТС-тэй тэмцэхойлголтыг нэмэгдүүлэх, сургалтад хамруулах; • Банк хоорондын гүйлгээ, цахим болон мөнгөн гуйвуулгын үйлчилгээндтавих хяналт шаардлагыг нэмэгдүүлж ФАТФ-ын 40 Зөвлөмжид бүрэн нийцүүлэх; • МУТС-тэй тэмцэх чиглэлээр ашиглаж буй программ хангамж, автоматжуулалтыг хөгжүүлэх.
--------------------------	--

Эх сурвалж: Монгол улсын үндэсний эрсдэлийн үнэлгээ, 2017

Мөнгө угаахтай холбоотой мэдээлэл байгаа бол Зохицуулагч байгууллагууд болох Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба, СЗХ-ны дэргэдэх Мөнгө угаах терроизмыг санхүүжүүлэх тэмцэх алба, Хууль сахиулах байгууллагууд болох Цагдаагийн Ерөнхий газар, Тагнуулын Ерөнхий газар, Авлигатай тэмцэх Газар зэрэгт мэдэгдэх үүрэгтэй (Монголбанк, 2020).

2.6. Сэжигтэй гүйлгээний индикаторууд

МУТСТ тухай хуулийн 7 дугаар зүйлд Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсвэл гэмт хэрэг үйлдэж олсон орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсвэл мэдсэн бол мэдээлэх үүрэгтэй этгээд энэ тухай 24 цагийн дотор батлагдсан маягт, журмын дагуу СМА-нд мэдээлнэ гэж заасан байна.

Сэжиглэх үндэслэл нь харилцагчийн бизнес, санхүүгийн түүх, бизнесийн зан үйл болон мөнгөн гүйлгээний дүн зэргээс шалтгаалдаг. Гэхдээ гүйлгээг сэжигтэй гэж тооцон мэдээлэхэд ямар нэгэн мөнгөн гүйлгээний тодорхой тогтсон босго дүн байдаггүй (Монгол банк, 2018).

Сэжигтэй гүйлгээг мэдээлсэн байдлаар харахад гүйлгээний тоо өсөх хандлага харагдаж байгаа боловч Монгол улстай төстэй эдийн засаг бүхий гадаадын улсуудтай харьцуулахад харьцангуй бага байгаа нь банкуудын сэжигтэй гүйлгээг илрүүлэлт хангалтгүй, харилцагчийн эрсдэлийн үнэлгээ болон гүйлгээний хяналт процессыг илүү автоматжуулах, одоо ашиглагдаж байгаа системүүдийг илүү сайжруулах шаардлагатай байна (Үндэсний эрсдэлийн үнэлгээ, 2016).

2.7. Дижитал шилжилт

Дижитал шилжилт нь өндөр технологийг ашиглан хаягдал багатай, өндөр бүтээмж, үр ашигтай эдийн засаг, нийгмийн гарцыг бий болгох тухай концепц юм. Дижитал шилжилтийн үр ашгийг дараах 3 бүлэгт хувааж авч үзэж болно (PwC's Strategy, 2018). Үүнд:

1. Автоматжуулалт нь алдаа гарахаас сэргийлж, хаягдлыг хамгийн бага байлгаснаар үйлдвэрлэлд зардлыг үлэмж бууруулж, нөөцийг хэмнэнэ.
2. Ажиллах хүчний зардлыг бууруулна.
3. Хөдөлмөрийн бүтээмжийг үлэмж нэмэгдүүлнэ.

Дэвшилтэт мэдээллийн технологийг ашиглаж интернэтэд холбогдсон бүхий л технологиудыг сайжруулж, инженерчлэлийн мэдлэгийг нэгтгэснээр үйлдвэрлэлийн сул зогсолтыг минимум байлгаж, илүү хурдан, жигд явуулж болно. Энэ тохиолдолд бүтээгдэхүүний чанар,

үйлдвэрлэлийн системийн үр ашгийг дээшлүүлэх, зардал хэмнэлт, тогтворжуулалтыг илүү хялбар удирдана (Yonghwan Kim, 2016).

Дэлхийн банкны тодорхойлж байгаагаар цахим засаглал нь иргэний үйлчилгээг цахимаар хүргэх гэж ойлгож болох боловч өргөн утгаараа энэ нь эдийн засгийн хөгжлийг дэмжих, засгийн газрын ил тод байдлыг нэмэгдүүлэх, үйлчилгээний хүртээмжийг сайжруулахын зэрэгцээ зардлыг бууруулах, төрийн захиргаа, нийтийн удирдлагыг шинэ төвшинд шилжүүлэх засгийн газрын технологийн өөрчлөлтийг хэлнэ. Судлаач нар цахим засаглалыг өөр өөрөөр тодорхойлсон ч нэг концепц дээр санал нийлсэн байдаг. Энэ нь мэдээллийг ил тод, нээлттэй байлгах, мэдээлэл олж авах боломжоор хангах замаар иргэд, байгууллага, иргэний нийгмийг чадавхжуулах юм (Ouyonno, 2003).

3. СУДЛАГДСАН БАЙДАЛ

3.1. Монгол улс дахь мөнгө угаалт, санхүүгийн терроризмтой тэмцэн хэрэгжүүлж буй өнөөгийн байдал

Монгол Улсын санхүүгийн системийн тогтвортой, аюулгүй байдлыг хангахын тулд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс сэргийлэх олон хуулийг үндсэн хуульд тусгасан байдаг. Мөнгө угаах үйл ажиллагаа нь Монгол Улсын дотоодын гэмт хэргийг тэтгэхийн зэрэгцээ гадаадад үйлдэгдсэн гэмт хэргээс олсон орлого, хөрөнгийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр чөлөөтэй дамжуулах, хадгалах, шилжүүлэх, өөрчлөхөд томоохон суурь нөхцөлийг бүрдүүлдэг. Ялангуяа, авлига, хээл хахууль, татвараас зайлсхийх үйл ажиллагаанаас олсон орлогыг Монгол Улсын газар нутгаас зугтаалгах, шилжүүлэхэд энэ үйл ажиллагаа чухал үүргийг гүйцэтгэж байна. (МУ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ, 2016)

Өнгөрсөн жилүүд дэх мөнгө угаалтын тоо хэмжээнээс харахад авлига, хээл хахуулийн үйл ажиллагаа, татвараас зайлсхийх тохиолдол ихсэж буйтай холбогдуулан Монгол улс ФАТФ-ын гаргасан 40 зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлэн удаа дараа саарал жагсаалтад орсон байдаг. Жишээлбэл:

- 2013 онд анх МУ өндөр эрсдэлтэй, хууль эрх зүйн орчин тун хангалтгүй байсан тул ФАТФ-ын Саарал жагсаалтад бичигдэж улмаар хууль батлан тодорхой хүчин чармайлтууд гаргаснаар 2014 онд гарсан байна.
- 2017 онд ФАТФ-ын Ази, Номхон далайн бүсийн орнуудын Мөнгө угаахтай тэмцэх бүлгийн хийсэн МУ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээгээр 40 зөвлөмжөөс 20 нь хангалтгүй мөнгө угаах эрсдэлтэй байсан тул “Эрчимтэй хяналт”-д орсон.
- Иймд 15 сарын хугацаанд дахь уг хяналтын үед Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн мэдээллийн албанаас дээрх хангалтгүй үнэлгээг сайжруулахад хугацааг сунгуулан хоёр жил чармайн зүтгэсний дараагаар ФАТФ-ын Ази номхон далайн бүсийн байгууллагын жилийн хурлаар танилцуулсан. Уг хурлаар Монголбанкны Дэд ерөнхийлөгч Б. Лхагвасүрэн 40 зөвлөмжөөс 35-ыг хангаж өмнөх бүдэрсэн 20 зөвлөмжөө 15-р ахиулж чадсан гэх мэдээллийг хүргэсэн (ICON.mn, 2019)

Дээрх хангалтгүй үнэлэгдсэн асуудлууд бүхэлдээ хууль сахиулах байгууллага, гааль, шүүх, тагнуул, АТГ болон Сангийн яам, Гадаад харилцааны яамтай холбогдох хэрэгжилтийн асуудлууд байв. Учир нь шууд хэрэгжилтийн үнэлгээний 11 үзүүлэлтээс дараах 4-т нь хангалтгүй үнэлгээ аван үүргээ биелүүлэх үүрэг хүлээн авсан байна. (ICON.mn, 2019)

Үүнд:


1. 3-р зорилт: Хяналтын байгууллагууд санхүүгийн институтийг зохих ёсоор нь шалгах, хяналт тавих, зохицуулдаг байх;
2. 7-р заалт: Мөнгө угаахтай холбоотой хэрэг, үйлдлүүдийг мөрдөн шалгаж, гэмт хэрэгтнүүдэд үр дүнтэй, хийсэн хэрэгт нь дүйцэхүйц, давтан үйлдэхгүй болгохуйц шийтгэл ногдуулах;
3. 8-р заалт: Гэмт хэргийн орлого, хэрэгслийг хураан авах;
4. 11-р заалт: Нийтээр устгах зэвсгийг түгээхтэй холбогдсон хувь хүмүүс, хуулийн этгээд нь хөрөнгө мөнгө босгох, шилжүүлэх хэрэглэхээс сэргийлэх.

Дээрх заалтуудыг хэрэгжүүлэх байгууллага нь цөм Санхүүгийн Зохицуулах Хороо, Сангийн яам, хууль сахиулах байгууллагууд, гаалийн ерөнхий газар, гадаад харилцааны яам зэрэг газруудын хариуцлагатай шууд хамааралтай байв.

- 2019 онд биелүүлэн хангах дөрвөн заалтаа хангаж чадаагүйн улмаас ахин саарал жагсаалтад орон 2020 оны 10 сард саарал жагсаалтаас гарсан байна (Eagle, 2019; Саарал жагсаалт ба Монгол Улс).

Ийн саарал жагсаалтад удаа дараа орох нь Монгол улсын аж ахуйн нэгж байгууллага, ард иргэдийн гадаад гүйлгээ бүгд хяналт, шүүлтэд орон хаагдан, хязгаарлагдаж байгаа юм. Түүнчлэн улсын нэр хүнд муудаж, гадаадын хөрөнгө оруулалт эрс багасан, бусад гадаад улсуудад харагдах үнэлэмж буурах юм (Монгол улс саарал жагсаалтад орсноор ямар асуудал үүсэх вэ, 2020).

Зураг 1. Мөнгө угаах гэмт хэрэг, нийслэл, дүүргээр (2018-2019 он)



Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2020)


2018 болон 2019 онуудад бүртгэгдсэн мөнгө угаах гэмт хэргийн үзүүлэлтийг дээрх зурагт харуулсан бөгөөд улсын хэмжээнд 2018 онд мөнгө угаах гэмт хэрэг 24 бүртгэгдэж, 2019 онд 2 дахин их буюу 54 бүртгэгдсэн байна. Үүнээс Улаанбаатар хотод 2018 онд 24 бүртгэгдсэн

ба Хан-Уул болон Чингэлтэй дүүргүүдэд хамгийн их буюу тус тус 7 бүртгэгдсэн байна. 2019 онд Улаанбаатар хотод 32 бүртгэгдсэн бөгөөд тэр дундаа Чингэлтэй болон Сүхбаатар дүүргүүдэд тус тус 10 буюу хамгийн их бүртгэгдсэн байна.

Дотоодын арилжааны банкуудын цахим шилжилт

Сүүлийн жилүүдэд мөнгө угаах, терроризмтой тэмцэх үйл ажиллагааны хүрээнд Монгол улс дотоодын арилжааны банкнууд цахим шилжилтийн арга техникийг нэвтрүүлэн дараах байдлаар ажиллаж байна. Судалгааны хүрээнд 2021 оны 1-р улирлын тайлангийн үр дүн дэх активын хөрөнгийн үзүүлэлт сайтай үнэлэгдсэн банкнуудаас сонгон авсан ба Хаан банк, Худалдаа Хөгжлийн банк, Голомт банкнуудын хэрэгжүүлж буй дижитал шийдлүүдийг онцлон тэдгээрийн хяналтын тогтолцоог судлалаа.

Зураг 2. Арилжааны банкнуудын зах зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Хаан банкны мөнгө угаахтай тэмцэх тогтолцоо: Хаан банк нь АНУ-ын ПАТРИОТ-ын тухай хуулийн гэрчилгээтэй, МУТСТ дотоод үйл ажиллагааны талаарх мэдээллийг гадаад улсын банк санхүүгийн байгууллагад хүргүүлэх, мэдээлэл солилцохдоо Wolfsberg группээс гаргасан стандарт асуулга, түүнээс гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлж үйл ажиллагаандаа ашиглан, W-8BEN-E маягт зэргийг ашиглан үйл ажиллагаагаа явуулдаг. Wolfsberg бүлгээс “Харилцагчийг таньж мэдэх”, “Төлбөрийн ил тод байдлын шалгуур” гэх мэт зөвлөмж гаргадаг.

Хаан банкны ашиглаж буй программ хангамжууд:

- Харилцагчийг зайнаас танин баталгаажуулах таних код буюу TPIN үйлчилгээг Монгол улсад анх удаа Хаан банк нэвтрүүлсэн бөгөөд энэхүү үйлчилгээ нь харилцагчаас асуудаг уламжлалт асуулт, хариултын аргыг орлох ба автомат хариулагч системд суурилсан, харилцагчийг автоматаар танин баталгаажуулах үйлчилгээ юм.
- Хаан банк нь харилцагч, түншүүдэд нэмэлт боломжуудыг олгохоор Alcatel утасны системийг IP-PAВХ нэгдсэн холболтоор солих ажлыг гүйцэтгэж, үүгээр дамжуулан Скайп бизнес болон харилцагчийн үйлчилгээний шинэ шийдэл болох Ameyo системийг нэвтрүүлснээр харилцагчдын мэдээллийн аюулгүй байдал, теле-борлуулалт, цуглуулга болон төрийн сангийн шугамд оруулсан. Энэхүү харилцагчийн үйлчилгээний шинэ платформ нь үйлчилгээний сувгуудыг нэгтгэж, нэгдсэн үйлчилгээг хөгжүүлэх, олон

улсын жишигт нийцсэн технологи бүхий системийг бий болгох замаар харилцагчийн үйлчилгээнд чухал түлхэц болдог.

- Хаан банк нь Wi-Fi сүлжээний Cisco ISE (NAC) аюулгүй байдлыг хангасан динамик VLAN сүлжээг нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн.

Голомт банкны мөнгө угаахтай тэмцэх тогтолцоо: Голомт банк нь харилцагч харилцаагаа цуцалснаас хойш 5 жилийн хугацаанд харилцагчийн эрсдэлийн үнэлгээ, харилцагчийн биеийнбайцаалт, харилцагчийн хяналт, ажилтнуудын сургалт, дотоод болон гадаад тайланг хадгалдаг байна. Голомт банкны комплаенсийн хэлтэс нь СМА-д сэжигтэй гүйлгээг тухай бүрд мэдээлэн ажилладаг ба мөнгө угаахтай холбоотой бүхий л хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөж ажилладаг. Хэрэв банкны ажилтан мөнгө угаахтай тэмцэх хууль тогтоомж болон бусад дүрэм журам зөрчсөн тохиолдолд банк болон ажилтнууд хуулийн дагуу торгууль шийтгэл хүлээдэг.

Голомт банкны ашиглаж буй программ хангамжууд:

- Голомт банк нь дижитал шилжилтийн хүрээнд зураг боловсруулалт, царай танилт, гар бичвэр таних, робот процесс автоматжуулалт зэргийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж үйлчилгээний чанар сайжирч, хурдыг нэмэгдүүлж, зардлын бууруулдаг.
- Голомт банк нь олон улсын нэр хүнд бүхий Мэдээллийн аюулгүй байдлын ISO27001, Төлбөрийн картын аюулгүй байдлын PCI-DSS стандартуудыг хангаж, үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлдэг. ISO 27001 болон PCI DSS стандартуудын баталгаажуулах аудит 2019 оны эхний хагас жилд амжилттай хийсэн. (Голомт банк, 2019)

ХХБ-ны мөнгө угаахтай тэмцэх тогтолцоо: “ХХБ нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, гүйлгээний хяналт шалгалт, санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, корреспондент банк, санхүүгийн байгууллагатай харилцах харилцаа, сургалт мэдээлэл болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэх эрсдэлийн үнэлгээний талаарх зохицуулалтуудыг нарийвчлан тусган үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг”. (Худалдаа хөгжлийн банк, 2021) Мөн мөнгө угаахтай тэмцэхтэй холбоотой бүхий л хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөхийн зэрэгцээ банкны хяналтын дотоод хөтөлбөр, бодлого, журмыг боловсруулж гарган үйл ажиллагаандаа чанд сахин ажилладаг.

ХХБ-ны ашиглаж буй программ хангамжууд:

- Худалдаа хөгжлийн банк нь ТиДиБи онлайн үйлчилгээндээ нэг удаагийн нууц үг үүсгэгч VASCO GO6 төхөөрөмж болон OTP мобайл аппликэйшнийг ашигладаг бөгөөд эдгээр нэг удаагийн нууц үг үүсгэгчид нь гарч болзошгүй эрсдэлээс таныг хамгаалах ба хамгийн чухал нь хэрэглэхэд хялбар, энгийн хурдан ажиллагаатай нэг удаагийн нууц үг үүсгэгч юм.
- БНСУ-ын финтек “VP” компанитай хамтран тус улсаас мөнгөн гуйвуулга хүлээн авах “VRemit” үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсэн.
- 2019 онд Visa Worldwide (Visa Inc.) байгууллагатай хамтран Виза карт эзэмшигчдийнхээ гүйлгээнд хиймэл оюун ухаанд суурилсан VAA/VRM буюу аливаа эрсдэлээс хамгаалах дэвшилтэт системийг амжилттай нэвтрүүлсэн.

- Банкны үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамж, систем, мэдээллийн сан, сүлжээ, холбоо, сервер, тоног төхөөрөмжүүд болон тэдгээрийн үйлдлийн систем, мэдээллийн аюулгүй байдал, ажилтны үйл ажиллагааг төлбөрийн картын системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах стандарт PCI-DSS (Payment Card Industry Data Security Standard)-ыг дахин баталгаажуулсан.
- Төлбөрийн системийн шинэчлэл төслийн хүрээнд банк хоорондын бага дүнтэй гүйлгээний АСН системийн холбогдох өөрчлөлтүүдийг амжилттай нэвтрүүлснээр банк хоорондын бага дүнтэй гүйлгээний үйл ажиллагааг улам найдвартай болгосон. (Худалдаа Хөгжлийн Банк, 2019)

Хүснэгт 2. Арилжааны банкуудын экспорт, импортын тоо баримт (2017-2020)

Он	Жилээр				Өөрчлөлт					
	2017	2018	2019	2020	2018/2017		2019/2018		2020/2019	
					дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
Эргэлт	10536	12887	13747	12875	2349	22%	861	7%	(872)	-6%
Экспорт	6201	7012	7620	7576	811	13%	608	9%	(43)	-1%
Импорт	4337	5875	6128	5299	1537	35%	253	4%	(829)	-14%
Тэнцэл	1863	1137	1492	2277	(726)	-39%	355	31%	785	53%

Эх сурвалж: Монгол банк

Ерөнхий тойм: 2018 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 22%-иар өссөн бөгөөд тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 728 сая ам.доллаар буурч 1,137 сая ам.долларын ашигтай байна. 2019 оны эхний 12 сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 7%-иар өсөж 13,747 сая ам.доллар болов. Уг тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 355 сая ам.доллаар өсөж 1,492 сая ам.долларын ашигтай гарлаа. 2020 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 6%-иар буурч 12,875 сая ам.доллар байв. Үүнд экспорт 43 сая ам.доллаар, импорт 829 сая ам.доллаар тус тус буурсан нь нөлөөлсөн ба тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 785 сая ам.доллаар өсөж 2,277 сая ам.долларын ашигтай гарлаа.

4. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй дижитал шилжилтийг Их Британи, АНУ, Сингапур улсуудын хэрэгжүүлдэг арга барилтай харьцуулан дараах байдлаар хүснэгтэд тусгав.

Гэмт этгээдүүд нь цахим банкны үйлчилгээ, цахим төлбөр тооцоо, криптовалюта, бохир мөнгийг хил давуулах гэх мэт олон шинэ технологийг ашиглах болсон. Эдгээр нь бодит цагийн горимоор олон тоотойгоор, зэрэг хийгдээд явагддаг тул уламжлалт арга замаар хянахад бэрхшээлтэй. Тиймээс банкнууд гүйлгээг хянах, хориг арга хэмжээнд орсон этгээдийн гүйлгээг шалгахад чиглэсэн сайн мэдээллийн технологийн системд хөрөнгө оруулалт хийх болсон.

1. Гүйлгээний хяналт: Гүйлгээний хяналтын системүүдээр мөнгө угаах гэмт хэргийн шинж чанартай гүйлгээнүүдийг илрүүлэхэд хүндрэлтэй. Учир нь гүйлгээний шинж чанарууд, сэжигтэй гүйлгээнүүдийн шинж чанарууд, мэдээллийн чанар, хүрэлцээ, ашиглаж буй программ системүүдийн үр ашиггүй байдал, илрүүлэлтэд хүний оролцоо их байх гэх мэт хүчин зүйлсээс хамаардаг.

Хүснэгт 3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дижитал шилжилтийн улс орнуудын харьцуулсан судалгаа

	Монгол	Их Британи	АНУ	Сингапур
Сонгосон шалтгаан	Судалгаагаа хэрэгжүүлэх улс	Мөнгө угаахтай тэмцэхэд ихээхэн хүчин чармайлт гаргадаг улс	Мөнгө угаахтай тэмцэхэд туршлага өндөртэй хөгжингүй орон	Олон улсын бизнесийн чухал төв тул цэвэр, найдвартай санхүүгийн системийг бий болгохыг зорьж МУТС-тэй үр дүнтэй тэмцдэг улс
Мөнгө угаахтай тэмцэх үр дүнтэй бодлогууд	<ol style="list-style-type: none"> 1. Мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөр 2. Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, хянах 3. МУТС-тэй тэмцэх тухай хууль 4. Гадаад, дотоодын болон олон улсын байгууллагуудтай хууль тогтоомжийн 	<ol style="list-style-type: none"> 1. Мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөр 2. Мэдээлэх үүрэг 3. Мөнгө угаах талаар мэдээлэх ажилтан 4. Мөнгө угаахтай тэмцэх сургалт 	<ol style="list-style-type: none"> 1. Мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөр 2. KYC ба CDD 3. Валютын гүйлгээг тайлагнах 4. Сэжигтэй гүйлгээний тайланг тайлагнах 	<ol style="list-style-type: none"> 1. Засаглал ба хяналт 2. KYC ба CDD 3. Тогтмол хяналт; 4. Нэр ба хориг арга хэмжээний скрининг 5. Сэжигтэй гүйлгээг тайлагнах 6. Албан хэрэг хөтлөлт, мэдээллийн менежмент

	хүрээнд хамтран ажиллах			7. Ажилтнуудын сургалт
Мөнгө угаахтай тэмцэх хууль тогтоомж	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013) Терроризмтой тэмцэх тухай хууль (2004) Авлигын эсрэг хууль (2006)	Терроризмын тухай хууль (2000) Гэмт хэргийн орлогын тухай хууль (2002) Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, мөнгө шилжүүлэх тухай хууль (2017) Хориг арга хэмжээ, мөнгө угаахтай тэмцэх тухай хууль (2018)	Банкны нууцын тухай хууль (1970) Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль (1986) Хар тамхины эсрэг хууль (1988) Патриот-ын хууль (2001)	Терроризмийг санхүүжилтийг таслан зогсоох тухай хууль (2002) Сингапурын мөнгөний эрх мэдлийн тухай хууль (2015)
Мөнгө угаахтай тэмцэх гол байгууллага	Санхүүгийн мэдээллийн алба (СМА)	Financial Conduct Authority (FCA)	Financial Crimes Enforcement Network (FinCEN)	Monetary Authority of Singapore (MAS)
Мөнгө угаахтай тэмцэх програм хангамж	ГрэйпСити хяналтын систем	Comply Advantage	AMLOCK TM Quantexa	Silent Eight
Дижитал шийдлүүд	ГрэйпСити нь 2000 онд байгуулагдаж, банк санхүү ба төлбөрийн шийдлийн программ хангамж боловсруулах чиглэлээр дагнан ажилласаар ирсэн бөгөөд монголын 12 арилжааны	Comply Advantage нь санхүүгийн компаниудын мэдээллийн сан дахь эрсдэлийг олж илрүүлэх, мөнгө угаах, санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд туслах машин сургалтыг ашигладаг. Платформын хэрэглэгчид 10 сая	AMLOCK TM нь KYC байдлыг үр дүнтэй удирдах, комплаенсийн процессыг сайжруулах, хэрэглэгчийн эрсдэлийг тасралтгүй тодорхойлох, үнэлэх цогц арга хэрэгслийг санал болгодог бөгөөд хамгийн сүүлийн	Silent Eight нь санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор хиймэл оюун ухаан Ашигладаг программ бөгөөд Австралийн шилдэг финтек, регтек шагналыг хүртсэн. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх

	<p>банкны 11 нь уг программ хангамжийн бүтээгдэхүүнийг ашигладаг. Бичил Санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлд зориулсан ПОЛАРИС системийг 160 орчим ББСБ, ХЗХ, бичил санхүүгийн байгууллага ашиглаж байна. (ГрэйпСити)</p>	<p>гаруй хүн, байгууллагыг хайж олох боломжтой бөгөөд хэдхэн товшилтоор регтекийн радарт санхүүгийн гэмт хэрэгтэй холбоотой холбоос байгаа эсэхийг харах боломжтой. (ALTFI, 2020)</p>	<p>үеийн технологи, график анализ, хиймэл оюун ухаан болон машин сургалтын загварыг ашигладаг. Энэ нь банкнууд, даатгалын компаниуд, аюулгүй байдлын компаниуд, ББСБ болон гар утасны түрийвч хэрэглэгчдэд сэжигтэй үйл ажиллагааг гүйлгээ ба хэрэглэгчийн түвшинд хялбархан илрүүлж, хянах боломжийг олгодог. (infotech, 2019)</p>	<p>комплаенс нь үйлчлүүлэгчид болон холбогдох этгээдүүдийн нэрсийг логик ашиглан төрөл бүрийн цагны жагсаалттай тулгаж Тохируулдаг нэрийн скрининг хийх үйл явцыг сайжруулахын тулд машин сурах, байгалийн хэл боловсруулах арга техникийг ашиглах зорилготойгоор Silent Eight-тэй хамтран ажиллаж байна (Standart chartered, 2018).</p>
--	---	---	---	--

Харьцуулсан судалгааны дүгнэлт: Дээрх судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол Улсад системүүдийг баталгаажуулан шалгахын тулд гар ажиллагаа зайлшгүй хэрэгтэй ба түүнтэй холбоотой бэрхшээлүүд их гардаг. Мөн гүйлгээний хяналтын системийн үр ашигтай байдал дутмаг, мэдээллийн хүрэлцээтэй байдалтай холбоотой сорилууд гардаг. Эдгээрийн гол шалтгаануудын нэг нь сэжигтэй гүйлгээний шинж чанаруудын өөрчлөлтийг тусгаагүй гүйлгээний хяналтын системд найдах явдал юм. Эдгээр системүүд нь харилцагчдын гүйлгээ, үйл ажиллагааг багц дүрмийн (сэжигтэй гүйлгээний шинж чанарууд) дагуу шалгах замаар ажилладаг бөгөөд сэжигтэй шинж тэмдэг илэрсэн тохиолдол бүрд комплаенсийн багт дохиог өгдөг. Уг мэдэгдлүүд нь комплаенсын зардлыг нэмэгдүүлдэг билээ. Гүйлгээний хяналтын систем нь бүх бизнесийн үйл ажиллагаанд хийгдэж чадахгүй байгаа байдал, банкны үйл ажиллагааны үндсэн системтэй холбогдож ажиллах тал дээр асуудал байсаар байна. Эдгээр хүндрэлүүдийг арилгаснаар банкнуудын гүйлгээний хяналтын систем сайжрах боломжтой харагдана. Монгол улс платформоор дамжуулан банк санхүүгийн байгууллагын ажилтнуудад тогтмол сургалт явуулан иргэдийн санхүүгийн боловсрол, мөнгө угаах гэмт хэргийн мэдлэг мэдээллийг сайжруулах зорилгоор хэвлэмэл бүтээгдэхүүн болон бусад арга хэмжээг авч ажиллах зүйтэй болох нь илэрч байна.


Шийдлийг боловсруулснаар дараах эрсдэлийг бууруулах боломжтой:

- Үйл ажиллагааны эрсдэл
- Системийн эрсдэл
- Улс төрийн эрсдэл
- Хөрвөх чадварын эрсдэл
- Нэр хүндийн эрсдэл

Банкнүүд санхүүгийн байгууллагуудын аюулгүй байдлыг хангах үүднээс мөнгө угаахтай тэмцэх болон КҮС стандартыг дагаж мөрддөг. Мөнгө угаахтай тэмцэх дүрэм журмууд нь санхүүгийн байгууллагуудаас үйлчлүүлэгчдийн гүйлгээг хянах, санхүүгийн сэжигтэй үйл ажиллагааны талаар тайлагнахыг шаарддаг. Хэрэв банкнүүд мөнгө угаахтай тэмцэх журмыг дагаж мөрдөөгүй бол асар их шимтгэл эсвэл хууль ёсны шийтгэл төлөх эрсдэлтэй байдаг. Дараах процесст МУ-ын 12 арилжааны банкны 11 нь авч хэрэгжүүлдэг ГрэйпСити хяналтын системийн процессыг Silent Eight-н явуулдаг үйл ажиллагаатай дараах байдлаар харьцуулан шинжлэл хийв.


Зураг 4. Silent Eight болон Грэйп Сити програмуудын харьцуулсан процесс

Silent Eight процесс



Эх сурвалж: Vectoeconomy

ГрэйпСити хяналтын системийн процесс



Эх сурвалж: ГрэйпСити Монгол

4. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар бид мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улс болон гадны орнуудад авч хэрэгжүүлж буй программ, үйлдлийн систем, дижитал шийдлүүдийг судалж үзлээ. Судалгааны үр дүнгээр бидний ашиглаж буй систем болон дижитал арга нь бусад улстай харьцуулахад хяналт шалгалт болон гүйцэтгэлийн хувьд дутуу дулимаг байгаа бөгөөд мэдээллийн бааз үүсгэх тал дээр “ихээхэн дутагдалтай” байна. Дээрх Silent Eight болон ГрэйпСити хяналтын системийн процессыг харьцуулан үзэхэд, Silent Eight нь дэлхийн олон орны хэлийг таних чадвартай бөгөөд үүн дээр тулгуурлан петабайт өгөгдлийг боловсруулж, тэдгээрийн хоорондын хамаарлыг дүрслэн гарган, харилцагчийн нэр, гадаад төрх гэх мэт

бүхий л мэдээлэлтэй баталгаажуулан харилцагчийг таньдаг бол ГрэйпСити хяналтын системийн хувьд олон улсын болон тухайн байгууллагаас сэжигтэй харилцагчдын мэдээллийг аван “Хар дэвтэр”-т тэмдэглэн үлдээдэг. ГрэйпСити хяналтын системд тухайн банк болон байгууллагаас өөрсдийн дүрмээ оруулах бөгөөд хяналтын систем нь уг оруулсан дүрэм, зааврын дагуу ажиллах үүрэгтэй бөгөөд энэхүү мэдээлэл болон дүрэм дээр үндэслэн сэжигтэй гүйлгээг шинжлэн ялгадаг байна. Хэрэв сэжигтэй гүйлгээ илэрсэн тохиолдолд банкны хариуцагч болон мониторинг мэдэгдэл харуулах болон гүйлгээг зогсоох зөвшөөрөл авдаг юм. Мөн түүнчлэн банкнуудын сэжигтэй гүйлгээг илрүүлэх ажиллагаа болон банкны ажилчдын авах арга хэмжээ, ойлголт дутмаг байна.

Арилжааны банкнууд худалдаанд суурилсан мөнгө угаалт, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулж, эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо сайжруулахын тулд эрсдэлийн удирдлагын засаглалаа сайжруулж, удирдлагын оролцоогоо нэмэгдүүлэн, харилцагчаа таньж мэдэх үйл ажиллагаандаа худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн авах харилцагчийн хувьд нэмэлт шаардлагуудыг тодорхойлж, дотооддоо гүйлгээний хяналт, сэжигтэй гүйлгээг мэдээлэх, мэдээллийн бааз үүсгэх чиглэлээр тогтмол сургалт хийж, үйл ажиллагаандаа хэвшүүлэх, мөн худалдааны санхүүжилтийн гүйлгээнд оролцогч ажилтнуудад зөвхөн бүтээгдэхүүн үйлчилгээ талаас нь биш, МУТС эрсдэл, анхаарах хүчин зүйлсийн талаар тогтмол сургалт орох, ажилтнуудын энэ талаарх мэдлэгийг дээшлүүлэх хэрэгтэй байгаа нь судалгаагаар харагдаж байна. Тиймээс бид энэхүү судалгаагаараа худалдаанд суурилсан мөнгө угаалт, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн удирдлагын олон улсын банкнуудын практик аргууд, зөвлөмж, зааварчилгаа, худалдааны санхүүжилтийн гүйлгээтэй холбоотой анхаарах хүчин зүйлсийг судалсан бөгөөд тэдгээр дээр үндэслэн одоогийн Монголын арилжааны банкнуудын худалдааны санхүүжилтийн үйл ажиллагаа дахь МУТС эрсдэлийн удирдлагын загварыг сайжруулж шинэ загвар боловсруулан арилжааны банкнуудад санал зөвлөмж өглөө.

Комплаенсийн үйл ажиллагаа нь доголдолтой эсвэл ийм ажиллагаа огт байхгүй бол энэ нь цаашлаад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд сөргөөр нөлөөлөх юм. Харин комплаенсын үйл ажиллагаа аливаа байгууллагын бүтцэд чухал ач холбогдолтой гэдэг ойлголт Монгол Улсад дэлгэрч эхлээд удаагүй байгаа билээ. Санхүүгийн байгууллагуудын хувьд өөр өөрсдийн ойлголтоор комплаенсын тогтолцоо нэвтрүүлж байгаа боловч олон улсын стандартад нийцсэн комплаенсын тогтолцоо нэвтрүүлсэн нь цөөхөн байна. Иймд банк санхүүгийн талын мэргэжилтэй бүх хүмүүст харилцагчтай санхүүгийн шинэ харилцаа үүсгэх, данс нээх, гүйлгээ хийх, үйлчилгээ үзүүлэхийн өмнө харилцагчаа таньж мэдсэн байх, өөрөөр хэлбэл хэнд, ямар үйлчилгээ үзүүлж байгаагаа бүрэн дүүрэн хариулттай мэдэж, түүндээ итгэлтэй байх, шаардлагатай мэдээ мэдээлэл, баримтыг харилцагчаасаа гаргуулан авч хянадаг байх, хяналтын тусгай программтай, оновчтой зөв хяналт хийх ёстой талаар мэдлэгтэй болгох хэрэгтэй. Түүнчлэн арилжааны банкнуудын хувьд “Wolfsberg group”-ээс гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллах нь олон улсын зах зээлд үйл ажиллагаа явуулах, гадаад улсын банк санхүүгийн байгууллагатай харилцахад чухал нөлөө үзүүлэхээр байна. Нөгөө талаас банк харилцагчдадаа комплаенс, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнээс үүсэх эрсдэлийг таниулах, учир болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажлууд зохион байгуулах нь зүйтэй юм.

5. САНАЛ ЗӨВЛӨМЖ

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гарч буй дижитал шилжилт, судалгааны ажлын хүрээнд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, санхүүгийн хяналтын тогтолцоог сайжруулахыг зорин дэлхийн санхүүгийн финтект баримтлан хэрэгжүүлдэг технологи, цахим шилжилтүүдийг нарийн судлан авч үүнд суурилан хөгжүүлэх боломж, шийдлийг судлалаа. Судалгааны үр дүнд дараах санал зөвлөмжүүдийг хүргэж байна.

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд мөнгө угаах, гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг зохих ёсоор хянан шалгах
- Хуулийн доорхойг нөхөх, үүнээс ашиг ологчдыг шалгах, зохицуулдаг байх
- Мөнгө угаахтай холбоотой хэрэг үйлдэгчийг давтан үйлдэхээс сэргийлэх арга хэмжээг зохиох
- Давтан гэмт хэрэг үйлдэж буй хүмүүст үр дүнтэй, хийсэн хэрэгт нь дүйцэхүйц шийтгэлийг ногдуулах
- Шууд хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих, үр дүн, хэрэгжилтийг шалгах
- Мөнгө угаах гэмт хэргийг шалган нэвтрүүлэх шат шатны үйл явцад зохих зөв бодлогыг хэрэгжүүлэх
- Сэжигтэй харилцагчийг танин мэдэх, зохих шалгалт, гүйлгээний хяналт зохицуулгад комлаенсын үйл ажиллагааг эрчимжүүлэх
- СМА-ын сэжигтэй гүйлгээг таних, хүлээн авах үйл явцыг технологийн хөгжилд суурилан түргэн шуурхай мэдэх боломжийг бүрдүүлэх
- Цахим шилжилтийн үйл ажиллагааг мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх бүх шатны байгууллагад нэвтрүүлэн сайжруулах
- Олон нийтэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зэрэг мэдээлэлтэй холбогдох мэдлэг, боловсролыг дээшлүүлэх сургалт, семинар, идэвхжүүлэлтийг сайжруулах
- Хууль, эрх зүйн хязгаарлалтуудад дутагдаж буй заалтуудыг оруулах, хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох
- Урьдчилан таамаглах, нийт өгөгдлүүдийг шүүх, сэжигтэй гүйлгээний эрсдэлийг бий болгож буй хүчин зүйлсийг тодорхойлон олж тогтоох, түүнд холбогдох арга хэмжээг авах
- Гадаад орны туршлага, үйл ажиллагаа дээр суурилан Монгол улсдаа хэрэгжүүлж болох судалгаа, шинжилгээг гүйцэтгэн, олон улсад хангагдаж буй шалгуур үзүүлэлтүүдийг дотоодын зах зээлдээ нэвтрүүлэх

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

About Business Crime Solutions. (2017). What is money laundering? Retrieved from https://www.moneylaundering.ca/public/law/what_is_ML.php

Deloitte. (2020). Anti-money laundering preparedness survey report. Anti-money laundering preparedness survey report.

Wolfsberg group, (2010). Sanctions Screening guideline.

AMLCFT. (2019). Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай мэдээллийн нэгдсэн систем. <https://amlcft.mn/-ээс> Гаргасан г2. (2021). Best Anti Money Laundering Software.

Блашникова, Е.А. Щербакова, Е.А. Сингапурскийн стартап silent eight как пример использования искусственного интеллекта в борьбе с од/фт. (2019). Москва, Россия.

Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль. (2013). Улаанбаатар, Монгол: Монгол Улсын Их Хурал.

Удамзаяа, С. (2021). Финтекийг ашиглан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хяналтын тогтолцоог сайжруулах нь

Оюун-эрдэнэ, Э. (2021). Арилжааны банкуудын комплаенсийн үйл ажиллагааг сайжруулах боломж, арга зам санхүүжүүлэх эрсдэлийн удирдлагыг сайжруулах боломж, арга зам.

Азжаргал, Ч. (2019). Арилжааны банкны худалдаанд суурилсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн удирдлагыг сайжруулах боломж, арга зам.

Анударь, А. (2019). Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд тулгамдаж буй асуудлууд.

Голомт банк. (2019). Жилийн тайлан. Улаанбаатар. Хаан банк. (2019). Жилийн тайлан. Улаанбаатар.

Худалдаа Хөгжлийн Банк. (2019). Жилийн тайлан. Улаанбаатар.

Худалдаа хөгжлийн банк. (2021). Комплайнс. <https://www.tdbm.mn/mn/12616/c-ээс> Гаргасан Монгол банк. (2020). Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь. Улаанбаатар.

Монгол банк. (2021). Үндэсний эрсдэлийн үнэлгээ. Санхүүгийн Мэдээллийн Алба: <https://fiu.mongolbank.mn/framework.aspx?id=02-ээс> Гаргасан

Монгол банк. (2020). Гадаад секторын статистик. Улаанбаатар.

Монгол банк. (2016). Монгол улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ. Улаанбаатар.

Санхүү Мэдээллийн Алба. (2018). Монгол улсын терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ. Улаанбаатар.

Санхүүгийн зохицуулах хороо. (2020). Мөнгө угаах гэж юу вэ? Улаанбаатар. Цолмонтуйа, М. (2018). Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам.



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

МОНГОЛБАНК

**МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ
ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТУС
ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ХҮҮХЭД ЗАЛУУСЫН
ОЙЛГОЛТ**

Г.Баясгалан⁴⁶, Н.Эрдэнэбаяр⁴⁷

⁴⁶ Монгол улсын их сургууль, ОУХНУС Олон улсын харилцааны тэнхимийн IV түвшний оюутан

⁴⁷ Монгол улсын их сургууль, ОУХНУС Олон улсын харилцааны тэнхимийн IV түвшний оюутан

1. ОРШИЛ

Сэдвийг сонгох үндэслэл: Мөнгө угаах гэмт хэрэг нь эдийн засгийн бодлого доголдох, хувийн хэвшлүүдийн чадамж доройтох зэрэг олон талаараа улс орны эдийн засаг, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг. Улс орнуудын жишээнээс харахад мөнгө угаах нь даамжирсаар хар тамхины худалдааг нэмэгдүүлэх, терроризмыг санхүүжүүлэх, төрийн албан хаагчид авлигад идэгдэх гэх мэт олон сөрөг талыг бий болгож байна. Энэ төрлийн гэмт хэргүүд нарийн төлөвлөгөөтэй гүйцэтгэгддэг боловч иргэд санамсаргүй байдлаар уг гэмт хэрэгт холбогдох боломжтой байдаг.

Улс орны ирээдүй болсон хүүхэд залуус уг гэмт хэргийн талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа учир энэ талаарх мэдлэг, мэдээллийг сайжруулах хэрэгтэй гэж үзсэн бөгөөд энэ мэдээллийн дутмаг байдал нь эрх зүйн зохицуулалтад иргэдэд мэдээлэх талаар хангалттай тусгаж өгөөгүйтэй холбоотой байх боломжтой хэмээн таамагласны үндсэнд уг сэдвийг сонгон судлахаар болсон.

Судалгааны ажлын зорилго: Энэхүү судалгааны зорилго нь Монгол улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой эрх зүйн орчныг харьцуулан судлах мөн түүнчлэн иргэдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн талаарх мэдлэгийн түвшинг тогтоох юм.

Судалгааны ажлын зорилт: Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- АНУ болон Монгол улсын “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг”-ийн талаарх эрх зүйн орчныг харьцуулан судлах
- 10-25 насны иргэдийн дээрх гэмт хэргийн талаарх мэдлэгийг судлах

Судалгааны арга зүй: Энэхүү сэдэвтэй холбоотой эрдэмтдийн хийсэн судалгаа, эрх зүйн баримт бичиг, мэдээ мэдээлэл зэргийг харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх аргыг ашигласан. Харин иргэдийн мэдлэгийг тогтоох судалгааны хэсэгт асуумжийн аргыг ашигласан болно.

Судалгааны түүвэр: Монгол улсын их сургуулийн 129 оюутан болон Бор-Өндөр Цогцолбор сургуулийн 21 сурагч оролцож, өгөгдөлд боловсруулалт хийсэн.

Судалгааны хамрах хүрээ: Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тухай өнөөгийн байдлаар Монгол улс болон АНУ-д хүчин төгөлдөр хэрэгжиж буй эрх зүйн баримт бичгүүдийг судалж үзсэн болно.

Судалгааны үр дүн, таамаглал: Хүүхэд, залуус мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн талаар хангалттай мэдлэггүй байгаа бөгөөд эрх зүйн баримт бичгүүдэд дээрх гэмт хэрэгтэй холбоотой мэдлэг, мэдээллийг иргэдэд олгох шаардлагатай тухай ямар нэгэн байдлаар тусгаагүйтэй холбоотой.

Түлхүүр үгс: Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, эрх зүйн орчин, иргэдийн мэдлэг мэдээлэл

2. ҮНДСЭН ХЭСЭГ

2.1. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн талаар ерөнхий ойлголт

Мөнгө угаах гэж юу вэ?

Мөнгө угаах гэдэг нь гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг буюу хууль бус эх үүсвэрийг нуун дарагдуулахын тулд хэлбэр, төрхийг хувиргаж, эзэмшигчийг нь өөрчлөн хуулийн ёсны хөрөнгө, орлого шиг харагдуулах төрөл бүрийн арга хэрэгсэл ашиглах үйл ажиллагаа юм. Мөнгө угаах нь ихэвчлэн дараах үндсэн зорилготой байдаг. Үүнд:

- хууль бус эх үүсвэрээс олсон орлого, эд хөрөнгийг өөрчлөн, шилжүүлэх;
- хууль бус эх үүсвэрээс олсон орлого, эд хөрөнгө болон эзэмшигчийг нь нуун далдлах;
- хууль бус эх үүсвэрээс олсон орлого, эд хөрөнгийг олж авах, эзэмших, ашиглах үр шимийг нь хүртэх;
- мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхэд оролцох, хамтрах, зөвлөгөө өгөх гэх мэт.

Мөнгө угаах үйл ажиллагаанд санхүүгийн салбарын нарийн мэргэшсэн мэргэжилтнүүдээс гадна хуулийн этгээд, санхүүгийн бус мэргэжлийн үйлчилгээ бизнес эрхлэгч, нягтлан бодогч, хуульч, халхавч компани, зуучлагч ашиглаж гүйлгээ хийх нь түгээмэл байдаг тул уг гэмт хэрэгтэй тэмцэх, хууль бус хөрөнгийг илрүүлэхэд олон салбар хамарсан өргөн хүрээний мэдлэг шаардагддаг. Мөнгө угаагчид гэмт хэргийн улмаас олсон хөрөнгөө хувиргаж болох дэлхийн зах зээл, дотоодын зах зээл дэх хэрэглээнд нэвтэрч буй төлбөр тооцооны хэрэгслүүд, өндөр өртөгтэй хөрвөх чадвартай үнэт металл, үнэт эдлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэхийг завдаж байдаг.

Мөнгө угаах үйл ажиллагааны үе шатууд

1. **Байршуулах үе:** гэмт хэргийн улмаас олсон орлого, хөрөнгийг хууль ёсны санхүүгийн системд байршуулах, мөнгөн тэмдэгтийг өөр дэвсгэрт, гадаад валютаар солиулах, бэлэн мөнгө тээвэрлэх, бэлэн мөнгийг банкны дансанд байршуулах г.м.
2. **Далдлах үе:** хууль бус, гэмт хэргийн гаралтай хөрөнгө, орлогын гарал үүслийг нуун дарагдуулах зорилгоор бэлэн бус шилжүүлэг хийх, өөр банкны дансанд байршуулах, банк хооронд салгаж, нийлүүлж шилжүүлэх, олон банк, улс орнуудаар дамжуулан эх үүсвэрийг нуун далдлах г.м.
3. **Буцааж нэгтгэх үе:** гэмт хэргийн улмаас олсон орлогын гарал үүслийг нь нуун далдалсан хөрөнгө, орлогоо хууль ёсны болгож харагдуулах халхавч зээлийн гэрээ хийх, хуурамч борлуулалт болон гэрээ хийх, худалдааны тайлан гаргах, санхүүгийн тайлан гаргах, хөрөнгийн эцсийн/ жинхэнэ өмчлөгчийг нуун дарагдуулах гуравдагч этгээдийг гүйлгээнд ашиглах, үнэтэй хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө, тансаг зэрэглэлийн машин, онгоц худалдан авах, хөрөнгө оруулалт хийх гэх мэт.

Мөнгө угаах гэмт хэрэг, түүний үр дагавар

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нь зөвхөн дэлхийн том санхүүгийн төв болон оффшор бүсийн асуудал биш бөгөөд хөгжиж байгаа улсуудад ч хамаатай хэрэг юм. Учир нь хөгжиж байгаа улс орнуудын эдийн засаг, санхүүгийн салбар нээлттэй болохын хэрээр эдгээр үйл ажиллагаанд өртөх эрсдэл улам нэмэгддэг. Мөн өндөр хөгжилтэй улс орнуудын

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЧАНГАРАХЫН ХЭРЭЭР МӨНГӨ УГААГЧ НАР ӨӨР УЛС ОРОН, ХӨГЖИЖ БАЙГАА УЛСУУД РУУ АНХААРЛАА ХАНДУУЛАХ БОЛСОН.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа нь улс орны санхүүгийн салбарын цогц байдал болон тогтвортой байдалд нөлөөлж нийт эдийн засаг, улс орны хөгжил гадаад нэр хүндэд нөлөөлж, олон улсын санхүүгийн системд сөрөг үр дагаврыг үзүүлэх эрсдэлтэй байдаг.

Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлого нь санхүүгийн системийг санхүүгийн урсгалыг тогтворгүй болгож, санхүүгийн салбарын хямрал үүсгэх нөхцөл болж, татварын орлого цуглуулалтад нөлөөлж, төр засгийн бодлогыг сулруулж, санхүүгийн байгууллагуудын нэр хүнд, гадаадын корреспондент банкны харилцаанд нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл мөнгө угаах нь мөнгөний эрэлтэд шалтгаангүйгээр нөлөөлж, гадаад хөрөнгийн урсгал, хүү, ханш тогтворгүй болж, эдийн засаг, санхүүгийн бодлогын арга хэрэгслийн үйлчлэл суларч зорилгодоо хүрэх боломжгүй болно.

Терроризмыг санхүүжүүлэх гэж юу вэ?

Терроризмыг санхүүжүүлэх гэдэг нь терроризм үйлдэхээр санаархаж, төлөвлөж эсхүл оролцох гэж буй хувь хүн, байгууллага болон бусад этгээдэд зориулан хууль ёсны болон хууль бус хөрөнгө, орлогыг хуримтлуулах, шилжүүлэх, зарцуулах үйл ажиллагаа юм.

Терроризмыг ихэвчлэн дараах эх үүсвэрээс олсон орлогоор санхүүжүүлдэг. Үүнд:

- их хэмжээний эд хөрөнгө хулгайлах;
- хар тамхи, зэвсгийн наймааны хууль бус худалдаа явуулах;
- хууль бус цагаачлал болон хүн худалдаалах;
- хүн барьцаалах, хулгайлах;
- айлган сүрдүүлэх;
- хууль ёсны болон хууль бус орлогоос хандив тусламж өгөх (хувь хүн, төрийн бус байгууллага, хүмүүнлэгийн байгууллага).

Мөнгө угаах нь хууль бус, гэмт хэргийн гаралтай хөрөнгийг хууль ёсны салбараар дамжуулан хууль бус гарал үүслийг нууж эцсийн үр шимийг хүртэх шунахайн сэдэлтэй үйлдэгддэг бол терроризмыг санхүүжүүлэх нь хууль ёсны эсхүл хууль бусаар олсон хөрөнгийн эх үүсвэрийг далдалж террорист үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор үйлдэгддэг. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх нь мөнгөний гарал үүсэл, зорилго, сэдлээрээ ялгаатай ч мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах, хувиргах болон байршуулах арга хэлбэрээрээ ижил төстэй.

2.2. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн талаарх АНУ-ын эрх зүйн орчин

АНУ-д AML хууль эрх зүйн гол эрх мэдэл нь Банкны нууцын тухай хууль (Bank Secrecy Act) юм. BSA нь 1970 онд байгуулагдсан бөгөөд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хамгийн чухал хэрэгслийн нэг болжээ. Түүнээс хойш хууль сахиулах болон зохицуулах байгууллагуудыг мөнгө угаахтай тэмцэх хамгийн үр дүнтэй арга хэрэгслээр хангах үүднээс бусад олон хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, BSA-г сайжруулсан. BSA-г Сангийн товчооны хэлтэс, FinCEN удирдаж, хэрэгжүүлдэг. FinCEN нь мөн АНУ-ын Санхүүгийн тагнуулын алба юм.

Банкны нууцын тухай хууль (1970)

- Хувь хүн, банк болон бусад санхүүгийн байгууллагуудын бүртгэл хөтлөлт, тайланд тавигдах шаардлагыг тогтоосон
- АНУ-ын нутаг дэвсгэрт зөөвөрлөж, шилжүүлсэн, эсвэл санхүүгийн байгууллагад хадгалуулсан валют болон бусад мөнгөний хэрэгслийн эх үүсвэр, хэмжээ, хөдөлгөөнийг тодорхойлоход туслах зорилготой.
- Банкууд 10,000 доллараас дээш мөнгөн гүйлгээг Валютын гүйлгээний тайланг ашиглан мэдээлэх, гүйлгээ хийж буй хүмүүсийг зөв тодорхойлох болон санхүүгийн гүйлгээний зохих бүртгэлийг хөтөлж цаасан бичгээр хадгалахаар тусгасан.

Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль (1986)

- Мөнгө угаах гэмт хэргийг холбооны гэмт хэрэг гэж тогтоосон
- CTR мэдүүлгээс зайлсхийхийн тулд гүйлгээг зохион байгуулахыг хориглоно
- BSA-ыг зөрчсөн тохиолдолд иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх журмыг нэвтрүүлсэн
- Банкуудад БХБ-ын тайлагнах, бүртгэл хөтлөх шаардлагуудын хэрэгжилтийг хангах, хянах журмыг тогтоож, хадгалахыг үүрэг болгов.

Хар тамхины эсрэг хууль (1988)

- Автомашины дилер, үл хөдлөх хөрөнгийн хаалтын ажилтнууд зэрэг бизнесийг хамруулж санхүүгийн байгууллагын тодорхойлолтыг өргөжүүлж, их хэмжээний валютын гүйлгээний тайланг гаргахыг үүрэг болгосон.
- 3000 доллароос дээш мөнгөний хэрэглүүрийг худалдан авагчдын хувийн мэдээллийг шалгах шаардлагатай.
- Аннунцио-Вайлигийн мөнгө угаахтай тэмцэх тухай хууль (1992)
- BSA зөрчлийн шийтгэлийг чангатгасан
- Шаардлагатай болон сэжигтэй үйл ажиллагааны тайлан, өмнө нь ашиглаж байсан гэмт хэргийн лавлагааны маягтуудыг устгасан
- Мөнгө шилжүүлэхэд шаардлагатай баталгаажуулалт, бүртгэл хөтлөлт
- Банкны нууцын тухай хуулийн зөвлөх групп (BSAAG) байгуулав

Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль (1994)

- Банкны агентлагуудад сургалтыг хянаж, сайжруулах, мөнгө угаахтай тэмцэх шалгалтын журмыг боловсруулахыг шаардсан
- Банкны байгууллагуудаас хэргийг хянаж, холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэх журмыг сайжруулахыг шаардсан
- ЗС-аас чөлөөлөх үйл явцыг боловсронгуй болгосон
- Мөнгөний үйлчилгээний бизнес (MSB) бүрийг MSB-ийн эзэмшигч эсвэл хяналтын этгээдээр бүртгүүлэх шаардлагатай болгосон
- Money Services Business-ээс санал болгож буй санхүүгийн үйлчилгээтэй холбогдуулан төлөөлөгчөөр ажиллах эрх бүхий бизнесүүдийн жагсаалтыг хөтлөхийг шаардсан
- Бүртгэлгүй MSB ажиллуулахыг холбооны гэмт хэрэгт тооцдог болгосон
- Улс орнуудад MSB-д хамаарах нэг төрлийн хуулиудыг батлахыг зөвлөсөн

Мөнгө угаах болон санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх стратегийн тухай хууль (1998)

- Шалгуулагчдад зориулсан мөнгө угаахтай тэмцэх сургалт явуулахыг банкны байгууллагуудад шаардсан
- Мөнгө угаахтай тэмцэх үндэсний стратеги боловсруулахыг Төрийн сангийн яам болон бусад агентлагт шаардсан
- Мөнгө угаах гэмт хэрэг их байгаа бүсүүдэд холбооны, муж, орон нутгийн түвшинд хууль сахиулах хүчин чармайлтыг төвлөрүүлэхийн тулд мөнгө угаах болон түүнтэй холбоотой санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хэсгүүдийг байгуулсан.

Терроризмыг таслан зогсоох, саатуулахад шаардлагатай зохих хэрэгслээр хангах замаар Америкийг нэгтгэж, хүчирхэгжүүлэх хууль буюу АНУ-ын эх оронч хууль (2001)

- Терроризмын санхүүжилтийг гэмт хэрэгт тооцож, үйлчлүүлэгчийг таних журмыг бэхжүүлэх замаар одоо байгаа BSA тогтолцоог нэмэгдүүлсэн.
- Санхүүгийн байгууллагууд гадаадын банкуудтай бизнес эрхлэхийг хориглосон
- Санхүүгийн байгууллагууд зохих шалгалтын журамтай байх шаардлагатай (мөн гадаадад хуульч болон хувийн банкны дансанд зохих шалгалтын журмыг сайжруулсан)
- Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох, санхүүгийн байгууллагуудын хооронд сайн дурын үндсэн дээр мэдээлэл солилцохыг шаардсанаар санхүүгийн байгууллагууд болон АНУ-ын засгийн газар хоорондын мэдээлэл солилцох үйл ажиллагаа сайжирсан.
- Мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөрт тавигдах шаардлагыг бүх санхүүгийн байгууллагуудад өргөжүүлсэн
- Мөнгө угаах гэмт хэргийн иргэний болон эрүүгийн шийтгэлийг нэмэгдүүлсэн
- Төрийн сангийн нарийн бичгийн даргад "мөнгө угаахтай холбоотой үндсэн асуудал"-ын харьяалал, байгууллага, гүйлгээнд "тусгай арга хэмжээ" авах эрхийг олгосон
- Бүртгэлийн хандалтыг хөнгөвчилж, банкнаас мэдээлэл авах хүсэлтэд 120 цагийн дотор хариу өгөхийг шаардсан
- Холбооны банкны агентлагууд банкуудын нэгдэл, худалдан авалт болон бизнесийн нэгдэлд зориулсан бусад өргөдлийг шалгахдаа банкны AML бүртгэлийг авч үзэхийг шаардсан

Тагнуулын шинэчлэл ба терроризмоос урьдчилан сэргийлэх тухай хууль (2004)

- Хэрэв нарийн бичгийн дарга мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд тус дөхөм үзүүлэхэд "боломжийн шаардлагатай" гэж үзвэл зарим санхүүгийн байгууллагууд хил дамнасан цахим мөнгөн шилжүүлгийн талаар тайлагнахыг шаарддаг зохицуулалтыг Төрийн сангийн нарийн бичгийн даргаас шаардах үүднээс BSA-д нэмэлт өөрчлөлт оруулсан
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй хууль, эрх зүйн орчин хангалттай сайн бүрдсэн байх шаардлагатай ч түүнээс гадна иргэн, хувь хүн болоод албан байгууллагуудын сонор сэрэмж, хариуцлагатай байдал маш чухал юм.

АНУ-ын TCF National Bank-ийн дэд ерөнхийлөгч, BSA, Compliance & Fraud-ын захирал Жеймс Камманс нь дээрх хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ч банк болон санхүүгийн

байгууллагууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй хэрхэн үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар 5 зөвлөмжийг гаргасан. Үүнд:

1. Технологийн тусламжтайгаар хайлтыг сайжруулах

Хайлтын явцад гарч ирж буй олон хуурамч эерэг шинж тэмдгүүдээс ноцтой аюул заналхийллийг ялгах нь улам бүр хэцүү болж байна.

"Байгууллагад байгаа бүх дансандаа тор тавихын тулд маш олон анхааруулгыг анхаарч үзэх хэрэгтэй" гэж Камманс хэлэв. "Хэрэв бид хуурамч эерэг үр дүнг бууруулж чадвал дансны хамрах хүрээг илүү нарийн түвшинд өргөжүүлж, тайланг илүү үр дүнтэй болгох боломжтой."

Тогтмол хайлт хийхийн тулд хиймэл оюун ухаан гэх мэт зарим төрлийн технологийг ашиглах нь AML албан тушаалтнуудын зарим ачааллыг бууруулж, хайлтыг өргөжүүлэхийн зэрэгцээ зарим хуурамч эерэг үр дүнгүүдийг арилгах боломжтой. Технологийн тусламжтайгаар "та сэрэмжлүүлгийг хэн нэгэн биеэр нэвтрүүлэхгүйгээр илүү өргөн хүрээг хамарсан мэдээллийг харах боломжтой" гэж Камманс хэлэв. "Энэ нь илүү сайн хамрах хүрээг бий болгож, ажилтнуудад цаг зав, анхаарал хандуулах ёстой данс руу хүчин чармайлтаа зориулах боломжийг олгодог."

2. Тогтмол хөндлөнгийн харилцаатай байх

TCF нь муж улсын болон орон нутгийн хууль сахиулах байгууллага, бүс нутгийн банкуудтай улирал тутам дугуй ширээний уулзалт зохион байгуулдаг бөгөөд энэ системээс зайлсхийхийн тулд хүмүүсийн ажиллаж буй чиг хандлага, шинэ арга замуудын талаар ярилцдаг гэж Камманс хэлэв. Хууль сахиулах байгууллага банкуудад шинэ луйврын талаар мэдээлэл өгдөг боловч ихэнхдээ "банкууд хууль сахиулахаас өмнө эдгээр [схемийг] ихэвчлэн хардаг. Бид тэдэнд маш их мэдээлэл өгч байна."

Тогтмол уулзалт хийснээр банкууд болон хууль сахиулах байгууллагууд бие биенээ цаг тухайд нь мэдээлэх, сэжигтэй зүйлүүдийг шалгах, боломжит сүлжээг илрүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж, мөнгө угаах гэмт хэргийн эсрэг нэгдсэн фронт бий болгож чадна.

3. Өгөгдлийн аналитик ашиглан загвар хайх

"Өгөгдлийн аналитик нь мөнгө угаахтай тэмцэх маш чухал хэсэг юм" гэж Камманс хэлэв. "Бид ихэвчлэн олон хүчин зүйлээс шалтгаалсан хэв маягийг олж хардаг - [хууран мэхлэлт] энэ газарзүйн бүс нутагт энэ тодорхой төрлийн бүтээгдэхүүн, энэ тодорхой боломжит ажил мэргэжилтэй үйлчлүүлэгчдээс болж байна."

AML албан тушаалтнууд эргэлзээтэй хэв маягийг хүлээн зөвшөөрсний дараа тэд үйлчлүүлэгчийн загварыг боловсруулж, болзошгүй эрсдэлийг ангилж, өдөр тутмын сөрөг мэдээний дохиог нэгтгэж болно. "Бид сөрөг мэдээ болон дансны ямар нэгэн шинж чанар, газар зүй эсвэл бусад хүчин зүйлсийн хооронд хамаарал байгаа эсэхийг харах болно" гэж тэр хэлэв. Зорилго нь "харилцагчийг банкинд орохоос нь өмнө эрсдэлд нь бодит цагийн дүн шинжилгээ хийх. Бодит байдлаас хойш хоёр гурав хоногийн дараа биш. Тэдэнд хэдхэн хоногийн л хэрэгтэй - мөнгө банк руу орж, алга болно."

TCF нь Thomson Reuters CLEAR гэх мэт зохих шалгалтын хэрэгслийг ашиглан данснуудыг болзошгүй сэрэмжлүүлэг эсвэл мөнгө угаах хэв маягтай илүү сайн холбоход ашигладаг. Олон тооны ПИН кодтой эсвэл татварын луйвартай холбоотой хүмүүсийг олох нь нэмэлт мөрдөн байцаалтыг өдөөж болох олон хүчин зүйлийн нэг юм.

4. Системээ стандартчилах

Олон банкууд өрсөлдөгчөө худалдаж авснаар өсөхийн хэрээр хуучин компьютерийн системийн сүлжээг нэгтгэдэг. Зарим хэлтэс нь хүснэгт, бусад нь дэвтэр ашиглаж болно. Системийн ийм ялгаа нь залилангийн эсрэг хүчин чармайлтад саад болж, янз бүрийн салбарууд хоорондоо үр дүнтэй харилцахаас сэргийлдэг.

Тийм ч учраас илүү олон санхүүгийн байгууллагууд бүрэн дижитал орчинд шилжиж, үүлэн программ хангамж болон том өгөгдлийн хэрэглээгээ өргөжүүлж, "стандарчилсан тодорхойлолтууд болон нэр томъёоны тодорхойлолтын бараа материалыг давхарлаж, бүх байгууллага даяар стандартчилах боломжтой" гэж Камманс хэлжээ.

5. Бүтцийн сургалт зайлшгүй чухал

AML албан тушаалтнууд юу хайхаа мэддэг байх ёстой. TCF нь сургагч багш, хөгжүүлэгч, чиглүүлэгч гэсэн гурван тусгай албан тушаалтантай бөгөөд ажилчдын шинэ чиг баримжаа олгох, сургах ажлыг хариуцдаг. Эдгээр сургагч багш нар хүн бүрийг хурдасгаж, банкийг бүхэлд нь хурдасгах зорилгоор албаны хүмүүст засч залруулах сургалт явуулдаг.

Сэжигтэй үйлдлүүдийг хайхад урд талын ажилтнуудыг сургах нь маш чухал бөгөөд эдгээр нь ажиглалтын эхний мөр юм. Ар талын ажилтнууд эхлээд сэжигтэй зүйлийг анзаарахгүй байж болох ч харилцагчийн үйлчилгээний төлөөлөгч данс эзэмшигч нь тэдний нэр дээр хийгдсэн үйлдлүүдийг мэдэхгүй байгаа мэт санаа зовж байгаагаа илэрхийлж болно.

Энэ мэтчилэн АНУ мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн эсрэг тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс хууль, эрх зүйн баримт бичгүүдээ тогтмол шинэчилж, сайжруулах, муж нэгж бүртээ хэрэгжилтийг нь хангах, ард иргэдийнхээ мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, улс орнуудад зөвлөх зэргээр шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.

2.3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн талаарх Монгол улсын эрх зүйн орчин

Улсын Их Хурлаар 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эхлүүлсэн. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд 2018 болон 2019 онуудад нэмэлт өөрчлөлт оруулснаар хуулийн хамрах хүрээг өргөжүүлж, олон улсын стандарт, шаардлагын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдийн төрлийг нэмэгдүүлсэн. (Монгол банк, 2020)

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн зорилт нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах эрх зүйн үндсийг тогтоох юм. Хэрвээ энэхүү хуульд тусгагдсан зүйл, заалтууд нь олон улсын эрх зүйн

ямарваа нэгэн актуудтай зөрчилдвөл олон улсын эрх зүйн баримт бичгийг дагахаар заагдсан байдаг болно. ("Мөнгө угаах болон терроризмтэй тэмцэх тухай хууль," 2013)

Монгол улсын Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйлд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн тохиолдолд;

1.1. нэргүй, дугаарласан, хуурамч нэрээр данс нээх, эсхүл гүйлгээ хийх;

1.2. хаагдсан данс ашиглах;

1.3. халхавч банктай харилцсан;

1.4. халхавч банктай харилцаа тогтоосон банктай харилцсан;

1.5. халхавч банктай өмнө нь харилцаа тогтоосон байсан харилцааг үргэлжлүүлэхийг хориглосон журам зөрчсөн бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. (Зөрчлийн тухай хууль, 2017) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн тухай хуульд зааснаар энэ төрлийн гэмт хэргийг (Санхүүгийн мэдээллийн албанд) мэдээлэх үүрэгтэй этгээдүүд нь:

1.Банк;

2.Банк бус санхүүгийн байгууллага;

3.Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;

4.Хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани;

5.Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;

6.Хадгаламж, зээлийн хоршоо;

7.Үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;

8.20 сая төгрөг бүхий бэлэн мөнгөний гүйлгээнд оролцсон бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;

9.Нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн харилцагчтай холбоотой дараах ажиллагааг бэлтгэсэн, хийсэн, эсхүл оролцсон бол:

- үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;
- харилцагчийн хөрөнгийг удирдах;
- банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;
- компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;
- хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах. ("Мөнгө угаах болон терроризмтэй тэмцэх тухай хууль," 2013)

Энэ хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээд үүргээ гүйцэтгээгүй бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж 5000-200,000 нэгжээр торгоно гэж Зөрчлийн тухай хуульд заасан байдаг. (Зөрчлийн тухай хууль, 2017)

Монгол улсын хилээр бэлэн мөнгө оруулах, гаргах тохиолдолд:

	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хууль	Зөрчлийн тухай хууль:
1	Зорчигч 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлэх бол энэ тухай гаалийн мэдүүлэгт үнэн зөв мэдүүлнэ.	Гаалийн байгууллагад: 1. Үнэн зөв мэдүүлэг гаргахаас зайлсхийсэн; 2. Үнэн зөв мэдүүлэг гаргахаас татгалзсан; 3. Худал мэдүүлсэн бол зөрчилтэй төлбөрийн хэрэгслийн, эсхүл валютын үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүн, хуулийн этгээдийг зөрчилтэй төлбөрийн хэрэгслийн, эсхүл валютын үнийн дүнгийн 15 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2	Дээр дурдсаны дагуу мэдүүлсэн бэлэн мөнгөний мэдүүлгийг гаалийн байгууллага нэгтгэж, сар бүр холбогдох журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлнэ.	
3	15.2-т заасан мэдүүлгийн маягтын загварыг Санхүүгийн мэдээллийн албаны даргатай зөвшилцөж Гаалийн ерөнхий газрын дарга батална.	

Харин энэ төрлийн гэмт хэрэгт оролцсон тохиолдолд Монгол Улсын Эрүүгийн Хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Үүнд:

- Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуух, далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эсхүл эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- Энэ гэмт хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан, эсхүл албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- Энэ гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ (Эрүүгийн хууль, 2002).

Тэгвэл Монгол Улсын Эрүүгийн хуульд Террорист хүн, террорист байгууллага болон террорист ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж шууд болон шууд бусаар, хууль бусаар болон санаатайгаар, бүхэлд нь болон хэсэгчлэн эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсан бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заажээ. (Эрүүгийн хууль, 2002)

Сонирхолтой нь Монгол улсын хэмжээнд дээрх гэмт хэрэгт холбогдон ял шийтгэл авч байсан тохиолдолд огт байхгүй юм. Тодруулбал хууль сахиулах байгууллагууд 2011-2018 оны хооронд 4345 хүнийг мөнгө угаасан байж болзошгүй асуудлаар шалгаснаас 46 хүний хэрэг мөрдөн шалгах шатанд шилжсэн байдаг бол үүнээс анхан шатны шүүхээр хоёр хүнд ял оногдуулсан байна. Гэвч Дээд шүүхийн шатанд эдгээр хоёр хэргийг хэрэгсэхгүй болгож байжээ (Бямбасүрэн, 2018).

2.4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн талаарх хүүхэд залуусын мэдлэг, ойлголтын талаарх судалгааны үр дүн

Энэ төрлийн гэмт хэргийн талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг сайжруулах талаарх эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа нь иргэд энэ гэмт хэрэгт санаатай болон санамсаргүй байдлаар холбогдох тохиолдлуудыг нэмэгдүүлж байна.

- Иргэд санамсаргүйгээр энэхүү төрлийн гэмт хэргийн золиос болдог жишээнүүдээс дурдвал:
- Бусдын хүсэлтээр Улсын хилээр бэлэн мөнгө, эд бараа тээвэрлэх
- Бусдад хувийн мэдээллээ алдах
- Бусдад өөрийн бичиг баримтыг хэрэглүүлэх боломж олгох
- Бусдад өөрийн дансыг ашиглуулах боломж олгох зэрэг юм. (Монгол банк, 2020)

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн талаарх хүүхэд, залуусын ойлголт ямар хэмжээнд байгааг судлах зорилгоор жижиг судалгаа явуулав. Уг судалгаанд МУИС-ийн 129 оюутан болон Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Бор-Өндөр Цогцолбор сургуулийн 21 сурагч хамрагдсан.

Судалгаанд хамрагдагсдын 87 нь буюу 58% нь эмэгтэй байсан бол 63 буюу 42% нь эрэгтэй хүмүүс байна.

График 1: Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа

Хүйсийн харьцаа





График 2: Судалгаанд оролцогчдын насны харьцаа


Насны ангилал



Судалгаанд хамрагдсан нийт 150 оролцогчдыг насаар нь ангилж үзвэл:

График 3: Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин

Боловсролын түвшин



Судалгаанд оролцогчдыг боловсролын түвшингээр нь ангилж үзвэл:

Дээд боловсрол-53


Бүрэн дунд боловсрол-76

Дунд боловсрол-21

Судалгааны үндсэн хэсэг болох “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх” гэмт хэргийн ойлголтын талаарх асуулт:

График 4: Мөнгө угаах гэмт хэргийн талаарх ойлголт


Мөнгө угаах гэмт хэргийн талаарх ойлголт



Судалгаанд оролцсон нийт 150 хүнээс 76 нь буюу 50.7% нь уг гэмт хэргийн талаар мэдлэгтэй байсан. Харин 65 иргэн буюу нийт судалгаанд оролцогчдын 43.3% нь уг нэршлийг сонсож байсан ч төдийлөн сайн мэдэхгүй гэж хариулсан бол үлдсэн 6% нь уг гэмт хэргийн талаар огт ойлголтгүй байсан юм.

График 5: терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн талаарх ойлголт

Терроризмийг санхүүжүүлэх тухай ойлголт




Та "терроризмыг санхүүжүүлэх" гэх ойлголтын талаар мэдэх үү?

Судалгаанд оролцсон нийт 150 хүнээс 51 нь буюу 34% нь уг гэмт хэргийн талаар мэдлэгтэй байсан. Харин 46 иргэн буюу нийт судалгаанд оролцогчдын 30.7% нь уг нэршлийг сонсож байсан ч төдийлөн сайн ойлголтгүй гэж хариулсан бол үлдсэн

35.3% нь буюу 1/3-ээс илүү хэсэг уг гэмт хэргийн талаар огт ойлголтгүй байсан юм.

График 6: Мөнгө угаах гэмт хэрэгт холбогдсоноор хүлээх хариуцлагын талаарх ойлголт

Мөнгө угаах гэмт хэргийн талаарх ойлголт




Та мөнгө угаах гэмт хэрэгт холбогдсоноор ямар хариуцлага хүлээдгийг мэдэх үү?

Судалгаанд оролцсон нийт 150 хүнээс 103 нь буюу 68.7% нь уг гэмт хэргийн улмаас ямар шийтгэл хүлээх талаар ойлголтгүй байса бол 47 оролцогч буюу нийт судалгаанд оролцогчдын 31.3% нь хүлээх хариуцлагын

талаар тодорхой хэмжээний ойлголттой байсан юм.

График 7: Терроризмийг санхүүжүүлэх гэмт хэрэгт холбогдсоноор хүлээх хариуцлагын талаарх ойлголт

Терроризмийг санхүүжүүлэх талаарх ойлголт




Та терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт холбогдсоноор ямар хариуцлага хүлээдгийг мэдэх үү?

Судалгаанд оролцсон нийт 150 хүнээс 116 нь буюу 77.3% нь уг гэмт хэргийн улмаас ямар шийтгэл хүлээх талаар ойлголтгүй байса бол 34 оролцогч буюу нийт судалгаанд оролцогчдийн

22.7% нь хүлээх хариуцлагын талаар тодорхой хэмжээний ойлголттой байсан юм.

График 8: Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх гэмт хэргийн талаарх иргэдийн ойлголт


Points scored



Таны бодлоор иргэд санамсаргүйгээр дээрх гэмт хэрэгт холбогдох боломжтой юу?

График 9: Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх гэмт хэргийн талаарх эрх зүйн зохицуулалттай танилцсан эсэх

эрх зүйн зохицуулалтын тухай




Та дээрх гэмт хэрэгтэй холбоотой үндэсний эрх зүйн зохицуулалттай танилцаж байсан уу?

Судалгаанд оролцсон нийт 150 хүнээс 136 нь буюу 90.7% нь дээрх гэмт хэрэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалттай танилцаж байсан бол 14 оролцогч буюу нийт судалгаанд оролцогчдын

ердөө 9.3% нь танилцаж байсан гэж хариулсан.

График 10: Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх гэмт хэргийн талаарх ойлголт

Points scored



Дээрх гэмт хэргүүдийн талаар та болон таны эргэн тойрны найзууд хангалттай мэдээлэлтэй гэж бодож байна уу?

График 11: Хүүхэд, залуусын хамгийн их хэрэглэдэг социал платформ

Та ямар цахим платформыг түлхүү хэрэглэдэг вэ?





График12: Хүүхэд, залуусын хамгийн их үздэг видео контентын хугацаа

Таны интернетээр дамжуулан үзэх видео контент ямар хугацаатай байвал зүгээр вэ?



Энэхүү судалгаанаас харахад хүүхэд залуусын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн талаарх ойлголт хангалтгүй түвшинд байгаа бөгөөд дийлэнх тохиолдолд тухайн гэмт хэргийг нэрнээс нь бусдаар мэдэхгүй байх тохиолдол их байна. Тодруулбал хүүхэд залуусын ердөө 30 орчим хувьд нь л мөнгө угаах гэмт хэрэгтэй холбогдсоноор ямар ял шийтгэл үүрч болох тухай мэдлэгтэй байгаа бол ердөө 20 орчим хувь нь л терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт холбогдсоноор ямар шийтгэл хүлээж болзошгүй мэдэж байгаа харамсалтай дүр зураг харагдаж байна. Мөн түүнчлэн судалгаанд хамрагдсан залуусын ердөө 9.3% нь л дээрх гэмт хэрэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалттай танилцсан байна.

Иймээс сүүлийн үед хүүхэд залуус дийлэнх цагаа өнгөрөөх болсон цахим сувгуудаар дамжуулан ялангуяа хүүхдүүдийн төвөгшөөлгүй үздэг видео контентоор дамжуулан уг гэмт хэрэгтэй холбоотой мэдээллийг түгээх боломжтой гэж бодож байна.

3. ДҮГНЭЛТ

Монгол улсад “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх” гэмт хэргийн тухай болон “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай” хуулиуд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн үндсэн эрх зүйн нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн Монгол улсын Эрүүгийн Хууль болон Зөрчлийн тухай хуулиудад дээрх гэмт хэрэгт холбогдвол хүлээх хариуцлагыг тодорхойлж буй.

Хэдийгээр бусад улс орнуудтай харьцуулахад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь Монгол Улсын хувьд танил болоод удаагүй ойлголт боловч бусад улс орны туршлагаас суралцах хэрэгцээ шаардлага тулгарсаар байна. АНУ-ын жишээн дээрээс харахад анх баталсан хууль, эрх зүйн баримт бичгүүдээ цаг үед нь нийцүүлэн тогтмол шинэчилж, зүйл заалтуудыг нь улам боловсронгуй болгосоор ирсэн байна. Түүнээс гадна банк болон санхүүгийн байгууллагын ажиллах хүчнээ мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд шаардагдах мэдлэг, чадварыг олгох сургалт, хөтөлбөрүүдийг тогтмол явуулдаг байна. Монгол улс үүнээс үлгэрлэн эрх зүйн орчиндоо хүүхэд, залууст эдгээр гэмт хэргийн хор уршиг, үр дагавар зэргийг таниулах тухай заалт оруулах эсвэл эрх бүхий байгууллагад иргэдийн мэдлэг, мэдээллийг сайжруулах болох юм.

4. САНАЛ ЗӨВЛӨМЖ

- Иймээс цахим ертөнц хөгжиж, хүүхэд залуусын анхаарлыг татах болсон платформуудаар хүүхдүүдийг залхаалгүй мэдлэг олгохоор 1-2 минутын бичлэгээр дамжуулан дээрх гэмт хэргүүдтэй холбоотой ойлголтыг өгөх;
- Мөн энэ талаар ерөнхий боловсролын сургуулиудын холбогдох хичээлийн хөтөлбөр, агуулгад дэлгэрэнгүй тусгаж өгөх шаардлагатай байна.
- Цаашлаад дотоод дахь банк, санхүүгийн байгууллагууд, тэдгээрийн ажилтан, мэргэжилтнүүдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн эсрэг тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар тогтмол сургалт, зөвлөгөөнүүдийг оруулж, мэдлэг чадварыг нь сайжруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд төр, хувийн хэвшлүүд хамтран үндэсний хэмжээнд бодлого дэвшүүлж, бодит ажил хэрэг болгох хэрэгтэй гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Эрүүгийн хууль (2014 онд шинэчлэн найруулсан ed.). (2002). legalinfo.mn.

Мөнгө угаах болон терроризмтэй тэмцэх тухай хууль. (2013). In Монгол Улсын Үндсэн Хууль. legalinfo.mn.

Зөрчлийн тухай хууль. (2017). legalinfo.mn.

Монгол банк. (2020). МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ.

Бямбасүрэн, Б. (2018). Татварын хар жагсаалтаас хортой "Саарал жагсаалт". ikon.mn.
<https://ikon.mn/opinion/190z>

<https://www.sankhuuginbolovsrol.mn/>

Гадаад цахим эх сурвалж

<https://legal.thomsonreuters.com/en/insights/white-papers/combating-money-laundering-five-ways-to-help>

<https://iclg.com/practice-areas/anti-money-laundering-laws-and-regulations/usa>

<https://www.fincen.gov/history-anti-money-laundering-laws>

ХАВСРАЛТ

Мөнгө Угаах, Терроризмыг Санхүүжүүлэх Гэмт Хэргийн Тухай хүүхэд залуусын мэдлэгийг тодорхойлох судалгааны асуулт:

1. Таны хүйс

- a. Эр b. Эм

2. Та хэдэн настай вэ?

- a. 10-15 c. 21-25 e. 31-35
b. 16-20 d. 26-30

3. Таны боловсролын түвшин:

- a. Бага c. Бүрэн дунд
b. Дунд d. Дээд

4. Та “мөнгө угаах” гэх ойлголтын талаар мэдэх үү?

- a. Тийм b. Үгүй
c. Сонсож байсан. Гэхдээ тодорхой мэдэхгүй.

5. Та “терроризмыг санхүүжүүлэх” гэх ойлголтын талаар мэдэх үү?

- a. Тийм b. Үгүй
c. Сонсож байсан. Гэхдээ тодорхой мэдэхгүй.

6. Та “мөнгө угаах” гэмт хэрэгт холбогдсоноор ямар хариуцлага хүлээдгийг мэдэх үү?

- a. Тийм b. үгүй

7. Та “терроризмыг санхүүжүүлэх” гэмт хэрэгт холбогдсоноор ямар хариуцлага хүлээдгийг мэдэх үү?

- a. Тийм b. үгүй

8. Таны бодлоор иргэд санамсаргүйгээр дээрх гэмт хэрэгт холбогдох боломжтой юу?

- a. Тийм c. Мэдэхгүй
b. Үгүй

9. Та дээрх гэмт хэрэгтэй холбоотой үндэсний эрх зүйн зохицуулалттай танилцаж байсан уу?

- a. Тийм b. Үгүй

10. Дээрх гэмт хэргүүдийн талаар та болон таны эргэн тойрны найзууд хангалттай мэдээлэлтэй гэж бодож байна уу?

- a. Тийм c. Магадгүй
b. Үгүй

11. Та ямар цахим платформыг түлхүү хэрэглэдэг вэ?

- a. Facebook c. Tik tok
- b. Instagram d. You tube

12. Таны интернетээр дамжуулан үзэх видео контент ямар хугацаатай байвал зүгээр вэ?

- a. 1 минут хүртэлх c. 2-3 минут
- b. 1-2 минут d. 3-с дээш



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

МОНГОЛБАНК

**ЗЭРЛЭГ АН АМЬТДЫГ ХУУЛЬ БУСААР
ХУДАЛДААЛАХ ЗАМААР МӨНГӨ УГААХ ГЭМТ
ХЭРЭГ ҮЙЛДЭХ ЯВДАЛ**

Ц.Бямбадорж⁴⁸,

⁴⁸ Дотоод хэргийн их сургууль, Цагдаагийн сургууль, эдийн засгийн мөрдөгч-эрх зүй хөтөлбөрийн 3223 дугаар дамжааны сонсогч. Цахим хаяг: byambadorj.bdj@gmail.com

ТОВЧ ХУРААНГУЙ

"MONEY LAUNDERING" буюу мөнгө угаах гэдэг нэр томъёо нь Америкаас гаралтай бөгөөд гэмт хэргийн замаар олсон эд хөрөнгийн эх үүсвэрийг нуун далдлах болон түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг хууль ёсны болгох үйлдлийг хэлнэ. Харин мөнгө угаах нэр томъёолол нь сонгодог хэлбэрээрээ 1920-иод онд Америкийн хуурай хууль үйлчилж байх үед Чикагогийн мафийн толгойлогч Ал Капоне өөрийн эзэмшлийн хувцас угаалгын газруудыг ашиглан хууль бус үйлдэл (архины худалдаа, рекет)-ээр олсон орлогоо угаалгын газрын ашиг мэт харуулж байсныг "L,expressee" сонинд "Хувцас биш мөнгө угааж байна" гэж бичсэнээр анх гарч ирсэн гэж үздэг. Зэрлэг ан амьтдыг хууль бусаар худалдаалах, улсын хилээр нэвтрүүлэх замаар олсон хөрөнгө мөнгийг эх үүсвэрийг нь далдлах зорилгоор мөнгө угаах гэмт хэргийг үйлддэг байна.

Гадаад орны болон Монгол Улсын иргэдэд ан амьтдыг хууль бусаар худалдаалах, улсын хилээр нэвтрүүлэх гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан шинж эрүүгийн хэрэг мөрдөн шалгах явцад илэрсэн тохиолдолд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлд заасан "Мөнгө угаах" гэмт хэргээр давхар зүйлчлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулна.

Өөрөөр хэлбэл энэ төрлийн гэмт хэргийн хувьд суурь гэмт хэрэг /анг predicate crime, орос предикатное преступление/ болон гэмт хэрэг үйлдэх замаар олсон хөрөнгө, мөнгийг хувиргасан, шилжүүлсэн үйлдлийг заавал нотолж, суурь гэмт хэрэг, буюу ан амьтдыг хууль бусаар худалдаалах гэмт хэргийн зүйл анги, мөнгө угаах гэмт хэргийн зүйл ангиар давхар зүйлчлэн шалгаж, хууль бусаар олсон хөрөнгө, мөнгийг нуусан, шилжүүлсэн, хувиргасан үйлдлийг тогтоох, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгийг битүүмжлэх, хураан авахад анхаарах шаардлагатай.

Ан амьтанг худалдсан, худалдан авсан үйлдэл нь нэн ховор, ховор амьтны түүхий эдийг хэн нэгэн олзворлосон эсэхээс үл хамаарч, худалдаалах, худалдах, бараа таваарын солилцоонд ашиглах, харилцан солилцох, аливаа нэг арга хэрэгслээр төлбөрийн хэрэгсэл болгон шилжүүлэх, шилжүүлэн авахыг хэлнэ. Амьтны тухай хуулийн 25.3-т заасан тодорхойлолт аваагүй амьтны гаралтай түүхий эдийг худалдах худалдан авахыг хориглосон бөгөөд "тодорхойлолт"-ыг зөвшөөрлийн бичиг гэж үзэж болно.

ТҮЛХҮҮР ҮГ

Мөнгө угаах гэмт хэрэг, "MONEY LAUNDERING" буюу мөнгө угаах, хууль бусаар ан агнах гэмт хэрэг, суурь гэмт хэрэг, гэмт хэргийн замаар олсон эд хөрөнгийг нуух, далдлах, зөөвөрлөх, эх үүсвэрийг өөрчлөх.

1. ҮНДСЭН ХЭСЭГ

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн ойлголт, мөн чанар

Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт байгаль орчин, байгаль хамгаалах болон амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцаанд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан үйлдлийг Монгол Улсын эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл юм.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн объектив шинж:

Объект нь байгаль орчин, байгаль хамгаалах болон амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцаа байна.⁴⁹ Мал, гэрийн тэжээвэр амьтнаас бусад манай орны “улсын тусгай хамгаалалттай газар”-т оршин буй аливаа амьтад, “нэн ховор”, “ховор” амьтныг агнах, барих, ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах, тэдгээр амьтдын эд эрхтнийг хууль бусаар худалдаалахыг хориглож, эрүүгийн эрх зүйн хамгаалалтад авч буй хэм хэмжээ байна.

Халдлагын зүйл нь амьтан, амьтны гаралтай түүхий эд, амьтны эд, эрхтэн, чихмэл байна. **тухайлбал, амьтны мах, дотор эрхтэн, булчирхай, цус, өөх тос, арьс, үс, ноос ноолуур, яс, өд, хайрс, хошуу, эвэр туурай зэрэг эрхтэн байх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй. Мөн түүнчлэн амьтны амьдрах орчин нь халдлагын зүйл байна.**

Амьтан гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавж зөөлөн биетэн хамаарна.⁵⁰

Агнуурын амьтан гэж арьс, үс, мах, болон бусад түүхий эдийг ашиглахаар агнаж ирсэн уламжлалтай, агнуурын нөөцтэй амьтныг ойлгоно.⁵¹

Ховор амьтан гэж тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөцтэй багатай, устгаж болзошгүй амьтныг ойлгоно.⁵²

Амьтны гаралтай түүхий эд гэж амьтны арьс, шир, үс, өд, эвэр, толгой, цус, өөх, тос, зэрэг эд эрхтэнийг ойлгоно.⁵³

Амьтны чихмэл гэж эрдэм шинжилгээ, танин мэдэхүйн зорилгоор хийсэн амьтны арьс, үсийг ашиглан уг амьтныг сэргээн бүтээснийг ойлгоно.

Гэмт хэргийн объектив тал:

Энэ гэмт хэргийн объектив тал нь Улсын тусгай хамгаалалттай газарт зөвшөөрөлгүй элбэг тархацтай аливаа амьтан, нэн ховор, ховор амьтныг агнасан барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийг хадгалсан, худалдсан, худалдан

⁴⁹ Амьтны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1

⁵⁰ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.4

⁵¹ Амьтны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7

⁵² Амьтны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4

⁵³ Амьтны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.20

авсан, тээвэрлэсэн, гадаад улс руу гаргасан, ховор амьтаны чихмэл, эд эрхтэн, тэдгээрийг гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн идэвхтэй үйлдэл байна.

Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан гэдэг нь “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хуульд заасан, дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар гэж ангилагдсан газарт нутагшин буй аливаа элбэг тархацтай болон ховор, нэн ховор амьтныг зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан үйлдлийг ойлгоно.

Ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан гэдэг нь мөн төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрөлгүй агнаж байгаа үйлдэл юм. Ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлөөр судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар эсхүл Монгол Улсын болон гадаадын иргэн тусгай төлбөр төлсөн, тодорхой нутаг дэвсгэрт амьтны сүргийн бүтцийг зохицуулах болон халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор л агнаж, барьж болно.

Зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн гэдэг нь тархац нутагтаа тоо толгой нь цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтныг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр тэжээж гаршуулах, үржүүлж буй үйлдэл, үйл ажиллагааг ойлгоно.

Түүхий эдийн зүйлийг хадгалсан гэдэг нь зохих зөвшөөрөлгүйгээр бэлтгэсэн амьтны түүхий эдийг эмчилгээ, ахуйн хэрэглээнд ашиглах, малгай хувцас хийх зорилгоор бүтээгдэхүүн болгоогүй, арьс үсээр нь хадгалж буй үйлдлийг ойлгоно.

Худалдсан, худалдан авсан үйлдэл нь нэн ховор, ховор амьтны түүхий эдийг хэн нэгэн олзворлосон эсэхээс үл хамаарч, худалдаалах, худалдах, бараа таваарын солилцоонд ашиглах, харилцан солилцох, аливаа нэг арга хэрэгслээр төлбөрийн хэрэгсэл болгон шилжүүлэх, шилжүүлэн авахыг хэлнэ. Амьтны тухай хуулийн 25.3-т заасан тодорхойлолт аваагүй амьтны гаралтай түүхий эдийг худалдах худалдан авахыг хориглосон бөгөөд “тодорхойлолт”-ыг зөвшөөрлийн бичиг гэж үзнэ.

Тээвэрлэсэн гэдэг нь зохих зөвшөөрөлгүйгээр бэлтгэсэн амьтны гаралтай түүхий эдийг тээврийн аливаа хэрэгслээр аль нэг цэгт, ямар нэгэн зорилгоор зөөвөрлөн авч явах үйлдлийг ойлгоно.

Гадаад улсад гаргасан гэдэг нь нэн ховор, ховор амьтны түүхий эдийг улсын хилээр нэвтрүүлж, гадаад улсад гаргасныг ойлгоно.

Амьтны чихмэл, түүхий эдийн цуглуулга нь аливаа зорилгоор нэн ховор, ховор амьтны эд эрхтэн болох арьс, үс, яс зэрэг амьтны гаралтай зүйлсээр чихмэл, цуглуулга хийж буй үйлдлийг ойлгоно.

Амьдрах орчныг алдагдуулсан гэдэг нь тархац нутагтаа тоо толгой нөөц нь багассан нэн ховор амьтан нь эмзэг учраас тэдгээр амьтны амьдрах орчин үүр ичээ, нутагшин буй газар орныг эвдэх сүйтгэх, байгалийн төрх байдлыг нь алдагдуулж буй идэвхтэй үйлдлийг ойлгоно.

Түүхий эдийг бэлтгэсэн гэдэг нь нэн ховор амьтны түүхий эдийг аливаа зорилгод ашиглахаар бэлтгэж, цуглуулж буй идэвхтэй үйлдлийг түүхий эдийг бэлтгэсэн гэнэ.

Хууль бусаар агнах гэмт хэрэг нь байгаль орчинд хохирол учирсан байхыг шаардахгүй, хууль бусаар ан агнаснаар, төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг. Хууль бусаар амьтны эд

эрхтнийг худалдах, худалдан авах, тээвэрлэх, хадгалах, бэлтгэх үйлдэл нь хууль бусаар агнасан, барьсан үйлдэлтэй салшгүй холбоо, хамааралтай байдаг.

Гэмт хэргийн субъектив тал

Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүнийг хүсч үйлдсэн байдаг.

Зэрлэг амьтан довтолж, хүний амь насанд аюул учруулахад хүрсэн үед амьтан агнасан нь санаа зорилгоороо өөр тул гэмт хэрэгт тооцохгүй.⁵⁴

Субъект нь Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, хувь хүн байна. Тухайн хүн Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, хоёрдмол харьяалалтай хүн аль нь ч байж болно.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийг нийгмийн аюулын шинж, түүний хэр хэмжээг харгалзан үндсэн болон хүндрүүлэх шинжид ангилдаг.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн хүндрүүлэх шинж /Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/

Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулсан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, түүхий эд, эд эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол хүндрүүлэн зүйлчилнэ.

Нэн ховор амьтан гэж тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устгах аюулд орсон амьтныг ойлгоно.⁵⁵

Нэн ховор, ховор амьтны амьдрах орчныг алдагдуулсан гэдэг нь тархац нутагтаа бүхэлдээ эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устгах аюулд орсон амьтны амьдрах орчин үүр ичээ, нутагшин буй газар орныг эвдэх сүйтгэх, байгалийн төрх байдлыг нь алдагдуулж буй идэвхтэй үйлдлийг ойлгоно.

Нэн ховор, ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан үйлдэл нь нэн ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрөлгүй агнаж байгаа үйлдэл юм. Нэн ховор амьтныг зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно.

Нэн ховор амьтны түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан гэж тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устгах аюулд орсон амьтныг гаралтай түүхий эдийн зүйлийг олж бэлтгэсэн, борцолсон, нэг газраас нөгөө газарт зөөж шилжүүлсэн, өөрийн болон

⁵⁴ Эрүүгийн хуулийн 4.3 дугаар зүйл.Гарцаагүй байдалд хохирол учруулах

1.Энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд тулгарсан аюулыг өөр арга хэрэгслээр арилгах боломжгүй нөхцөл байдалд учирч болох байсан аюулын хэр хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр энэ хуульд заасан гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийж бусдад хохирол учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй.

⁵⁵ Амьтны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3

бусдын орон байр, агуулах, тээврийн хэрэгсэлд байлгасан, бусдад мөнгө болон бусад зүйлээр зарсан, худалдан авсан, улсын хилээр нэвтрүүлж, гадаад улсад гаргасан зэргийг ойлгоно.

Дээрх төрлийн гэмт хэргийн криминалистик шинж ба мөрдөн шалгах ажиллагаа

Хууль бусаар ан агнах гэмт хэргийг илрүүлэх мөрдөн шалгах ажиллагаа нь нийтлэг үйлдэгдэг гэмт хэргийг шалгах процесс ажиллагааны нэгэн адил явагдах боловч гэмт хэргийн шинж, өвөрмөц онцлогоос хамаарч анхаарах, заавал мэдсэн байх хэд хэдэн шаардлагууд байдаг. Үүнд: Хэргийг мөрдөн шалгах анхан шатны ажиллагаанд тухайн хэргийг илрүүлэх тухай асуудал онцгой чухал байр эзэлдэг. Учир нь иргэдийн эрүүл мэндийн болон өмчийн эсрэг гэмт хэрэг шиг хэн нэгэн энэ хэргийн гомдол, нэхэмжлэл тэр бүр гаргаад байдаггүй. Хүрээлэн буй орчны төлөө санаа тавьдаг, эсхүл ажил үүргийн хувьд холбоо хамааралтай хүмүүсийн мэдээлэлд ихэвчлэн тулгуурлан илэрч шалгагдаж байна.

Сүүлийн үед байгаль орчны сэтгүүл зүй хөгжиж, эрэн сурвалжлах идэвхтэй ажиллагаа явуулж, олон мэдээллийг нийтэд ил болгож байна. Тийм учраас тэднээс мэдээлэл авах нь зүйтэй. Аялагч, эрдэм шинжилгээ судалгаа хийж буй судлаач, аялал жуулчлал, ан агнуурын зөвшөөрөлтэй компани, хөдөө орон нутагт ажилладаг геологи, уул уурхай ажилчдаас хууль бус ан агнуурын үнэ цэнтэй мэдээлэл олж авч болно.

Олон улсын болон дотоодын төрийн бус байгууллага, иргэний нисэх, авто тээвэр, төмөр замын байгууллагаас амьтны эд эрхтэн зөөж тээвэрлэж байгаа хууль бус үйлдлийн талаар мэдэж байж болзошгүй тул тэдгээр байгууллагын ажилтан албан тушаалтнаас мэдээлэл авах ажлыг зохион байгуулах нь үр дүнтэй.

Төрийн байгууллагын хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцдаа гэмт хэргийн шинжтэй мэдээллийг хамтын ажиллагааны хүрээнд харилцан солилцож байх нь чухал байдаг. Үүнд гаалийн байгууллагын хяналт шалгалт, мэргэжлийн хяналтын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа болон хяналт шалгалт, гадаадын иргэн харьяатын алба, хил хамгаалах байгууллага, цэргийн анги салбарын алба хаагчид, төрийн захиргааны төв байгууллага болох Байгаль орчны яам түүний харьяа байгууллага, орон нутгийн төр захиргааны байгууллагын албан тушаалтан – Иргэдийн хурлын төлөөлөгч, засаг дарга, орон нутгийн байгаль хамгаалагч, тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нараас мэдээлэл авч болно.

Түүнээс гадна хууль сахиулах байгууллага тагнуул, авилагтай тэмцэх газар, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо нь энэ гэмт хэргийн мэдээлэл олж авч болох эх сурвалж болж болно.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн шалгахад анхаарах асуудал

Мөрдөгч хэргийг шалгахад эрүүгийн хуулийн 24.5-д заасан гэмт хэргийн объектив үйлдлийг нэг бүрчлэн сайтар тогтоох ёстой.

Гэмт хэргийн объектив үйлдлийг гэмт хэргийн ойлголт, шинж гэсэн хэсэгт дурдсан бөгөөд хэргийг шалгахад хэргийн гол нотлох баримт болох амьтан, амьтны эд эрхтнийг илрүүлэх, хураан авах, шинжлэх, байгаль орчин амьтны аймагт учирсан хохирлыг тогтоох зэрэг ажиллагааг дэс дараалалтай хийх ёстой.

Амьтны эд эрхтэн худалдах, худалдан авах, хадгалсан, тээвэрлэсэн үйлдлийг шалгахдаа тухайн эд эрхтэн нь нэн ховор, ховор амьтны эд эрхтэн мөн эсэхийг өөрийн туршлага, эсхүл амьтныг эд эрхтэн таних лавлах ном зэргээс харж баримжаална.

Хэрвээ нэн ховор амьтан биш ховор болон элбэг тархацтай амьтны эд эрхтэн байвал Амьтны тухай хуулийн **12 дугаар зүйлд** тодорхойлолт аваагүй амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглоно **гэж заасны дагуу** тухайн амьтны эд эрхтэнд олгосон гарал үүслийн тодорхойлолт зэргийг үзэж шалгах нь зүйтэй.

Харин амьтны эд эрхтнийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн үйлдэлд хохирлыг хэмжээг тооцохдоо Амьтны тухай хуулийн 37.3-д⁵⁶ заасны баримтлан ан амьтныг агнасан, барьсантай адилтган үзэж, нөхөн төлбөр ногдуулна. Өөрөөр хэлбэл тухайн нэг амьтны эд эрхтнийг нэг амьтан агнасанатай адилтган үзнэ.

Практикт тулгардаг өөр нэг асуудал бол тусгай зөвшөөрөлтэйгөөр ан агнасан байдаг боловч тухайн зөвшөөрлийн бичигт дурдагдсан амьтны эд эрхтэн тоо хэмжээндээ байгаа эсэхийг нягтална. Хэрэв хэмжээ хэтэрсэн⁵⁷ байвал хэтэрсэн тэр хэсгийг зөвшөөрөлгүй ан агнасан барьсан эсвэл хадгалах тээвэрлэх худалдах үйлдэл байвал хууль бус гэж үзнэ.

2. МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ҮНДСЭН ШИНЖ⁵⁸

Объект нь банк, санхүүгийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа байна.

“Мөнгө угаах” гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг хэлнэ.⁵⁹

Объектив тал нь гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан үйлдэл эс үйлдэхүй байна.

“Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан” гэж гэмт хэргийн улмаас олсон мөнгө гэдгийг нь баттай мэдсээр байж түүнийг зориуд авч ашигласан, өөрийн эзэмшилд оруулсан байхыг ойлгоно.

⁵⁶37.3. Энэ хуулийн 25.3-т заасан тодорхойлолт аваагүй амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг цуглуулсан, худалдсан, худалдан авсан, гадаадад гаргахыг завдсан этгээдийг тухайн зүйл ан амьтныг агнасан, барьсантай адилтган үзэж, нөхөн төлбөр ногдуулна.

⁵⁷ Амьтны тухай хуулийн 37.4. Ан амьтан агнах эрхийн бичиг, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн, түүнчлэн зөвшөөрөлгүй ан амьтан агнасан этгээдэд нөхөн төлбөр ногдуулна.

⁵⁸ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүйн тусгай анги, УБ., 2018., 223-224 дахь тал

⁵⁹ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2013 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно.

Хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах гэж тухайн мөнгө, эд хөрөнгийн эх үүсвэрийг хууль бус гэдгийг мэдсээр хууль ёсны мэт болгож эргэлтэд оруулсан, эх үүсвэрийг нь өөрчилсөн байхыг хэлнэ.

Гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн гэж эх үүсвэрийг нь өөрчлөх, тухайн хүний нэрээс хасах, өөр хүнд шилжүүлэх хэлбэрээр илэрнэ.

Субъект нь Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, хувь хүн байна. Тухайн хүн Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, хоёрдмол харьяалалтай хүн аль нь ч байж болно.

Субъектив тал нь Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан гэм буруугийн санаатай хэлбэртэй үйлдэгдэнэ.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн статистик тоон мэдээллийг сүүлийн зургаан жилээр харуулав. Доорхоос дүгнэхэд жил ирэх тусам хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн гаралтын тоо ихсэж байна.

Статистик үзүүлэлт	Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
Өссөн дүн	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	330	367	489	622	601



Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүгийн заргын хуулийн зохицуулалтын талаар ⁶⁰	Оросын Холбооны Улсын Эрүүгийн хуулийн зохицуулалтын талаар	Монгол улсын эрүүгийн хууль
Эрүүгийн заргын хуулийн 341 дүгээр зүйл	Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйл	Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйл
<p>Улсын чухалд тооцогдсон хамгаалах ховор нандин, мөхөх шахсан зэрлэг амьтныг хууль бусаар авлаж, алсан, эсхүл чухалтайд тооцогдсон хамгаалах ховор нандин, мөхөх шахсан зэрлэг амьтан хийгээд түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг хууль бусаар худалдан авсан, зөөвөрлөсөн, худалдсан байвал, таван жилээс доош хугацаатай хорих буюу хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгээд зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэнэ. Үйл байдал нь хүнд ноцтой байвал таван жилээс дээш арван жилээс доош хугацаатай хорихоор шийтгээд зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэнэ. Үйл байдал нь онц ноцтой хүнд ноцтой байвал, 10 жилээс дээш хугацаатай хорихоор шийтгээд зоосоор яллах буюу эд хөрөнгийг нь хураан авахаар нийлүүлэн шийтгэнэ. Ан хийх хууль тогтоолоос зөрчиж, ангийн хориотой газар, агнах хориотой хугацаанд буюу хориотой багаж, аргаар агнаад зэрлэг амьтны эх баялгийг эвдсэн үйл байдал нь хүнд ноцтой байвал 3 жилээс доош хугацаатай хорих, хорьж хөдөлмөрлүүлэх, захиран хамаарах буюу зоосоор яллахаар шийтгэнэ.</p>	<p>Хууль бусаар ан агнах 1. Хууль бус агнуур, хэрэв энэ үйлдлийг хийсэн бол: (а) их хэмжээний хохирол учруулах; б) тээврийн хэрэгсэл, нисэх онгоц, тэсрэх бодис, хий, шувуу, амьтныг үй олноор нь устгах бусад аргыг ашиглан; в) агнахыг бүрэн хориглосон шувуу, амьтдын хувьд; г) тусгай хамгаалалттай байгалийн нутаг дэвсгэр, экологийн гамшгийн бүс, экологийн онцгой байдлын бүсэд агнасан бол 500 мянган рубль хүртэл хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ. 2. Албан тушаалын байдлаа ашиглан, эсхүл урьдчилан тохиролцож хэсэг бүлэг этгээд, эсхүл зохион байгуулалттай бүлэг үйлдэж, онц их хэмжээний хохирол учруулсан бол 500,000-аас нэг сая рубль хүртэл төгрөгөөр торгох, эсхүл гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих эсхүл, гурваас таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах. (Энэ зүйлд заасан их хэмжээний хохирол нь Оросын Холбооны Улсын Засгийн газраас баталсан хувь хэмжээ, аргачлалын дагуу дөчин мянган рублиэс дээш, ялангуяа их хэмжээний нэг зуун хорин мянган рубльтэй тэнцэх хэмжээний хохирол гэж тооцогдоно.</p>	<p>1.Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2.Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, нэн ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>

⁶⁰ Б.Батзориг, Э.Зууннасан., Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүгийн ба эрүүгийн хуулийн заргын хууль. УБ., 2006 он, 95 дахь тал

<p>Эрүүгийн заргын хуулийн 312 дугаар зүйл (Мөнгө угаах)</p>	<p>Эрүүгийн хуулийн тусгай ангийн 174 дүгээр зүйл. Гэмт хэргийн аргаар бусдын олж авсан мөнгө, бусад эд хөрөнгийг хууль ёсны болгох (угаах).</p>	<p>Монгол Улсын Эрүүгийн хуулийн 18.6 дугаар бүлэг (Мөнгө угаах гэмт хэрэг)</p>
<p>Гэмт хэргийн аргаар олсон эд хөрөнгийг нуун дарагдуулах, тээвэрлэх, худалдан авах, худалдахад зуучлах гэмт хэрэг үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих, богино хугацаагаар баривчлах, хяналт тавих, эсхүл бие даан хорих ял шийтгэнэ.</p>	<p>1.Бусдын гэмт хэргийн замаар санаатайгаар олж авсан мөнгө, бусад эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хууль ёсны хэлбэрт оруулах зорилгоор санхүүгийн гүйлгээ, бусад хэлцэл хийсэн бол -</p> <p>120 мянган рубль хүртэл торгох, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар цалин орлогыг хураах эсхүл нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгэл оногдуулна.</p> <p>2.Энэ үйлдлийг их хэмжээний хохирол учруулж үйлдсэн, -</p> <p>200 мянган рубль хүртэл хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс хоёр жил хүртэл хугацаагаар ялтны цалин, бусад орлого, эсхүл тодорхой хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ.</p> <p>хоёр жил хүртэл хугацаагаар, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хасаж, тавин мянган рубль хүртэл төгрөгөөр торгох, эсхүл гурван сар хүртэл хугацаагаар ялтны цалин, бусад орлогын хэмжээгээр торгох.</p> <p>3.Энэ зүйлийн нэг, хоёрдугаар хэсэгт заасан үйлдлүүд:</p> <p>а) урьдчилан тохиролцсоны дагуу хэсэг бүлэг хүмүүс;</p> <p>б) албан тушаалын байдлаа ашигласан, -</p> <p>гурван жил хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах эсхүл гурваас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хасаж, таван зуун мянган рубль хүртэл төгрөгөөр торгох, эсхүл ялтны хөдөлмөрийн хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох. эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ. .</p>	<p>1.Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2.Энэ гэмт хэргийг:</p> <p>2.1.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж;</p> <p>2.2.байнга тогтвортой үйлдэж;</p> <p>2.3.албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>

	<p>4.Энэ зүйлийн нэг, гурав дахь хэсэгт заасан үйлдлүүд нь:</p> <p>а) зохион байгуулалттай бүлэг;</p> <p>б) онц их хэмжээгээр, -</p> <p>таван жил хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг нь нэг жил хүртэл хугацаагаар хасах эсхүл гурваас долоо жил хүртэл хугацаагаар хорих, нэг сая рубль хүртэл төгрөгөөр торгох, эсхүл ялтны цалин, бусад орлогын хэмжээгээр торгох.</p> <p>Анхаарна уу. Энэ зүйл болон энэ хуулийн 174.1-д их хэмжээний мөнгө болон бусад эд хөрөнгөтэй хийсэн санхүүгийн гүйлгээ, бусад хэлцлийг нэг сая таван зуун мянган рублиас дээш дүнтэй мөнгө болон бусад эд хөрөнгөтэй хийсэн санхүүгийн гүйлгээ гэж үзнэ.</p>	<p>3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.</p>
--	--	--

Дээрх Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эрүүгийн заргын хууль, Оросын Холбооны Улсын эрүүгийн хууль, Монгол Улсын эрүүгийн хуулиудаас тухайн орнуудын хууль бусаар ан агнах, Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлийн ялгаатай болон төсөөтэй талыг харуулсан ба Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эрүүгийн заргын хуульд хууль бусаар ан агнах гэмт хэргийг үйлдсэн бол таван жилээс доош хугацаатай хорих буюу хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгээд зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэнэ. Мөн мөнгө угаах гэмт хэргийг үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих, богино хугацаагаар баривчлах, хяналт тавих, эсхүл бие даан хорих ялаар шийтгэдэг байна.

Оросын Холбооны Улсын эрүүгийн хуульд хууль бусаар ан агнах гэмт хэрэг үйлдсэн бол 500 мянган рубль хүртэл хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэх бөгөөд уг гэмт хэргийг албан тушаал ашиглан эсхүл бүлэглэн зохион байгуулалтай үйлдсэн бол 500,000-аас нэг сая рубль хүртэл төгрөгөөр торгох, эсхүл гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих эсхүл, гурваас таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах санкцтайгаар зохицуулдаг байна. Харин мөнгө угаах гэмт хэргийн хувьд 120 мянган рубль хүртэл торгох, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар цалин орлогыг хураах эсхүл нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгэл оногдуулах агаад их хэмжээний хохирол учруулсан бол 120 мянган рубль хүртэл торгох, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар цалин орлогыг хураах эсхүл нийтэд тустай ажил хийлгэх, бүлэг хүмүүс болон албан тушаалын байдлаа ашиглан үйлдсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг нь нэг жил хүртэл хугацаагаар хасах эсхүл гурваас долоо жил хүртэл хугацаагаар хорих, нэг сая рубль хүртэл төгрөгөөр торгох, эсхүл ялтны цалин, бусад орлогын хэмжээгээр торгох ялаар шийтгэхээр хуульчилсан байна.

Харин манай улсын хувьд ялын зөөлөн бодлого баримталж гол төлөв торгох ялаар шийтгэдэг болох нь дээрх хүснэгтэн үзүүлэлтээс харагдаж байна. Монгол Улсын хувьд хоёр их гүрний голд оршдог орны хувьд хоёр хөршийн хэрэглэж буй хууль тогтоомжиос өөрийн оронд хэрэглэх боломжтой хэсгийг хуулбарлан авч ижил төсөөтэй аргаар хэрэглэх нь зүйтэй гэж судлаач бидний зүгээс үзэж байна.

3. ДҮГНЭЛТ

Монгол Улсын эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйлд Хууль бусаар ан ангах гэмт хэргийн санкц нь таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс 5 жил хүртэлх хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Харин 18.6 дугаар зүйл. Мөнгө угаах гэмт хэргийн санкц нь зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах эсхүл зургаан сараас нэг жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэнэ, харин хүндрүүлэх нөхцөлөөр үйлдсэн тохиолдолд нэг жилээс 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан байна. Иймд Мөнгө угаах гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл дээр улсын хилээр хууль бусаар бараа нэвтрүүлсэн тохиолдолд хүндрүүлэх нөхцөл болохыг хуульчлах шаардлагатай байгаа бөгөөд хууль бусаар ан агнах гэмт хэргийг үйлдсэн этгээд Монгол Улсын хилээр тухайн амьтны түүхий эдийг нэвтрүүлж гадаад орны иргэн, хуулийн этгээдүүдэд зарж борлуулан их хэмжээний ашиг олдог тул хэд хэдэн төрлийн гэмт хэргийг давхар үйлддэг байна. Мөн хууль бусаар ан агнах гэмт хэргийг гаралт өдөр ирэх тусам

нэмэгдэж байгааг статистик тоон мэдээллээс харагдаж байгаа тул Цагдаагийн ерөнхий газар нь гадаад орны цагдаагийн байгууллага болон Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, зэрэг байгууллагатай харилцан уялдаа холбоотой хамтран ажиллах, мэдээ мэдээлэл солилцох шаардлагатай байгааг харуулж байна.

4. САНАЛ:

1. Цагдаагийн ерөнхий газар нь гадаад орны цагдаагийн байгууллага болон Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, зэрэг байгууллагатай харилцан уялдаа холбоотой хамтран ажиллах санамж бичих гаргах;
2. Хууль бусаар ан агнах гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг мэдсээр байж авсан, эзэмшсэн, ашигласан, түүний хууль бус эх үүсвэрийг нуун далдлах гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга эзэмшигч эд хөрөнгийг эрхийг нуун далдалсан, эсхүл терроризмыг санхүүжүүлсэн үйлдлийг мөрдөн шалгах ажиллагаа явуулах нэгжийг Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст нэг хэсэг болгон оруулах ажлыг зохион байгуулж орон тоо нэмэх;
3. Хууль бусаар ан ангах гэмт хэрэг, Мөнгө угаах гэмт хэргийн талаарх сургалтыг Экологийн цагдаагийн албаны мөрдөгч нарт чиглүүлэн Дотоод хэргийн Их сургуулийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхим багш нар “Сургалтын модуль” хөтөлбөр боловсруулж сургалтыг зохион байгуулах;
4. Экологийн цагдаагийн албаны мөрдөгч нарт зориулсан дээрх төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгахад анхаарах асуудал сэдэвт гарын авлага Дотоод хэргийн Их сургуулийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимээс гаргаж алба хаагч нарт олгох;
5. Хууль бусаар ан ангах гэмт хэрэг, Мөнгө угаах гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизтэй хамтран 10 минутын видео шторк гарган олон нийтэд хүргэх;
6. Монгол Улсын эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлд шинээр 3 дахь хэсэг оруулж (зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн эсхүл байнга тогтвортой үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ) гэх заалтыг оруулах тус тус саналтай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүйн тусгай анги, УБ., 2018он
- Б.Батзориг, Э.Зууннасан., БХНАУ-ын Эрүүгийн ба эрүүгийн хуулийн заргын хууль. УБ., 2006 он
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэл
- Эрүүгийн хууль
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
- Амьтны тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Оросын Холбооны Улсын Эрүүгийн хууль
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүгийн хууль.



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА
МОНГОЛБАНК

**МОНГОЛ УЛСЫН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦООГ
ТЕХНОЛОГИД СУУРИЛАН САЙЖРУУЛАХ НЬ**

Н.Чойжамц⁶¹, Д.Сүхбат⁶²

⁶¹ Их засаг олон улсын их сургууль Санхүү эдийн засгийн сургууль БаЭЗ-ын 341-р бүлэг

⁶² Их засаг олон улсын их сургууль Санхүү эдийн засгийн сургууль БаЭЗ-ын 341-р бүлэг

ТОВЧ ХУРААНГУЙ

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх нь эдийн засаг, нийгмийн ихээхэн сөрөг үр дагавартай болохыг ойлгуулах нь чухал юм. Хууль бус мөнгө гаднаас орж ирсэн бол зорилгодоо хүрээд гэнэт орж ирсэн шигээ гэнэт буцаад гарна. Их хэмжээний мөнгө гэнэт орж ирээд гэнэт гарах нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг эвдээд зогсохгүй хямралд ч хүргэж болох юм. Үүний зэрэгцээ олон улсын тавцанд дотоодын банк, санхүүгийн байгууллагуудын нэр хүнд унах, банк, санхүүгийн байгууллагаар дамжин хийгдэж байгаа гадаад гүйлгээг саатуулан шалгах, тэдгээртэй харилцахаас татгалзах хүртэлх арга хэмжээг гадны орнууд авч болох эрсдэлээс сэргийлэх, хяналт тогтолцоог сайжруулах сэдвийн хүрээнд судалгааны ажил хийлээ.

Уг судалгааны ажилд Мексикийн гэмт бүлэглэлүүд АНУ руу хар тамхи хэрхэн тээвэрлэсэн бодит кейс судалгааг хийж, мөнгө угаах гэмт хэргийн арга техник, Монгол улсын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөгжлийн үйл явц, арилжааны банк, Төв банкны санхүүгийн мэдээллийн албаны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэж буй үйл ажиллагаа, зохицуулалтын өнөөгийн байдал зэргийг судлан, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх програм хангамж нэвтрүүлж буй банк, санхүүгийн байгууллагуудын кейс судалгаа, иргэдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх мэдлэгийг тодорхойлох асуулгын судалгаа зэргээр судалгаа шинжилгээгээ хийлээ. Судалгааны үр дүнд гадаад улс орны банк санхүүгийн байгууллагууд нь ихэвчлэн мөнгө угаахтай тэмцэх зорилгоор иргэд, компанитай хамтран ажилладаг бөгөөд тэдгээрийн санал болгож буй платформуор дамжуулан мөнгө угаахаас урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ, үйл ажиллагааны үр ашгаа дээшлүүлж, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаагаа улам боловсронгуй болгох зэрэг үр ашигт үйл ажиллагаанд хүрэн ажиллаж байна. Иймд Монгол улсын хувьд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор технологийн шийдлийг зайлшгүй үйл ажиллагаандаа нэвтрүүлж, уг технологийг сайжруулж ажиллах шаардлага тулгарч байна.

Судалгааны ажлын үр дүнгээс харахад манай улсын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх талаарх мэдээлэл дутмаг байдлаас үүсэх эрсдэл санхүүгийн салбарын тогтолцоонд нөлөөлж болох зэргийг тооцож цаашид авч хэрэгжүүлэх санхүүгийн шинэ технологийг нэвтрүүлэх санал зөвлөмжийг гаргалаа

Хууль бус мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх нь дотоодынх бол энэ нь хээл хахууль, авлигыг нэмэгдүүлэх, шударга өрсөлдөөнийг үгүй хийх, шударгаар бизнес эрхлэгчдийг зах зээлээс шахаж монополь байдал бий болгох зэрэг олон сөрөг үр дагавартай. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо дутуу хөгжсөн орнуудыг мөнгө угаагчид ашиглах эрсдэл өндөр юм. Банк санхүүгийн системийн хөгжлийг дэмжих, иргэдийн санхүүгийн системд итгэх итгэлийг хадгалах зорилгоор хувийн хэвшил, банк санхүүгийн байгууллага, иргэн бүрийн үүрэг, хувь нэмэр, идэвх санаачилга, оролцоо хэрэгтэй юм.

ТҮЛХҮҮР ҮГС

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, технологийн шийдэл, зохицуулалт

1. ОРШИЛ

Энэхүү судалгааны ажлын зорилго бол Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны эрсдэлийг ойлгох, түүнээс урьдчилан сэргийлэх, хяналтын тогтолцоог технологийн шийдэлд тулгуурлан сайжруулах арга зам, боломжийг эрэн хайх, техник технологийн шийдэлд суурилан олж нээх, зохицуулах талаар оюутан залуус, иргэдэд хүртээмжтэй үр дүнтэй оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлэх тогтолцооны сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.

Судалгааны ажлын зорилт:

- ✓ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны судалгаа онолын судалгаа
- ✓ Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх гадаадын кейс судалгаа
- ✓ Монгол улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх өнөөгийн байдлын судалгаа
- ✓ Мөнгө терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх технологи нэвтрүүлж буй банк, санхүүгийн байгууллагуудын кейс судлагаа
- ✓ Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх иргэдийн мэдлэгийг тодорхойлох асуулгын судалгаа
- ✓ Үүний үр дүнд гаргасан гарц шийдлээ боловсруулан, нэгдсэн дүгнэлт болон санал шийдэл зөвлөмж гаргана.

Судалгааны асуудал: Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх иргэдийн мэдлэг технологийн ашиглалт шийдэл үр дүнгүй байна.

Онолын судалгаа: Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх түүнд үйлдэгдэж буй гэмт хэргийн арга, үе шат, санхүүгийн хориг арга хэмжээ авах байгуулага болон технологийн талаарх онолын ойлголтуудын судалгаа. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо эдийн засаг санхүүгийн салбарт үзүүлэх сөрөг нөлөө, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хэлбэр зэрэг онолын судалгааг хийлээ.

Судалгаа шинжилгээ: Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодит кейс судалгааг хийж, мөнгө угаах гэмт хэргийн арга техник, санхүүгийн технологи нэвтрүүлж буй банк, санхүүгийн байгууллагуудын кейс судлагаа, асуулгын судалгааны аргыг ашиглаж хийж гүйцэтгэлээ.

Мөнгө угаах гэмт хэрэг нь дэлхий дахины хувьд хүнд сэдвүүдийн нэг байсаар байна. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх арга техник хөгжихийн хэрээр мөнгө угаагчдын арга техник улам сайжирсаар байна.

2. ОНОЛЫН ХЭСЭГ

2.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэж юу вэ ?

Илт хууль бусаар олсон хөрөнгийг мэдсээр байж олж авсан, хувиргасан, шилжүүлсэн, эсхүл хууль ёсны байдалтай болгохын тулд эх үүсвэрийг нь халхавчилсан, нуун далдалсан, өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэн, бодит шинж чанар, хэлбэр, байршлыг нь өөрчилсөнийг мөнгө угаах гэж “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх” тухай хуулиар тогтоосон. Анх мөнгө угаах арга нь энгийн байсан бөгөөд гэмт хэрэгтэн Аль Капонегийн хууль бусаар олсон мөнгөө хууль ёсны болгох үүднээс Чикаго хотын хими цэвэрлэгээ, угаалгын газруудыг ашигладаг байсан учир ийм төрлийн хууль бус ажиллагааг “Мөнгө угаах” буюу “Money Laundering” гэж нэрлэх болжээ. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь Монгол Улсын санхүүгийн системийн тогтвортой, найдвартай байдалд аюул, заналхийлэл учруулах бөгөөд гэмт этгээд, гэмт бүлэг, бүлэглэлүүд гэмт хэргээс олсон орлого, хөрөнгөөр дамжуулан санхүүгийн системд өөрийн нөлөөг тогтоох, гэмт үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засагт хор уршигтай үйл ажиллагаа юм. Энэ төрлийн гэмт хэрэг нь олон улсын түвшинд тулгамдсан асуудалд тооцогдсон хэвээр байгаа билээ.

Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж буй түгээмэл аргууд:

1. Хар зах зээл дээрх Колумбын песогийн арилжаа;
2. Хадгаламжинд байршуулах;
3. Хууль ёсны бизнест хөрөнгө оруулах;
4. Гадаадын банкууд;
5. Итгэлцэл дээр суурилсан банкны үйл ажиллагаа ашиглах зэрэг байна.

Мөнгө угаах гэмт хэргийн үе шат

Байршуулах үе шат: Хууль бусаар олсон мөнгөө байршуулах шаардлагатай байдаг. Тухайлбал, гэмт этгээд өөр хүний банкны дансанд хууль бусаар олсон мөнгөө анхаарал татахааргүй хэмжээтэйгээр таслан хийх, үнэт цаас, чек, хувьцаа худалдан авах, эсхүл байр, байшин худалдан авах замаар байршуулж болно.

Нуун далдлах үе шат: Гарал үүслийг нь нуун далдлах, хууль ёсны орлого мэт харагдуулах зорилгоор нэгэнт байршуулсан мөнгөө эргэлтэнд оруулдаг. Жишээ нь, худалдан авсан үнэт цаас, аяллын чекээ эргүүлэн зарах эсвэл гадаад худалдаа эрхэлж буй мэт харагдуулах зорилгоор мөнгө угаахтай тэмцэх хяналтын механизм бүрдээгүй орнууд руу шилжүүлэх гэх мэт аргыг хэрэглэдэг.

Буцаан төвлөрүүлэх үе шат: Нэгэнт гарал үүслийг нь тогтооход бэрх болсон эсхүл хууль ёсны мэт харагдах болсон мөнгөө эргүүлэн өөрийн нэр дээр төвлөрүүлдэг аж.

Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг гэдэг нь хууль ёсны болон хууль бус орлогыг террорист үйл ажиллагаанд зарцуулахыг хэлдэг. Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр нь терроризмыг санхүүжүүлэхтэй ижил төстэй явагддаг тул энэ хоёр гэмт хэргийг нягт холбодог. Гэвч агуулгын хувьд энэ хоёр нь тусдаа явагддаг. Тухайлбал, мөнгө угаах нь хууль бус орлогыг хууль ёсны мэт харуулахыг зорьдог байхад терроризмыг санхүүжүүлэх нь хууль ёсны орлогоор ч бас санхүүжиж болдог.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хэлбэр

Авлигатай холбоотой: МУЭ/ТСТ арга хэмжээний хүчийг сулруулах улмаар мөнгө угаалтыг хөнгөвчлөхөд хүргэж болзошгүй авлига (албан тушаалтнуудад хахууль өгөх), үүнд улс төрийн нөлөөтэй хүмүүс (УТНХ)-ийн боломжит нөлөөлөл багтана. Валютын арилжаа/бэлэн мөнгөний хөрвүүлэлт: илрүүлэлтийн эрсдлийг багасгахын тулд улс хооронд зөөвөрлөх, эсвэл валютын арилжааны тайлагналтад сул шаардлага тавьдаг байдлыг ашиглах, тухайлбал мөнгийг өөр улс руу тээвэрлэхийн тулд замын чек худалдан авах.

Бэлэн мөнгө зөөвөрлөгчид/валют зөөвөрлөх: гүйлгээний/бэлэн мөнгөний тайлагнах арга хэмжээнээс бултагын тулд валютыг нууцаар шилжүүлэх.

Мөнгө тушаах бүтцийг өөрчлөх (Structuring/smurfing): Мэдээлэх үүрэг хүлээлгэн тогтоосон босго хэмжээнээс зайлсхийхийн тулд олон гүйлгээг (дансанд мөнгө тушаах, данснаас зарлагадах, шилжүүлгүүд) янз бүрийн хүмүүс их хэмжээний мөнгийг жижиг дүнтэйгээр зарим үед олон тооны дансанд шилжүүлэх арга юм.

Зээлийн картууд, чекүүд болон энгийн вексель (promissory note) г.м: Ихэвчлэн өөр улсын санхүүгийн байгууллага дахь мөнгөнд/санд нэвтрэх хэрэгслээр ашигладаг.

Шилжүүлэх боломжтой үнэт эдлэлийг худалдан авах (үнэт чулуу, үнэт металл г.м): Өмчлөлийг нь нуух, эсвэл илрүүлтэд өртөхгүй байдлаар зөөх болон санхүүгийн салбар дахь МУТСТ арга хэмжээнээс зайлсхийх техник – жишээ нь очир эрдэнийг өөр улс руу зөөх.

Үнэтэй хөрөнгө худалдан авах (үл хөдлөх хөрөнгө, морин уралдаан, автомашин г.м): Гэмт хэргийн орлогоор өндөр үнэ бүхий арилжих боломжтой бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийснээр гэмт хэргээс олсон орлого гэдгийг нь нууж, тайлагнах шаардлагад бага хамааралтай байдлыг ашиглах.

Бараа солилцоо (бартер): Санхүүгийн салбарын МУТСТ арга хэмжээнээс зайлсхийхийн тулд мөнгө болон санхүүгийн хэрэгслийг хэрэглэхгүйгээр героиныг алтны гулдмайгаар шууд солилцох. Бэлэн бус шилжүүлгийг хэрэглэх: Илрүүлэлт болон хураан авах арга хэмжээнээс зайлсхийхийн тулд санхүүгийн байгууллагуудын хооронд ихэвчлэн нөгөө улс орон руу электрон шилжүүлэг хийх.

Нууц банк/албан бус гуйвуулгын үйлчилгээ (hawala, hundi г.м): Итгэлцлийн сүлжээн дээр суурилсан албан бус механизмыг ашиглан мөнгө гуйвуулах. Голдуу уламжлалт банкны салбартай зэрэгцэн оршдог бөгөөд зарим улс оронд хууль бус (албан бус) гэж тооцогддог байна. Уг сүлжээг мөнгө угаагч болон терроризмыг санхүүжүүлэгч этгээдүүд ашиглан хөрөнгийг илрүүлтэнд өртүүлэхгүй, өөрсдийн хяналтанд буй мөнгөний гарал үүслийг нуун шилжүүлдэг Худалдаанд суурилсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх ажиллагаа: санхүүгийн тунгалаг байдлын хууль зохицуулалтуудаас зайлсхийхийн тулд худалдааны санхүүжилтын замууд болон бараа бүтээгдэхүүнийг ашиглан ихэнх тохиолдолд нэхэмжлэхийг өөрчлөх.

Тоглоомын үйл ажиллагаанууд (казино, морин уралдаан, интернетээр бооцоотой тоглох г.м): Мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах буюу хууль ёсны тоглогчоос хожлын тасалбарыг худалдан авах; казиногийн чипийг гэмт хэрэгтэй холбоотой гүйлгээнд төлбөрийн хэрэгсэл болгон хэрэглэх; онлайн мөрийтэй тоглоомыг гэмт хэргийн орлогыг нуухад ашиглах.

Ашгийн бус байгууллагыг ашиглах (ТББ): Террорист санг өсгөн арвижуулах, мөнгөний эх үүсвэр болон мөн чанарыг нуун далдлах, террорист санг түгээхэд ашиглах.

Санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх: Арилжих боломжтой хэрэгслүүдийг худалдан авах замаар гэмт хэргийн орлогын эх үүсвэрийг нуун далдалж, тайлагналтын харьцангуй доогуур шаардлагыг ашиглах.

Холих (mingling=бизнесийн хөрөнгө оруулалт): Мөнгө угаалтын үндсэн алхам буюу гэмт хэргийн орлогыг хууль ёсны мөнгөтэй холилдуулан эх үүсвэрийг нь нуун далдлах юм. Халхавч компаниуд/корпорацуудыг ашиглах: Хөрөнгийг хянаж буй этгээдийг таньж мэдэхээс зайлсхийж, тайлагналтын харьцангуй доогуур шаардлагыг ашиглах. Оффшор банкууд/бизнесүүд, тухайлбал итгэлцлийн үйлчилгээ үзүүлэгч компанийг ашиглах: хөрөнгийг хянаж буй этгээдийг таньж мэдэхээс сэргийлж, дотоодын эрх бүхий байгууллагын хориг хязгаарлалтаас зайлсхийхийн тулд мөнгийг шилжүүлэх. Итгэмжлэгдэгч, итгэлцлүүд, гэр бүлийн гишүүд болон гуравдагч талуудыг ашиглах: Хууль бус хөрөнгийг хянаж буй этгээдүүдийг таньж мэдэхээс сэргийлэх зорилготой. Гадаадын банкны дансуудыг ашиглах: Дотоодын эрх бүхий байгууллагын хориг хязгаарлалтаас холдуулах болон хууль бус хөрөнгийг хянаж буй этгээдийг таньж мэдэхээс зайлсхийхийн тулд мөнгийг шилжүүлэх. Бусдын хувийн мэдээлэл/баримт бичгийг хулгайлан ашиглах/ (identity fraud/false identification): мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх олон аргуудтэй холбоотой этгээдийг таньж мэдэхээс зайлсхийх.

Мэргэжлийн үйлчилгээний “хаалгач”-дыг ашиглах (хуульчид, нягтлан бодогчид болон боркерууд г.м): Хөрөнгийн эцсийн өмчлөгчид болон хууль бус мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах зорилготой юм. Түүнчлэн гэмт хэрэгтнүүдэд мөнгө угаах “мэргэжлийн” зөвлөгөө өгөхөөр авлига авсан мэргэжилтнүүдийг хамааруулж болно. Төлбөрийн шинэ технологиуд: мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх сүүлийн үеийн төлбөрийн технологиуд. Жишээлбэл, гар утсанд суурилсан гуйвуулга болон төлбөрийн систем.

Эх сурвалж: Монгол банк, Санхүү мэдээллийн алба

2.2. Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага

ФАТФ-аас Монгол Улсын 2 дахь удаагийн Харилцан үнэлгээг 2017 онд хийж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог дутагдалтай гэж дүгнэсэн байна. Монгол Улс холбогдох арга хэмжээг авч ажилласан боловч 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр ФАТФаас манай орныг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу “Саарал” жагсаалтад оруулсан. Үүнтэй холбогдуулан саарал жагсаалтаас гарах үйл явцын хүрээнд Монгол Улс ФАТФ-тай хамтран Шууд хэрэгжилтийн хүрээнд авч хэрэгжүүлэх нийт 6 ажил бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг даалгавар авсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг даалгаврыг биелүүлэхээр Монгол Улсын Ерөнхий Сайдын 172 дугаар захирамжаар 2019 оны 12 дугаар сард Сангийн Сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. Түүнчлэн Засгийн газрын 2019 оны 463 дугаар тогтоолоор ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас Монгол Улсыг гаргах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд, хувийн хэвшил болон мэргэжлийн холбоодын хамтарсан ажлын хэсгүүд уг төлөвлөгөөний дагуу эрчимтэй ажилласан. Үүний үр дүнд 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсыг ФАТФ-ын стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргасан талаар ФАТФ-ын ээлжит хурлаар албан ёсоор мэдэгдсэн. Монгол Улс бусад улс орнуудтай харьцуулахад хамгийн богино хугацаанд буюу 1 жилийн дотор Саарал жагсаалтаас гарч чадсан улс болсон нь улс төрийн өндөр түвшний дэмжлэг, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайн байсны үр дүн юм. Монгол Улсыг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Европын Холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй

тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтад (хар жагсаалт гэж нэрлэгддэг) оруулсан. Иймд ФАТФ-аас Монгол Улсыг саарал жагсаалтаас гаргасан болон төрийн байгууллагуудын Европын комисстой хамтран ажилласны үр дүнд 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр 2015/849 тоот тогтоолыг гаргаж, Монгол Улсыг Европын Холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтаас хассан билээ. Монгол Улс цаашид хар, саарал жагсаалтад орохгүйн тулд ФАТФ-аас гаргасан олон улсын стандарт, зөвлөмжүүдийг дагаж мөрдөх, хууль эрх зүйн орчноо тогтмол шинэчлэх, хэрэгжилтийг хангах, хяналт тогтолцоог үе шаттайгаар авч хэрэгжүүлэх, иргэдийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатай юм.

2.3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо эдийн засаг санхүүгийн салбарт үзүүлэх сөрөг нөлөө

Мөнгө угаах нь эдийн засаг, нийгмийн ихээхэн сөрөг үр дагавартай. Хууль бус мөнгө гаднаас орж ирсэн бол зорилгодоо хүрээд гэнэт орж ирсэн шигээ гэнэт буцаад гарна. Их хэмжээний мөнгө гэнэтийн шилжилт нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг эвдээд зогсохгүй хямралд ч хүргэж болох юм. Үүний зэрэгцээ олон улсын тавцанд дотоодын банк, санхүүгийн байгууллагуудын нэр хүнд унах, банк, санхүүгийн байгууллагаар дамжин хийгдэж байгаа гадаад гүйлгээг саатуулан шалгах, тэдгээртэй харилцахаас татгалзах хүртэлх арга хэмжээг гадны орнууд авч болох юм. Хууль бус мөнгө дотоодынх бол энэ нь хээл хахууль, авлигыг гааруулах, шударга өрсөлдөөнийг хавчих, шударгаар бизнес эрхлэгчдийг зах зээлээс шахаж монополь байдал бий болгох зэрэг олон сөрөг үр дагавартай. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо дутуу хөгжсөн орнуудыг мөнгө угаагчид ашиглах эрсдэл өндөр юм. Манайх шиг жижиг эдийн засагтай улс оронд хөрөнгө оруулалт, мөнгөний хэрэгцээ их байгаа нь ойлгомжтой. Тэр ч хэмжээгээр банкуудад хуримтлал үүсгэх, хөрөнгө оруулалтыг дэмжих сонирхол их байгаагийн зэрэгцээ банкаар дамжиж байгаа орлого, хөрөнгийн цаад эх үүсвэр, бизнесийн мөн чанарын талаар сонирхох, судлах хэрэгцээ байхгүй мэт ойлгосоор удлаа. Гэтэл энэ байдал нь эргээд санхүүгийн системийн найдвартай, тогтвортой байдалд заналхийлж болзошгүй байна.

3. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

3.1. Кейс судалгаа. Мексикийн гэмт бүлэглэлүүд АНУ-руу мансууруулах бодис тээвэрлэсэн хэрэг.

Мөнгө угаах гэмт хэрэг гэдэг нь хууль бус ашгийг хууль ёсны харагдуулж өөрчилхийг хэлнэ. Жишээлбэл: Хар тамхи зарсан мөнгө нь бохир мөнгө юм. Учир нь хууль бусаар хилээр нэвтэрсэн, хуулиар хориглосон барааг зарсан, татвар төлөгдөөгүй. Иймд энэ мөнгийг хууль ёсны харагдуулахын тулд тэд цахилгаан бараа авч буцааж зарах аргаар ашиг олжээ. Мөн тэд казинод орж уг мөнгийг мөрийтэй тоглоомны ашиг байсан гэдэг аргаар угааж болно. Саяхнаас энэ гэмт хэргийг эрүүгийн хуульд тусгаж өгсөн боловч уг хуулийн хэрэгжилт ямар түвшинд байгааг оюутнууд болон иргэдэд мөнгө угаах гэмт хэргийн талаар мэдээлэл зорилгоор нэгэн хар тамхины бүлэглэлийн мөнгө угаасан нэгэн баримтыг дэлгэе.

Мексикийн гэмт бүлэглэлүүд хэрхэн АНУ-руу мансууруулах бодис тээвэрлэсэн бэ? Хар тамхитай тэмцэх газраас уг бодит болсон үйл явдлыг олж илрүүлжээ. Тухайн хэрэгт Колумб улсаас 1 тонн кокаин захиалагдсан байна. Уг экспортын кофенд кокаиныг нууж мэргэжлийн жолоочтой дунд оврын ачааны машинд ачиж хойд зүгт Төв Америкийг чиглэсэн хөдөлжээ. Жолооч замд ямар нэгэн асуудал, шалгалт таарсан тохиолдолд маш энгийнээр ачааг жижиг усан завьд шилжүүлэн ачихаар төлөвлөсөн байна. Шалгалттай хэсгийг өнгөрсний дараа

буцаад ачааны машинд кокайныг ачиж үргэлжлүүлэн хойшоо явсаар хил дээр ирнэ. Тухайн хил дээр тэд хуулийн байгууллагын анхаарал сулруулах хүчин зүйлүүд бий болохыг хүлээнэ. Үүнд: хил дээр маш их хэмжээний хүмүүс хил нэвтэрхээр бөөгнөрөх, машины түгжрэл үүсэх, тэмдэглэлт баярын өдрүүд, байгалийн онцгой нөхцөл зэрэг болно. Тохиромжтой цаг бий болоход толгойлогч нар жолооч нарт дохио өгсөнөөр тэд ачааны машин дунд холилдон АНУ-ын хилээр нэвтэрч хойд зүгт чиглэн явна. Ийнхүү кокайн хар тамхины түгээгч нарт хүргэхэд бэлэн болно. Хар тамхитай тэмцэх газрын мэдээллэсэнээр кокайн ачсан дунд оврын ачааны машины хамгийн эхний зорилго нь хилийн гүнрүү нэвтрэх байсан байна. Тус албаны мэдээллэсэнээр тэд эхний зорилгодоо хүрэхийн тулд гэр бүлийн гэгддэг жижиг овчрын автобусыг ашиглаж Лас Вегас, Лос Анжелес, Сан Франциско зэрэг хотуудаар дамжин Портланд хүртэл тээвэрлэсэн байна. Тухайн газар бүрт хар тамхины бүлэглэлийн дунд түвшний толгойлогч нар орон нутгийн түгээгч нараас мөнгө цуглуулж авна. Түгээгч нар худалдаж авсан кокайныг нунтагтай хольж нэг тонныг таван тонн болгоно. Өөрөөр хэлбэл Мексикийн гэмт бүлэглэлүүд 48 цагийн дотор арав гаран хотуудын гудамжинд зуун зуун зуучлагч болон мянга мянган хар тамхи хэрэглэгч болох Америкчуудад хар тамхиар хангажээ. Хэдийгээр хууль бус хар тамхины худалдааны өртөгийг тооцоход хүндрэлтэй боловч нэгэн мужийн гадаад худалдаа хариуцсан байгууллагын дүгнэлтээр нэг цаг тутам 4 сая ам долларын өртөгтэй хар тамхи АНУ руу орж ирсэн гэсэн урьдчилсан дүгнэлтийг гаргажээ. Энэхүү хууль бус нийлүүлэлтийн өртөг зарим хэсэг хот мужуудад харилцан адилгүй байна. Жишээлбэл: Хар тамхитай Тэмцэх газрын үзэж буйгаар 17,000\$ үнэтэй 1кг кокайн хол зам, дээрх эрсдлийг туулсаар зүүн эргээс баруун эрэг хүрэхэд үнэ нь нэмэгдэж 22,000\$ болж өсчээ. Баруун эрэгт хүрэхдээ зэрэгцэн кокайн зарсан хууль бус бэлэн мөнгө буцаад Мексик рүү хил дамна эсвэл хамгийн сүүлчийн эрсдэл болох цахилгаан бараа болон бусад эрэлт ихтэй ашигтай барааг худалдан авч хууль ёсоор ачааны машинаар тээвэрлэн буцна. Барааг зарж мөнгөө буцаан цуглуулсанаар хар тамхины гэмт бүлэглэлийнхэн бохир мөнгөө угааж дуусна.

3.2. Монгол улсын санхүүгийн технологийн өнөөгийн байдал

Монгол улсын финтекийн хөгжил 2017 онд банк санхүүгийн байгууллагуудын мэдээлэл дээр суурилсан судалгаа хийсэн бөгөөд банкны заалаар үзүүлж буй үйлчилгээний жилийн өртөг финтекээр дамжуулан эцсийн хэрэглэгчдэд үзүүлж буй яг ижил үйлчилгээний өртгөөс 10.2 дахин өндөр гарсан. Монгол улсад зарим банкууд 2014 оноос санхүүгийн технологийн шийдлийг нэвтрүүлж эхэлсэн.

Хүснэгт 1. Монгол улсын санхүүгийн технологийн үйлчилгээ

№	Үйлчилгээ	Лого	Үйл ажиллагааны чиглэл
1	MonPay үйлчилгээ		Хамгийн бага шимтгэлтэйгээр MonPay гар утасны аппликейшнаар дамжуулан нь хэрэглэгчдэд орлого, зарлага, мөнгөн шилжүүлэг, мини апп, төлбөр төлөх, хөнгөлөлт эдлэх, зээл авах боломжуудыг олгодог. MonPay нь Мобифинанс ББСБын бүтээгдэхүүн үйлчилгээ юм.
2	Qpay үйлчилгээ		Төлбөрийн мэдээллийг хялбар унших, төлбөртооцоо хийх, худалдан авалт хийх зэрэг үйлдлүүдийг хялбаршуулах зорилготой. Ихэвчлэн интернет банкыг ашиглан энэхүү үйлчилгээг авдаг.

3	LendMN		<p>LendMN Гар утасны аппликейшн ашиглан зээл авах, төлбөр тооцоо хийх, орлого хүлээн авах боломжийг хурдан, шуурхай, барьцаагүй, хүүгүй олгох боломжийг хэрэглэгчдэд хүргэдэг. ЛэндМН нь хөрөнгийн зах зээлд нээлттэй арилжаалагдах “ЛЭНДМНБОНД”-ыг гаргасан бөгөөд энэ бонд нь Монголын хөрөнгийн зах зээл дээр финтек компанийн гаргаж буй анхны нээлттэй бонд юм. ЛэндМН банк бус санхүүгийн байгууллага 2019 оны 3-р сарын байдлаар нийт 1.2 сая удаа, 240 тэрбум төгрөгийн зээлийг иргэдэд олгоод байна</p>
4	Social Pay		<p>Голомт банкны төлбөр тооцооны хэрэгсэл бөгөөд худалдан авалт, төлбөрийн үйлчилгээ, картын үйлчилгээг үзүүлдэг үйлчилгээ юм.</p>
5	Most money		<p>Мост финтек ХХК-ний үйлчилгээ бөгөөд Most money үйлчилгээг 2012 онд нэвтрүүлсэн. Гар утас интернэтээ ашиглан, билл төлөх, нэгж худалдан авах, худалдан авалт хийх, төрийн үйлчилгээг авах боломжтой юм.</p>

AND Global бол Ази тивд хурдтай өргөжин тэлж байгаа, машин суралцах, хиймэл оюун ухаанаар ажилладаг технологийн компани ба LendMN, SuperUp, зэрэг аппликейшныг хөгжүүлэгч санхүүгийн технологийн толгой компани юм. Энэхүү технологийн компани нь 10.3 сая долларын хөрөнгө оруулалтыг Японы Марубэни корпорациас авсан ба энэ нь Монгол улсад анхдагч төдийгүй Ази тивдээ дээгүүрт орох хамгийн том хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтуудын нэг юм.


Монгол улс нь Саарал жагсаалтаас 2020 онд гарсан бөгөөд одоогийн байдлаар FATF-ын зөвлөмж, зааврыг дагаж мөрдөх зайлшгүй шаардлагатай байгаа учир FATF-ын зөвлөмж 15-ын дагуу виртуал хөрөнгийн үйл ажиллагааг сайжруулах, зохицуулах хэрэгцээ шаардлага тулгарч байгаа тул Монгол банк виртуал хөрөнгийн үйл ажиллагааг зохицуулах, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэхээр холбогдох байгууллагатай хамтран ажиллаж байна. Гэвч энэхүү хуулийн төсөл нь хэрэглэгчийн эрх хамгаалах, цахим аюулгүй байдал, бусад эрсдэлийг зохицуулахгүй болно.

Эх сурвалж (Монгол банк, 2021)

3.3. Асуулгын судалгаа

Энэхүү мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх иргэдийн мэдлэгийг тодорхойлох судалгааг цахим мэдээлэлийн системийг ашиглан нийт 141 хүнээс авсан бөгөөд тэдний 60% нь эмэгтэй, 40% нь эрэгтэй, 72.60% нь 16-25 насны, 16.20% нь 26-35 насны, 11.20% нь 36-45-дээш насны, хүмүүс бөглөсөн. Боловсролын хувьд 49.00% нь бакалавр, 37.80% нь бүрэн дунд боловсролтой хүмүүс дийлэнх бөглөсөн.

Зураг 1. Та мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар хэр их мэдэх вэ?



Судалгаанд оролцогчдын 63.50% нь мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаармэднэ 25.40% нь мэднэ гэхдээ хангалттай биш гэж хариулсан бол 8.8% нь тодорхой хэмжээнд судлаж байсан 2.30% нь хаа нэгтэй сонсож байсан гэж хариулснаас үзэхэд иргэдийн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх мэдлэг дутмаг буй нь харагдаж байна

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Зураг 2. Та мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх талаарх мэдээллийг хаанаас олж авдаг вэ?




Судалгаанд оролцогчдын 70.70% нь цахим мэдээллийн орчиноос авдаг 40.60% нь телевиз зар сурталчилгаанаас, 16.20% нь найз нөхдөөсөө таньдаг хүмүүс, 8,3% нь огт мэдээлэл авдаггүй гэж хариулсан байна. Иймд цахим орчин, социал медиа сувгуудыг түлхүү ашиглах нь зохистой гэж үзэж байна.

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хяналтын тогтолцоог сайжруулах нь:


Зураг 3 Та дараах асуултуудыг сайтар уншин өөрт тохирох хариултыг үнэн зөвөөр бөглөнө үү.



Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт


Судалгаанд оролцогчдоос мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх талаар ерөнхий мэдлэгийг шалгах асуултуудыг тавьсан бөгөөд тэдний ихэнх нь эдгээр асуулттай санал нийлж байгаа боловч судалгаанд оролцогчдоос нийт 61 хүн огт санал нийлэхгүй байна гэж хариулсан нь мэдлэг дутмаг байгааг харуулж байна.

Зураг 4 Та дараах асуултуудыг сайтар уншин өөрт тохирох хариултыг үнэн зөвөөр бөглөнө үү.



Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Зураг 5 Хэрвээ танд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хэрэгтэй холбоотой мэдээлэл байгаа бол хаана хандах вэ?



Хэрвээ танд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хэрэгтэй холбоотой мэдээлэл байгаа бол хаана хандах вэ? талаарх судлагаанд 78.80% нь хууль сахиулах байгууллагад хандана гэсэн байгаа бол 22.80% нь хаана хандахаа мэдэхгүй байна гэж хариулсан тул иргэдэд мөнгө угаах гэмт хэргийн талаарх мэдээллийг сайн олгох хэрэгтэй гэж үзлээ.

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Асуулгын судалгааны дүгнэлт

Энэхүү судалгаанаас харахад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг байна. Тэдэнд интернет, цахим орчинг ашиглан мэдээлэл өгөх, мөнгө угаах нь ямар их хор уршигтайг сурталчилах, уг гэмт хэрэг нь Монгол улсын санхүүгийн салбарт хэрхэн нөлөөлдөг, бидний амьдралд хэрхэн нөлөөлдөг, ямар арга хэмжээнүүдийг авч хангаж ажиллаж байдаг эсэх талаарх мэдээллийг хүргэх, цаашлаад хүүхэд залууст дунд ангиас нь эхлэн нийгэм, эдийн засаг хичээлүүдэд боловсролын яамнаас үе шаттайгаар оруулах нь зүйтэй гэж үзэж байна. Түүний үр дүнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, багаасаа мөнгө угаалтын талаарх хор нөлөөг мэддэг ухамсартай иргэн болно гэж үзлээ.

ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

1. Шийдвэрлэх асуудал

Асуулгын судалгааны үр дүнгээс хархад иргэдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх мэдлэг мэдээлэл дутмаг, Монгол улсын санхүүгийн технологийн ашиглалт түүнд суурилсан платформ шинэ технологийг ашиглан иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн тогтолцоогоор дамжуулан нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Иргэдийн судалгааны байдлаас харахад мэдээллийн дутмаг байдлаас үүсэх эрсдэл нийгэм, эдийн засаг, санхүүгийн салбарын эрсдэл хэрхэн сөргөөр нөлөөлж байдгыг ойлгуулах хууль эрх зүйн актыг улам боловсоронгуй болгож ажиллах тэдгээрийн мэдээллийг санхүүгийн технологи ашиглан хүргэх нэмэгдүүлэх шаардлага зайлшгүй тулгарч байна.

2. Санал

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шийдэл, санхүүгийн шинэ технологи. Монгол улсад мөнгө угаахтай тэмцэх зорилгоор хиймэл оюун ухаан болон регтекийн шийдэлд суурилсан технологийн платформ байгуулах боломжтой бөгөөд мөн сэндрокс туршилтад мөнгө угаахтай тэмцэх программ хангамжууд оролцох боломжтой болсон байна. Мөнгө угаахтай тэмцэх санал болгож буй платформын хувьд арилжааны банк болон Төв банкинд

санал болгох бөгөөд мөнгө угаахтай тэмцэх арилжааны банкны комплаенс болон Төв банкны СМА-тай хамтран ажиллах боломжтой. Энэхүү технологийн платформын гол зорилго нь Монгол улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах, үр дүнтэй шийдлийг арилжааны банк болон Төв банкинд санал болгож хамтран ажиллах зорилготой. Үйл ажиллагааны хувьд медиа скрининг, сөрөг медиа скрининг, улс төрийн нөлөө бүхий этгээдийн жагсаалтын скан, onboarding, KYC ба CDD, хэрэглэгчийн скрининг ба хяналт, хориг арга хэмжээний скрининг, API ашиглан үйл ажиллагааг автоматжуулах, гүйлгээний хяналт зэрэгт хяналт тавин, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллахаас гадна мөнгө угаахтай тэмцэх бүхий л хууль тогтоомжийг чанд сахин ажиллах болно. Платформоор дамжуулан Монгол улсын мөнгө угаах тогтолцооны сүүлийн үеийн мэдээ мэдээлэл болон бусад улс орны мөнгө угаахтай хэрхэн тэмцэж буй шийдлүүдийн мэдээ мэдээллийг тогтмол хүргэх болно.

3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зөвлөмж

Энэхүү судалгааны ажлынхаа хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зөвлөмж, түүнээс урьдчилан сэргийлэх, хяналтыг сайжруулахын тулд дэлхийн санхүүгийн технологид суурилан хөгжүүлэх боломж, шийдлийг судлалаа. Судалгааны үр дүнд тулгуурлан дараах санал зөвлөмжүүдийг бидний зүгээс өгч байна.

- ✓ Төв банкны санхүүгийн мэдээллийг албаны сэжигтэй гүйлгээний тайлан хүлээн авах үйл явцыг технологид суурилан улам түргэн шуурхай авах боломжийг нэмэгдүүлэх
- ✓ Мөнгө угаахтай тэмцэх зорилгоор технологийн шийдлийг зайлшгүй үйл ажиллагаандаа нэвтрүүлж, уг технологийг сайжруулж ажиллах
- ✓ Технологид суурилсан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх бүтээгдэхүүн үйлчилгээ болон регтек, түүний шийдлүүдийн талаарх ойлголтыг олон нийтэд дэлгэрүүлэх
- ✓ Гадаад улс орны туршлагыг судлан Монгол улсдаа хэрэгжүүлэх боломжийг судлан, олон улсад тавигдаж буй шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллахад дотоодын зах зээлийг бэлдэх
- ✓ Шинээр нэвтрүүлж буй мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бүтээгдэхүүний учирч болох үйл ажиллагааны эрсдэл болон бусад эрсдэлийг урьдчилан таамаглах
- ✓ Мөнгө угаах гэмт хэргийн одоогийн хууль эрх зүйн хязгаарлалтын асуудлыг тодорхойлох, түүнийг цаашид хэрхэн сайжруулж болохыг урьдчилан таамаглах
- ✓ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх

4. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлынхаа хүрээнд арилжааны банкны хувьд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хяналтын тогтолцоог иргэдийн мэдлэгийн түвшинд тулгуурлан сайжруулах арга зам, боломжийг эрэн хайх, техник технологийн шийдэлд суурилан олж нээхийг зорьсон бөгөөд судалгааны үр дүнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хяналтын үйл ажиллагааг сайжруулах боломжит арга хэрэгсэл, шийдлүүд тодорхойлогдсон байна гэж үзсэн. Энэхүү судалгааны ажлынхаа явцад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх гадаадад болсон бодит кейс судалгаа, мөнгө угаах гэмт хэргийн арга техник, Монгол улсын мөнгө угаах гэмт хэргийн хөгжлийн үйл явц, арилжааны банк, Төв банкны мөнгө угаахтай тэмцэж буй үйл ажиллагаа, зохицуулалтын өнөөгийн байдал зэргийг судлан, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх програм хангамж нэвтрүүлж буй банк, санхүүгийн байгууллагуудын кейс судлагаа, иргэдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх мэдлэгийг тодорхойлох асуулгын судлагаа зэргээр судалгаа шинжилгээгээ хийлээ. Судалгааны үр дүнд гадаад улс орны банк санхүүгийн байгууллагууд нь ихэвчлэн мөнгө угаахтай тэмцэх зорилгоор иргэд, компанитай хамтран ажилладаг бөгөөд тэдгээрийн санал болгож буй платформоор дамжуулан мөнгө угаахаас урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ, үйл ажиллагааны үр ашгаа дээшлүүлж, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаагаа улам боловсронгуй болгох зэрэг үр ашигт үйл ажиллагаанд хүрэн ажиллаж байна. Иймд Монгол улсын хувьд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор технологийн шийдлийг зайлшгүй үйл ажиллагаандаа нэвтрүүлж, уг технологийг сайжруулж ажиллах шаардлагатай байна. Асуулгын судалгааны үр дүнд иргэдийн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх мэдлэг боловсролыг зайлшгүй сайжруулах шаардлагатай бөгөөд бага наснаас эхлэн хүүхдүүдэд мөнгө угаах гэж юу болох, түүний хор уршиг, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, мөнгө угаахтай холбоотой мэдээлэл байвал хаана хандах зэргийг ойлгуулан, мөнгө угаалтын талаарх мэдлэг мэдээллийг сайжруулснаар мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх боломжтой юм.

Судалгаа шинжилгээний үр дүнд гарсан шийдлүүдээ Монгол улсад хэрхэн хэрэгжүүлвэл зохих, хэрхэн хөгжүүлэх талаарх судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд үүний үр дүнд иргэд, компаниас санал болгох хиймэл оюун ухаан болон регтекийн зохицуулалтын шийдэлд суурилсан мөнгө угаахтай тэмцэх шинэ санхүүгийн технологийг нэвтрүүлэх хөгжүүлэх боломжтой гэж үзлээ. Мөнгө угаахтай тэмцэх технологийн хувьд арилжааны банк болон Төв банкинд санал болгох бөгөөд мөнгө угаахтай тэмцэх арилжааны банкны комплаенс болон Төв банкны дэргэдэх санхүүгийн мэдээллийн албатай хамтран ажиллах бүрэн боломжтой. Үйл ажиллагааны хувьд мөнгө угаахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх бүхий л цэсийг энэхүү технологид суурилуулахаас гадна мөнгө угаахтай тэмцэх бүхий л хууль тогтоомж, дүрэм журмыг чанд сахин ажиллах болно. Платформоор дамжуулан Монгол улсын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны сүүлийн үеийн мэдээ мэдээлэл болон бусад улс орны мөнгө угаахтай хэрхэн тэмцэж буй шийдлүүдийн мэдээ мэдээллийг тогтмол хүргэхээс гадна банкны ажилтнуудад тогтмол сургалт, семинар зохион байгуулах боломжтой бөгөөд платформыг тогтмол шинэчлэж, сүүлийн үеийн хувилбарыг банкуудад санал болгоно. Мөн орчин үеийн платформыг зохицуулалтын орчны тусламжтайгаар олон шинэ, хиймэл оюун ухаан, регтект суурилсан компаниудыг дэмжих боломжтой учир сэндбокс зохицуулалтаар мөнгө угаахтай тэмцэх шинэ шийдэл олох боломжтой гэж үзлээ. Иймд санхүүгийн шинэ технологийг ашигласнаар үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, аливаа үйл явцыг хурдасгах, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах учир

мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл явцыг сайжруулах бүрэн боломжтой гэж үзлээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Азжаргал, Ч. (2019). Арилжааны банкны худалдаанд суурилсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн удирдлагыг сайжруулах боломж, арга зам.

Монгол банк. (2020). Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь.

Санхүүгийн зохицуулах хороо. (2020). Улаанбаатар. Мөнгө угаах гэж юу вэ?

(Монгол банк , 2021) санхүүгийн мэдээллийн алба

Монгол банк. (2019). Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь. Улаанбаатар.

Монголбанк олон нийтийн боловсрол, мэдээллийн төв, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь

Монгол улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ 2021

Бохир \$ Угаах гэмт хэргийн бодит эх сурвалж

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт

ХАВСРАЛТ

Хавсралт 1

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх талаарх иргэдийн мэдлэгийг тодорхойлох судалгаа

Сайн байна уу? Танд энэ өдрийн мэнд хүргэе! Энэхүү судалгааг бөглөхөд 1-2 минут шаардагдах бөгөөд үнэтэй цагаа зарцуулж, судалгаанд хамрагдсан танд баярлалаа.

1. Та мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар хэр их мэдэх вэ? Мэднэ
 - ✓ Мэднэ, гэхдээ хангалттай биш
 - ✓ Тодорхой хэмжээнд судлаж байсан
 - ✓ Хаа нэгтээ сонсож байсан
 - ✓ Огт мэдэхгүй
2. Та мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ? (Та хэдэн ч хариулт сонгож болно)
 - ✓ Найз нөхөд
 - ✓ Гэр бүл
 - ✓ Телевиз, зар сурталчилгаа
 - ✓ Интернет, цахим орчин (Facebook, Twitter гэх мэт)
 - ✓ Огт мэдээлэл авдаггүй
3. Та дараах асуултуудыг сайтар уншин өөрт тохирох хариултыг үнэн зөвөөр бөглөнө үү.
 - ✓ Огт санал нийлэхгүй байна
 - ✓ Санал нийлэхгүй байна
 - ✓ Бага зэрэг санал нийлж байна
 - ✓ Ерөнхийдөө санал нийлж байна
 - ✓ Бүрэн санал нийлж байна
 - Мөнгө угаах гэмт хэрэг нь авлига, хээл хахууль, хууль бусаар олж авсан хөрөнгөө нуун далдлахын тулд үйлдэгддэг.
 - Мөнгө угаах нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг доройтуулдаг.
 - Мөнгө угаах нь нийгэм болон эдийн засагт маш их хор хөнөөлтэй.
4. Та дараах асуултуудыг сайтар уншин өөрт тохирох хариултыг үнэн зөвөөр бөглөнө үү.
 - ✓ Огт тийм зүйл тохиолдож байгаагүй
 - ✓ 1-3 удаа
 - ✓ 4-6 удаа
 - ✓ 8-с дээш
 - Тань руу үл мэдэх дугаараас залгах юм уу мессеж, чат бичин тодорхой нэгэн данс руу мөнгө хийхийг шаардаж байсан эсэх:
 - Таны данснаас их хэмжээний мөнгө алга болж байсан эсэх:
 - Та онлайн худалдаагаар бараа захиалаад бараагаа авч чадаагүй тохиолдол байсан эсэх:
5. Хэрвээ танд мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэл байгаа бол хаана хандах вэ? (Та хэдэн ч хариулт сонгож болно)
 - ✓ Арилжааны банкинд
 - ✓ Монгол банкинд
 - ✓ Санхүүгийн зохицуулах хороонд
 - ✓ Хууль сахиулах байгууллагад (Цагдаа, Тагнуул, АТГ)
6. Таны хүйс
 - ✓ Эрэгтэй
 - ✓ Эмэгтэй

7. Таны нас
 - ✓ 16-25
 - ✓ 26-35
 - ✓ 36-45 - дээш
8. Таны боловсролын түвшин
 - ✓ Бага
 - ✓ Бүрэн бус дунд
 - ✓ Бүрэн дунд
 - ✓ Тусгай дунд
 - ✓ Бакалавр
 - ✓ Магистр
 - ✓ Доктор



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

МОНГОЛБАНК

**ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ**

Д.Отгонбаяр⁶³, С.Амбасэлмаа⁶⁴

⁶³Их Засаг Хууль зүйн сургуулийн эрх зүйн ангийн IV дамжааны оюутан. Цахим хаяг: ambaselmaa6@gmail.com

⁶⁴Их Засаг Хууль зүйн сургуулийн эрх зүйн ангийн IV дамжааны оюутан. Цахим хаяг: dansranotgonbaar@gmail.com

ТОВЧ ХУРААНГУЙ

Сүүлийн жилүүдэд залилах гэмт хэргийн гаралт, учруулсан хохирол жил дараалан байнга өсөж, үйлдлийн арга нь улам нарийсч, зохион байгуулалттайгаар үйлдэгдэх хандлагатай болж байна. Урьд өмнө зөвхөн хувь хүн энэ төрлийн гэмт хэргийн халдлагад өртдөг байсан бол өнөө цагт хувь хүмүүсийн хүрээнээс хальж байгууллага, аж ахуйн нэгж, цаашилбал улс орон дамжин үйлдэгдэх болсон. Залилан мэхлэгчид шинжлэх ухаан, техникийн сүүлийн үеийн ололтыг соргоогоор ашиглаж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцлийг шинжлэх ухааны үүднээс судалсны үндсэн дээр явуулахыг зүй ёсоор шаардаж байна.

Энэхүү илтгэлээр Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-д заасан “залилах” гэмт хэргийн үйлдлийн аргыг авч үзэхээс гадна залилах гэмт хэргийг зүйлчлэхэд тулгамдаж буй асуудал болох иргэний эрх зүйн маргаанаас хэрхэн ялган зүйлчлэхийг тайлбарлахыг оролдлоо.

Илтгэлийн бүтцийн хувьд удиртгал, үндсэн хэсэг, дэвшүүлж буй асуудал, харьцуулсан судалгаа, дүгнэлт, санал, эх сурвалж гэсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд дэвшүүлж буй асуудлаараа нийгэмд тулгамдаж буй асуудлыг хөндөж, судлаач оюутнуудын зүгээс өөрийн санал, зөвлөмжийг дэвшүүлсэн болно.

ТҮЛХҮҮР ҮГ

Эрүүгийн хууль, залилах гэмт хэрэг, шүүхийн шийдвэр, эрүүгийн хариуцлага, иргэний эрх зүй

1. ОРШИЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 3-т “Монгол Улсын иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй...” мөн Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт Монголын ард түмэн бид эрхэм зорилго болгон тунхаглан зарласан зүйлийн дотор “Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх...” зорилго чухал байр суурь эзэлдэг. Залилах гэмт хэрэг нь энэ зорилгод туйлын харш гэмт үйлдэл бөгөөд хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдэл гэсэн ухагдахууныг тохиолдлоор нэг заалтад оруулаагүй нь тодорхой бөгөөд энэ гурван зүйл харилцан хамааралтай цогц ойлголт болох нь Үндсэн хуулийн дээрх заалтаас харагдаж байна. Чухалчлан авч үзвэл үндэсний эв нэгдэл нь хүмүүсийн итгэл үнэмшилгүйгээр хангагдах боломжгүй бөгөөд залилах гэмт хэрэг нь хүмүүсийн итгэл үнэмшил, шударга ёсонд ноцтой хохирол шууд бусаар учруулдаг утгаараа судлан буй сэдвийн чухал болохыг тодорхойлж байна.

Залилах гэмт хэргийн сүүлийн таван жилийн нөхцөл байдлыг авч үзвэл 2017 онд улсын хэмжээнд нийт 32259 гэмт хэрэг бүртгэгдснээс 2996, 2018 онд 36220 гэмт хэрэг бүртгэгдснээс 5373, 2019 онд 31524 гэмт хэрэг бүртгэгдснээс 4688, 2020 онд 23064 гэмт хэрэг бүртгэгдснээс 4270, 2021 онд 25429 гэмт хэрэг бүртгэгдснээс 6658 нь залилах гэмт хэрэг бүртгэгдсэн байна⁶⁵. Дээрхээс үзвэл нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 9.3 хувиас 25.8 хувийг залилах гэмт хэрэг эзэлж байгаа нь өндөр үзүүлэлт юм.

2017.07.01-нээс 2022.03.18-ныг хүртэл Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдэгдсэн хэргүүдийн⁶⁶ дотор 22 хэрэг нь бага хэмжээний хохирол буюу 300,000 төгрөгөөс доош хэмжээний хохирол учруулсан үйлдэлд ял оногдуулж байгаа нь бусад гэмт хэрэгт оногдуулсан ялтай харьцуулахад Эрүүгийн эрх зүйн шударга ёсны зарчим буюу “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна”⁶⁷ гэх агуулгатай харшилж байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан⁶⁸ залилах гэмт хэргийн ойлголт, өнөөгийн байдал, үйлдлийн арга, хэлбэр, түүнээс үүдэн энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэхэд учирч буй бэрхшээлүүд, дэлхийн бусад улс оронд залилах гэмт хэргийг хэрхэн шийдвэрлэдэг талаар харьцуулан судалж, залилах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, саналаа дэвшүүлэхээр уг сэдвийг сонгон судаллаа.

⁶⁵ ҮСХ, www.1212.mn

⁶⁶ <https://shuukh.mn/cases/2/1>

⁶⁷ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

⁶⁸ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17 дугаар зүйлийн 17.3 дах хэсэг

2. ҮНДСЭН ХЭСЭГ

2.1. Залилах гэмт хэргийг онолын үүднээс авч үзэх нь

“Залилан мэхлэх” үгийн утга нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, хүч хэрэглээгүй ашиглан шамшигдуулах нэгэн хэлбэрийг нэрлэж ирсэн эрүүгийн эрх зүйн уламжлал болсон нэр томъёо. Хуурч мэхлэх нь хохирогчид худал мэдээ сэлт өгөх буюу зайлшгүй мэдээлэх ёстой нөхцөл байдлын талаар дуугүй өнгөрөх замаар бусдын эд хөрөнгийг хууль бусаар, үнэ төлбөргүй авсан байдаг. Итгэл эвдэх нь гэм буруутай этгээд хохирогчидтой тогтоосон итгэмжилсэн хувийн харилцаа болон тусгайлан олгосон бүрэн эрхээ ашигласан байдаг онцлогтой⁶⁹.

Залилах гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт заасан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт хамаарах ба өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн төрөлд залилах гэмт хэрэг хамаарах болсоны хууль зүйн учир холбогдол бол төрлийн объектоороо нийтлэг байгаад оршино. Залилах гэмт хэрэг гэж бусдын өмчлөх эрхэд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэм аюултай, гэм буруутай үйлдэл юм⁷⁰.

2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: Залилах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний онцлог нь:

1. **Хуурч**⁷¹. Хуурах гэж бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар олж авахын тулд үгээр буюу үйлдлээр эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэхийг ойлгоно⁷². Онолын хувьд хуурч мэхлэхийг “ашиглан шамшигдуулах арга болохын хувьд худал мэдээ сэлт өгөх буюу заавал мэдээлэх нөхцөл байдлын талаар дуугүй өнгөрөх явдал мөн”⁷³ гэж үздэг.
2. **Баримт бичиг**⁷⁴, **эд зүйл**⁷⁵, **цахим хэрэгсэл ашиглах**⁷⁶ гэдгийг доктор С.Гантулга, Б.Энхболд нар бүтээлдээ бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар авахын тулд хуурамч бичиг баримт, эд зүйл, цахим хэрэгсэл, цахим сүлжээ, цахим мэдээлэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, техник хэрэгсэл ашиглах, тусгай албаны хувцас, хэрэглэл, цол, тэмдэг хэрэглэж зориудаар төөрөгдүүлэх, дутуу буюу

⁶⁹ С.Нарангэрэл “Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг” анхны хэвлэл., 2021, 147 дах тал

⁷⁰ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй тусгай анги/сурах бичиг/. УБ., 2018. 186 дахь тал

⁷¹ Залилан мэхлэгчид хохирогч эд хөрөнгөө сайн дураараа шилжүүлэн өгөхөд хүрэхүйц итгэл төрүүлэхээр үнэмшүүлэн ярьж хууран мэхэлсэн байхыг ойлгоно. Хуурч мэхлэх арга нь худал хэлэх, хуурамч баримт бичиг, факс, дүрс болон дуу авианы бичлэг техник хэрэгсэл, компьютерийн мэдээлэл, сүлжээ ашиглах буюу тусгай албаны хувцас, хэрэглэл, цол, тэмдэг хэрэглэж зориудаар төөрөгдүүлэх, дутуу буюу зориулалтын бус, эсхүл хуурамч буюу чанарын доголдолтой эд зүйлээр төлбөр хийх зэргээр илэрнэ

⁷² С.Гантулга, Б.Энхболд “Эрүүгийн эрх зүй” /тусгай анги/ сурах бичиг. УБ., 2018, 187 дах тал

⁷³ С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй/Тусгай анги/. УБ., 1998. 138 дахь тал

⁷⁴ Өөр хүний, хуурамч, зассан баримт бичиг үзүүлэх, ашиглах, тодорхой хугацааны дараа баримт бичгийг гарган өгөхөө илэрхийлэн бичиж баталгаа гаргах, ижил нэртэй хүн, аж ахуйн нэгжийн баримт бичиг үзүүлэх зэрэг хамаарна.

⁷⁵ /Хуурамч, бүрэн бус, зориулалтын бус, чанаргүй, гологдмол эд зүйлээр солио хийх, өөр хүний эд зүйл авчран өгч сольж авах ... зэрэг/

⁷⁶ E-mail, message бичиж илгээх, интернет худалдаа хийх нэрээр өөр компани, хүний нэрийн өмнөөс харилцаж, өөрийн данс уу мөнгө шилжүүлэн авах, эзнийг хуурч авсан банкны карт, пин кодыг ашиглан АТМ-ээс мөнгийг авах ... зэрэг цахим хэрэгслээр дамжуулан хуурч мэхэлсэн үйлдлүүдийн үр дүнд эд хөрөнгөө шилжүүлж өгсөн байх/

- зориулалтын бус, эсхүл хуурамч буюу чанарын доголдолтой эд зүйлээр төлбөр хийх зэргийг ойлгоно гэж тэмдэглэжээ.
3. **Зохиомол байдлыг зориудаар бий болгох** гэж эд хөрөнгийн эзэмшигч, өмчлөлгчийг төөрөгдүүлэх, хууран мэхлэхийн тулд зохиомол байдлыг зориуд бий болгохыг ойлгоно⁷⁷. Тухайлбал, өөрийгөө амжилттай бизнесмен, баян, их хэмжээний эд хөрөнгийн өв залгамжлагч, томоохон үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч мэтээр зохиомол байдлыг бүрдүүлж болно.
 4. **Сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах** гэж бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар авахын тулд хохирогчийн сүсэг бишрэл, шашны итгэл үнэмшлийг ашиглан төөрөгдүүлэхийг ойлгоно⁷⁸.
 5. **Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж** гэдгийг шууд ойлгож, хэрэглэнэ. Тухайлбал, урьд эрхэлж байсан ажил, албан тушаал, нэр хүндийг ашиглах, олон жил хамтран бизнес хийсэн, гэрээт борлуулагчаар ажилласан, олон жилийн өмнөөс бие биенээ мэдэх болсон байдал, итгэлийг урвуулах зэрэг хэлбэртэй байж болно⁷⁹.

Энэхүү хэргийг үйлдсэн гэм буруутай этгээдийг 450-14 000 нэгжтэй тэнцэх буюу 450 000- 14 сая төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цагийн нийтэд тустай ажил хийлгэх, 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх үндсэн ялын төрлөөс гэм буруутай этгээдийн хувийн байдалд тохируулан сонгож хэрэглэх боломж олгосон.

Хүндрүүлэх бүрэлдэхүүн /ЭХ-ийн 17.3.2 дах хэсэг/

Залилах гэмт хэргийг үйлдсэн этгээд:

- a) **Албан тушаалын байдлаа ашиглаж** /албан тушаалын эрх мэдлээ бусдын эд хөрөнгийг залилан авахад ашигласан байх/,
- b) **Бусдад ноцтой эсхүл их хэмжээний** /50 мянган нэгжтэй тэнцэх буюу 50 сая төгрөгнөөс дээш эд хөрөнгийн/ **хохирол учруулж үйлдсэн** бол гэм буруутай этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас хүндрүүлэн 10 000- 40 000 нэгжтэй тэнцэх буюу 10- 40 сая төгрөгөөр торгох, эсхүл 2-8 жилийн хорих ял шийтгэнэ.

Хүндрүүлэх бүрэлдэхүүн /ЭХ-ийн 17.3.3 дах хэсэг/

Залилах гэмт хэргийг үйлдсэн этгээд:

- a) Байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон /бусдыг залилан мэхэлж эд хөрөнгийг авч, түүнээс олсон орлогоороо амьдралаа залгуулдаг болсон байх/,

⁷⁷ С.Гантулга, Б.Энхболд “Эрүүгийн эрх зүй” /тусгай анги/ сурах бичиг. УБ, 2018, 187 дах тал

⁷⁸ Тухайлбал, бусдыг бөө болгож өгөх, хохирогчид болон түүний ойр дотны хүнд таагүй зүйл тохиолдохоос “аргалах” зэргээр хохирогчийг төөрөгдүүлж, түүнээс мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг ишлжүүлэн авах явдал түгээмэл байна.

⁷⁹ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй тусгай анги/сурах бичиг/. УБ.,2018. 188 дахь тал

- б) Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн /ААН-ийн нэрээр⁸⁰ халхавчлан албан ёсны үйл ажиллагаа явуулж байгаа мэт ойлголтыг олон түмэнд төрүүлэн хуулиар зөвшөөрөөгүй, хориглосон үйл ажиллагаа явуулсан байна⁸¹.
- с) Зохион байгуулалттай гэмт бүлэг /гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав ба түүнээс олон хүний тогтвортой нэгдэл/ үйлдсэн гэм буруутай этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэн 5-12 жилийн хорих ял шийтгэнэ гэж хуульчилжээ.

2.2. Залилах гэмт хэргийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэх нь

Залилах гэмт хэрэг болон иргэний эрх зүйн гэрээний харилцааг ялган зааглах асуудал нь эрүүгийн болон иргэний эрх зүйн онолын чухал асуудал төдийгүй иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой эрүүгийн болон иргэний процессын явцад тулгамдаж буй асуудал болоод байна.

Цагдаагийн Ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас гаргасан “Залилах” гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, судалгааны тайланд “Цагдаагийн байгууллагад хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг худалдах, худалдан авах, түрээслэх, түрээслүүлэх, арилжих, өндөр хүүтэй мөнгө зээлэх нэрээр гэрээ байгуулж, хохирогчийн эд хөрөнгийн эзэмших, өмчлөх эрхийг шилжүүлэн авахдаа өөрсдийн үйлдлийг гэмт хэргийн шинжгүй, иргэний эрх зүйн харилцааны явцад үүссэн гэрээний маргаантай асуудал болгож харагдуулах зорилгоор нотариатаар батлуулж, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр акт мэтээр үйлдэж байгаа нь уг гэмт хэргийн нэг шалтгаан болж байна⁸² гэжээ.

Практикт түгээмэл байгаа асуудлууд нь нэг талаас гэрээгээр халхавчилсан залилах үйлдэл байхад цагдаагийн байгууллагаас гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл хүлээн авч бүртгэхдээ гэрээ байгуулсан бол гэмт хэргийн шинжгүй иргэний журмаар шийдвэрлүүлэх маргаан хэмээн иргэдийн гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах болон шалгах аас аль болох татгалзах, нөгөө талаас иргэдийн хувьд иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган маргааныг шийдвэрлүүлэх талаар эрх зүйн мэдлэг дутмаг, шүүхэд хандахад улсын тэмдэгтийн хураамж төлдөг, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширдаг, олон сар, жил үргэлжлэх магадлалтай, шүүхийн шийдвэр биелэгддэггүй зэргээс шалтгаалан иргэний эрх зүйн харилцаанаас үүдэлтэй маргааныг цагдаагийн байгууллагаар шалгаж шийдвэрлүүлэх сонирхол ихтэй байна.

Мөн иргэд хоорондын гэрээнээс үүссэн харилцааны явцад гэрээний нэг тал нь хүлээсэн үүргээ биелүүлэх хөрөнгө, санхүүгийн болон үүрэг хариуцлагын хувьд боломжгүй болсон

⁸⁰ Жишээ нь: Казакстан улсын иргэн Жи тайм компаний захирал М.Матар 2015-2017 онд сүлжээний бизнесийн халхавчаар 11734 хүнээс 24 тэрбум залилсан пирамид тогтолцооны луйврыг цагдаагийн байгууллагаас шалгах үед 6,4 тэрбум төгрөг, 400 сая төгрөгний машин, 3 тэрбум төгрөгний эд бараа битүүмжлэгдсэн байдаг.

⁸¹ Ихэвчлэн хүмүүсийн тодорхой хэмжээний мөнгийг маш хурдан хугацаанд өсгөж өгөхөө амлаж итгүүлэн хуурч өөртөө татан төвлөрүүлж авна. Хамгийн эхэнд мөнгөө өсгүүлэхээр өгсөн цөөн хүний мөнгийг амласныхаа дагуу өсгөж өгч байгаа дүр үзүүлэн шуум тарааж үнэмшүүлэн итгүүлнэ. Энэхүү үйл явцыг сонссон, мөнгөө өсгүүлж авах хүсэлдээ хөтлөгдсөн олон түмэн эцэг, эх, үр хүүхэд, ах, дүүс, төрөл, төрөгсөд, найз нөхөд, ажлын газрынхан, нутаг орон, танил талын хүрээгээрээ нэг нь нөгөөгийнхөө ар араасаа татагдаж орж мөнгөө өгсөөр олон арав, зуу, мянган хүний, хэдэн тэрбумаар тоологдох мөнгийг залилан авч үрэн таран хийсэн байх/

⁸² ЦЕГ. “Залилах” гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, судалгаа. УБ., 2020, 8 дахь тал

хэдий ийнхүү нөхцөл байдлаа нуун дарагдуулах, бодит байдлаа үгүйсгэх, цаашид гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх ямар ч боломжгүй болсон хэдий ч биелүүлж чадна гэж хоосон таамаглах, нөгөө талд худал нөхцөл байдлыг бий болгон ярьж итгүүлэн үнэмшүүлэх, төөрөгдүүлэх, нэмж шунахайн сэдэлтээр эд хөрөнгө түүний эрхийг өөртөө шилжүүлэн авах явдал нэн түгээмэл болж байна⁸³.

Судлаач Ц.Цэлмэг, Д.Оросоо нар залилах гэмт хэрэг, иргэний хэрэг хоёрын нийтлэг ба төстэй тал нь:

- Хуулиар хамгаалагдсан бусдын өмчлөх эрхэнд халдаж гэм хор учруулсан байдаг;
- Иргэний хэргийн хариуцагч болон залилах гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдийн гэм буруутай сэтгэхүйн хандлага нь үйлдэл, эс үйлдэхүйтэй нь нөхцөлдөж байдаг;
- Иргэний хэргийн хариуцагч болон залилах гэмт хэрэг үйлдэж байгаа этгээд нь хэрэг хариуцах чадвартай, эцэстээ хууль зүйн хариуцлага хүлээдэг.

Залилах гэмт хэрэг, иргэний хэрэг хоёрын ялгаатай талыг тодорхойлохдоо:

- Залилах гэмт хэргийн иргэний хэргээс ялгагдах гол шинж нь нийгмийн хор аюулаараа ямагт их, гэрээгээр халхавчилж үүргийн гүйцэтгэлийг биелүүлэхгүй гэсэн санаа, зорилго агуулсан байдаг.
- Иргэний хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгч, хуулийн этгээд нь залилах гэмт хэргийн субъект байх боломжгүй, иргэний хэргийн харилцаанд оролцогчид тэгш эрхтэй байдаг бөгөөд талуудын харилцан зөвшилцөл дээр тулгуурладаг. Харин залилах гэмт хэрэгт түүнийг үйлдсэн этгээд, нөгөө талаас төрийн хуулийн байгууллага давуу эрхтэй харилцаанд оролцдог.
- Хохирлын хувьд залилах гэмт хэргийн бодит хохирлыг төлүүлэхэд шүүх анхаарал хандуулдаг бол иргэний хэрэгт олох байсан орлого, алданги, мөнгөний хүү зэргийг тооцон гаргуулдаг⁸⁴ гэжээ.

Улсын Дээд шүүх 2006 оны 12 сарын 21-ний өдрийн 51 дугаар тогтоолоор Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан “бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах” гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар тайлбар гаргасан.

Уг тогтоолд “гэрээний харилцаа нь Иргэний хууль тогтоомжийн дагуу үүсч, гэрээний биелэлтийн талаар мэдээлэл солилцож, харилцан гомдлын шаардлага гаргаж, эрсдлийг залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэхгүй. Харин гэрээгээр хүлээсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шалтаглаж бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг бүгдийг буюу заримыг шилжүүлэхгүй байх гэмт санаа зорилго төрж, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх замаар хуурч мэхлэх, итгэл эвдэх,

⁸³ Ц.Гантулгабат. Залилах гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэхэд анхаарах асуудал. Гэмт хэрэгтэй тэмцэх асуудал. 2018 №3. 39 дэх тал

⁸⁴ Ц.Цэлмэг, Д.Оросоо "Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ" Нээлттэй Нийгэм Форум. Шүүхийн шийдвэрийн судалгаа: Цуврал 2. УБ., 2021, 153 дахь тал

тодорхой үйлдэл хийсэн нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад тогтоогдвол залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ”⁸⁵ гэж тодорхойлжээ.

Залилах гэмт хэргийн халхавч болсон гэрээ хэлцэл нь хуурч мэхлэх, итгэл эвдэх аргад үндэслэгдсэн, шунахайн сэдэлтээр, дан ганцаар ашиг олох, гэрээнд оролцогч нөгөө талаа хохироох зорилгоор хийгдсэн байдаг бол иргэний эрх зүйн гэрээний харилцаа нь талуудын чөлөөт байдал, тэгш эрхэд суурилан, харилцан тодорхой үр дүнд хүрэхэд чиглэдэг учир гэрээ анхнаасаа биелэгдэх бодит боломжгүй байсан нь тогтоогдсон, гэрээний нэг тал үүнийг урьдчилан мэдсээр байж байгуулсан, нөгөө тал (хохирогч) нь мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан бол залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзнэ.

Мөн бусдын эд хөрөнгийг “зээл” нэрээр халхавчлан залилан мэхэлж авах нь уг зээлийг буцаан төлөх бодит баталгаагүй, тухайлбал, барьцаа хөрөнгөгүй, хөрөнгө нь биет байдлын болон эрхийн зөрчилтэй, түүнчлэн Иргэний хуульд заасан барьцааны гэрээ байгуулах журмыг санаатай зөрчсөн байдаг зэргээрээ иргэний эрх зүйн зээлийн гэрээнээс ялгагдана. Гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор барьцааны гэрээ байгуулахад барьцаалсан эд хөрөнгө нь үүрэг гүйцэтгүүлэгч гэрээний үүргийн шаардлагаа хангуулж авахад ямар нэгэн саад бэрхшээлгүй, боломжтой байх ёстой тул барьцааны эд хөрөнгө үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг анхнаасаа хангах боломжгүй байсан, үүрэг гүйцэтгэгч үүнийг мэдэж байсан ч санаатайгаар нуун далдалсан нь тогтоогдвол залилах гэмт хэрэг гэж үзнэ.

1) Б.С нь Т.Х-тай бүлэглэн 2016 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн хашаан дотор төмөр гир /гантель/ дотроос улаан мөнгөн ус хайж, цааш үнэд хүргэж зарах гэсэн В.Т, Х.С нарын хүсэл сонирхлыг ашиглан өөрийнхөө олж ирсэн “СССР” гэсэн бичиглэлтэй төмөр гирийг “жинхэнэ гир мөн байна, худалдаж авах нь зүйтэй” гэж итгүүлэн, уг гирийг Т.Х-аар дамжуулан В.Т, Х.С нарт нийт 49,700,000 төгрөгөөр худалдаж мөнгийг нь Т.Х-тай хуваан авсан буюу хуурч, зохиомол байдлыг зориудаар бий болгох, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж залилсан,

Уг хэргийг Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаас дараах байдлаар дүгнэжээ. Үүнд:

- “Уг хэргийг үйлдэхдээ шүүгдэгч нар нь хохирогч В.Т, Х.С нарын иргэний гүйлгээнд байдаггүй эд зүйлийг (улаан мөнгөн ус агуулсан төмөр туухай) худалдан авах гэсэн хүсэл сонирхлыг ашиглан тэдгээрийн хайж буй зүйлийг борлуулж буй мэтээр худал хэлэн хуурч дээрх мөнгийг хууль бусаар авсан үйлдлийг хоёр шатны шүүх залилах гэмт хэргийн шинжийг хангасан гэж дүгнэж, гэмт хэрэг үйлдэхэд тэдний гүйцэтгэсэн үүрэг, оролцоог үндэслэлтэй тогтоон хууль буцаан хэрэглэх замаар хэргийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн зохих заалтуудыг журамлан тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зөв зүйлчилжээ” гэж дүгнэжээ⁸⁶.

Дээрх байдлыг дүгнэн үзэхэд Улсын Дээд шүүхээс өнөөдрийн нийгмийн харилцааны онцлог байдлыг харгалзан 2015 онд батлагдсан Эрүүгийн хуульд хуульчлагдсан “Залилах” гэмт хэргийн шинжтэй уялдуулан Залилах гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний


⁸⁵ Б.Амартүвшин “Эрүүгийн болон иргэний эрх зүйн харилцан хамаарал”. Эрх зүйн сэтгүүл, МУИС-ХЗС, УБ., 2014/2, 125-132 дах тал

⁸⁶ Улсын Дээд шүүхийн тогтоол. 2021 оны 04 сарын 02-ны өдөр дугаар 184

харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар шинээр тайлбар гаргах шаардлагатай гэж үзэж байна.

3. АСУУДАЛ ДЭВШҮҮЛЭХ НЬ

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2010-2021 онд нийт 317.211 гэмт хэрэг бүртгэгдсэн байгаагаас 2002 оны Эрүүгийн хуулийн 148, 2015 оны Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлгийн 17.3-д заасан “Залилах” гэмт хэрэг 33740 бүртгэгдсэнээс 28458 буюу 84.3 хувь нь Нийслэлд, 5160 буюу 15.3 хувь нь орон нутагт, 139 буюу 0.4 хувь нь бусад газар /хилийн чандад/ тус тус үйлдэгдсэн байна.



Залилах гэмт хэрэг /2010-2021 он/

Дээрх графикаас хархад залилах төрлийн гэмт хэрэг нь сүүлийн 12 жилд тогтмол өссөн бөгөөд сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөж байна.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2010-2021 онд бүртгэгдсэн гэмт хэргийн Эрүүгийн хуулийн бүлгээр нь авч үзвэл нийт хэргийн 159.327 буюу 50.2 хувийг Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг байгаа бол залилах гэмт хэрэг нийт хэргийн 10.6 хувийг, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 21.2 хувийг тус тус эзэлж байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 1468 буюу 4.4 хувь нь бүлэглэн, 9080 буюу 26.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 466 буюу 1.4 хувь нь хүүхэд оролцож, 213 буюу 0.6 хувь нь гадаадын иргэн оролцож үйлдсэн байна.

Залилах гэмт хэргийн үйлдлийн аргыг мэдээллийн санд шивсэн байдлаар нь дээрх хүснэгтэд харуулсан бөгөөд 80.1 хуурч мэхэлсэн, 15.0 итгэл эвдсэн, 2.2 гэрээ хэлцэл байгуулж залилуулсан үйлдлүүд хамгийн их бүртгэгджээ.

2010-2021 оны хооронд гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан нийт хохирлын 199.3 тэрбум төгрөг буюу 28.2 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн байна.

2021 онд залилах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн хариуцлагын төрлөөс харахад анхан шатны шүүхээр нийт 390 хэргийн 308 нь хэрэгт торгох ял, давж заалдах шатны шүүхээр нийт 287 хэрэг шийдвэрлэсний 185 нь хэрэгт нь торгох ял, УДШ-ээр шийдвэрлэгдсэн 226 хэргийн 222 хэрэгт торгох ял оногдуулсан байна.

Залилах гэмт хэргийн гаралт нь 2015 онд Эрүүгийн хууль шинэчлэн батлагдсанаас хойш эрс нэмэгдэх, эрүүгийн хариуцлагын бодлого харилцан адилгүй, гэмт хэргийн шинжийг ялимгүй агуулсан үйлдэлд ногдуулах эрүүгийн хариуцлага хэт хатуу гэж үзсэнийг дараах Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн байдлаар харуулбал,

Хэрэг 1.

Хэргийн талаар:

Шүүгдэгч ... нь Чингэлтэй дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Кентаур” зочид буудлын орчимд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний орой 20 цагийн үед Т.Мягмаршагайгаас “гар утсаар чинь яриад өгье” гэж хэлэн иргэн Т.Мягмаршагайгийн өмчлөлийн 150.000 төгрөгийн үнэ бүхий Самсунг Эс-6 загварын гар утсыг хуурч эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан гэмт хэрэгт холбогджээ.

Шүүхийн шийдвэрлэлт:

Шүүгдэгч ... -ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар бусдыг хуурч бусдын эд хөрөнгийг шилжүүлэн авч залилах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцугай. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч ...г 1 /нэг/ жил 5 /тав/ сарын хорих ял оногдуулж шийтгэсүгэй⁸⁷.

Хэрэг 2.

Хэргийн талаар:

Шүүгдэгч Х.Х.Б- нь 2020 оны 07 дугаар сарын 04-ний өдөр Дархан-Уул аймгийн Дархан сумын 5-р багаас иргэн Ж.Ж.Т-ийн 09-** ДАА улсын дугаартай тоёота Приус-20 маркийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлэхдээ “Самсунг жи-7” маркийн гар утсыг утсаар ярьчаад өгье гэж хуурч авч 230000 төгрөгийн хохирол учруулсан гэх гэмт хэрэгт холбогджээ.

Шүүхийн шийдвэрлэлт:

Шүүгдэгч Х.Б-ыг бусдыг хуурч, зохиомол байдлыг зориудаар бий болгон өмчлөгчийн эд хөрөнгийг шилжүүлэн залилан авч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцугай. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Х.Х.Б-ыг 6 сарын хугацаагаар хорих ялаар шийтгэсүгэй .

Бага бус хэмжээний хохирол буюу 300.000 төгрөгнөөс доош үнийн дүнтэй эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 22 шийтгэх тогтоолд бусдыг хуурч, зохиомол байдлыг зориудаар бий болгосон гэх хоёр үндсэн шинжийг шүүхийн шийдвэрт хэрэглэж байна. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 22 шийтгэх тогтоолоос 7-д нь 6 сараас-1 жил 5 сар хүртэл хорих ялаар шийтгэх ба тэдгээр гэмт хэргийн шүүгдэгч нар нь анх удаа гэмт хэрэг үйлдсэн байна.

Дээрх шүүхийн шийдвэрүүдийг харьцуулан үзвэл Залилах гэмт хэргийн бүрэлдэхүүнд материаллаг бүрэлдэхүүн буюу гэмт үйлдлийн улмаас тодорхой тоон үзүүлэлт бүхий хохирол, хор уршиг шаардаж, гэмт хэргийн нийгэмд аюултай гэх шинжийг хангахад илүү зохимжтой юм. Хохирлыг хэмжээ нь 300,000 төгрөгийн хэмжээнд хүрэхгүй байгаа тохиолдолд ЭХТА-ийн 17.3 дугаар зүйлийн 17.3.1 дэх хэсгээр зүйлчилж буй нь 2015 оны Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан эрүүгийн хариуцлагын зорилготой нийцэхгүй, гэмт хэргийн шинжтэй ялимгүй үйлдэлд ногдуулсан ял нь хүндэтсэн гэж үзэх талтай. Дээрх эрүүгийн хэргүүдээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг зааж өгөөгүй, хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар хууль тогтоогчийн зүгээс баталсан нь гэмт хэргийн нөхцөл байдлыг өөрчлөх, ихсэх нөхцлийг бүрдүүлсэн байна.

Иймд тус заалтыг “бага хэмжээнээс ихгүй хохирол учруулсан бол” гэж өөрчилж материаллаг бүрэлдэхүүнтэй болгох шаардлагатай байна.

2015 оны Эрүүгийн хуульд залилах гэмт хэргийг хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан үйлдлээр илрэхээр хуульчилсан. Гэтэл дэлхий дахин даяарчлагдахын хэрээр залилах гэмт хэрэг үйлдэгчдийн арга, заль нарийсч үйлдлийн арга нь өөрчлөгдсөөр байгаа бөгөөд зөвхөн дээрх үндсэн 6 шинжид хумигдах нь тохиромжгүй байна. Иймд эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тогтмол судлаж, эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг боловсронгуй болгоход цаг үргэлж анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

4. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

ОХУ

Оросын холбооны улс залилан мэхлэх гэмт хэргийг хуурч мэхлэх эсвэл итгэл эвдэх гэсэн 2 аргаар үйлдвэл гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан бөгөөд хүндрүүлэх нөхцөлд хохирлын хэмжээг их хэмжээний, ноцтой, онц их хэмжээний гэж зааснаар онцлог зохицуулалт болсон. Залилах гэмт хэргийг цахим төлбөрийн хэрэгсэл ашиглах, даатгалын залилан, компьютерийн мэдээллийн салбарт залилан хийх, зээлийн залилан, төлбөр хүлээн авахдаа залилан хийх зэргээр залилах гэмт хэргийг өргөн хүрээнд авч үзсэн байна. Тухайлбал: Залилан мэхлэх (мошеничество) /159 дүгээр зүйл/ : Залилан мэхлэх буюу бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг хуурч мэхлэх эсхүл итгэл эвдэх замаар, урьдчилан үгсэн тохиролцсон, албан тушаалын байдлаа ашиглаж, зохион байгуулалттай бүлэглэл онц их хэмжээний эсхүл орон байраа алдах хэмжээний хохирол учруулж, бизнесийн үйл ажиллагааны хүрээнд хүлээсэн гэрээний үүргийг санаатайгаар зөрчсөн бол торгох, албадан хөдөлмөр эрхлэх, эрх чөлөөг хязгаарлах, баривчлах, хорих ял оноодог байна.

ХБНГУ

ХБНГУ- ын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн нэр нь Залилан мэхлэх болон ашиглан завших гэмт хэрэг бөгөөд залилан мэхлэх гэмт хэргийг хэд хэдэн зүйлд хуваан тодорхойлсон онцлогтой байна. Тухайлбал, залилан мэхлэх (263 дугаар зүйл), компьютерийн залилан (263а дугаар зүйл), нөхөн төлбөрийн залилан (264 дүгээр зүйл), үндсэн хөрөнгө оруулалтын залилан (264а дүгээр зүйл), даатгалын залилан (265 дугаар зүйл), гэсэн гэмт хэргүүдийг тодорхойлсон .

Залилан мэхлэх гэмт хэргийн ерөнхий шинжийг тодорхойлохдоо өөртөө болон өөр этгээдэд хууль бус материаллаг давуу байдал бий болгох зорилгоор бодит байдлыг гуйвуулж, нуун дарагдуулж, хуурамч байдалд түшиглэн бусдыг төөрөгдүүлж бусдад эд хөрөнгийн хохирол учруулсан бол гэмт хэрэгт тооцохоор заасан байна. Энэ нь ерөнхий агуулгын хувьд манай Эрүүгийн хуулийн зохицуулалттай ижил төстэй гэж ойлгож болохоор байна.

Мөн түүнчлэн албан тушаалын байдлаа ашиглаж, их хэмжээний хохирол учруулж, зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүний хувиар үйлсдэн шинжийг хүндрүүлэх нөхцөлд тооцсон нь адилхан байгаа бол бусдыг санхүүгийн хүнд байдалд оруулсан, арилжаа, бизнесийн зорилгоор үйлдсэн гэх шинжүүдийг бусдад ноцтой хохирол учруулсан, байнга үйлдэж, амьдралын эх үүсвэр болгосон гэх нь адил төстэйгээс гадна нөхөн төлбөрийн залилан хийх гэмт хэргийн олон шинжийг тодорхойлсныг манай эрүүгийн хуулийн 18.2 болон 18.15 дугаар зүйлд заасан хууль бусаар нийгмийн халамж үйлчилгээ авсан, мөн хууль бусаар

даатгалын нөхөн төлбөр авсан үйлдлүүдийг зарим талаар адилтгаж болох боловч, үүнээс үүдэлтэйгээр даатгалаас бусад төрлийн нөхөн олговор, тэтгэлэг, төлбөр зэргийг хууль бусаар авахыг эрүүгийн хуулиар бүрэн хориглож чадсан эсэх, эсхүл эдгээр үйлдлийг залилах гэмт хэргээс ялгаж зүйлчлэх зэрэг нь хууль хэрэглээний хувьд бэрхшээл дагуулж болзошгүй юм. Үүнтэй нэгэн адил үндсэн хөрөнгө оруулалт, хувьцаа болон даатгалын харилцаатай холбоо бүхий зах зээлийн нийгэмд үйлдэгддэг залилах болон луйврын шинжтэй хууль бус үйлдлийг зөв олж таньж, оновчтой томъёолоход хуульч эрдэмтэд төдийгүй, практик хуульчдын санаачилга, оролцоо чухал юм.

5. ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсад үйлдэгдэж буй залилах гэмт хэрэг өсөн нэмэгдэж, үйлдлийн арга нь улам нарийсч байгаа нь эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны тусламжтайгаар судалгаа, шинжилгээ хийж гүйцэтгэж, санал, зөвлөмж боловсруулах замаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

2002 оны Эрүүгийн хуульд залилан мэхлэх гэмт хэргийн шинжийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх олж авсны улмаас бага бус, үлэмж, их, онц их хэмжээний хохирол учруулсан бол ял шийтгэнэ гэж хуульчилсан нь шударга ёсны зарчимд нийцүүлж байжээ.

Харин 2015 оны Эрүүгийн хуульд хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан үйлдлээр илэрнэ гэж заасан.

Залилах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй учир хор уршиг шаардахгүй, залилах үйлдэл хийгдсэнээр гэмт хэрэгт тооцно. Хүндрүүлэх бүрэлдэхүүнд байгаа ноцтой болон их хэмжээний хохирол нь об'ектив талын нэмэгдэл шинж болж байгаа учир мөрдөн байцаалтын явцад хохирол, хор уршгийг нь заавал тогтоох шаардлага үүсэж байна.

Судлаач оюутнуудын зүгээс дараах саналуудыг дэвшүүлж байна.

1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд “Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол” гэснийг авсан гэдгийн ард “бага хэмжээнээс ихгүй хохирол учирсан” гэж өөрчилж материаллаг бүрэлдэхүүнтэй болгох.

2. Хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлд хохирлын хэмжээг бага, үлэмж, их гэж гурав ангилсан бөгөөд онц их хэмжээний хохирлыг хуульчлаагүйгээс залилах гэмт хэрэг үйлдэж, тэрбумаас дээш хэмжээний хохирол учруулсан этгээдүүд хэт хөнгөн ял авч, хохирол барагдахгүй байх нөхцөл бүрджээ. Тиймээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйл 2.2 дахь хэсэг бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулвал гэсэн хэсэгт онц их хэмжээний хохирол гэж нэмэлтээр оруулах.

3. Залилах гэмт хэргийг төрөлжүүлэн ангилж, түүнд хүлээлгэх ял, эрүүгийн хариуцлагыг тус бүрт нь ялгаж зааглан хуульчлах. Тухайлбал: Хөдөлмөрийн Даатгалын, Зээлийн, Цахим, Шуудангийн, Нийгмийн халамжийн гэх мэт

АШИГЛАСАН МАТЕРИАЛ**А. Хууль тогтоомж**

1. Монгол Улсын Үндсэн хууль.,УБ, 1992 он
2. Монгол Улсын Эрүүгийн хууль.УБ, 2015 он
3. Монгол Улсын Эрүүгийн хууль.УБ., 2002 он
4. Монгол Улсын Иргэний хууль.,УБ, 2002 он
5. Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль. УБ., 2021 он

Б. Ном, сурах бичиг

1. Амартүвшин. С. “Эрүүгийн болон иргэний эрх зүйн харилцан хамаарал”.Эрх зүйн сэтгүүл, МУИС-ХЗС, УБ., 2014 он
2. Гантулга. С, Энхболд. Б. Эрүүгийн эрх зүй тусгай анги/сурах бичиг/. УБ., 2018 он
3. Доржпалам. Х. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй./Ерөнхий анги/. УБ., 2019 он
4. Доржпалам. Х. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй./Тусгай анги/. УБ., 2021 он
5. Должин. С. Хувийн эрх зүй эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. УБ., 2017 он
6. Нарангэрэл. С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. /анхны хэвлэл/. УБ., 1996 он
7. Нарангэрэл. С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ., 1999 он
8. Нарангэрэл. С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй/Тусгай анги/. УБ., 1999 он
9. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. “Залилах” гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, судалгаа. УБ., 2020 он
10. Цэлмэг. Ц, Д.Оросоо "Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ" Нээлттэй Нийгэм Форум. Шүүхийн шийдвэрийн судалгаа: Цуврал 2. УБ., 2021 он
11. ШЕЗ “Шүүхийн эрх мэдэл” мэдээлэл арга зүйн улирал тутмын эмхэтгэл. УБ., 2016 он
12. ШЕЗ “Эдийн засгийн гэмт хэрэг”. УБ., 2017 он
13. Уголовная ответственность за мошенничество: автореф. дис. ... канд. юрид. наук / М. Ю. Хмелева. – Омск, 2008
14. Уголовная ответственность за мошенничество в сфере страхования автотранспортных средств: дис. ... канд. юрид. наук / А. В. Филиппов. – Москва, 2010
15. Улсын Дээд шүүхийн тогтоол. 2021 оны 04 сарын 02-ны өдөр дугаар 184
16. Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 сарын 31 өдрийн дугаар 214 шийтгэх тогтоол

В. Цахим эх сурвалж:

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан. <https://legalinfo.mn/mn>
2. <https://mongolia.hss.de/mn/>